



**МОНГОЛБАНК**  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

# ЖИЛИЙН ТАЙЛАН 2021



# МОНГОЛБАНК



## ЖИЛИЙН ТАЙЛАН 2021



Монголбанкны Ерөнхийлөгч  
Б.Лхагвасүрэн



## Өмнөх үг

Өнгөрсөн 2021 онд дэлхий нийтэд Ковид-19 цар тахлын давалгаа үргэлжилсэн хэдий ч Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарт сэргэлт гарч, том сорилтуудыг амжилттай даван гарлаа. КОВИД-19 цар тахлаас үүдэн эдийн засаг 2020 онд 5.3 хувийн агшилттай байсан бол 2021 онд 1.2 хувийн өсөлттэй гарлаа. Эдийн засаг ийнхүү сэргэж, зээлийн хүү буурч, зээл олголт идэвхжихэд төсөв, мөнгөний бодлогын багц арга хэмжээг банкны салбараар дамжуулж хэрэгжүүлсэн нь гол нөхцөлийг бүрдүүлэв. Банкны салбарын зээлийн өсөлт 21.3 хувиар өсөж, шинээр олгосон төгрөгийн зээлийн дундаж хүү 14.3 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2 нэгж хувиар буурав. Цар тахлаас шалтгаалсан хил, боомтын хязгаарлалтаас үүдэн нүүрсний экспорт саатсан хэдий ч төгрөгийн гадаад валюттай харьцах ханш оны туршид тогтвортой байж, гадаад валютын улсын нөөц өндөр түвшинд тогтвортой хадгалагдлаа.

Банкны салбарын шинэчлэл амжилттай үргэлжилж, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр батлагдлаа. Ингэснээр, банкныг нээлттэй, хувьцаат компани болгох, банкны хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулж, өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх, банк татан буугдсан үед төлбөр барагдуулах дарааллыг ойлгомжтой болгох, банкны систем дэх нөлөө бүхий банкны тодорхойлолтыг нарийвчлан боловсронгуй болгох чиглэлд өөрчлөлтүүд орлоо. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох журмуудыг боловсруулж бэлтгэснээр банкууд нээлттэй компани болж, үнэт цаасаа анх удаа олон нийтэд санал болгох (IPO) төлөвлөгөөгөө ирүүлж, эхнээсээ 2021 ондоо багтаж IPO-гоо амжилттай гаргав.

Түүнчлэн, санхүүгийн салбарын эрх зүйн орчин, технологийн дэд бүтэц, төлбөр тооцоо, хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг сайжруулж, цар тахлын үеийн түр зохицуулалтыг ердийн нөхцөлд шилжүүлэх төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэллээ. Монголбанк Үндэсний төлбөр тооцооны ₮ картыг EMV технологид шилжүүлсэн амжилтаар “Bloomberg TV Mongolia Awards 2021”-ийн “Шилдэг инновац” шагналыг хүртлээ. “₮” картыг олон улсын жишигт нийцсэн EMV чип технологид амжилттай шилжүүлснээр нууцлал, аюулгүй байдал сайжирч, улмаар ₮ картын мэдээллийг хуулбарлах эрсдэл буурснаас гадна мобайл төлбөр тооцооны дэвшилтэд шийдлийг нэвтрүүлэхэд чухал алхам боллоо. EMV чиптэй ₮ картыг хэрэглэнд нэвтрүүлснээр төлбөр төлөх, гүйлгээ хийх явц илүү хялбар, хурдан болсон. Тухайлбал, иргэд өөрийн төлбөрийн картыг зайнаас уншуулж мөнгөн дүнгийн тодорхой хязгаар дотор ПИН кодгүй гүйлгээ хийх, улмаар нийтийн тээвэр, машин зогсоол, замын төлбөр зэрэг төлбөр тооцоог хурдан шуурхай хийх боломж бүрдсэн. Ингэснээр арилжааны банкууд болон Финтек компаниуд шинэ төлбөрийн үйлчилгээ нэвтрүүлэх суурь нөхцөлийг бүрдүүллээ.

Монголбанкны хувьд эдийн засгийн сэргэлтийг бат суурьтай байлгах, банкны салбарт хэрэгжиж буй шинэчлэлийг амжилттай үргэлжлүүлэх үүднээс мөчлөг сөрсөн, өөрийн орны нөхцөл байдалд бүрэн

нийцтэй бодлогыг хэрэгжүүлж байна. Төв банк бодлогын тохиргоог судалгаа, шинжилгээнд үндэслэн боловсруулж, гаргасан шийдвэр, түүний үндэслэлийг нээлттэй, ил тодоор тайлбарлахын зэрэгцээ олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажилд хувь нэмрээ үргэлжлүүлэн оруулах болно.

Бид хамтдаа сорилтыг боломж болгож, эдийн засгаа тогтвортой сэргээж, банкны шинэчлэлийг амжилттай үргэлжлүүлж чадна гэдэгт итгэл төгс байна.


Монгол Улс хөгжин цэцэглэж, мандан бадрах болтугай!

МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

# МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СХЕМ





## ГАРЧИГ

|                                                                                    |            |
|------------------------------------------------------------------------------------|------------|
| <b>1. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ</b>                                    | <b>9</b>   |
| 1.1. Бодит сектор .....                                                            | 9          |
| 1.2. Гадаад сектор .....                                                           | 13         |
| 1.3. Мөнгө, санхүүгийн сектор .....                                                | 20         |
| 1.4. Монгол Улсын нэгдсэн төсөв .....                                              | 28         |
| <b>2. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ</b>                                              | <b>31</b>  |
| 2.1. Мөнгөний бодлогын үндсэн зорилт, арга хэмжээ, үр дүн .....                    | 31         |
| 2.2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа .....      | 34         |
| 2.3. Банкны салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогын хэрэгжилт ..... | 39         |
| 2.4. Гадаад валютын улсын нөөцийн удирдлага .....                                  | 43         |
| 2.5. Монгол Улсын төлбөрийн систем .....                                           | 44         |
| 2.6. Банк, санхүүгийн салбарын хууль тогтоомжийн шинэчлэл, өөрчлөлт .....          | 49         |
| 2.7. Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр .....             | 51         |
| <b>3. МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>                         | <b>57</b>  |
| 3.1. Нээлттэй захын үйл ажиллагаа .....                                            | 57         |
| 3.2. Төв банкны санхүүжилт .....                                                   | 62         |
| 3.3. Бусад санхүүжилт .....                                                        | 62         |
| 3.4. Засгийн газрын үнэт цаас .....                                                | 64         |
| 3.5. Монголбанкны валютын захын оролцоо .....                                      | 65         |
| 3.6. Алтны санхүүжилт, үнэт металлын худалдан авах үйл ажиллагаа .....             | 67         |
| <b>4. МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b>                     | <b>69</b>  |
| 4.1. Монголбанкны бүтэц, орон тоо .....                                            | 69         |
| 4.2. Гадаад харилцаа .....                                                         | 70         |
| 4.3. Төв банкны олон нийттэй харилцах харилцаа .....                               | 71         |
| 4.4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ .....        | 74         |
| 4.5. Дотоод аудит .....                                                            | 82         |
| 4.6. Эрсдэлийн удирдлага .....                                                     | 82         |
| 4.7. Бэлэн мөнгөний удирдлага .....                                                | 85         |
| 4.8. Мэдээллийн технологи .....                                                    | 89         |
| 4.9. Монголбанкнаас 2021 онд баталсан хэм хэмжээний актын хураангуй .....          | 90         |
| 4.10. Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэн .....                             | 92         |
| <b>5. АУДИТААР БАТАЛГААЖСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b>                                  | <b>93</b>  |
| <b>6. СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТ</b>                                                    | <b>221</b> |






## 1.1 БОДИТ СЕКТОР

### Үйлдвэрлэл


Дотоодын нийт бүтээгдэхүүн<sup>1</sup> (ДНБ)-ий бодит хэмжээ 2021 онд өмнөх оноос 1.4%<sup>2</sup>-иар өсжээ. Эрэлт буюу эцсийн ашиглалт талаас эдийн засгийн өсөлтийн Засгийн газрын хэрэглээ 1 нэгж хувийг, 18.3 нэгж хувийг хөрөнгө оруулалт, -4.5 нэгж хувийг өрхийн хэрэглээ бүрдүүлсэн байна (Зураг 1.1).

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор БНХАУ-ын талаас авч хэрэгжүүлсэн “Тэг Ковид” бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн хилийн хорио, цээрээс үүдэн өнгөрсөн оны мөн үеэс бараа, үйлчилгээний экспорт 14.5%-иар буурч улмаар цэвэр экспорт -13.4 нэгж хувийн нөлөө үзүүлжээ.

Зураг 1.1. ДНБ-ий өсөлт, эцсийн ашиглалтын аргаар



Зураг 1.2. ДНБ-ий өсөлт, үйлдвэрлэлийн аргаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл өнгөрсөн онд 3.1 хувийн бууралттай байсан бол 2021 онд жилийн өсөлт нь 4.3 нэгж хувиар нэмэгдэж ДНБ-ий өсөлтийн 1.2 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Харин уул уурхай, олборлох салбар нь ДНБ-ий өсөлтийн 0.2 нэгж хувийг бүрдүүлжээ (Зураг 1.2).

Уул уурхайн бус салбар дотроо тээвэр, агуулахын салбар 16.7%-иар буурч өсөлтөд 0.8 нэгж хувь, барилгын салбар 32.7%-иар буурч өсөлтөд 1.3 нэгж хувийн сөрөг нөлөөг үзүүлсэн байна. Түүнчлэн хөдөө аж ахуйн салбар 5.5%-иар буурч өсөлтөд 0.8 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлсэн нь хүн амын хүнсний болон экспортын хэрэгцээнд зориулан бэлтгэх малын тоо толгой өнгөрсөн оны хэмжээнд хүрээгүй нь голлон нөлөөлжээ (Зураг 1.3).

<sup>1</sup> 2015 оны суурь үнээр тооцсон.

<sup>2</sup> Үйлдвэрлэлийн аргаар тооцсон бодит ДНБ-ий өсөлт.


Зураг 1.3. ДНБ-ий өсөлт, үйлдвэрлэлийн салбаруудаар




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Мөн сүүлийн 6 улирал дараалан уналттай байсан барилгын салбарын хувьд 2021 онд 32.7%-иар буурч эдийн засгийн өсөлтөд 1.3 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлсэн нь орон сууцны болон инженерийн барилга байгууламж нэлээдгүй хувиар агшсантай холбоотой байна. Харин эрчим хүчний салбар 9.4%-иар нэмэгдэж, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 0.3%-иар өсч нийт ДНБ-д 0.2% болон 0.03%-ийн тус тус эерэг нөлөөг үзүүлжээ (Зураг 1.4).

Зураг 1.4. ХАА, аж үйлдвэрлэлийн салбаруудын өсөлт



Зураг 1.5. Үйлчилгээний салбаруудын өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


## Инфляц

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлд Төв банк инфляцын зорилтыг 2021-2023 онд жилийн 6 хувийн орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулахаар тусгасан. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх улсын инфляц оны эхний улиралд нам түвшинд, II, III улиралд зорилтот түвшний орчимд байсан бол IV улиралд зорилтот түвшнээс давж оны эцэст 13.4 хувьд хүрч нэмэгдлээ.

“КОВИД-19” цар тахлаас шалтгаалан хямарсан дэлхийн эдийн засаг 2021 онд хурдтай сэргэж нийлүүлэлтээс давсан эрэлтийг үүсгэсэн нь дэлхий нийтээр инфляцыг эрчимжүүлж байна. Үүний дээр олон улсын тээвэр логистикийн саатал, түүнийг дагасан үйлдвэрлэлийн доголдол, түүхий эдийн өндөр үнэ зэрэг нь импортоор дамжин үнэ өсөх нөхцөлийг бүрдүүлж байна. Дотоодын бараа бүтээгдэхүүнүүдийн хувьд тээврийн болон үйлдвэрлэлийн зардал нэмэгдсэн, малын халдварт өвчин дэгдсэн, хүнсний ногооны үнэ улирлын хандлагаас эрт өссөн нь инфляц нэмэгдэхэд нөлөөллөө (Зураг 1.6).

Цар тахлын үед өрхийн санхүүгийн дарамтыг зөөллөх, хэрэглээнд зарцуулах орлогыг дэмжих зорилгоор мөнгө, сангийн бодлого, макро зохистой бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж байсан нь эрэлтийг тэтгэх нөлөөтэй байв. 2021 онд эдийн засгийн идэвхжил алгуур сэргэсэн нь эрэлтийн гаралтай инфляцыг тодорхой хэмжээнд нэмэгдүүлэх нөлөөтэй байв.

Зураг 1.6. Сарын болон жилийн инфляц



Хүснэгт 1.1 Жилийн инфляцын задаргаа (УБ)

| Нэр                      | Жин         | Жилийн өсөлт  | Жилийн инфляцад эзлэх хувь |
|--------------------------|-------------|---------------|----------------------------|
| <b>Мах</b>               | <b>0.10</b> | <b>24.3%</b>  | <b>2.4%</b>                |
| <b>Шатахуун</b>          | <b>0.06</b> | <b>48.3%</b>  | <b>2.2%</b>                |
| Хүнсний ногоо            | 0.02        | 44.4%         | 1.0%                       |
| Түлшний мод              | 0.01        | 39.0%         | 1.0%                       |
| Нийтийн хоолны үйлчилгээ | 0.04        | 22.6%         | 1.0%                       |
| Сүү, сүүн бүтээгдэхүүн   | 0.04        | 19.9%         | 0.8%                       |
| <b>Сайжруулсан түлш</b>  | <b>0.02</b> | <b>100.0%</b> | <b>0.7%</b>                |
| Нийт                     | 0.29        |               | 9.1%                       |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Жилийн инфляцад<sup>3</sup> нөлөөлсөн гол хүчин зүйлсийг дэлгэрүүлбэл (Хүснэгт 1.1)

- **Махнаас бусад дотоодын хүнс** инфляцын 2.3 нэгж хувийг бүрдүүлэв. Үүнд: 1) хилийн асуудлаас шалтгаалан 10-р сард импортын хүнсний ногооны нийлүүлэлт тасалдахад дотоодын хүнсний ногооны үнэ өсөж өндөр түвшинд хадгалагдсан, 2) цар тахал, шатахууны үнийн өсөлттэй холбоотойгоор үйлдвэрлэлийн зардал нэмэгдсэн нь дотоодын хүнсний үнэд нөлөөлж байна.
- **Дотоодын махны** үнэ жил бүрийн IV улиралд буурдаг хэдий ч 2021 оны 10-р сараас хойш улирлын хандлагынхаа эсрэг буюу өссөнөөр оны эцэст инфляцын 2.2 нэгж хувийг бүрдүүлэв. Үүнд, 10-р сард орон нутагт малын гоц халдварт өвчин дэгдсэн нь махны нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлж үнэ нь өсөх нөхцөлийг бүрдүүлсэн байж болохоор байна.
- **Импортын хүнс** инфляцын 1.8 нэгж хувийг бүрдүүлэв. Үүнд: 1) 10-р сард “Замын-Үүд” боомт хаагдсанаас хойш зарим хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдсан, 2) хилийн саатал болон шатахууны үнэ өссөнтэй холбоотойгоор тээврийн зардал нэмэгдсэн, 3) олон улсад хүнсний үнэ өндөр байгаа зэргээс импортын хүнсний бүтээгдэхүүний үнэ IV улиралд эрчтэй нэмэгдсэн нь нөлөөлөв.
- **Шатахууны үнэ** инфляцын 2.2 нэгж хувийг бүрдүүлэв. Төгрөгийн ханш тогтвортой байсан хэдий ч дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлт нь хилийн үнээр дамжин дотоодын шатахууны үнэ 2021 онд дунджаар 850 төгрөгөөр нэмэгдлээ.


<sup>3</sup> Улаанбаатар хотын жилийн инфляц

- **Хатуу түлш бүлэг** инфляцын 1.7 нэгж хувийг бүрдүүлэхэд 1) **түлшний модны** үнэ жилийн 39 хувиар өссөн, 2) **сайжруулсан түлш** 50 хувийн хөнгөлөлттэй үнээр зарагдаж байгаа хэдий ч өмнөх оны 75 хувиар хямдарсан суурь үеийн нөлөөгөөр оны эцэст инфляцыг 0.7 нэгж хувиар нэмэгдүүлсэн нь нөлөөллөө.


### Ажил эрхлэлт

Хөдөлмөрийн захын 2021 оны байдлыг тоймлон авч үзвэл ихэнх үзүүлэлтүүд нь өмнөх оноос бага зэрэг буурсан бөгөөд цар тахлаас өмнөх үеийн түвшинтэй харьцуулахад сул хэвээр байна. Тухайлбал, хөдөлмөрийн насны хүн ам 2021 оны дунджаар өмнөх оноос 1.4%-иар буурч, 2,104.7 мянгад хүрсэн байна. Үүний дотор эдийн засгийн идэвхтэй хүн ам өмнөх оноос 0.8%-иар өсч 1,226.5 мянга болсон бол идэвхгүй хүн ам 4.4%-иар буурч 878.2 мянга болсон байна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам өсч, идэвхгүй хүн ам буурсан тул ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оноос даруй 1.3 нэгж хувиар өсч 58.3%-д хүрэв. (Зураг 1.7). Мөн нийт ажилгүй иргэдийн тоо ажилчдын тооноос илүү ихээр нэмэгдсэн тул ажилгүйдлийн түвшин 0.5 нэгж хувиар өсч 8.1%-д хүрэв (Зураг 1.8).

Зураг 1.7. Ажиллах хүчний оролцооны түвшин



Зураг 1.8. Ажилгүйдлийн түвшин




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Улсын хэмжээнд нийт ажилчдын тоог эдийн засгийн үйл ажиллагааны гол салбаруудаар авч үзвэл 2021 онд 487.1 мянга буюу 43.2% нь үйлчилгээний салбарт, 277.8 мянга буюу 24.7% нь хөдөө аж ахуйн салбарт, 218.7 мянга буюу 19.4% нь аж үйлдвэрийн салбарт, 143.5 мянга буюу 12.7% нь худалдааны салбарт тус тус ангилагдаж байна (Зураг 1.9).

Нийт ажил эрхлэлт 2021 онд өмнөх онтой харьцуулахад 0.2%-иар нэмэгдсэн бөгөөд үүнд хөдөө, аж ахуй болон аж үйлдвэрийн салбарын ажилчдын өсөлт голлон нөлөөлжээ. Харин худалдаа болон үйлчилгээний салбарт ажиллагчдын тоо саарсан үзүүлэлттэй байна.

Зураг 1.9. Ажилчдын тооны өсөлт (хувиар), ажилчдын тоо (эдийн засгийн салбараар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

## 1.2 ГАДААД СЕКТОР

### Төлбөрийн тэнцэл


2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр урсгал ба хөрөнгийн данс 1,832 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 1,835 сая ам.долларын ашигтай гарснаар, төлбөрийн тэнцлийн алдагдал 222 сая ам.долларт хүрсэн. Алдаа ба орхигдуулга 224 сая ам.доллар байна.

Зураг 1.10 Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл




Эх сурвалж: Монголбанк

Зураг 1.11 Урсгал ба хөрөнгийн дансны тэнцлийн бүтэц



Урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 1,832 сая ам.долларын алдагдалтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 220%-иар буюу 1,261 сая ам.доллараар өссөн дүн бөгөөд үүнд анхдагч орлогын дансны алдагдал голлон нөлөөлжээ.

Зураг 1.12. Санхүүгийн дансны тэнцлийн бүтэц



Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн дансны тэнцэл 1,835 сая ам.долларын ашигтай гарч өнгөрсөн оны гүйцэтгэлээс 22%-иар буюу 331 сая ам.доллаароор өссөн байна.

### Барааны гадаад худалдаа<sup>4</sup>

Монгол Улсын барааны гадаад худалдааны тэнцэл 2021 онд 2,398 сая ам.долларын ашигтай гарч, сүүлийн найман жил дараалсан ашигтай үзүүлэлтийг үзүүлээ.

Хүснэгт 1.2. Барааны гадаад худалдаа, сая ам.доллар

| Төрөл   | 2015  | 2016  | 2017   | 2018   | 2019   | 2020   | 2021   | Өөрчлөлт (21'/20') |      |
|---------|-------|-------|--------|--------|--------|--------|--------|--------------------|------|
|         |       |       |        |        |        |        |        | Дүн                | Хувь |
| Эргэлт  | 8,467 | 8,274 | 10,538 | 12,887 | 13,747 | 12,875 | 16,096 | 3,221              | 25%  |
| Экспорт | 4,669 | 4,916 | 6,201  | 7,012  | 7,620  | 7,576  | 9,247  | 1,671              | 22%  |
| Импорт  | 3,798 | 3,358 | 4,337  | 5,875  | 6,128  | 5,299  | 6,849  | 1,550              | 29%  |
| Тэнцэл  | 872   | 1,558 | 1,863  | 1,137  | 1,492  | 2,277  | 2,398  | 121                | 5%   |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

Худалдааны тэнцэл 2,398 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оноос 5%-иар буюу 121 сая ам.доллаароор өссөн үзүүлэлт юм. Тодруулбал, импорт 29%-иар буюу 1,550 сая ам.доллаароор, экспорт 22%-иар буюу 1,671 сая ам.доллаароор тус тус өсч, худалдааны нийт эргэлт өмнөх оноос 25%-иар буюу 3,221 сая ам.доллаароор өссөн байна.

**Экспорт:** 2021 онд зэсийн хүдэрийн үнэ өнгөрсөн оны түвшнээс 1,122 сая ам.доллаароор, чулуун нүүрс 640 сая ам.доллаароор, төмрийн хүдэр 313 сая ам.доллаароор, боловсруулаагүй нефть 123 сая ам.доллаароор тус тус өссөн нь уул уурхайн бүтээгдэхүүний экспорт 21% буюу 1,469 сая ам.доллаароор өсөхөд нөлөөлсөн байна.

Мөн аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны гүйцэтгэлээс 56%-иар буюу 130 сая ам.доллаароор, мал аж ахуйн гаралтай экспорт 27%-иар буюу 80 сая ам.доллаароор тус тус өссөн нь нийт экспортын өсөлтөд нөлөөлжээ.


<sup>4</sup> ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэсэн тоон мэдээлэл бөгөөд аргачлалын ялгаатай байдлаас шалтгаалан Төлбөрийн тэнцлийн статистикаас зөрүүтэй болно.

Олон улсын зах зээл дээрх экспортын голлох эрдэс бүтээгдэхүүнүүдийн үнэ 2021 онд өндөр түвшинд хадгалагдлаа. Дэлхийн эдийн засаг 2020 сүүлээс хурдацтай сэргэж, аж үйлдвэрлэл идэвхжин, түүхий эдийн эрэлт нэмэгдсэн ч нийлүүлэлт эрэлтийг даган эрчимтэй сэргэж чадаагүйгээс түүхий эдийн үнэ ийнхүү өсөв.

**Алтны үнэ:** Алтны үнэ 2021 онд дунджаар 1,800 ам.доллар/унцад хүрч өмнөх оноос 1.6 хувиар өсчээ. Үүнд 1) КОВИД-19 цар тахлын хувилбарууд тархаж, тодорхой бус байдал өндөр хэвээр байсан, 2) дэлхий нийтийн нийлүүлэлтийн гинжин хэлхээнд доголдол үүссэн, түүхий эдийн үнэ өссөн, эрэлт эрчимжсэн зэргээс улс орнуудын инфляц нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.

**Зэсийн үнэ:** Лондонгийн металлын бирж дэх цэвэр зэсийн үнэ 2021 онд дунджаар 9291 ам.доллар/тонн байсан нь өмнөх оноос даруй 50 хувиар нэмэгдсэн дүн юм.

**Зураг 1.14 Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн индекс (2011/1=1.0)**



Эх сурвалж: Блүмберг

Зэсийн үнэ ийнхүү өсөхөд 1) глобал эдийн засаг хурдацтай сэргэж зэсийн эрэлт огцом нэмэгдсэн, 2) голлох металлын биржүүд дээрх зэсийн нөөц түүхэн бага утгад хүрсэн, 3) зэсийн томоохон нийлүүлэгч болох Чилид ажил хаялт болсны зэрэгцээ Перугийн томоохон ордын тээвэрлэлт хийдэг гол замыг орон нутгийн иргэд хааснаас шалтгаалж нийлүүлэлт буурсантай холбоотой байна.

**Коксжих нүүрсний үнэ:** Хятадын Далианы биржийн коксжих нүүрсний үнэ 2021 онд дунджаар 221 ам.доллар/тоннд хүрч өмнөх оноос 69 хувиар нэмэгдэв.

Нүүрсний үнэ ийнхүү өсөхөд 1) БНХАУ-ын зүгээс Австралийн нүүрсний импортод тавих хориг үргэлжилсэн, цар тахлаас шалтгаалж Монголоос авах нүүрсний импорт 2021 оны турш саатсан, 2) БНХАУ-д эрчим хүчний хямрал болсноор эрчим хүчний нүүрсийг коксжих нүүрсээр орлуулж хэрэглэсэн, 3) БНХАУ-ын дотоодын нүүрсний уурхайнуудад 2021 оны турш хүрээлэн буй орчны хяналт өндөр байсан, 4) тэг КОВИД бодлогын нөлөөгөөр БНХАУ-ын зарим коксжих нүүрсний уурхайнууд түр зогссон зэрэг нөлөөллөө.

**Төмрийн хүдрийн үнэ:** Төмрийн хүдрийн үнэ 2021 онд 156 ам.доллар/тонн-д хүрч өмнөх оноос 50 хувиар өслөө. Үүнд 1) гангийн эрэлт, үнэ дэлхийн зах зээлд өндөр байснаар төмрийн хүдрийн эрэлт нэмэгдсэн, 2) БНХАУ 2021 оны сүүлээс төсөв, мөнгөний бодлогын төлөвөө зөөлрүүлсэн нь түүхий эдийн эрэлтийг дэмжиж төмрийн хүдрийн үнэ өндөр байхад голлох нөлөөлөв.

**Түүхий нефтийн үнэ:** Брент маркын газрын тосны үнэ 2021 онд дунджаар 70 ам.доллар/баррельд хүрсэн нь өмнөх оноос 64 хувиар өссөн үзүүлэлт боллоо. Нийлүүлэлт талаас, ОПЕК+ нэгдэл цар тахлаас шалтгаалж эрэлт тогтвортой сэргэхгүй байх эрсдэлээс болгоомжлон 2021 оны турш үйлдвэрлэлээ алгуур нэмэгдүүлсэн ч цар тахлын өмнөх түвшинд хүргэсэнгүй.

Эрэлт талаас, КОВИД-19 цар тахлын Омикрон хувилбар гарахад дэлхийн улс орнууд урьд өмнө авч байсантай адил хатуу арга хэмжээ аваагүй тул эрэлт өндөр түвшинд хадгалагдав.



Түүнчлэн, оны сүүлийн саруудад ОХУ-Украиний геополитикийн хурцадмал байдлаас шалтгаалж тодорхой бус байдал нэмэгдэн, газрын тосны үнэ ийнхүү нэмэгдлээ.

### Хүснэгт 1.3. Экспорт, голлох ангиллаар, сая ам.доллар

| Төрөл                  | 2015         | 2016         | 2017         | 2018         | 2019         | 2020         | 2021         | Өөрчлөлт (21'/20') |            |
|------------------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------------|------------|
|                        |              |              |              |              |              |              |              | Дүн                | %          |
| <b>Уул уурхай</b>      | <b>4,092</b> | <b>4,236</b> | <b>5,519</b> | <b>6,200</b> | <b>6,751</b> | <b>7,039</b> | <b>8,509</b> | <b>1,469</b>       | <b>21%</b> |
| Зэсийн хүдэр, баяжмал  | 2,280        | 1,608        | 1,613        | 2,012        | 1,796        | 1,778        | 2,900        | 1,122              | 63%        |
| Мян.тонн               | 1,478        | 1,562        | 1,447        | 1,437        | 1,404        | 1,395        | 1,283        | -113               | -8%        |
| Чулуун нүүрс           | 555          | 972          | 2,256        | 2,786        | 3,074        | 2,124        | 2,764        | 640                | 30%        |
| Мян.тонн               | 14,426       | 25,714       | 32,990       | 35,758       | 36,467       | 28,587       | 15,708       | -12,879            | -45%       |
| Төмрийн хүдэр, баяжмал | 227          | 250          | 310          | 342          | 576          | 640          | 952          | 313                | 49%        |
| Мян.тонн               | 5,065        | 6,085        | 6,258        | 7,449        | 8,449        | 8,202        | 7,106        | -1,096             | -13%       |
| Мөнгөжөөгүй алт        | 421          | 758          | 595          | 144          | 418          | 1,788        | 1,005        | -783               | -44%       |
| Кг                     | 11,343       | 19,169       | 14,548       | 3,432        | 9,069        | 30,491       | 17,250       | -13,241            | -43%       |
| Бусад                  | 609          | 648          | 744          | 914          | 886          | 710          | 888          | 178                | 25%        |
| <b>Уул уурхайн бус</b> | <b>578</b>   | <b>680</b>   | <b>680</b>   | <b>812</b>   | <b>869</b>   | <b>537</b>   | <b>738</b>   | <b>201</b>         | <b>37%</b> |
| <b>Нийт дүн</b>        | <b>4,669</b> | <b>4,916</b> | <b>6,199</b> | <b>7,012</b> | <b>7,620</b> | <b>7,576</b> | <b>9,247</b> | <b>1,671</b>       | <b>22%</b> |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

2021 онд экспорт 22%-иар буюу 1,671 сая ам.доллараар өсөхөд үнийн нөлөө голлон тайлбарлаж байна. Тодруулбал, 2021 онд экспорт үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 68%-иар өсч тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 46%-иар буурсан байна. Энэ нь дэлхийн зах зээл дээр түүхийн эдийн үнэ нэмэгдсэнтэй холбоотой экспортын тоо хэмжээ буурсан боловч экспорт өссөн байна.

**Импорт:** 2021 онд импорт өнгөрсөн оны үзүүлэлтээс 29%-иар буюу 1,550 сая ам.доллараар өсөхөд дараах хүчин зүйлс голлон нөлөөлөв. Үүнд:

- Хэрэглээний барааны импортын хувьд өнгөрсөн оны хэмжээнээс 642 сая ам.доллараар өссөн, үүнд: хүнс болон эм, тарианы импорт 402 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлсөн.
- Хөрөнгө оруулалтын шинж чанартай бүтээгдэхүүний импорт 21%-иар буюу 470 сая ам.доллараар өссөн. Тодруулбал, машин, механик тоног төхөөрөмж, эд ангийн импорт 25%-иар, барилгын материалын импорт 21%-иар тус тус өссөн.
- Харин нефтийн бүтээгдэхүүний импорт 315 сая ам.доллараар өссөн нь дэлхийн зах зээл дээрх нефтийн бүтээгдэхүүний үнэ өссөнөөс голлон шалтгаалсан байна.

### Хүснэгт 1.4. Импорт, голлох ангиллаар, сая ам.доллар

| Төрөл                                  | 2015         | 2016         | 2017         | 2018         | 2019         | 2020         | 2021         | Өөрчлөлт (21'/20') |            |
|----------------------------------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------------|------------|
|                                        |              |              |              |              |              |              |              | Дүн                | %          |
| <b>Хэрэглээний бүтээгдэхүүн</b>        | <b>1,101</b> | <b>1,159</b> | <b>1,285</b> | <b>1,643</b> | <b>1,631</b> | <b>1,542</b> | <b>2,184</b> | <b>642</b>         | <b>42%</b> |
| Түргэн эдэлгээтэй                      | 643          | 652          | 733          | 864          | 859          | 878          | 1,315        | 437                | 50%        |
| Удаан эдэлгээтэй                       | 459          | 507          | 553          | 779          | 772          | 664          | 869          | 205                | 31%        |
| <b>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн</b> | <b>1,447</b> | <b>1,155</b> | <b>1,702</b> | <b>2,396</b> | <b>2,661</b> | <b>2,290</b> | <b>2,760</b> | <b>470</b>         | <b>21%</b> |
| Машин, тоног төхөөрөмж, эд анги        | 757          | 687          | 1,077        | 1,512        | 1,801        | 1,419        | 1,771        | 352                | 25%        |
| Барилгын материал                      | 473          | 283          | 441          | 648          | 654          | 599          | 727          | 127                | 21%        |
| Хөрөнгө оруулалтын бусад бараа         | 218          | 185          | 183          | 236          | 206          | 272          | 262          | -10                | -4%        |


|                            |              |              |              |              |              |              |              |              |            |
|----------------------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|--------------|------------|
| Аж үйлдвэрлэлийн орц       | 512          | 508          | 552          | 717          | 665          | 634          | 762          | 127          | 20%        |
| Нефтийн бүтээгдэхүүн       | 708          | 531          | 791          | 1,112        | 1,166        | 817          | 1,132        | 315          | 39%        |
| Дизель түлш                | 377          | 255          | 428          | 577          | 669          | 432          | 590          | 158          | 36%        |
| Мян.тонн                   | 655          | 548          | 805          | 849          | 1,080        | 1,027        | 989          | -38          | -4%        |
| АИ-92, АИ-95               | 228          | 165          | 244          | 251          | 289          | 222          | 353          | 131          | 59%        |
| Мян.тонн                   | 361          | 332          | 354          | 352          | 476          | 529          | 514          | -15          | -3%        |
| А-80                       | 46           | 26           | 33           | 45           | 38           | 23           | 38           | 15           | 65%        |
| Мян.тонн                   | 73           | 53           | 57           | 65           | 65           | 57           | 59           | 2            | 3%         |
| Бусад нефтийн бүтээгдэхүүн | 57           | 85           | 87           | 240          | 169          | 140          | 151          | 11           | 8%         |
| Мян.тонн                   | 58           | 124          | 153          | 292          | 223          | 250          | 202          | -47          | -19%       |
| Бусад                      | 29           | 6            | 7            | 7            | 5            | 15           | 11           | -4           | -27%       |
| <b>Нийт дүн</b>            | <b>3,798</b> | <b>3,358</b> | <b>4,337</b> | <b>5,875</b> | <b>6,128</b> | <b>5,299</b> | <b>6,849</b> | <b>1,550</b> | <b>29%</b> |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк


### Үйлчилгээний гадаад худалдаа

Үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 2021 онд өмнөх оноос 5%-иар буурч 1,380 сая ам.долларт хүрсэн. Үйлчилгээний дансны алдагдал ийнхүү буурахад тээврийн үйлчилгээний алдагдал 111%-иар буурч 24 сая ам.долларын ашигтай, барилга, барилгын ажил үйлчилгээний алдагдал 30%-иар буурч 68 сая ам.долларт тус тус хүрсэн нь голлон нөлөөлжээ.

Зураг 1.15. Үйлчилгээний экспорт



Зураг 1.16. Үйлчилгээний импорт



Эх сурвалж: Монголбанк

**Хүснэгт 1.5. Үйлчилгээний гадаад худалдаа, сая ам.доллар**

| Үйлчилгээний гадаад худалдааны дансны нэр төрөл  | 2015        | 2016          | 2017          | 2018          | 2019          | 2020          | 2021          | Өөрчлөлт (21'/20') |            |
|--------------------------------------------------|-------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|--------------------|------------|
|                                                  |             |               |               |               |               |               |               | Дүн                | %          |
| Тээвэр                                           | -106        | -176          | -284          | -561          | -594          | -212          | 24            | 236                | -111%      |
| Аялал жуулчлал                                   | -176        | -166          | -137          | -415          | -412          | -521          | -545          | -24                | 5%         |
| Барилга, барилгын ажил үйлчилгээ                 | -81         | -137          | -218          | -165          | -107          | -97           | -68           | 29                 | -30%       |
| Даатгал болон тэтгэврийн үйлчилгээ               | -24         | -15           | -20           | -21           | -23           | -21           | -24           | -2                 | 12%        |
| Санхүүгийн үйлчилгээ                             | -52         | -205          | -24           | -121          | -207          | -145          | -148          | -3                 | 2%         |
| Оюуны өмч ашиглах эрхийн төлбөр                  | -13         | -23           | -15           | -15           | -25           | -23           | -30           | -7                 | 30%        |
| Харилцаа холбоо, компьютер, мэдээллийн үйлчилгээ | -72         | -69           | -48           | -64           | -55           | -70           | -99           | -29                | 41%        |
| Бизнесийн бусад үйлчилгээ                        | -174        | -529          | -435          | -590          | -546          | -343          | -486          | -143               | 42%        |
| Бусад үйлчилгээ                                  | -18         | -18           | -35           | -27           | -23           | -18           | -4            | 14                 | -79%       |
| <b>Нийт үйлчилгээ</b>                            | <b>-715</b> | <b>-1,338</b> | <b>-1,216</b> | <b>-1,978</b> | <b>-1,992</b> | <b>-1,450</b> | <b>-1,380</b> | <b>70</b>          | <b>-5%</b> |

Эх сурвалж: Монголбанк

**Гадаад хөрөнгө оруулалтын позиц**

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр -39,017 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 5%-иар буюу 1,699 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Монгол Улсаас гадагш хийсэн нийт хөрөнгө оруулалтын дүн буюу гадаад актив 8,238 сая ам.доллар, үүний 53%-ийг гадаад валютын улсын нөөц, 32%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 10%-ийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 5%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.

Монгол Улсад оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн буюу пассив 47,255 сая ам.доллар, үүний 55%-ийг шууд хөрөнгө оруулалтын пассив, 35%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 10%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 53% буюу 13,953 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, 47% буюу 12,273 сая ам.долларыг охин компанийн толгой компаниасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг, санхүүжилт эзэлж байна.

**Хүснэгт 1.6. Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын позиц, сая ам.доллар**

| А. ГАДААД АКТИВ                       |  | 8,238 | Б. ГАДААД ПАССИВ                     |  | 47,255         |
|---------------------------------------|--|-------|--------------------------------------|--|----------------|
| 1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу) |  | 824   | 1. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас) |  | 26,226         |
| 2. Багцын хөрөнгө оруулалт            |  | 417   | 2. Багцын хөрөнгө оруулалт           |  | 4,539          |
| 3. Санхүүгийн дериватив               |  | 11    | 3. Санхүүгийн дериватив              |  | 0              |
| 4. Бусад хөрөнгө оруулалт             |  | 2,619 | 4. Бусад хөрөнгө оруулалт            |  | 16,489         |
| 5. Нөөц актив                         |  | 4,366 |                                      |  |                |
|                                       |  |       | <b>В. ПОЗИЦ</b>                      |  | <b>-39,017</b> |

Эх сурвалж: Монголбанк

Гадаад хөрөнгө оруулалтын богино позицийн жилийн өсөлтийг данс тус бүрээр тайлбарлавал:

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 1,892 сая ам.доллараар өсч, багцын хөрөнгө оруулалтын богино позиц 179 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 167 сая ам.доллараар, гадаад валютын улсын нөөц 160 сая ам.доллараар тус тус буурсан дүнтэй байна.

**Хүснэгт 1.7. Гадаад хөрөнгө оруулалтын позицын өөрчлөлт, сая ам.доллар**

| Үзүүлэлтүүд                            | 2015           | 2016           | 2017           | 2018           | 2019           | 2020           | 2021           | Өөрчлөлт<br>(21'/20') |           |
|----------------------------------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|-----------------------|-----------|
|                                        |                |                |                |                |                |                |                | Дүн                   | %         |
| Гадаадын шууд хөрөнгө оруулалтын позиц | -20,257        | -15,822        | -17,525        | -19,690        | -21,891        | -23,510        | -25,402        | -1,892                | 8%        |
| Багцын хөрөнгө оруулалтын позиц        | -2,844         | -3,351         | -4,668         | -4,589         | -5,146         | -4,301         | -4,122         | 179                   | -4%       |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслийн позиц     | -51            | -15            | 0              | -1             | 9              | 4              | 11             | 8                     | 214%      |
| Бусад хөрөнгө оруулалтын позиц         | -6,800         | -11,458        | -12,846        | -12,891        | -13,144        | -14,037        | -13,870        | 167                   | -1%       |
| Гадаад валютын улсын нөөц              | 1,323          | 1,296          | 3,008          | 3,542          | 4,341          | 4,526          | 4,366          | -160                  | -4%       |
| <b>Нийт позиц</b>                      | <b>-28,629</b> | <b>-29,350</b> | <b>-32,031</b> | <b>-33,630</b> | <b>-35,831</b> | <b>-37,318</b> | <b>-39,017</b> | <b>1,699</b>          | <b>5%</b> |

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

**Гадаад өр**

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2021 оны эцэст 33,190 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 3%-иар буюу 829 сая ам.доллараар өсөв. Үүнд: Монгол Улсын Засгийн газрын гадаад улсаас авсан хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, өрийн бичгийн үлдэгдэл 2%-иар буюу 171 сая ам.доллараар буурсан. Төв банкны гадаад өр ОУВС-гаас олгосон ЗТЭ-ийн хуваарилалт, алтны санхүүжилт зэргээс шалтгаалан 15%-иар буюу 341 сая ам.доллараар өссөн.

Хувийн салбарын гадаад өрийн үлдэгдэл нь компани хоорондын зээлийн өсөлтөөр голлон тайлбарлаж байна. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн толгой компаниасаа авсан зээлийн санхүүжилт өнгөрсөн онтой харьцуулахад 8%-иар буюу 867 сая ам.доллараар өссөн. Харин бусад секторын гадаад өр 2% буюу 208 сая ам.доллараар буурсан байна.

**Хүснэгт 1.8. Монгол Улсын нийт гадаад өр, сая ам.доллар**

| Үзүүлэлт                                         | 2015          | 2016          | 2017          | 2018          | 2019          | 2020          | 2021          | Өөрчлөлт<br>(21'/20') |           |
|--------------------------------------------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|-----------------------|-----------|
|                                                  |               |               |               |               |               |               |               | Дүн                   | %         |
| <b>НИЙТ ГАДААД ӨР</b>                            | <b>22,718</b> | <b>24,625</b> | <b>27,413</b> | <b>28,715</b> | <b>30,702</b> | <b>32,362</b> | <b>33,190</b> | <b>829</b>            | <b>3%</b> |
| Засгийн газар                                    | 3,760         | 4,869         | 7,317         | 7,184         | 7,806         | 8,654         | 8,483         | -171                  | -2%       |
| Засгийн газрын гадаад өр/<br>ДНБ (%)             | 31%           | 41%           | 66%           | 59%           | 57%           | 66%           | 56%           | -0.1                  | -15%      |
| Төв банк                                         | 1,960         | 1,791         | 2,025         | 2,030         | 1,985         | 2,221         | 2,562         | 341                   | 15%       |
| Хадгаламжийн байгууллага<br>(Төв банкнаас бусад) | 2,129         | 2,417         | 2,309         | 2,230         | 2,138         | 1,651         | 1,651         | 0.4                   | 0.02%     |
| Богино хугацаат                                  | 407           | 469           | 411           | 764           | 610           | 594           | 408           | -185                  | -31%      |
| Урт хугацаат                                     | 1,721         | 1,948         | 1,898         | 1,466         | 1,528         | 1,057         | 1,243         | 186                   | 18%       |
| Бусад сектор                                     | 3,749         | 8,121         | 8,189         | 8,042         | 8,407         | 8,430         | 8,222         | -208                  | -2%       |
| Богино хугацаат                                  | 326           | 394           | 599           | 609           | 562           | 683           | 400           | -284                  | -42%      |
| Урт хугацаат                                     | 3,423         | 7,727         | 7,591         | 7,433         | 7,845         | 7,747         | 7,822         | 75                    | 1%        |
| Хөрөнгө оруулагчаас авсан зээл                   | 11,121        | 7,426         | 7,572         | 9,228         | 10,366        | 11,406        | 12,273        | 867                   | 8%        |

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

Засгийн газрын гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2013-2016 онуудад 29%-41% хооронд, харин 2017 онд 66% болж өсч, 2018 болон 2019 онд харгалзан 59%, 57% хүрч буурсан бол 2020 онд 66%-д хүрч эргэн өссөн.


Тэгвэл 2021 онд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, Засгийн газрын гадаад өрийн бууралтаас шалтгаалан 56%-д хүрч буурсан үзүүлэлттэй байна (олон улсын аргачлалын дагуу Хөгжлийн банкны гадаад өрийг бусад сектор хэсэгт ангилсан).

### 1.3 МӨНГӨ, САНХҮҮГИЙН СЕКТОР

#### Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд

Мөнгөний нийлүүлэлт (M2<sup>5</sup> мөнгө) 2020 онд 16.2 хувийн өсөлттэй байсан бол 2021 оны эхний хагаст дунджаар 25.4 хувиар өсчээ. Тухайлбал, 2021 оны 4 дүгээр сард хамгийн их буюу 32.1 хувиар өссөн бөгөөд үүнээс хойш өсөлтийн хурд саарч оны эцсийн байдлаар 13.8 хувьд хүрч, мөнгөний нийлүүлэлт 27.9 их наяд төгрөг болов. M2 мөнгөний өсөлтийг эх үүсвэр талаас нь авч үзвэл төгрөгийн харилцахын өсөлт 9.0 нэгж хувийг, төгрөгийн хадгаламжийн өсөлт 6.1 нэгж хувийг, гадаад валютын харилцах 1.4 нэгж хувийг, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.4 нэгж хувийг, гадаад валютын хадгаламж -3.0 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна. Мөн хөрвөх чадвартай мөнгө болох M1<sup>6</sup> мөнгө 2021 онд мөнгөний нийлүүлэлт өсөхөд 9.4 нэгж хувиар нөлөөлсөн бөгөөд төгрөгийн харилцах 2,200.8 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 94.0 тэрбум төгрөгөөр өссөн нь M2 мөнгөний өсөлтийг голлон тайлбарлаж байна. Харин бусад хадгаламжийн өсөлт 2021 онд мөнгөний нийлүүлэлт өсөхөд 4.4 нэгж хувиар нөлөөлсөн бөгөөд төгрөгийн хадгаламж 1,483.9 тэрбум төгрөгөөр, гадаад валютын харилцах 347.5 тэрбум төгрөгөөр тус тус өсч, гадаад валютын хадгаламж 743.5 тэрбум төгрөгөөр буурчээ.

Зураг 1.17 Мөнгөний нийлүүлэлт, эх үүсвэр талаас



Эх сурвалж: Монголбанк


Мөнгөний нийлүүлэлтийн жилийн 13.8 хувийн өсөлтийг байршуулалт талаас нь задалбал аж ахуйн нэгжээс авах авлага 17.6 нэгж хувийг, Засгийн газрын цэвэр зээл 4.4 нэгж хувийг, гадаад цэвэр актив -8.2 нэгж хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл гадаад цэвэр актив мөнгөний нийлүүлэлтэд эзлэх хувь буурч, дотоод цэвэр активд түлхүү байршуулах болсон байна. Тодруулбал аж ахуйн нэгжээс авах авлагын

<sup>5</sup> Мөнгөний нийлүүлэлт (M2) нь M1 мөнгө болон иргэд, байгууллагын хадгаламж, гадаад валютын харилцахаас бүрдэнэ.

<sup>6</sup> M1 мөнгө нь иргэд, байгууллагын төгрөгийн харилцах болон хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгөнөөс бүрдэнэ.

өсөлт нь хадгаламжийн байгууллагууд<sup>7</sup>-ын зээл олголт өссөнтэй холбоотой бол Засгийн газрын цэвэр зээлийн өсөлтөд нийгмийн даатгалын сангийн хадгаламжийн бууралт голлон нөлөөлжээ.

**Зураг 1.18. Мөнгөний нийлүүлэлт, байршуулалт талаас**




Эх сурвалж: Монголбанк

Банкуудын олгосон зээл 2020 онд 5.0 хувийн бууралттай байсан бол 2021 оны I улирлын эцсээс эхлэн өсөв. Улмаар 2021 оны эцсийн байдлаар 21.3 хувиар өсч, 20.7 их наяд төгрөгт хүрэв. Хэрэглээний зээл<sup>8</sup> ба хадгаламж барьцаалсан зээл 2021 оны эхний хагаст бууралттай байсан бол оны эцэст 3.6 хувийн өсөлттэй байв. Тухайн онд уул уурхай, үл хөдлөх, худалдааны салбарын зээл өмнөх онтой харьцуулахад байнгын өсөлттэй байсан бөгөөд оны эцсийн байдлаар худалдааны салбар 8.1 хувь, үл хөдлөх 3.9 хувь, боловсруулах үйлдвэрлэл 1.6 хувь, уул уурхай 0.5 хувийн өсөлттэй байлаа.

<sup>7</sup> Монгол Улсын хувьд хадгаламжийн байгууллагад банкууд болон хадгаламж, зээлийн хоршоод оруулдаг.

<sup>8</sup> Хэрэглээний зээл=Цалин+Тэтгэвэр+Картын зээл+Малчны зээл+бусад хэрэглээний зээл

Зураг 1.19. Банкуудын олгосон зээлийн үлдэгдэл, салбарын ангиллаар




Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн үлдэгдлийн бүтцийг авч үзвэл хэрэглээний ба хадгаламж барьцаалсан зээл 2021 онд өмнөх оноос 1.9 нэгж хувиар өсч нийт зээлийн 25.7%-ийг, худалдааны салбарын зээл 3.8 нэгж хувиар буурч нийт зээлийн 19.9%-ийг, үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл 0.9 нэгж хувиар буурч нийт зээлийн 14.3%-ийг тус тус эзэлж байна

### Санхүүгийн салбар


Монгол Улсын санхүүгийн салбарт 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 11 банк, 534 банк бус санхүүгийн байгууллага, 209 хадгаламж зээлийн хоршоо, 17 даатгалын компани, 57 даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч 25 компани үйл ажиллагаа явуулж байна. Банкнаас бусад санхүүгийн салбарын үйл ажиллагааны цар хүрээ жилээс жилд нэмэгдэж буй боловч нийт санхүүгийн зах зээлийн 90 гаруй хувийг банкны салбар дангаараа бүрдүүлсэн хэвээр байгаа юм.

Зураг 1.20. Санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбарын ДНБ-нд эзлэх хувь хэмжээ



Эх сурвалж: УСХ, СЗХ

Зураг 1.21. Санхүүгийн дэд салбаруудын нийт салбарт эзлэх хувь хэмжээ /2021 он, активын хэмжээгээр/



Эх сурвалж: СЗХ

Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын нийт актив 2021 оны эцэст өмнөх оны мөн үеэс 35.0 хувиар өсч 2.7 их наяд төгрөгт хүрчээ. Түүнчлэн ББСБ-ын зээлийн багц өмнөх оны мөн үеэс 51.6 хувиар буюу 685.1 тэрбум төгрөгөөр өссөн нь нийт активын өсөлтийн 34.1 хувийг тайлбарлаж байна. ББСБ-ын зээлийн өрийн үлдэгдлийн 90.5 хувь нь хэвийн, 2.5 хувь нь хугацаа хэтэрсэн, 7.0 хувь нь чанаргүй зээл байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.3 нэгж хувиар, хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь хэмжээ 2.4 нэгж хувиар түс түс буурсан дүнтэй байна.

2021 оны эцсийн байдлаар Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-дын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.8 хувиар өсч 291.2 тэрбум төгрөгт, ХЗХ-дын нийт зээлийн үлдэгдэл 27.4 хувиар өсч 213.4 тэрбум төгрөгт тус тус хүрчээ. ХЗХ-дын нийт зээлийн багцын 3.5 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байна.

Даатгалын салбарт 2021 оны эцэст ердийн даатгалын 15, урт хугацаат даатгалын 1, давхар даатгалын 1 компани нийт 17 даатгагч үйл ажиллагаа явуулж байна. Даатгалын компаниудын нийт активын хэмжээ 425.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар өссөн байна. Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүр болох даатгалын гүнзгийрэлт (даатгалын хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээ)-ийн түвшин олон улстай харьцуулахад доогуур хэвээр байна. 2021 онд даатгалын гүнзгийрэлт 0.58 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.03 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм. Даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 247.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний дийлэнх хэсгийг ердийн даатгалын компаниуд бүрдүүлжээ. Даатгалын компаниуд нийт хураамжийн орлогын 28.3 хувьтай тэнцүү хэмжээний буюу 69.9 тэрбум төгрөгийг даатгалын нөхөн төлбөрт олгосон байна. 2020 оны эцсийн байдлаарх ашигт ажиллагааны үзүүлэлтүүдтэй харьцуулахад активын өгөөж 0.4 нэгж хувиар, өөрийн хөрөнгийн өгөөж 1.0 нэгж хувиар түс түс өсжээ.

2021 онд нийт 1.4 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасны арилжаа хийгдсэний 74.1 хувийг компанийн бондын арилжаа, 21.6 хувийг хувьцааны арилжаа, 4.0 хувийг хөрөнгө оруулалтын сангийн арилжаа тус тус эзэлжээ. Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 6.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.9 их наяд төгрөгөөр буюу 97.5 хувиар өссөн байна.

**Хүснэгт 1.9. Банкнаас бусад санхүүгийн салбарын голлох үзүүлэлтүүд /2021 он, тэрбум төгрөг/**


| Үзүүлэлтүүд                 | ББСБ    | ХЗХ   | Даатгал |
|-----------------------------|---------|-------|---------|
| Актив                       | 2,709.9 | 291.1 | 425.4   |
| Өр төлбөр                   | 910.8   | 227.3 | 225.9   |
| Эзэмшигчдийн өмч            | 1,589.1 | 63.9  | 199.5   |
| Зээлийн өрийн үлдэгдэл      | 2,012.2 | 213.4 | -       |
| Чанаргүй зээл               | 140.2   | 7.4   | -       |
| Тайлант үеийн ашиг          | 210.0   | 10.7  | 25.2    |
| Даатгалын хураамжийн орлого | -       | -     | 247.5   |
| Даатгалын нөхөн төлбөр      | -       | -     | 69.9    |

Эх сурвалж: СЗХ

## Банкны салбар

Банкны салбар тайлант оны эцсийн байдлаар нийт 11 банк, 15,958 ажилтан, 1,393 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт хадгаламжийн дансны тоо 3.0 сая, нийт зээлдэгчдийн тоо 946.4 мянгад хүрлээ.

**Зураг 1.22. Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ.**




Эх сурвалж: СЗХ, УСХ




Банкны системийн нийт актив 2021 онд өмнөх оноос 4.5 их наяд төгрөгийн буюу 12.5 хувийн өсөлт үзүүлж, 40.8 их наяд төгрөгт хүрлээ. Энэ нь активын жилийн өсөлт нь -0.3 хувь байсан өмнөх оны мөн үеэс 12.8 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна. Активын жилийн өсөлтийн дийлэнх хэсгийг зээлийн өсөлт бүрдүүлж байна.

Банкны салбарын зээлийн үлдэгдэл тайлант оны эцэст 20.9 их наяд төгрөгт хүрч, зээлийн цэвэр үлдэгдэл нийт активын 47.2 хувийг бүрдүүлж байна. Банкны системийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 22.0 хувиар буюу 3.8 их наяд төгрөгөөр өссөн бөгөөд Эдийн засгийг идэвхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд олгосон ажлын байрыг дэмжих зээл, репо санхүүжилтийн эх үүсвэртэй зээл, ипотекийн зээлийн өсөлт голчлон тайлбарлаж байна.

Зураг 1.23. Зээлийн динамик, өсөлт (их наяд төгрөг, хувь)



Зураг 1.24. Зээлдэгчийн бүтэц, зээлдэгчээр (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Монголбанк

Тайлант жилд эдийн засгийн бүх салбарын зээл өсөлт үзүүлсэн бөгөөд худалдааны салбар, хэрэглээний салбарын зээлийн өсөлт нийт зээлийн өсөлтийн 62.4 хувийг тайлбарлаж байна.


Тайлант оны эцэст банкны системийн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн харьцаа 9.1 хувь, анхаарал хандуулах зээлийн харьцаа 6.6 хувьтай байна. Чанаргүй зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.9 хувиар буюу 70.8 тэрбум төгрөгөөр өссөн байна. Байгууллагын чанаргүй зээл 5.8 хувиар буюу 77.1 тэрбум төгрөгөөр өссөн бол иргэдийн чанаргүй зээл 1.3 хувиар буюу 6.3 тэрбум төгрөгөөр буурсан.

Зураг 1.25. Чанаргүй зээлийн хувь, зээлдэгчээр



Эх сурвалж: Монголбанк

Зураг 1.26. Иргэдийн чанаргүй зээлийн хувь



Зээл олгосон голлох салбаруудаас уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарын чанаргүй зээлийн хувь харгалзан 23.3, 17.8, 17.1 хувь байгаа нь банкны системийн дунджаас өндөр байгаа бол худалдааны салбарын зээлийн чанаргүй зээлийн хувь хамгийн бага буюу 2.9 хувьтай байна.

Банкны салбарын татан төвлөрүүлсэн нийт эх үүсвэр 2021 оны эцэст 36.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 12.4 хувиар буюу 4.1 их наяд төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Эх үүсвэрийн жилийн өсөлтийн дийлэнх хэсгийг харилцах дансны үлдэгдлийн өсөлт бүрдүүлж байна.

Зураг 1.27. Эх үүсвэр (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Монголбанк

Харилцах дансны үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 46.0 хувиар буюу 2.6 их наяд төгрөгөөр өссөн бол хадгаламж 0.8 хувиар буюу 147.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нийт эх үүсвэрийг бүтцийн хувьд авч үзвэл харилцах, хадгаламжийн дансны үлдэгдлийн нийт эх үүсвэрт эзлэх хувь 74 хувь байгаа бөгөөд өмнөх оноос 2 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Харилцах, хадгаламжийн дансны өсөлтөд бүх нийтийн хөл хорио тогтоосноор иргэдийн хүнсний хэрэглээнээс бусад хэрэглээний зардал түр хугацаанд хойшилсон, төрөөс цахилгаан, дулаан ашиглалтын зардлыг хөнгөлсөн зэрэг нөлөөлсөн байж болзошгүй. Түүнчлэн ипотекийн зээлийн болон хүүгийн төлбөрийг хойшлуулсан нь иргэдийн зээлийн өр төлбөрөө төлөхөөр төлөвлөсөн байсан мөнгөн хөрөнгө харилцах, хадгаламжийн дансанд хуримтлагдсан нөлөөлөл байж болзошгүй.

Зураг 1.29. Банкны цэвэр ашиг




Эх сурвалж: Монголбанк

Зураг 1.28. Өөрийн хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөг)



Зураг 1.30. Банкны салбарын орлого, зардлын бүтэц



Банкны салбарын нийт орлого 4.7 их наяд төгрөгт хүрсний 69.1 хувийг хүүгийн орлого, 29.0 хувийг хүүгийн бус орлого бүрдүүлж байна. Хүүгийн орлогын 71.3 хувийг зээлийн хүүгийн орлого, 23.6 хувийг үнэт цаасны хүүгийн орлого, үлдэх 5.1 хувийг харилцах, хадгаламжид төлөгдсөн хүүгийн орлого бүрдүүлж байна. Харин нийт зардал тайлант онд 4.3 их наяд төгрөгт хүрсний 41.3 хувийг хүүгийн, 54.5 хувийг хүүгийн бус зардал бүрдүүлж байна. Хүүгийн зардлын 73.8 хувийг харилцах, хадгаламжийн хүүгийн зардал, 18.2 хувийг зээл, үнэт цаасны хүүгийн зардал, 8.0 хувийг бусад хүүгийн зардал бүрдүүлж байна.

2020 онд банкны салбар 38.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол тайлант жилд банкны салбарын ашиг 371.6 тэрбум төгрөг, активын өгөөж 1.0 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 9.6 хувьд хүрлээ.

Банкны салбарын 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 14.5 хувь, нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 14.5 хувь, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 41.6 хувь байна.


Тайлант онд Коронавируст халдвар (Ковид-19)-ын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр, нийт актив, ашигт ажиллагаа нэмэгдэж, улмаар банкны зохистой харьцааны үзүүлэлтүүд сайжирч санхүүгийн салбар тогтворжлоо.

### Банкны систем дэх цар тахлын нөлөө

Монголбанкнаас банк, санхүүгийн салбарт Ковид-19 цар тахлын үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад шаардлагатай арга хэмжээ болон банкны салбарт үзүүлэх хөнгөлөлтүүдийг дэлхийн улс орнуудын туршлага, банкны болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн авч хэрэгжүүлж ирсэн.


Энэхүү арга хэмжээний хүрээнд 2021.12.31-ний өдрийн байдлаар банкуудын нийт 175,604 зээлдэгчийн 5.13 их наяд төгрөгийн зээл Ковид-19-т өртсөн байгаагаас 77% буюу 139,519 зээлдэгчийн нийт 3.94 их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийжээ. Ковид-19-т өртсөн болон бүтэц өөрчилсөн зээлийн дүн 2020 онд эрчимтэй нэмэгдэж байсан бол 2021 оны эхнээс харьцангуй тогтворжих хандлагатай боллоо.

Зураг 1.31. Ковид-19-т өртсөн зээл болон бүтэц өөрчилсөн зээл (тэрбум төгрөг, зээлдэгчийн тоо)



Эх сурвалж: Монголбанк

Зураг 1.32. Ковид-19-т өртсөн зээлийн чанар (тэрбум төгрөг, хувь)



Монголбанкны Банкны хяналт шалгалтын хорооны 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хурлаас гарсан зөвлөмжийн дагуу банкуудад “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д түр хугацаагаар мөрдүүлж буй хөнгөлөлттэй зохицуулалтыг 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл урьдчилан тогтоосон хуваарийн дагуу хэсэгчлэн сунгахаар шийдвэрлэсэн.

Ингэснээр зээлдэгчдийн зээлийн эргэн төлөх нөхцөлийг дахин өөрчлөх, эргэн төлөлтийн доголдолтой зээлийн ангилал, зээлийн түүхийг түр хугацаанд бууруулахгүй, дордуулахгүй байх эсэхийг бие даан шийдвэрлэх боломжийг банкуудад нээлттэй үлдээлээ. Зээлийн чанарын ангиллыг бууруулах хугацаа

хэтэрсэн хоногийг /90 хоног болгосон байгааг/ 2021 оны 8 дугаар сараас 75 хоног, 2021 оны 10 дугаар сараас 60 хоног, 2021 оны 12 дугаар сараас 45 хоног, 2022 оны 02 дугаар сараас 30 хоног, 2022 оны 4 дүгээр сараас 15 хоног болгож, хэвийн горимд аажмаар шилжүүлэхээр зохицууллаа.

Түүнчлэн банкуудад түр хугацаанд мөрдүүлж байсан төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа болон экспортын аккредитивт хамаарах хөнгөлөлттэй зохицуулалтыг тус тус хэвийн горимд шилжүүллээ.

Банкуудад хяналт шалгалтын хүрээнд мөрдүүлж буй дээрх журам, зааварт түр хугацааны хөнгөлөлттэй зохицуулалтуудыг хэсэгчилсэн байдлаар үргэлжлүүлэх нь банкны салбарын тогтвортой байдлыг хадгалах, системийн эрсдэлийг бууруулах, төлбөрийн чадварыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ. Ингэснээр Ковид-19 цар тахалд өртсөн 213,701 зээлдэгчийн 6.75 их наяд төгрөг, үүнээс бүтэц өөрчлөгдсөн 107,558 зээлдэгчийн 4.73 их наяд төгрөгийн зээл төлөгдсөн байна.

#### Хүснэгт 1.10. Ковид-19-т өртсөн зээл төлбөр хариуцагчаар (тэрбум төгрөг)

| № | Зээлийн төрлөөр  | Нийт зээл*    | Ковид19-т өртсөн | Нийт зээлд эзлэх % | Бүтэц өөрчилсөн дүн | БӨ** зээл/ Ковид өртсөн | Ажлын байр дэмжих зээл | Өртсөн зээлд эзлэх % | Репо санхүүжилтийн зээл | Өртсөн зээлд эзлэх % |
|---|------------------|---------------|------------------|--------------------|---------------------|-------------------------|------------------------|----------------------|-------------------------|----------------------|
|   | <b>Нийт зээл</b> | <b>20,240</b> | <b>5,138</b>     | <b>25%</b>         | <b>3,945</b>        | <b>77%</b>              | <b>1,795</b>           | <b>35%</b>           | <b>633</b>              | <b>12%</b>           |
| 1 | ААН-ийн зээл     | 10,207        | 2,672            | 26%                | 1,901               | 71%                     | 1214                   | 45%                  | 479                     | 18%                  |
| 2 | Иргэдийн зээл    | 7,768         | 1,608            | 21%                | 1,318               | 82%                     | 580                    | 36%                  | 154                     | 10%                  |
| 3 | Ипотекийн зээл   | 2,265         | 859              | 38%                | 726                 | 85%                     | -                      | -                    | -                       | -                    |
| 4 | Ипотек МИК       | 2986          | 2487             | 83%                | 2381                | 96%                     | -                      | -                    | -                       | -                    |

Эх сурвалж: Фина тайлан, банкуудаас ирүүлсэн зээлийн дэлгэрэнгүй жагсаалтаас (2021.12.31)

Тайлбар: \*\* - Бүтэц өөрчилсөн зээл (2021.12.31)

Системийн нийт зээлийн 25 хувь нь Ковид-19 цар тахлын нөлөөнд автсан бөгөөд үүний 77 хувьд бүтцийн өөрчлөлт хийжээ. Ковид-19-т өртсөн зээлийн 35 хувь нь ажлын байр нэмэгдүүлэх хөнгөлөлттэй зээл, 12 хувь нь репо санхүүжилттэй зээл эзэлж байна.

#### Хүснэгт 1.11. Ковид-19-т өртсөн зээл эдийн засгийн салбараар (тэрбум төгрөг)

| № | Зээлийн төрлөөр         | Нийт зээл*    | Ковид19-т өртсөн | Өртсөн зээлд эзлэх % | Бүтэц өөрчилсөн дүн | БӨ** зээл/ Ковид өртсөн | Ажлын байр дэмжих зээл | Өртсөн зээлд эзлэх % | Репо санхүүжилтийн зээл | Өртсөн зээлд эзлэх % |
|---|-------------------------|---------------|------------------|----------------------|---------------------|-------------------------|------------------------|----------------------|-------------------------|----------------------|
|   | <b>Нийт зээл</b>        | <b>20,240</b> | <b>5,138</b>     | <b>25%</b>           | <b>3,945</b>        | <b>77%</b>              | <b>1,795</b>           | <b>35%</b>           | <b>633</b>              | <b>12%</b>           |
| 1 | Уул уурхай              | 2,196         | 526              | 24%                  | 405                 | 77%                     | 15                     | 2.86%                | 5                       | 0.91%                |
| 2 | Боловсруулах үйлдвэрлэл | 1,465         | 332              | 23%                  | 187                 | 56%                     | 162                    | 49%                  | 89                      | 27%                  |
| 3 | Худалдаа                | 3,967         | 705              | 18%                  | 500                 | 71%                     | 1013                   | 144%                 | 236                     | 34%                  |
| 4 | Барилга                 | 1,680         | 462              | 27%                  | 328                 | 71%                     | 149                    | 32%                  | 40                      | 9%                   |
| 5 | Үл хөдлөх хөрөнгө       | 2,897         | 1001             | 35%                  | 812                 | 81%                     | 7                      | 0.72%                | 15                      | 1.47%                |
| 6 | Бусад                   | 8,035         | 2112             | 26%                  | 1,712               | 81%                     | 448                    | 21%                  | 248                     | 12%                  |

Эх сурвалж: Фина тайлан, банкуудаас ирүүлсэн зээлийн дэлгэрэнгүй жагсаалтаас (2021.12.31)

Тайлбар: \*\* - Бүтэц өөрчилсөн зээл (2021.12.31)

Системийн хэмжээнд уул уурхайн салбарын зээлийн 24 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн зээлийн 23 хувь, худалдааны салбарын 18 хувь, барилгын салбарын 27 хувь, үл хөдлөх хөрөнгийн зээлийн 35 хувь, иргэдийн зээлийн 26 хувь нь тус тус Ковид19-т өртсөн байна.

**Хүснэгт 1.12 Ковид-19-т өртсөн зээл анхаарал хандуулах шаардлагатай эдийн засгийн салбар (тэрбум төгрөг)**

| № | Зээлийн төрлөөр             | Нийт зээл* | Ковид19-т өртсөн | Өртсөн зээлд эзлэх % | Бүтэц өөрчилсөн дүн | БӨ** зээл/Ковид өртсөн зээл | Ажлын байр дэмжих зээл | Өртсөн зээлд эзлэх % | Рено санхүүжилт нийт зээл | Өртсөн зээлд эзлэх % |
|---|-----------------------------|------------|------------------|----------------------|---------------------|-----------------------------|------------------------|----------------------|---------------------------|----------------------|
| 1 | Боловсруулах үйлдвэрлэл     | 1,465      | 332              | 23%                  | 187                 | 56%                         | 162                    | 49%                  | 89                        | 27%                  |
| 2 | Цахилгаан, хий,             | 75         | 17               | 22%                  | 12                  | 70%                         | 15                     | 90%                  | 4                         | 21%                  |
| 3 | Усан хангамж, хаягдал мнжмт | 25         | 3                | 12%                  | 2                   | 55%                         | 5                      | 148%                 | 2                         | 71%                  |
| 4 | Барилга                     | 1,680      | 462              | 27%                  | 328                 | 71%                         | 149                    | 32%                  | 40                        | 9%                   |
| 5 | Тээвэр ба агуулах           | 627        | 180              | 29%                  | 145                 | 81%                         | 30                     | 17%                  | 31                        | 17%                  |
| 6 | Төрийн үйл ажиллагаа        | 1          | 0                | 24%                  | 0                   | 75%                         | 0                      | 99%                  | 0                         | 0%                   |
| 7 | Бусад                       | 5,178      | 1224             | 24%                  | 980                 | 80%                         | 213                    | 17%                  | 95                        | 8%                   |

Эх сурвалж: Фина тайлан, банкуудаас ирүүлсэн зээлийн дэлгэрэнгүй жагсаалтаас (2021.12.31)

Тайлбар: \*\* - Бүтэц өөрчилсөн зээл (2021.12.31)

Ковид 19-т өртсөн болон бүтэц өөрчилсөн зээлийн өрийн үлдэгдлийн эргэн төлөлтийн байдлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

**Хүснэгт 1.13. Ковид-19-т өртсөн болон бүтэц өөрчилсөн зээлийн өөрчлөлт (2020.12.31-2021.12.31) (тэрбум төгрөг)**

| № | Зээлийн төрлөөр  | 2021.01.01 | 2021.12.31 | Нийт гарсан өөрчлөлт | Өөрчлөлтийн зардлага    |        |                  |       |      |
|---|------------------|------------|------------|----------------------|-------------------------|--------|------------------|-------|------|
|   |                  |            |            |                      | Эргэн төлөлтөөр буурсан |        | Шинээр нэмэгдсэн |       |      |
|   |                  | Дүн        | Дүн        | Дүн                  | Хувь                    | Дүн    | Хувь             | Дүн   | Хувь |
| 1 | Ковид19-т өртсөн | 8,435      | 5,138      | -3,297               | -39.08%                 | -5,170 | -61%             | 1,874 | 22%  |
| 2 | Бүтэц өөрчилсөн  | 5,415      | 3,945      | -1,470               | -27.15%                 | -3,454 | -64%             | 1,984 | 37%  |

Эх сурвалж: Фина тайлан, банкуудаас ирүүлсэн зээлийн дэлгэрэнгүй жагсаалтаас (2021.12.31)

Цаашид Монголбанкны зүгээс хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд цар тахлын болон эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан тухай бүр зохих тохируулгыг хийж ажиллах болно. Энэ нь банкны салбарын тогтвортой байдлыг хадгалах, системийн эрсдэлийг бууруулах, төлбөрийн чадварыг ханган ажиллах, эрсдэл хуримтлагдах, эрсдэлээс хамгаалах нөөц, хөрөнгийн хуваарилалтыг зохистой түвшинд хадгалах, төлбөрийн чадварын дарамт үүсгэхгүй байх зорилттой уялдана.

**1.4. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ****Засгийн газрын санхүү**

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 12'689 тэрбум төгрөг, нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 15'598 тэрбум төгрөгт хүрч, төсвийн тэнцэл 2'909 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 6.8 хувьтай тэнцүү алдагдалтай байв (Хүснэгт 1.14).

**Хүснэгт 1.14. Төсвийн үндсэн үзүүлэлтүүд**

| их наяд төгрөг               | 2020        | 2021        |             | 2021/2020        |
|------------------------------|-------------|-------------|-------------|------------------|
|                              | Гүй.        | Тод.        | Урьд.Гүй.   | Өөрчлөлтийн хувь |
| <b>Нийт орлого</b>           | <b>10.4</b> | <b>13.7</b> | <b>14.3</b> | <b>37.5</b>      |
| Сангуудын орлого             | 1.0         | 1.7         | 1.6         | 60.0             |
| <b>Тэнцвэржүүлсэн орлого</b> | <b>9.4</b>  | <b>12.1</b> | <b>12.7</b> | <b>35.1</b>      |
| Татварын орлого              | 8.5         | 10.6        | 11.3        | 32.9             |
| Татварын бус орлого          | 0.9         | 1.4         | 1.4         | 55.6             |
| <b>Нийт зардал</b>           | <b>14.0</b> | <b>15.7</b> | <b>15.6</b> | <b>11.4</b>      |
| Анхдагч зардал               | 13.0        | 14.8        | 14.8        | 13.8             |
| Хүүний зардал                | 1.0         | 1.0         | 0.8         | -20.0            |
| <b>Нийт тэнцэл</b>           | <b>-3.6</b> | <b>-2.0</b> | <b>-1.3</b> | <b>-</b>         |
| ДНБ-д эзлэх хувь             | -9.4        | -4.8        | -3.0        | -                |
| <b>Тэнцвэржүүлсэн тэнцэл</b> | <b>-4.5</b> | <b>-3.7</b> | <b>-2.9</b> | <b>-</b>         |
| ДНБ-д эзлэх хувь             | -12.0       | -8.8        | -6.6        | -                |
| <b>Анхдагч тэнцэл</b>        | <b>-3.5</b> | <b>-2.7</b> | <b>-2.1</b> | <b>-</b>         |
| ДНБ-д эзлэх хувь             | -9.4        | -6.5        | -4.7        | -                |


Эх сурвалж: Сангийн яам

## Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

Тэнцвэржүүлсэн орлого 12.7 их наяд төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оноос 35 хувиар, “Оюу толгой” компаниар төлүүлсэн татварын орлого (1.0 их наяд төгрөг)-ыг хасаж тооцвол 27 хувиар тус тус өссөн байна. Төсвийн орлого ихэнх дэд бүлгийн хувьд өмнөх оноос өссөн (Зураг 1.33) бөгөөд үүнээс гол өссөн бүлгүүдийг авч үзвэл:

- ААНОАТ-ын орлого: **+820 тэрбум (58.8%)** төгрөг. Үүнд, “Оюу толгой” компаниар төлүүлсэн татварын орлогын 600 тэрбум төгрөг нь ААНОАТ-ын орлогод бүртгэгджээ;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого: **+670 тэрбум (42.3%)** төгрөг. Үүнээс, цар тахлын үеийн НДШ-ийн хөнгөлөлт 2021 онд өмнөх оноос 500 орчим тэрбум төгрөгөөр буурав;
- НӨАТ-ын орлого: **+630 тэрбум (28.7%)** төгрөг;
- ХХОАТ-ын орлого: **+280 тэрбум (32.7%)** төгрөг;
- Импортын барааны гаалийн албан татвар: **+200 тэрбум (27.3%)** төгрөгөөр нэмэгджээ.

Зураг 1.33. Төсвийн орлогын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам

## Нэгдсэн төсвийн нийт зардал

Урьдчилсан дүнгээр 2021 онд төсвийн татаас, шилжүүлгийн зардал 50% орчим өссөн бол бусад зардал 2020 оны түвшинд хадгалагдав (Зураг 1.34). Цар тахлын үед иргэдийн орлогыг дэмжих зорилгоор нэг удаагийн тэтгэмж, урамшуулал, хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн дүнгээр олгох зэрэг арга хэмжээ хэрэгжүүлж, улмаар төсвийн нийт зардлын 47%<sup>10</sup>-ийг татаас, шилжүүлгийн зардал бүрдүүлжээ. Татаас ба шилжүүлгийн зардлын дэд бүлгүүдийг өмнөх онтой харьцуулбал:


- Нэг удаагийн тэтгэмж<sup>11</sup>: **+ 1.0 их наяд төгрөг**;
- Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж: **+ 330 тэрбум (32.8%)** төгрөг;
- Өндөр насны тэтгэвэр: **+ 120 тэрбум (7.4%)** төгрөг;
- Халамжийн тэтгэвэр: **+ 20 тэрбум (13.1%)** төгрөгөөр өсжээ.

<sup>9</sup> Аж ахуй нэгжийн орлогын албан татвар бүрдүүлэлт 2021 онд 2.2 их наяд төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оноос 58.8 хувиар өссөн дүн юм. Татварын маргаантай холбоотой орлогыг хасаж тооцвол жилийн өсөлт 15.8 хувь байна.

<sup>10</sup> 2010-2020 оны дундаж 32 хувь

<sup>11</sup> Бүх нийтийн бэлэн байдал хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Засгийн газраас иргэн бүрд 300'000 төгрөгийн нэг удаагийн тусламж олгов.

Зураг 1.34. Төсвийн зардлын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам

**Төсвийн алдагдал, өрийн эргэн төлөлтийг санхүүжүүлсэн эх үүсвэр**

Тайлант онд гадаад зээл, үнэт цаас эргүүлэн төлөх, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд нийт 7.0 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдлаа. Үүнээс 4.1<sup>12</sup> их наяд төгрөгийг гадаад зээл, үнэт цаасаар, 729 тэрбум төгрөгийг тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдлээс, 2.9 их наяд төгрөгийг харилцах данснаас бүрдүүлжээ (Хүснэгт 1.15).

Хүснэгт 1.15. Санхүүжилтийн шаардлага болон эх үүсвэр бүрдүүлсэн байдал

| их наяд төгрөг                          | 2020        | 2021/2020   | Өөрчлөлт    |
|-----------------------------------------|-------------|-------------|-------------|
|                                         | Гүй.        | Урьд.Гүй.   |             |
| <b>Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b> | <b>4.5</b>  | <b>2.9</b>  | <b>-1.6</b> |
| Харилцах болон хадгаламжийн данс        | 2.1         | 2.2         | 0.0         |
| <b>ЗГ-ын бонд</b>                       | <b>-0.2</b> | <b>-0.6</b> | <b>-0.3</b> |
| Шинээр гаргах                           | 1.7         | 2.8         | 1.1         |
| Үндсэн төлбөр                           | -2.0        | -3.4        | -1.4        |
| <b>ЗГ-ын зээл</b>                       | <b>2.5</b>  | <b>0.6</b>  | <b>-1.9</b> |
| Шинээр гаргах                           | 3.2         | 1.3         | -1.8        |
| Үндсэн төлбөр                           | -0.7        | -0.7        | 0.0         |
| ТС-ийн хуримтлагдсан үлдэгдэл           | 0.1         | 0.7         | 0.6         |
| Өмч хувьчлал                            | 0.0         | 0.0         | 0.0         |

Эх сурвалж: Сангийн яам

<sup>12</sup> “Century” төслийн хүрээнд Чингис (\$660 сая), Гэрэгэ (\$340 сая) бондын нийт 2.8 их наяд төгрөгийн өрийг дахин санхүүжүүлэв.




## 2.1 МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮНДСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

*Мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлж, хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляц 2021-2023 онд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулна.*

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ээр хэмжигдэх инфляц 2021 оны 12 дугаар сард улсын хэмжээнд жилийн 13.4 хувь, Улаанбаатар хотод 14.8 хувь буюу зорилтот түвшин (6 хувь(+/-2))-ээс өндөр гарлаа. Үүнд хилийн хязгаарлалт, малын халдварт өвчний тархалт, тээврийн зардлын өсөлттэй холбоотойгоор нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт сүүлийн хагас жилд эрчимжсэнээс инфляцын дийлэнх хэсгийг бүрдүүлж байна. Харин хөл хорио шат дараатай суларсан ч эдийн засгийн сэргэлт, эрэлтийн шалтгаантай инфляц төдийлөн нэмэгдсэнгүй.

Нийлүүлэлтийн хүчин зүйлсийг дэлгэрүүлж тайлбарлавал 1) малын гоц халдварт өвчин тархсан нь махны үнэ болон нийлүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлэв, 2) хилийн хязгаарлалтаас үүдэлтэйгээр нийлүүлэлт саатаж, импортын үнэ эрчтэй нэмэгдсэн, 3) гадаад үнийн өсөлтийг даган дотоодын шатахууны үнэ өссөн, 4) шатахуун болон импортын үнийн өсөлтийн 2 дах үеийн нөлөөгөөр зарим бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өссөн, 5) сайжруулсан түлшний үнийн хөнгөлөлт өмнөх оны мөн үеэс буурсан, мөн түлшний модны үнэ өссөн нь инфляцад том нөлөөтэй байв. Цаашид дэлхий нийтэд үүсээд буй үнийн өсөлт болон олон улсын тээвэр, логистикт бий болсон саатал, түгжрэл, үүнээс улбаалсан тээврийн зардлын өсөлт хэр удаан үргэлжлэх нь тодорхой бус байна.

Зураг 2.1 Жилийн инфляц, хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлант оны эхний хагас жилд Ковид-19 цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлж буй санхүүгийн хүндрэл дарамтыг зөөлрүүлэх, дунд хугацаанд инфляцын зорилтыг алдагдуулахгүйгээр эдийн засгийн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэв. Оны эхний хагаст хэдийгээр нийлүүлэлтийн шалтгаанаар зарим барааны үнэ нэмэгдэж байсан хэдий ч инфляц зорилтот интервалын орчимд буюу 2021 оны 6 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 6.6 хувь, Улаанбаатар хотод 7.1 хувьтай гарсан бөгөөд цаашид төв банкны зорилтот түвшний орчимд тогтворжих хүлээлттэй байв. Нөгөө талаас эдийн засаг харьцангуй сэргэж эхэлсэн ч салбаруудын өсөлт харилцан ялгаатай, цаашдын төлөв жигд бус, цар




тахлын сөрөг нөлөө төдийлөн буураагүй, тодорхой бус байдал өндөр хэвээр байсан тул бодлогын хүүг түүхэн доод хэмжээ болох 6 хувьд хэвээр хадгалах шийдвэрийг гаргав. Түүнчлэн, 2021 оны 1 дүгээр улирлын Мөнгөний бодлогын хорооны ээлжит хурлаар урт хугацаат репо санхүүжилтийг боловсруулах, үйлчилгээ болон 200 дээш ажиллагчидтай худалдааны салбарын аж, ахуйн нэгжүүдийг хамруулахаар өргөтгөсөн. Энэхүү шийдвэр нь Монгол Улсын Засгийн газраас боловсруулсан Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгогдох зээлийн зориулалттай давхцал үүссэнийг арилгаж, репо санхүүжилтийн үр нөлөөг дээшлүүлэх, цаашлаад эдийн засаг, бизнесийн идэвхжилийг дэмжих зорилготой. Улмаар урт хугацаат репо санхүүжилтийн хэмжээг 2021 оны 1-3 дугаар улиралд харгалзан 250, 350, 250 хүртэлх тэрбум төгрөгөөр олгохоор шийдвэрлэв. Мөн эдийн засгийг дэмжих, зээлдэгчийн өрийн дарамтыг багасгах зоригоор репо санхүүжилтийн хүүг 0.5 нэгж хувиар бууруулсан.

Оны сүүлийн хагаст Ковид-19 вирусийн хоёр ч шинэ хувилбар дэлхий даяар тархаж, дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ огцом өсч, БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлогын хүрээнд хилийн хязгаарлалт чангарч, нийлүүлэлтийн гинжин сүлжээ тасалдаж, логистикийн саатал, тээврийн зардлыг огцом нэмэгдүүлсэн. Эдгээр нь гадаад, дотоод эдийн засгийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлсний зэрэгцээ зардлын инфляц буюу нийлүүлэлтийн шалтгаантай инфляцыг эрчимжүүлэх нөлөөг үзүүлэх эрсдэлийг шинээр үүсгэсэн. Иймээс эдийн засгийн сэргэлтийн төлөв, инфляцын зорилтоо хангахад үүсч болзошгүй эрсдэл, инфляцын хүлээлтийг харгалзан бодлогын шийдвэрийг гаргасан юм. Тодруулбал, жилийн инфляц 2021 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 8.9 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 9.1 хувьд хүрч өссөн бөгөөд инфляцын дийлэнх хэсгийг суурь үеийн нөлөө, олон улсын нийлүүлэлтийн сүлжээ, логистикийн сааталтай холбоотой нийлүүлэлтийн хүчин зүйлс тайлбарлаж байв. Инфляц ийнхүү нийлүүлэлтийн шалтгаанаар өссөн ч 2 улсын хамтын ажиллагааны хүрээнд хилийн хязгаарлалт богино хугацаанд шийдвэрлэгдэнэ гэсэн хүлээлттэй байсан бөгөөд 2022 оны сүүлийн хагасаас инфляц зорилтын орчимд тогтворжих төсөөлөлтэй байсан. Хилийн хязгаарлалтаас гадна дэлхийн эдийн засгийн өсөлт нэмэгдэж, ихэнх экспортын бүтээгдэхүүний үнэ өндөр түвшинд хадгалагдаж байсан боловч үүнээс бий болж буй эерэг нөлөө хүлээлтээс бага, вирусийн шинэ хувилбарын тархалт үргэлжлэн цар тахлаас үүдэлтэй тодорхой бус байдал нэмэгдсэнээс хөдөлмөрийн зах зээлийн идэвхжил сул, эдийн засгийн сэргэлт салбаруудаар харилцан адилгүй, эмзэг байсан. Иймд мөнгөний бодлогын төлөвийг 2021 оны 3 дугаар улиралд хэвээр хадгалах, урт хугацаат репо санхүүжилтийн хэмжээг өмнөх улирлуудаас харьцангуй бууруулан 2021 оны 4 дүгээр улиралд 100 хүртэлх тэрбум төгрөгөөр олгох шийдвэрүүдийг гаргав. Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 4 дүгээр улирлын ээлжит хурлаар буюу 11 дүгээр сарын гүйцэтгэлээр жилийн инфляц хилийн хязгаарлалт, малын халдварт өвчний тархалт, тээврийн зардлын өсөлт зэрэг нийлүүлэлтийн шалтгаантайгаар нэмэгдэн, өмнөх төсөөллөөс давж улсын хэмжээнд 10.5 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 10.0 хувьд хүрсэн. Нийлүүлэлтийн сүлжээний саатал, хилийн хязгаарлалт, хүнс, шатахууны үнийн хүлээлтээс давсан өсөлт зэргээс шалтгаалан инфляц хурдан буурахгүй байх эрсдэлтэй тул урт хугацаат репо санхүүжилтийн зориулалтыг өргөтгөн шатахуун болон хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийг шаардлагатай түвшинд хүртэл бүрдүүлэхэд ашиглаж болохоор өргөтгөхөөр шийдвэрлэв. Түүнчлэн, эдийн засгийн өсөлт 2 улирал дараалан хүлээлтээс бага гарсан бөгөөд үүнтэй холбоотойгоор эрэлтийн шалтгаантай инфляц харьцангуй бага, мөн өрхийн хэрэглээ сэргээгүй, гадаад болон дотоод эдийн засгийн орчинд цар тахлаас үүдэлтэй тодорхой бус байдал өндөр хэвээр байсан тул оны сүүлийн хагаст бодлогын хүүг өсгөх нөхцөл бүрдээгүй юм. Гэвч нийт инфляц нэмэгдэн, Төв банкны зорилтот түвшнээс давсан тул бодлогын тохируулгыг хийж эхлэх хүрээнд репо санхүүжилтийн хүүг буцаан бодлогын хүүнээс 0.5 нэгж хувиар өндрөөр тогтоох шийдвэрийг гаргасан бол долларжилтын эрсдэлээс сэргийлэх зорилгоор гадаад валютын татан төвлөрүүлсэн хөрөнгөд тооцох заавал байлгах нөөцийн хувийг 3 нэгж хувиар нэмэгдүүлж 18 хувьд хүргэв. Улмаар Төв банк эдийн засгийн сэргэлт болон инфляцын төлөвтэй уялдуулан мөнгөний бодлогын тохиргоог тухай бүр хийхээ мэдэгдсэн.

## Мөнгөний зах, хүүний түвшин


Банкуудын зээл олгох эсвэл хадгаламж татах шийдвэр нь банк хоорондын зах дээрх санхүүгийн хэрэгслүүдийн хүүнээс хамаарч байдаг. Иймд Монголбанкнаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүний нэгдсэн бодлого болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийн тусламжтай банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүг бодлогын хүүтэй ойролцоо түвшинд хадгалахыг зорьдог билээ (Зураг 2.2).

Зураг 2.2 Мөнгөний бодлогын шилжих механизм



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.3 Банк хоорондын захын хүү, хувиар




Эх сурвалж: Монголбанк

## Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2021 оны эцэст 2,849.34 төгрөгт хүрч, оны эхнээс 0.019 хувиар чангарсан байна (Зураг 2.4). Монголбанкнаас богино хугацааны валютын эрэлт, нийлүүлэлтийн зөрүү, ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад оролцож, тайлант хугацаанд ханшийн өдрийн дундаж хэлбэлзэл 0.011 нэгж хувь буюу тогтвортой түвшинд байв. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш тайлант хугацаанд нэг өдөр хамгийн ихдээ 0.033 хувиар буюу 0.95 төгрөгөөр суларч (өмнөх оноос 3.80 төгрөгөөр буурсан), 0.035 хувиар буюу 0.99 төгрөгөөр чангарсан (өмнөх оноос 1.07 төгрөгөөр буурсан) бөгөөд тайлант хугацаанд ханш өдрийн хэлбэлзэл  $\pm 0.1$  хувийн интервалд байв (Зураг 2.5).


Коронавируст (Ковид-19) цар тахлын улмаас эдийн засагт бий болсон сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор 2020 онд бодлогын хүүг шат дараалан бууруулж, 6.0 хувьд буюу түүхэн доод түвшинд хүргээд байсан нь 2021 оны туршид хадгалагдав. Дээрх бодлогын өөрчлөлтийн үр дүнд 2021 онд банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү өмнөх онтой харьцуулахад 2.8 нэгж хувиар буурснаар 6.0 хувь орчимд хүрч, банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүний бодлогын хүүнээс хазайх абсолют хазайлт 0.0 хувь болж буурав (Зураг 2.3).

**Зураг 2.4. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан хаалтын ханшийн хэлбэлзэл (төгрөгөөр)**



Эх сурвалж: Монголбанк

**Зураг 2.5. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өдрийн хэлбэлзлийн давтамж**



Эх сурвалж: Монголбанк

## 2.2 МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

*I. Монгол Улсыг Европын Холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтаас гаргах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлуудын талаар*

Монгол Улс нь 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу “Саарал жагсаалт”-нд багтсан. Үүнтэй холбогдуулан Монгол Улсыг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Европын Холбооны “Хар жагсаалт” гэж нэрлэгддэг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтад оруулсан. Иймд Монгол Улсыг Европын Холбооны жагсаалтаас гаргах хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авсан арга хэмжээ, ахиц дэвшлийн талаарх мэдээллийг Сангийн яам, Гадаад харилцааны яамаар дамжуулан Европын Холбоонд удаа дараа хүргүүлж, цахим хурал уулзалтуудыг зохион байгуулсан.

Эдгээр арга хэмжээний үр дүнд ФАТФ-аас Монгол Улсыг 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдөр “Саарал жагсаалт”-аас гаргасантай холбогдуулан Европын Комиссоос 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 2015/849 тоот тогтоолыг нийтэлж, Монгол Улсыг Европын Холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтаас хассаныг зарлав.

Монгол Улсыг Европын Холбооны жагсаалтаас гаргаснаар Европын Холбооны гишүүн улс орнуудын банк, санхүүгийн байгууллагуудтай бизнесийн харилцаа тогтоох, гүйлгээг богино хугацаанд хийж гүйцэтгэх, Европын Холбооны санхүүжилтээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломж нэмэгдэх зэрэг зэрэг үр дагавартай юм.

### II. ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээг сайжруулах ажлын хүрээнд

Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргасан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт болох 40 Зөвлөмжийн хэрэгжилтийн талаар жил бүр Ази, номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт тайлагнах үүрэгтэй.

Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудтай хамтран Монгол Улсын 2021 оны Явцын тайланг боловсруулж, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2021 оны 2 дугаар сарын 1-ний өдөр хүргүүлсэн. Тайланг боловсруулах чиглэлээр Санхүүгийн мэдээллийн албанаас ажлын төлөвлөгөө гаргаж, нийт 5 удаа цахим хурал зохион байгуулж ажиллав.

Энэхүү явцын тайланд “Хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй байсан ФАТФ-ын Зөвлөмж 1, 8, 15-ын үнэлгээг ахиулах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ахиц дэвшлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тусгасан. Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн үнэлгээний багаас ирүүлсэн хүсэлтийн дагуу тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл, тайлбарыг тухай бүр нийт 5 удаа хүргүүлснээс гадна хамтарсан цахим уулзалтыг зохион байгуулсан.

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн Харилцан үнэлгээний хорооны 2021 оны 7 дугаар сарын хуралдаанаар Монгол Улсын 2021 оны Явцын тайланг хэлэлцэн баталж, 2021 оны 8 дугаар сарын 13-ны өдөр тайланг албан ёсоор цахим хуудаснаа нийтлэв.

Уг тайланд Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр эрсдэлд суурилсан аргачлалыг үр дүнтэй хэрэгжүүлж байна хэмээн дүгнэсэн. Улмаар Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Зөвлөмж 1-ийн техник хэрэгжилтийн үнэлгээ “Хэсэгчлэн биелүүлсэн” байсныг “Дийлэнхийг биелүүлсэн” болгож ахиулсан. Харин Зөвлөмж 8, 15-ын хувьд хууль, эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай гэж үзэн техник хэрэгжилтийн үнэлгээг хэвээр үлдээв (Хүснэгт 2.1). Үүнд:

#### Хүснэгт 2.1. Монгол Улсын 2021 оны Явцын тайлангийн үр дүн

| №  | ФАТФ-ын Зөвлөмжийн нэр   | Өмнөх үнэлгээ          | Одоогийн үнэлгээ            |
|----|--------------------------|------------------------|-----------------------------|
| 1  | Эрсдэлийн үнэлгээ        | “Хэсэгчлэн биелүүлсэн” | “Дийлэнхийг биелүүлсэн” ( ) |
| 8  | Ашгийн бус байгууллагууд | “Хэсэгчлэн биелүүлсэн” | “Хэсэгчлэн биелүүлсэн” (=)  |
| 15 | Шинэ технологи           | “Хэсэгчлэн биелүүлсэн” | “Хэсэгчлэн биелүүлсэн” (=)  |

Эх сурвалж: Монголбанк, СМА

Монгол Улсын 2021 оны Явцын тайланд Зөвлөмж 1, 8, 15 гэсэн 3 зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээг ахиулах зорилгоор авч хэрэгжүүлсэн дараах арга хэмжээг тайлагнав. Үүнд:

**Зөвлөмж 1:** Энэхүү зөвлөмжийн дагуу улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тогтмол үнэлж, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. Иймд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу Санхүүгийн мэдээллийн албанаас санаачлан Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх ажлыг зохион байгуулж, холбогдох төр болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэсэн. Мөн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А-31 тоот тушаалаар “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-д холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан. Үүний дүнд мэдээлэх үүрэгтэй этгээдүүд эрсдэлийн үнэлгээ хийж, бага эрсдэлтэй харилцагчийг хялбаршуулсан байдлаар таньж мэдэх боломжтой болсон.

**Зөвлөмж 8:** Энэ хүрээнд ашгийн бус байгууллагын салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгох, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, уг салбартай холбоотой мөрдөн шалгах, яллах үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр авсан холбогдох арга хэмжээний талаар Явцын тайланд тусгасан. Тухайлбал, Санхүүгийн мэдээллийн албанаас Хууль зүй, дотоод хэргийн яам болон Терроризмтой тэмцэх зөвлөлтэй хамтран ашгийн бус байгууллагын салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Мөн энэ салбарын хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор Холбооны эрх зүйн байдлын тухай хууль болон Сангийн эрх зүйн байдлын

тухай хуулийн төслийг батлуулах хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллав. Эдгээр хуулийг батлуулснаар ашгийн бус байгууллагын салбарын хяналт шалгалт, зохицуулалтын тогтолцоо болон хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

**Зөвлөмж 15:** Шинэ технологитой холбоотой тус зөвлөмжийн шаардлагуудыг хангах хүрээнд Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам хамтран Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг боловсруулсан. Тус хуулийн төслийг Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдөр УИХ-аар хэлэлцэхийг дэмжсэн. УИХ-ын Байнгын хорооноос Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсгийг төр, хувийн хэвшлийн 30 гаруй төлөөлөлтэйгээр байгуулсан бөгөөд Монголбанк, Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөл ажлын хэсэгт орж ажиллав. Энэ хүрээнд виртуал хөрөнгийн салбарын талаарх олон улсын туршлага, хууль, эрх зүйн орчинтой холбоотой судалгааг хийж гүйцэтгэсэн. Улмаар Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн УИХ-ын чуулганаар батлав. Уг хууль батлагдсанаар Монгол Улсад виртуал хөрөнгийн салбарын хууль, эрх зүйн орчин бүрдэж, ФАТФ-ын зөвлөмжийг биелүүлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын тогтолцоо бий болох, мэдээлэх үүрэгтэй этгээдийг тодорхойлох, стандарт шаардлагад нийцсэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчидтэй болох зэрэг ач холбогдолтой юм.

Мөн Зөвлөмж 15-ын хэрэгжилтийг хангах хүрээнд Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, хууль сахиулах болон бусад байгууллагууд хамтран виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэн Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлсэн. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдсантай холбогдуулан тус үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу шинэчлэх талаар Санхүүгийн мэдээллийн албанаас Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулж, ажлын хэсэг байгуулахаар шийдвэрлэв.

#### Шигтгээ 1. Виртуал хөрөнгийн салбарын тухай гарын авлага



ФАТФ-ын Зөвлөмж 15-ын дагуу улс орнууд виртуал хөрөнгийн зохицуулалтыг тодорхойлж, холбогдох эрсдэлийг удирдах чиг үүргийг хүлээсэн. Виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь Монгол Улсад төдийгүй, дэлхий дахинд шинээр үүсч буй салбар юм. Иймд Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуультай холбогдуулан хамтран ажиллагч байгууллагуудад энэ чиглэлийн ойлголт өгч, мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор 2021 оны 11 дүгээр сард “Виртуал хөрөнгийн ерөнхий ойлголт, зах зээл ба зохицуулалтын нөхцөл байдал” гарын авлагыг ажлын дотоод хэрэгцээнд зориулан боловсруулж, түгээсэн. Энэхүү гарын авлагад тархмал бүртгэлийн технологи, блокчейн, криптовалют, койн зэрэг виртуал хөрөнгийн салбарын үг хэллэгийн тодорхойлолт, уг салбарт оролцогчид, тухайн үеийн олон улсын зах зээл болон Монгол Улсын нөхцөл байдал, виртуал хөрөнгийг ашиглаж хийх гэмт хэргийн эрсдэл, ФАТФ-ын стандарт зэрэг шаардлагатай агуулгыг хамруулсан болно.

Монгол Улсын 2021 оны Явцын тайлангийн үр дүнд ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилт нийт 38 Зөвлөмжийн хувьд дийлэнхийг болон бүрэн биелүүлсэн гэсэн үнэлгээтэй болсон. ФАТФ-ын Зөвлөмж тус бүрийн техник хэрэгжилтийн үнэлгээ дараах байдалтай байна (Хүснэгт 2.2). Үүнд:



## Хүснэгт 2.2 Монгол Улсын ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийн үнэлгээ

/Бүрэн биелүүлсэн: C-compliant, Дийлэнхийг биелүүлсэн: LC-largely compliant, Хэсэгчлэн биелүүлсэн: PC-partially compliant, Биелүүлээгүй: NC-noncompliant/

| Зөвлөмж 1  | Зөвлөмж 2  | Зөвлөмж 3  | Зөвлөмж 4  | Зөвлөмж 5  | Зөвлөмж 6  | Зөвлөмж 7  | Зөвлөмж 8  |
|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|
| LC         | LC         | LC         | LC         | LC         | LC         | LC         | PC         |
| Зөвлөмж 9  | Зөвлөмж 10 | Зөвлөмж 11 | Зөвлөмж 12 | Зөвлөмж 13 | Зөвлөмж 14 | Зөвлөмж 15 | Зөвлөмж 16 |
| LC         | LC         | C          | LC         | LC         | C          | PC         | LC         |
| Зөвлөмж 17 | Зөвлөмж 18 | Зөвлөмж 19 | Зөвлөмж 20 | Зөвлөмж 21 | Зөвлөмж 22 | Зөвлөмж 23 | Зөвлөмж 24 |
| LC         | LC         | LC         | LC         | C          | LC         | LC         | LC         |
| Зөвлөмж 25 | Зөвлөмж 26 | Зөвлөмж 27 | Зөвлөмж 28 | Зөвлөмж 29 | Зөвлөмж 30 | Зөвлөмж 31 | Зөвлөмж 32 |
| LC         | LC         | LC         | LC         | C          | C          | C          | LC         |
| Зөвлөмж 33 | Зөвлөмж 34 | Зөвлөмж 35 | Зөвлөмж 36 | Зөвлөмж 37 | Зөвлөмж 38 | Зөвлөмж 39 | Зөвлөмж 40 |
| LC         | LC         | LC         | C          | C          | LC         | LC         | LC         |

Эх сурвалж: Монголбанк, СМА

Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс ФАТФ-ын 40 Зөвлөмжийн үр дүнтэй хэрэгжилтийг хангаж, үнэлгээг ахиулах зорилгоор “ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулсан. Тус төлөвлөгөөг Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр баталж, зөвлөлийн гишүүн байгууллагуудад хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгов. Үндэсний зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн ээлжит хурлаар төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцсэн бөгөөд Монгол Улсын 2022 оны Явцын тайланг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэхээр тогтов.

### Шигтгээ 2. Олон улсын корреспондент банкны харилцааны нөхцөл байдал, түүний ач холбогдол

ФАТФ-ын Зөвлөмж 13-т санхүүгийн байгууллагын хил дамнанас корреспондент банкны харилцааг хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлагуудыг тусгасан байдаг. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас корреспондент банкны харилцааны нөхцөл байдал, чиг хандлагын талаар олон улсын байгууллагуудаас гаргасан судалгааг танилцуулж байна.

Корреспондент банкны харилцаагаар дамжуулан банкууд өөр улс орнуудын санхүүгийн үйлчилгээнд нэвтэрч, харилцагчдадаа хил дамнанас төлбөрийн үйлчилгээг үзүүлж, олон улсын худалдаа, санхүүгийн хүртээмжийг дэмжих боломж олгодог чухал ач холбогдолтой юм. Харин 2008 оны санхүүгийн хямралаас хойш дэлхий дахинаа корреспондент банкны харилцаа буурч, эрсдэлээс зайлсхийх зорилгоор хязгаарласан тохиолдол ихээр ажиглагдах болсон. Ялангуяа эдгээр үйлчилгээг үзүүлж буй зарим банкууд тогтоосон харилцааныхаа тоог цөөлж, шинээр цөөн хэдэн харилцаа тогтоох болсон байна (BIS, 2016).

Өнөөгийн олон улсын корреспондент банкны харилцаанд нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйл бол эрсдэлээс зайлсхийх арга хэмжээ юм. Эрсдэлээс зайлсхийх гэдэг нь санхүүгийн байгууллагууд эрсдэлийг удирдах бус харин түүнээс зайлсхийхийн тулд өндөр эрсдэлтэй гэж тооцогдсон харилцагчтай бизнесийн харилцаагаа таслах, хязгаарлах арга хэмжээг хэлнэ (US Department of State). Ашиг багатай, бизнесийн нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтайгаас гадна мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хяналт шалгалт нэмэгдэж байгаагаас үүдэн эрсдэлээс зайлсхийх хүрээнд АНУ, Их Британи, Австрали дахь корреспондент банкны харилцаа хумигдахад хүрсэн. Олон улсын корреспондент банкны харилцааны хувьд зохицуулалтын арга хэмжээтэй уялдуулан корреспондент банкууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсаар байна.

### ТӨЛБӨРИЙН БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЦИЙН ХОРОО (СРМ), 2019

Олон улсын корреспондент банкны харилцааны тоо 2011-2018 онд 20 хувиар буурсан.



### ДЭЛХИЙН БАНКНЫ СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИД

Дэлхийн банкны 2015 оны корреспондент банкны судалгаанд нийт 91 эрх бүхий банкны зохицуулалтын байгууллага, 20 үндэстэн дамнасан том хэмжээний банк, 170 орон нутгийн болон бүс нутгийн жижиг банк хамрагдав.


Дэлхийн банкны судалгаанд олон улсын корреспондент банкны харилцааг цуцлахад нөлөөлсөн хэд хэдэн голлох шалтгаануудыг дурдсан байна (World Bank, 2015). Үүнээс судалгаанд оролцогчдын дийлэнх нь корреспондент банкны харилцаатай байх нь ашиггүй учир корреспондент банкны харилцаагаа цуцалж байна гэжээ. Удаагаар нь ерөнхий эрсдэл өндөр, хууль эрх зүй, зохицуулалт болон хяналт шалгалтын өөрчлөлтүүд, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй зэрэг шалтгаанууд корреспондент банкны харилцааг бууруулахад нөлөөлсөн байна.

Корреспондент банкны харилцаанд гарч буй чиг хандлага

- Ностро дансны бууралт:

Ностро данс гэдэг ойлголт нь энгийнээр гадаадын банканд нээсэн дотоодын банкны данс юм. Корреспондент банкны харилцаанд ностро дансыг ашиглаж гадаад валютын арилжааны төлбөр тооцоог хийдэг. Олон улсын корреспондент банкны харилцаанд ажиглагдаж байгаа бас нэг томоохон чиг хандлага бол Ностро дансны бууралт юм. Уг хандлагад Латин Америк, Карибын тэнгисийн орнууд хамгийн их хямралд өртсөн байна.

- Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өртгийн өсөлт:



Дэлхийн банкнаас улирал тутам эрхлэн гаргадаг мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өртөг, зардлыг дүгнэх зорилготой тайлан судалгаанд 2021 оны 3 дугаар улирлын байдлаар дэлхий дахинд 200 ам.доллар шилжүүлэх дундаж өртөг нь нийт дүнгийн 6.30 хувь буюу 12.6 ам.доллар байна гэх үр дүн гарчээ (World Bank, 2021). Хамгийн сүүлд хийгдсэн судалгааны үр дүнд Зүүн Азийн бүс нутаг мөнгө хүлээж авах үед хамгийн зардал багатай (нийт мөнгөн дүнгийн 4.49%), Африкийн Сахарын цөлөөс урагш бүс нутаг мөнгө хүлээн авах үед хамгийн өртөг өндөр (8.27%) байжээ. Улмаар банк нь мөнгөн гуйвуулгын зардлын хувьд хамгийн өндөр өртөгтэй (10.40%) үйлчилгээ үзүүлэгч болсон байна.

Иймд өнөөгийн корреспондент банкны харилцааны чиг хандлага нь зардал өсөх, зохицуулалтын шаардлагууд улам бүр нэмэгдэх болон хүлээгдэж буй эрсдэл өндөр байгаа нь корреспондент үйл ажиллагааны ашгийн хэмжээг бууруулж, улмаар корреспондент банкны харилцааг сайжруулах боломжийг хязгаарлан, тааламжгүй нөхцөлийг бүрдүүлж байна. Ялангуяа эдийн засгийн цар хүрээ энэ төрлийн бизнест ихээхэн нөлөөлдөг бөгөөд зарим банкууд ашиг орлогоороо комплаенсийн зардлаа нөхөхөд хүндрэлтэй болоод байна. Улмаар энэ төрлийн бизнес нь “бага эрсдэл - бага ашиг” бизнесийн төрлөөс “өндөр эрсдэл - бага ашиг” төрөлд шилжих хандлагатай байна.

## 2.3 БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

### Банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-366 дугаар тушаалаар баталсан “Эрүүл, найдвартай, ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчид хүртээмжтэй, цахимжсан банкны тогтолцоог бий болгох банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд 2021 онд доорх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**Зорилт 1:** Банкны салбарын хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, банкны үйл ажиллагааны зохистой засаглалыг сайжруулан ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай банкны тогтолцоог бий болгох.

Банкны системд нөлөө бүхий банкныг нээлттэй хувьцаат компани хэлбэрээр, бусад банкныг хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, банкны хувьцаа эзэмшлийн хэт төвлөрлийг бууруулж, **өмчлөл-удирдлага-хяналтын** тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх, улмаар банкны зохистой засаглалыг бэхжүүлэх үзэл баримтлал бүхий Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон түүнийг дагалдан гарах Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг Монгол Улсын Их Хурлын 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэн батлууллаа.

Банкны тухай хуулийн энэхүү зохицуулалтаар банкны хувь эзэмшлийн хэлбэрийг хувьцаат компани хэлбэрээр өөрчлөх шаардлагатай. Ингэснээр банкны удирдлага, хяналт, засаглал сайжирч улмаар хадгаламж, харилцах эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад түлхэц болно.

Банкны тухай хуулийн энэхүү зохицуулалтын холбогдох журам, аргачлалыг боловсруулж, батлуулаад байна.

- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн А-86 дугаар тушаалаар “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ыг баталсан. Уг журмын хүрээнд хувьцаат компани хэлбэртэй банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд тавигдах шаардлага, баримтлах зарчмыг тодорхойлж, Монголбанканд тайлагнадаг байх зохицуулалтыг оруулсан;
- Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А-90/85 дугаар хамтарсан тушаалаар “Банкийг хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт тавих түр журам”-ыг баталсан. Тус журмын дагуу банкууд 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулагдах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцийг өөрчлөх төлөвлөгөөг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн бөгөөд Монголбанк тус төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа;
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А-104 дүгээр тушаалаар “Банкны системд нөлөө бүхий банкныг тогтоох аргачлал”-ыг батлуулж, тус аргачлалыг үндэслэн мөн өдрийн А-105 дугаар тушаалаар банкны системд нөлөө бүхий банкны жагсаалтыг шинэчлэн баталсан. Ингэснээр Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу нээлттэй хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулагдах шаардлагатай банкуудыг тодорхойлсон;
- Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн А-262/262 дугаар тушаалаар “Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн



хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам"-ыг батлуулсан. Уг журмаар хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахад Монголбанкнаас зөвшөөрөл авах, Монголбанканд мэдэгдэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

- Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу банкны системд нөлөө бүхий банк нээлттэй, бусад банк хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулагдах үүргийг хүлээсэн. Үүний хүрээнд Богд банк сайн дурын үндсэн дээр 2021 оны 4 дүгээр улиралд хувьцаагаа эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэн анхдагч зах зээлийн арилжаагаа амжилттай зохион байгуулж, хуулийн шаардлагыг амжилттай биелүүлсэн анхны банк болоод байна.

**Зорилт 2:** Банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишигт нийцүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн эрүүл, найдвартай банкны тогтолцоог бий болгох.

Банкны тухай хуульд 2018 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц санг урьдчилан (ex-ante) бүрдүүлэх эрх зүйн үндэс тавигдаж, улмаар “Банкны тогтворжуулалтын сангийн журам”-ыг 2021 онд баталснаар банкны системд нөлөө бүхий банкуудаас сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх эрх зүйн боломж бүрдлээ.

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоо болон банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тогтолцоог сүүлийн 20 гаруй жилд бүрдүүлж чадсан нь банкны харилцагч, хадгаламж эзэмшигч, зээлдүүлэгч, хувь нийлүүлэгчдийн хувьд эрсдэлийг бууруулах хоёр тулгуурт тогтолцоо болж чадсан. Банкны тогтворжуулалтын санг бүрдүүлснээр банкны салбарын тогтвортой байдлын гурав дахь тулгуур болох тогтолцоо бий болов.


Ингэснээр банкны салбарт хүндрэл үүсэхэд системээсээ бүрдүүлсэн эх үүсвэрээр бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг санхүүжүүлэх боломж үүслээ. Сангийн үндсэн зорилго нь банкны системд нөлөө бүхий банкинд бүтцийн өөрчлөлт хийх тохиолдолд төрөөс татвар төлөгчдийн мөнгийг зарцуулахгүйгээр банкны системээс хураамжаар бүрдүүлсэн хөрөнгөөр бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг санхүүжүүлж банкны салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэнэ.

Банкны төлбөрийн чадваргүйдэл, дампуурал, бүтцийн өөрчлөлтийн асуудал нь санхүүгийн зах зээл болон олон нийтэд цочрол ихтэй, сөрөг үр дагавартай байдаг тул олон нийтийг аль болох айдас, сандралд оруулахгүйгээр шуурхай, тодорхой шийдвэрлэх нь системийн тогтвортой байдалд ач тустай байдаг.

Банкны бүтцийн өөрчлөлтийг шийдвэрлэхэд ямагт санхүүжилт хэрэгцээтэй байдаг бөгөөд Монгол Улсад урьдчилан байгуулсан сан байдаггүй, тухайн үед нь Монголбанк болон Засгийн газраас санхүүжилтийг шийддэг асуудал сангийн зорилтот түвшинд хүрсэн үед шийдэгдэх хөрс суурь бүрдлээ.

Монгол Улсын хувьд банкны хяналт шалгалт, хадгаламжийн даатгал гэсэн хоёр тулгуурт аргаар банкны системийн олон нийтэд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах зохицуулалтын аргачлалыг ашиглаж байгаа бөгөөд банкны тогтворжуулалтын санг ашиглах нь шинэ, гурав дахь нэмэлт тулгуур аргачлал болох эхлэл боллоо.

Зураг 2.6. Банкны салбарын тогтвортой байдлын баталгааг дэмжих 3 тулгуурт тогтолцоо



Эх сурвалж: Монголбанк

### Монголбанкнаас /Засгийн газартай хамтран/ хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүд

Коронавируст халдвар (Ковид-19)-ын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулж, эдийн засгийг идэвхжүүлэх зорилтын хүрээнд банкуудын зээлийн эрсдэлийг бууруулж, бизнесийн үйл ажиллагаа, ажлын байрыг дэмжих, хөдөө аж ахуйг дэмжих, барилгын салбар, түүний дагалдах салбарыг дэмжих зорилгоор Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 42 дугаар тогтоолоор “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г баталж шат дараатайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.


Тус төлөвлөгөөний 2.1-д тусгагдсан “Ажлын байрыг дэмжих зээл”, 2.3-д тусгагдсан “Ипотекийн зээл”, 2.4-т тусгагдсан “Репо санхүүжилтийн зээл”, 2.5-д тусгагдсан хаврын тариалалт, ноос, ноолуур бэлтгэлийн чиглэлээр “Хөдөө аж ахуйг дэмжих зээл” болон малчдын үйл ажиллагааг дэмжсэн “Малчдыг дэмжих зээл”-ийг банкуудын эх үүсвэрт тулгуурлан олгох, уг зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжид Засгийн газраас хүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасан Засгийн газрын санхүүгийн зуучлагч, банканд хяналт тавих чиг үүрэгтэйгээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Тус ажлын хүрээнд нийт 6.5 их наяд төгрөгийн зээл олгохоор төлөвлөснөөс 4.3 их наяд төгрөгийн зээлийг 62,733 зээлдэгчид олгосон бөгөөд 66 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж, иргэд болон аж ахуйн нэгжийн 144,860 ажлын байрыг дэмжсэн байна.

### Ажлын байрыг дэмжих зээл

Иргэд болон аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаа, ажлын байрыг дэмжих зорилготой “Ажлын байрыг дэмжих зээл”-ийн талаар банкуудаас ирүүлсэн мэдээг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэгтгэхэд банкуудад нийт 6.4 их наяд төгрөгийн 62,965 зээлийн хүсэлт ирснээс 25,439 зээлдэгчид 1,952.6 тэрбум төгрөгийг олгож, хэрэгжилт 97.6 хувьтай байна. Ингэснээр 5,673 аж ахуйн нэгжид 1,293.4 тэрбум төгрөгийн зээл олгож, 80,224 ажлын байр, 19,766 иргэнд 659.1 тэрбум төгрөгийн зээл олгож 28,014 ажлын байрыг тус тус дэмжсэн буюу нийт 108,238 ажлын байрыг дэмжсэн байна. Мөн аж ахуйн нэгжийн зээлийн үндсэн төлбөрийн 60 хувийг зээлийн батлан даалтын сангаар гаргасан 28.2 тэрбум төгрөгийн 208 зээл олгогдсон байна.

Зураг 2.7. Ажлын байрыг дэмжих зээл 2021.12.31-ний өдрийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



### Репо санхүүжилжилтийн зээл

Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зорилготой “Репо санхүүжилжилтийн зээл”-ийн талаар **банкуудаас ирүүлсэн мэдээг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэгтгэхэд** нийт 3,395 харилцагчид 834.9 тэрбум төгрөгийн зээл олгосон. Үүнээс 1,581 иргэний 186.1 тэрбум төгрөгийн зээл, 1,814 аж ахуйн нэгжийн 648.8 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгоод байна. Ингэснээр нийт 36,622 ажлын байрыг дэмжсэн байна.

Зураг 2.8 Репо санхүүжилтийн зээл 2021.12.31-ний өдрийн байдлаар (тэрбум төгрөгөөр)



### Хөдөө аж ахуйн зээл

Хөдөө аж ахуйн зориулалттай хаврын тариалалт, ноос, арьс шир, ноолуур бэлтгэл, махны нөөц бүрдүүлэлт, улаан буудай худалдан авах, малчдыг дэмжих зэрэг нийт 494.3 тэрбум төгрөгийн зээлийг 20,607 харилцагчид зээл олгожээ. Үүнээс орон нутагт 20,221 харилцагчийн 270.7 тэрбум төгрөгийн зээл, Улаанбаатар хотод 386 харилцагчийн 223.6 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгоод байна. Олгосон нийт зээлийн 40.4 хувь буюу 199.6 тэрбум төгрөг малчдыг дэмжих зээл, 8.8 хувь буюу 43.3 тэрбум төгрөг хаврын тариалалтын зээл, 19.2 хувь буюу 94.9 тэрбум төгрөг ноолуур бэлтгэлийн зээл, 8.6 хувь буюу 42.4 тэрбум төгрөг улаан буудай, тосны ургамал худалдан авахад зориулсан зээлд, 19.7 хувь буюу 97.6 тэрбум төгрөг махны нөөц бүрдүүлэхэд зориулсан зээл, 2.7 хувь буюу 13.2 тэрбум төгрөг арьс шир бэлтгэл зориулан, 0.6 хувь буюу 3.2 тэрбум төгрөг ноос бэлтгэлийн зээл тус тус бүрдүүлж байна.


## Хүснэгт 2.3. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр (тэрбум төгрөгөөр)

| №    | Зээлийн төрөл               | Олгосон зээл | Тоо    | Дуусах хугацаа |
|------|-----------------------------|--------------|--------|----------------|
| 1    | Ноолуур бэлтгэл             | 94.9         | 38     | 2021/07/30     |
| 2    | Ноос бэлтгэл                | 3.2          | 4      | 2021/09/30     |
| 3    | Арьс шир бэлтгэл            | 13.2         | 9      | 2021/12/30     |
| 4    | Хаврын тариалалт            | 43.3         | 629    | 2021/10/31     |
| 5    | Махны нөөц бүрдүүлэх        | 97.6         | 46     | 2021/12/31     |
| 6    | Улаан буудай, тосны ургамал | 42.4         | 11     | 2021/12/31     |
| 7    | Малчдыг дэмжих              | 199.6        | 19,870 | 2021/12/31     |
| Нийт |                             | 494.3        | 20,607 |                |

## 2.4 ГАДААД ВАЛЮТЫН УЛСЫН НӨӨЦИЙН УДИРДЛАГА

"Төв банкны тухай хууль"-ийн 21 дүгээр **Зураг 2.9 Төв банкны бодлогын хүү (%)**

зүйлд заасны дагуу Монголбанк гадаад валютын нөөцийн найдвартай байдлыг хангах, хөрвөх чадварыг алдагдуулахгүй байх, дээрх нөхцөлүүд бүрэн хангагдсан тохиолдолд үр өгөөжийг нэмэгдүүлэх гэсэн зарчмын дагуу гадаад валютын улсын нөөц (ГВУН)-ийн удирдлагыг хэрэгжүүлдэг. ГВУН-ийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт нь олон улсын жишигт нийцсэн, оролцогч талуудын эрх, үүргийг нарийвчлан тодорхойлсон давхар хяналтын тогтолцоог бий болгоход чиглэсэн байдаг.



Эх сурвалж: Блүүмберг


Монголбанк 2021 онд ГВУН-ийн бүтцийг хүлээн зөвшөөрөгдөхүйц эрсдэлийн түвшинд баталж, түүний хүрээнд нөөцийн актив, хөрөнгө оруулалтын тохиромжтой хугацаа, хэрэгслүүдийг тус тус тодорхойлон ажиллаа.

Ковид-19 вирусн нөлөөгөөр дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, тодорхойгүй байдал нэмэгдсэн нь олон улсын зах зээлийн хөрөнгө оруулалтын орчинг тогтворгүй болгосон. Дэлхийн олон улсын Төв банкууд эдийн засгийн тодорхойгүй байдлыг харгалзан мөнгөний зөөлөн бодлого баримталж, эдийн засгийн өсөлтийг дэмжив. Тайлант онд АНУ-ын Холбооны нөөцийн банк, Европын төв банк болон Английн төв банк бодлогын хүүгээ 0 орчимд тогтвортой хадгалжээ. (Зураг 2.9).

Монголбанкнаас валютын нөөцийг дэлхийн эдийн засагт тэргүүлэгч АНУ, Япон, Франц, Англи зэрэг орнуудын Төв банк, Засгийн газар, Олон улсын төлбөр тооцооны банк зэрэг зээлжих зэрэглэл өндөртэй байгууллагуудад харилцах, хадгаламж, үнэт цаас хэлбэрээр байршуулж удирдлаа. Харин нөөцийн урт хугацаат багцыг АНУ-ын Засгийн газар, олон улсын санхүүгийн корпорацийн 0-5 жилийн хугацаатай үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх замаар удирдаж, олон улсын бенчмарк өгөөжийг давуулан биелүүлэв.

Монголбанкны дотоодын зах зээлээс худалдан авсан алтны хэмжээ 20.8 тн хүрч, өмнөх оны үзүүлэлтээс 12 хувиар буурлаа. Олон улсын зах зээлд алтны үнэ өндөр байсан тул нөөцөд эзлэх мөнгөжсөн алтны багцын хэмжээг хэвээр хадгалж, голч түвшнөөс дээгүүр удирдаж ажилласан.

Зураг 2.10 Гадаад валютын улсын нөөц (сая ам.доллар) ба импортын хэрэгцээг хангах түвшин (сараар)



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын улсын нөөц 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4,366.1 сая ам.долларт хүрч, оны эхнээс 3.71 хувиар буюу 168.2 сая ам.доллараар буурсан. Энэхүү үзүүлэлт нь:

- Валютын төлбөртэй барааны импортын сүүлийн 3 сарын дундаж гүйцэтгэлээр авч үзэхэд 8.6 сарын буюу 34.6 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд,
- Валютын төлбөртэй бараа болон үйлчилгээний импортын сүүлийн 3 сарын дундаж гүйцэтгэлээр авч үзэхэд 6.6 сарын буюу 26.5 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд,

тус тус байгаа нь олон улсын жишиг доод түвшин болох импортын 3 сарын буюу 12 долоо хоногийн хэрэгцээнээс 2-5 сараар өндөр байна (Зураг 2.10). Харин Монгол Улсын Их хурлын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн үзэл баримтлалд заасан “ГВУН нь валютын төлбөртэй импортын нэг жил буюу 52 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшнөөс багагүй байх” тухай шаардлагыг хангахгүй байна.

## 2.5 МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

Монгол Улсын хэмжээнд зах зээлийн 60 орчим хувийг эзэлж байгаа үндэсний брэнд ₮ картыг EMV чип технологид шилжүүлсэн амжилтаараа Монголбанк нь “Bloomberg TV Mongolia Awards 2021”-ийн “Шилдэг инновац” шагналыг хүртлээ. Технологийн энэ шинэчлэлийг нэвтрүүлснээр ₮ картын нууцлал, аюулгүй байдал олон улсын жишигт хүрч, картын мэдээллийг токенжуулан нийтийн тээвэр, автомашины зогсоол, замын төлбөр зэрэг үнийн дүн багатай гүйлгээг хийхдээ картаа зайнаас уншуулж төлбөр тооцоо гүйцэтгэх боломж нээгдсэн. Түүнчлэн, олон улсын ISO/IEC 7816-5 буюу “Нэгдсэн хэлхээний картын стандарт”-ыг үндэсний стандартаар батлуулсан бөгөөд ₮ картны чипэнд харилцагчийн хувийн болон санхүүгийн мэдээллийг өөрийн орны төлбөрийн системийн онцлогт тохирсон аппликейшныг боловсруулж, ашиглах боломж бий болж байна. Ингэснээр, банкууд, финтекүүдэд төлбөр тооцооны шинэ үйлчилгээ нэвтрүүлэх суурь систем хөгжүүлэх давуу талтай бөгөөд цаашид чиптэй ₮ картаа ашиглан QR кодоор гүйлгээ хийх, ₮ картын мэдээллийг токенжуулах (tokenization) зайн технологийг нэвтрүүлэх суурь тавигдаж байна.



Монголбанк нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах зорилтынхоо хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайд, Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга, Хадгаламжийн Даатгалын Корпорацийн гүйцэтгэх захирлын хамтарсан тушаалаар “Сэндбокс орчны зохицуулалтын журам”-ыг баталсан. Энэ журам нь төлбөр тооцооны системд дэвшилтэд шийдлийг нэвтрүүлэхийг зорьж буй финтек байгууллагыг дэмжих зорилготой юм. Үүнтэй уялдуулан Монголбанк нь Инновацийн оффисыг 2021 онд байгуулсан бөгөөд олон нийтэд шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулах финтек байгууллагатай хууль, эрхзүйн орчин, дэд бүтцийн шийдлийн талаар санал солилцох, шаардлагатай тохиолдолд програм, техник хангамжийн туршилтыг хийх орчныг бий болголоо.

Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар “QR кодын мессежний бүтэц, заавар”-ыг баталсан бөгөөд төлбөрийн системийн нийт оролцогч 2022 оны 5 дугаар сараас эхлэн мөрдөн ажиллана. Энэ тушаалаар QR код ашиглан хийх худалдан авалтын бүх гүйлгээнд харилцагчаас шимтгэл авахгүй байхаар тусгасан. Ингэснээр, олон улсын жишигт нийцсэн, дэвшилтэт технологид суурилсан төлбөрийн шинэ сувгаар илүү хялбар, хурдан, нууцлалын өндөр төвшинд төлбөр тооцоог гүйцэтгэх боломж бүрдэнэ.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал, технологийн дэвшил болон эдийн засгийн бусад нөлөөллөөс шалтгаалж бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээ дэлхий даяар өсөж байна. Төлбөрийн карт болон бага дүнтэй гүйлгээний тоон үзүүлэлтээс харахад картын гүйлгээний өдрийн дундаж тоо 2020 онд 555,000 ширхэг байсан бол 2021 онд 827,000 ширхэг болон өсөж өмнөх оны мөн үеэс 49 хувиар, бага дүнтэй гүйлгээний өдрийн дундаж тоо 177,000 ширхэг байсан бол 2021 онд 268,000 ширхэгт хүрч өмнөх онтой харьцуулахад 52 хувиар тус тус өссөн байна. Манай улсын хувьд энэ хандлага илүү цахимжсан буюу төлбөрийн картаа зайнаас уншуулах, интернэт, мобайл банк, QR кодоор гүйлгээ хийх зэргээс харилцагч өөртөө ашиглахад хялбарыг сонгож санхүүгийн үйлчилгээ авах дэд бүтэц хэдийнээ бий болсон.

Монголбанкны санаачилгаар гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд банк хоорондын бага дүнтэй (бодит цагийн) гүйлгээний харилцагчийн төлөх шимтгэлийг 200 төгрөг болгож бууруулсан. Энэ шийдвэр нь нэг талаас харилцагчийн төлөх шимтгэлийг тодорхой хэмжээгээр бууруулах, цахим суваг ашиглан төлбөр тооцоо гүйцэтгэхийг идэвхжүүлэх, нөгөө талаас үндэсний төлбөрийн системийн оролцогч үйл ажиллагааны найдвартай, үр ашигтай, аюулгүй байдлыг хангаж ажиллах, гүйлгээний даацыг нэмэгдүүлэх хөшүүрэг болж байна.

Цар тахлын үед авч хэрэгжүүлж байгаа бас томоохон шийдвэрийн нэг нь Автомат клиринг хаус систем (ACH+)-ээр бодит цагийн горимд дамжих гүйлгээний мөнгөн дүнгийн дээд хязгаар 3 сая төгрөг байсныг 5 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн явдал юм. Бидний зүгээс судалгааг ACH+ системээр дамжих гүйлгээний мөнгөн дүнгийн дээд хязгаарыг 4 эсхүл 5 сая төгрөг болгон нэмэгдүүлэхэд системд ачаалал, эрсдэл үүсэх эсэх, төгрөгийн ханш, дундаж цалинтай харьцуулсан хүчин зүйлсийг чухалчилж үзсэн. Ингэснээр, банк хоорондын 5 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй гүйлгээ харилцагчийн дансанд бодит цагийн горимоор шууд тусгагдахын зэрэгцээ иргэд, жижиг, дунд бизнес эрхлэгчид бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ төлбөрийг нэг удаа өндөр дүнтэй, бага шимтгэлтэй гүйлгээгээр хийх боломжтой болсон.

Монголбанкнаас Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Төлбөрийн системийн шинэчлэл төслийн хүрээнд төлбөрийн картын системийн шинэчлэлийг 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр амжилттай нэвтрүүлсэн. Тус систем нь гүйлгээ боловсруулах өндөр хурд, хүчин чадалтай бөгөөд системийн ачаалал даах, олон тооны шинэ төрлийн гүйлгээг дэмжих, нууцлал аюулгүй байдлыг хангах чадамжтай олон улсын стандартад нийцсэн цогц систем юм. Систем нэвтэрснээр оролцогчид нөөцөө урьдчилан тооцоолж, дансанд тусгаарлан байршуулж удирдах, маргаантай болон алдаатай гүйлгээг илрүүлсэн агшинд харилцан тохиролцож, холбогдох залруулгын гүйлгээг өөр хоорондоо үүсгэн шийдвэрлэх боломжтой болсон зэрэг давуу тал бий болж байна.

Монголбанк нь бага дүнтэй төлбөрийн системийг бүрэн шинэчилж, АСН+ буюу Автомат клиринг хаус пласийн үндсэн системийг 2019 онд нэвтрүүлсэн билээ. Тайлант хугацаанд энэхүү шинэчлэлийг үргэжлүүлж, тус системийн томоохон дэд бүрэлдэхүүн хэсэг болох дансны нэгдсэн санг (ДНС) нэвтрүүлсэн нь хэрэглэгчийн дансны нэр, дугаар бүхий мэдээллийг системд бүртгэлжүүлж, төлбөр гүйцэтгэхээс өмнө мэдээллийн лавлагааг баталгаажуулан банк хоорондын төлбөр тооцоонд ашиглах боломжтой болсон. Дансны нэр, дугаар зөрөх шалтгаанаар өдөрт дунджаар 20,000 орчим гүйлгээ цуцлагддаг байсан бол DNS-г ашигласнаар алдаатай гүйлгээний тоо эрс буурсан байна. Одоогоор DNS-д системийн 16 оролцогчийн 11 сая гаруй данс бүртгэгдээд байна.

Сүүлийн жилд Монголбанкнаас хэрэгжүүлж буй томоохон төслүүдийн нэг бол Мобайл төлбөр тооцооны токен систем нэвтрүүлэх ажил юм. Тус системийг нэвтрүүлснээр картын мэдээллийг гар утсандаа бүртгүүлж, мобайл хэтэвч байдлаар ашиглан, зайнаас төлбөр тооцоог хурдан шуурхай, аюулгүй гүйцэтгэж, картын мэдээлэл алдагдах болон залилан, луйврын гүйлгээний эрсдэл буурах юм. Түүнчлэн банк, санхүүгийн байгууллагууд гар утсаар гүйлгээ хийх болон токен үйлчилгээний нэгдсэн системийн үйлчилгээг авч, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын давхардсан зардлыг хэмнэх боломжтой. Одоогийн байдлаар систем нийлүүлэгч байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулан нэвтрүүлэлтийн ажлыг эхлүүлээд байна.

Тайлант хугацаанд Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ)-д Мэдээллийн аюулгүй байдлын хяналтын төвийг байгуулж, нууцлал аюулгүй байдлыг хянах, үнэлгээ хийх, цахим халдлагаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах зориулалт бүхий цогц систем, програм хангамжийг амжилттай нэвтрүүлээд байна. Төлбөр тооцооны систем хурдацтай хөгжиж, цахим төлбөрийн хэрэглээ нэмэгдэхийн хэрээр мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах асуудал чухлаар хөндөгдөж байна. Системийг нэвтрүүлснээр банк, оролцогч хоорондын төлбөрийн системийн болон нэгдсэн сүлжээний нууцлал аюулгүй байдлыг өндөр төвшинд хангаж, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой юм.

Мөн Төлбөрийн системийн шинэчлэл төслийн хүрээнд Үндэсний брэнд ₮ картын EMV/NFC стандартын 460,000 ширхэг бэлдцийг карт гаргагч банкуудад хөнгөлөлттэй үнээр нийлүүлээд байна.

### **Төлбөрийн системийн хяналт, зөвшөөрөл**

Монголбанк Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн хүрээнд Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагааны журам, Төлбөрийн картын журам, Цахим мөнгөний журмын дагуу энэ онд нийт 12 зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авсан. Зөвшөөрөл авахаар ирүүлсэн баримт бичгийг судалж үзэн дараах байдлаар шийдвэрлэсэн. Үүнд:

Олгосон зөвшөөрөл:

- Төлбөрийн карт гаргах, хүлээн авах зөвшөөрлийг 1 байгууллагад;
- Төлбөрийн хэрэгсэл – цахим мөнгө гаргах зөвшөөрлийг 2 байгууллагад;
- Хөдөлгөөнт банкны процессорын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 байгууллагад;
- Төлбөрийн картын процессорын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 банк, 1 байгууллагад;
- Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрлийг 1 банканд тус тус олгосон байна.

Харин цахим мөнгө гаргах хүсэлт гаргасан 1, систем ажиллуулах 1 байгууллага, төлбөрийн карт гаргах хүлээн авах зөвшөөрөл хүссэн 1 байгууллагад хууль, журмын шаардлага хангаагүй тул холбогдох зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэр гарсан.

Монголбанк нь оператор болон оролцогчийн эрх зүйн баримт, мэдээлэл, статистик үзүүлэлтүүдийг тодорхой давтамжтайгаар цуглуулж, дүрэм, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж

байна. Газар дээр хийсэн шалгалтын үр дүнг системийн найдвартай, үр ашигтай байдлын үнэлгээнд ашигладаг. Төлбөрийн системийн оролцогчдыг хамруулсан газар дээрх шалгалтыг 2021 онд дараах байдлаар хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Төв банкны хариуцсан төлбөрийн системийн операторын үйл ажиллагааны шалгалт /Банксүлжээ систем, ҮЦГТ-ийн бага болон картын клирингийн систем/;
- Бусад төлбөрийн системийн операторын үйл ажиллагааны шалгалт /ХХБ-ны картын клирингийн систем/;
- Төлбөрийн системийн оролцогчийн үйл ажиллагааны шалгалт (банкуудын иж бүрэн шалгалт);
- Төлбөрийн картын процессорын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудын шалгалт;
- Цахим мөнгөний үйл ажиллагааны иж бүрэн шалгалт.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд мэдэгдэж, залруулах талаар хянан шалгагч нар өөрийн бүрэн эрхийн хүрээнд арга хэмжээ авч ажиллалаа. Монгол Улсад цар тахал бүртгэгдсэн нөхцөл байдалтай уялдуулан зарим шалгалтыг анх удаа зайнаас хийж гүйцэтгэсэн.

ОУТТБ-аас гаргасан Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн 24 зарчим, 5 үүрэг хариуцлагын хэрэгжилт их дүнтэй төлбөрийн системийн түвшинд хэрхэн хангагдаж байгааг тодорхойлж, хэрэгжилтийн түвшинг ахиулж, тогтмол хангуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Банксүлжээ систем болон Төв банкны үнэт цаасны системд үнэлгээг хийсэн. Банксүлжээ системийн үнэлгээний үр дүнгээс харахад дэд бүтцийн 24 зарчмын 13 зарчим хэрэгжсэн, 4 зарчим ерөнхийдөө хэрэгжсэн, 1 зарчим хэсэгчлэн хэрэгжсэн, 7 зарчим хамааралгүй ба Төв банкны үнэт цаасны системийн үнэлгээний хувьд 24 зарчмын 13 зарчим бүрэн хэрэгжсэн, 4 зарчим ерөнхийдөө хэрэгжсэн, 7 зарчим хамааралгүй байна.

Төлбөрийн системийн оролцогч хоорондын 2021 оны гүйлгээний нийт тоо, дүнг өмнөх онтой харьцуулбал гүйлгээний тоо 50.2 хувиар, гүйлгээний дүн 46.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Төлбөрийн системийн оролцогч хоорондын 2020-2021 оны байдлаарх их, бага дүнтэй гүйлгээний тоон үзүүлэлтийг Хүснэгт 2.4, өсөлт бууралтыг Зураг 2.10-т үзүүлэв.

**Хүснэгт 2.4 Банк хоорондын 2020-2021 оны гүйлгээний тоо, дүн (мянган ширхэг, их наяд төгрөг)**

|                   | 2020 он  |       | 2021 он   |            |       |            |
|-------------------|----------|-------|-----------|------------|-------|------------|
|                   | Тоо      | Дүн   | Тоо       | Өөрчлөлт % | Дүн   | Өөрчлөлт % |
| I улирал          | 17,375.0 | 67.4  | 25,791.1  | 48.4%      | 109.4 | 62.2%      |
| RTP <sup>1</sup>  | 12,599.9 | 3.1   | 19,008.1  | 50.9%      | 4.3   | 39.3%      |
| ACH <sup>2</sup>  | 4,454.9  | 0.2   | 6,402.9   | 43.7%      | 0.9   | 281.5%     |
| RTGS <sup>3</sup> | 320.2    | 64.2  | 380.0     | 18.7%      | 104.3 | 62.5%      |
| II улирал         | 22,014.9 | 84.5  | 35,907.2  | 63.1%      | 135.0 | 59.8%      |
| RTP               | 15,498.3 | 3.7   | 22,949.2  | 48.1%      | 5.52  | 51.2%      |
| ACH               | 6,113.6  | 0.6   | 12,421.1  | 103.2%     | 2.44  | 280.5%     |
| RTGS              | 403.1    | 80.2  | 536.9     | 33.2%      | 127.0 | 58.4%      |
| III улирал        | 24,626.8 | 91.3  | 32,633.7  | 32.5%      | 125.0 | 36.8%      |
| RTP               | 17,435.7 | 4.07  | 25,377.5  | 45.6%      | 6.1   | 50.1%      |
| ACH               | 6,764.7  | 0.61  | 6,664.8   | -1.5%      | 0.9   | 45.0%      |
| RTGS              | 426.4    | 86.7  | 591.4     | 38.7%      | 118.0 | 36.1%      |
| IV улирал         | 24,302.6 | 109.5 | 38,278.9  | 57.5%      | 147.6 | 34.8%      |
| RTP               | 17,705.5 | 4.12  | 30,815.8  | 74.1%      | 7.68  | 86.4%      |
| ACH               | 6,171.8  | 0.87  | 6,767.9   | 9.7%       | 1.07  | 23.3%      |
| RTGS              | 425.2    | 104.5 | 695.3     | 63.5%      | 138.9 | 32.9%      |
| Нийт              | 88,319.3 | 352.7 | 132,610.9 | 50.2%      | 516.9 | 46.6%      |

<sup>1</sup> RTP – Бага дүнтэй төлбөрийн систем (бодит цагийн гүйлгээ)


<sup>2</sup> ACH – Бага дүнтэй төлбөрийн систем (багцын гүйлгээ)

<sup>3</sup> RTGS – Банксүлжээ буюу их дүнтэй төлбөрийн систем



|            |          |       |          |       |        |        |
|------------|----------|-------|----------|-------|--------|--------|
| RTP        | 63,239.4 | 14.9  | 98,150.6 | 55.2% | 23.6   | 58.2%  |
| эзлэх хувь | 71.6%    | 4.2%  | 74.0%    |       | 4.6%   |        |
| ACH        | 23,505.0 | 2.4   | 32,256.7 | 37.2% | 5.3    | 124.7% |
| эзлэх хувь | 26.6%    | 0.6%  | 24.3%    |       | 1.02%  |        |
| RTGS       | 1,574.9  | 335.5 | 2,203.6  | 39.9% | 488.1  | 45.5%  |
| эзлэх хувь | 1.8%     | 95.1% | 1.7%     |       | 94.42% |        |

Зураг 2.11. Банк хоорондын 2020-2021 оны гүйлгээний тоо, дүн



Зураг 2.11-с үзэхэд гүйлгээний тоо, дүн өмнөх оны мөн үеүдтэй харьцуулахад тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал, технологийн дэвшил болон эдийн засгийн бусад нөлөөллөөс шалтгаалж бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээ өссөнтэй холбоотой юм. Тайлант оны эцэст 38.3 сая ширхэг 147.7 их наяд төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны эцсээс 14 сая ширхэг, 38.2 их наяд төгрөгөөр өсжээ.

### Төлбөрийн карт

Төлбөрийн картын хэрэглээний үзүүлэлт өсөж байгаа нь бэлэн бус төлбөрийн хэрэгслийг өдөр тутмын төлбөр тооцоонд ашиглах иргэдийн сонирхол өндөр болж байгааг харуулж байна. Банкууд ₮ карт, Виза, Мастеркарт, Юнионпэй, Американ экспресс болон Жэй Си Би гэсэн 6 төрлийн төлбөрийн картыг өөрийн оноосон нэрээр гаргаж байна. Энэ оны байдлаар нийт картын 59.1 хувийг үндэсний брэнд ₮ карт дангаар эзэлж, зах зээлд түлхүү ашиглагдаж байгааг Хүснэгт 2.5-с харж болно.

Хүснэгт 2.5 Төлбөрийн картын болон төхөөрөмжийн тоо 2018-2021 он

| Картын хэрэглээний тоо (сая ширхэг)                | 2018 он | 2019 он | 2020 он | 2021 он | Өсөлт (%) |
|----------------------------------------------------|---------|---------|---------|---------|-----------|
| Картын тоо                                         | 4.3     | 3.7     | 4.1     | 4.4     | 7.3%      |
| Идэвхитэй ашиглагдаж буй картын тоо                | 1.6     | 1.9     | 1.9     | 2.2     | 15.8%     |
| <b>Картын тоо - картын төрлөөр (мянган ширхэг)</b> |         |         |         |         |           |
| ₮ карт                                             | 3,115.6 | 2,600.8 | 2,594.6 | 2,600.3 | 0.2%      |
| Виза                                               | 680.1   | 392.7   | 519.0   | 661.6   | 27.5%     |
| Мастеркарт                                         | 28.4    | 76.3    | 123.4   | 151.3   | 22.6%     |
| ЮнионПэй                                           | 458.0   | 664.6   | 828.0   | 1,022.3 | 23.5%     |
| Амекс                                              | 7.3     | 4.5     | 4.1     | 3.5     | (13.7%)   |
| ЖейСиБи                                            | 1.8     | 9.2     | 8.7     | 7.3     | (16.4%)   |
| <b>Төхөөрөмжийн тоо<sup>4</sup></b>                |         |         |         |         |           |
| ПОС                                                | 42,014  | 59,703  | 70,753  | 84,302  | 19.1%     |

<sup>4</sup> Төхөөрөмжийн ангиллыг 2019 оны дөрөвдүгээр улирлаас эхлэн 9 төрлөөр бүртгэж эхэлсэн

|                 |       |       |       |       |         |
|-----------------|-------|-------|-------|-------|---------|
| МПОС            | 3,784 | 2,803 | 2,036 | 105   | (94.8%) |
| ПОБ             | 2,177 | 2,242 | 2,915 | 2,844 | (2.4%)  |
| АТМ             | 2,358 | 1,259 | 1,084 | 1,049 | (3.2%)  |
| СДМ             | -     | 388   | 42    | 19    | (54.8%) |
| СРМ             | -     | 1,674 | 1,595 | 1,764 | 10.6%   |
| Цахим худалдаа  | -     | 773   | 1,112 | 5,008 | 350.4%  |
| КИОСК (пос-той) | -     | 163   | 264   | 584   | 121.2%  |
| Бусад           | -     | 0     | 0     | 0     | -       |

Хүснэгт 2.6-аас үзэхэд тайлант онд төлбөрийн картын тоо 7.3 хувиар, картыг идэвхтэй ашиглагчийн тоо 15.8 хувиар тус тус өссөн байна. Төхөөрөмжийн тоон мэдээг авч үзэхэд ПОС төхөөрөмжийн тоо өмнөх оноос 19.1 хувиар өссөн нь бараа үйлчилгээний төлбөр тооцоог төлбөрийн картаар буюу бэлэн бусаар хийх боломж нэмэгдсэнийг харуулж байна.

Хүснэгт 2.6 Төлбөрийн картын гүйлгээний тайлан 2020-2021 он (мянган ширхэг, тэрбум төгрөг)

| № | Төхөөрөмж       | Утга | 2020 он    | 2021 он   | Өсөлт/бууралт | Өсөлт/бууралт хувиар |
|---|-----------------|------|------------|-----------|---------------|----------------------|
| 1 | ПОС             | Тоо  | 371,838.1  | 489,852.6 | 118,014.5     | 31.4%                |
|   |                 | Дүн  | 8,641.0    | 12,640.7  | 3,999.7       | 46.3%                |
| 2 | МПОС            | Тоо  | 102.5      | 23.2      | (79.3)        | (77.4%)              |
|   |                 | Дүн  | 3.1        | 0.8       | (2.3)         | (73.5%)              |
| 3 | ПОБ             | Тоо  | 1,390.1    | 1,019.9   | (370.2)       | (26.6%)              |
|   |                 | Дүн  | 331.5      | 258.3     | (73.2)        | (22.1%)              |
| 4 | АТМ/СРМ/СДМ     | Тоо  | 105,566.3  | 81,563.2  | (24,003.0)    | (22.7%)              |
|   |                 | Дүн  | 27,162.3   | 28,394.9  | 1,232.6       | 4.5%                 |
| 5 | Цахим худалдаа  | Тоо  | 1,555.2    | 3,629.8   | 2,074.6       | 133.4%               |
|   |                 | Дүн  | 109.1      | 260.1     | 151.0         | 138.4%               |
| 6 | КИОСК (пос-той) | Тоо  | 323.2      | 838.8     | 515.6         | 159.5%               |
|   |                 | Дүн  | 7.5        | 20.5      | 13.0          | 173.6%               |
| 7 | Бусад           | Тоо  | 0.0        | 0.0       | -             | -                    |
|   |                 | Дүн  | 0.0        | 0.0       | -             | -                    |
|   | Нийт (Улс)      | Тоо  | 480,775.47 | 480,775.5 | 576,927.6     | 96,152.1             |
|   |                 | Дүн  | 36,254.41  | 36,254.4  | 41,575.3      | 5,320.9              |

Гүйлгээний үзүүлэлтийн хувьд тайлант онд ПОС төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний тоо хамгийн өндөр буюу 489.9 сая ширхэг байна. Харин гүйлгээний дүнгийн хувьд АТМ, СРМ, СДМ төхөөрөмжүүдээр хийгдсэн гүйлгээний дүн хамгийн их буюу 28.4 их наяд төгрөгийн үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс хамгийн их хэрэглээ нь өссөн төхөөрөмж нь киоск байсан ба гүйлгээ нь 159.5 хувиар, гүйлгээний дүн нь 173.6 хувиар тус тус өссөнийг Хүснэгт 2.6-т зааснаар харж болно.

## 2.6 БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ШИНЭЧЛЭЛ, ӨӨРЧЛӨЛТ

Тайлант оны туршид Монголбанкнаас Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасан үндсэн зорилт, эрхлэх үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн суурь нөхцөл болсон банк санхүү, эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх чиглэлээр хууль тогтоомжийг шинэчлэлийг үргэлжлүүлэв. Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл”-д Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах зорилгоор Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын зөвлөмжтэй үндэсний хууль тогтоомжийг уялдуулах, санхүүгийн гэрээ, хэлцлээс үүдсэн хэрэг, маргааныг богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх болон санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохоор заасан билээ.

Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээ авах олон улсын байгууллага (ФАТФ)-ын зөвлөмжийн нийцлийг хангаж, эрсдлийн харилцан үнэлгээний үр дүнг дээшлүүлэх хүрээнд Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөл, холбогдох судалгааг боловсруулж хууль санаачлагчид уламжилсан. Тус хуулийн төслөөр виртуал хөрөнгө, хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг, тэдгээрт тавигдах нийтлэг болон нэмэлт шаардлагыг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлж, үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх, хяналтын механизмыг бий болгох тухай тусгасан. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийн УИХ-ын 2021 намрын ээлжит чуулганаар баталсан бөгөөд Монгол Улсад виртуал хөрөнгийн салбарын хууль, эрх зүйн орчин бүрдэж, ФАТФ-ын зөвлөмжийг биелүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын тогтолцоо бүрдэх үндэс бүрдээд байна.

Монгол Улсын банкны салбарын одоогийн нөхцөлд байдалд шинжилгээ хийсэн судалгааны үр дүнг харгалзан хууль, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах хэрэгцээ, шаардлагын хүрээнд банкны хувьцаа эзэмшлийн хэт төвлөрлийг бууруулж өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх, үүнд компанийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд банкны үйл ажиллагааг хувьцаат компани хэлбэртэйгээр явуулах шаардлагыг тогтоосон дараах агуулга бүхий Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг УИХ-аас 2021 оны намрын ээлжит чуулганы хуралдаанаар баталлаа.

Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги” бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд зээлийн эх үүсвэр болон үйл ажиллагааны зардлыг бууруулах, харилцагч, хадгаламж эзэмшигчийн хууль ёсны эрхийг хамгаалах зорилгоор банк, эрх бүхий этгээдээс иргэд, хуулийн этгээдэд санал болгож байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоох, зээл олгоход баримтлах суурь зарчим, бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг үндэслэлтэй тогтоохтой холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулсан Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг УИХ-ын 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар баталж, мөн оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байна. Монголбанкнаас тус хууль батлагдсантай холбоотойгоор зээл олголтын журам, барьцаа хөрөнгийн үнэлгээний журмын төслийг боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу баталж мөрдүүлэх юм.

Тус стратегийн баримт бичгийн хүрээнд Монголбанкнаас үүргийн гүйцэтгэлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хангуулахад гардаг аливаа хүндрэлийг бууруулах зорилгоор Хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Санхүүгийн түрээсийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Татварын багц хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Хөдлөх хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн саналыг боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А-411 дүгээр тушаалаар байгуулж, хууль тогтоомжид заасан хэрэгцээ шаардлагын тандан болон үр нөлөө, зардлын холбогдох судалгааг хийж, судалгаанд үндэслэсэн хууль эрх зүйн орчны шинэчлэлийг үргэлжлүүлээ.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн 2.2 дахь хэсэгт заасан санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах үндсэн зорилтын хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А-6 дугаар тушаалаар “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн зүгээс 2021 онд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Азийн хөгжлийн банк (АХБ)-тай хамтарсан “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах салбарын хөгжлийг дэмжих, мэдлэг олгох техникийн туслалцаа”-ны төслийн хүрээнд “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийн саналыг дотоод болон гадаад мэргэжилтэн зөвлөхийн туслалцаатайгаар дахин шинэчлэн боловсруулж, хууль санаачлагчид уламжлаад байна.

Банк санхүүгийн салбарыг технологийн шинэчлэлтэй уялдуулан цахим шилжилтийг эрчимжүүлэх, түүнийг оновчтой зохицуулж банкны салбарын хөгжлийг дэмжих салбар хоорондын хууль тогтоомжийг Улсын Их Хурлаас баталсан болно. Үүнд, санхүүгийн зуучлалын хурдан шуурхай хүргэх тухай Цахим гарын үсгийн тухай, банкны харилцагчдийн мэдээллийн нууцлалыг хангахтай холбогдсон Хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын тухай, төрийн болон хувийн хэвшлийн мэдээллийн дэд бүтцийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон Кибер аюулгүй байдлын тухай хуулийг тус тус баталжээ.

## 2.7 ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд иргэдийн санхүүгийн зах зээлд ухаалгаар оролцох оролцоог нэмэгдүүлэх, оновчтой шийдвэр гаргалтыг дээшлүүлэх зорилгоор Монголбанк, Сангийн яам, БСШУЯ, Санхүүгийн Зохицуулах Хороо хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг 2016 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөтөлбөрийг холбогдох төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран тэргүүлэх 4 чиглэлээр буюу сургуулийн насанд, залуу үед, хөдөө орон нутгийн иргэд болон цахим хуудас, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг хэрэгжүүлж байна. Мөн түүнчлэн Монголбанк, ХХААХҮЯ хамтран Бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ үзүүлэгчдэд санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлд анхаарал хандуулан дунд хугацааны төлөвлөгөөг хамтран баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Санхүүгийн боловсрол дээшилснээр дараах голлох үр дүнд хүрнэ:

- Иргэдийн санхүүгийн бүтээгдэхүүний талаарх ойлголт нэмэгдэж, илүү үр дүнтэй ашиглана;
- Иргэд өөрийн хэрэгцээнд тохирсон, зөв бүтээгдэхүүн сонгох боломжтой болно;
- Санхүүгийн залилангаас урьдчилан сэргийлж, түүнд өртөх иргэдийн тоо буурна;
- Иргэдийн хадгаламж нэмэгдэж, чанаргүй зээлийн түвшин багасна;
- Хөрөнгийн зах зээл дэх оролцоо, хөрөнгө оруулалт өснө.

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах гол сэдвүүдэд чиглэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн талаар суурь ойлголтууд;
- Төсөв болон санхүүгийн төлөвлөлт;
- Хадгаламж;
- Зээл;
- Финтек ба Криптовалют;
- Хөрөнгө оруулалт;
- Санхүүгийн эрсдэлээс хамгаалах (Даатгал гэх мэт);
- Тэтгэврийн хуримтлал үүсгэх;
- Нийгмийн даатгал болон татварын талаар ойлголтууд;
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаар ойлголтууд.

2021 онд тус хөтөлбөрийн хүрээнд дараах ажлууд хийгдсэн болно. Үүнд:

## Хууль эрх зүйн орчин

### *Монгол Улсын Засгийн газар*

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 299 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын санхүүгийн салбарыг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн зорилго 6.2 “Монгол Улсын иргэд өөрийн болон өрхийн санхүүгээ зохистой удирдах мэдлэг, чадвар болон итгэл үнэмшилтэй болгоно” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### *Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл*

2020 оны 11 дугаар сарын 05-ны өдрийн УИХ-ын “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 32-р тогтоолын зорилт 3.3 “Санхүүгийн хүртээмжийг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх зорилгоор иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх” хэмээн тусгагдсаныг хэрэгжүүлж ажиллалаа.

### *Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл*

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5-р зүйлийн 1.7-д “Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” гэж заасны дагуу Монголбанкнаас бусад байгууллагуудтай хамтран санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт зохих саналыг тусган ажиллаж байна.

Энэ хуулийн зорилт нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн хэрэглэгчтэй харилцах, Санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүн санал болгох, нийлүүлэхэд тавигдах шаардлагыг тогтоох, мөнгө хүүлэлтийн эсрэг зээлдэгчийн эрх болон санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах, түүнтэй холбоотой гомдол, маргааныг хянан шийдвэрлэх, олон нийтэд санхүүгийн боловсрол олгох замаар санхүүгийн зах зээлийн зохистой хөгжил, хүртээмж, чадамжийг дээшлүүлэхэд оршино.

### *Зээлийн хүүг бууруулах стратеги*

СТБЗ-ийн зөвлөмжөөр Монголбанкнаас “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023”-ийг хэрэгжүүлж байгаа ба уг стратегийн 11 дэх Зорилтод “Санхүүгийн байгууллага, тэдгээрийн хэрэглэгч болон олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх” заалт, УИХ-ын 21 дугаар тогтоолоор батлагдсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах чиглэлд “Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх” заалтыг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.

## Сургуулийн насны хүүхдүүдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад санхүүгийн боловсрол олгох “Бизнес судлал” хичээлийг сонгон судлахаар БСШУ-ны сайдын 2019 оны А/491 тоот “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалыг баталсан. Уг тушаалын хэрэгжилтийг хангаж ЕБС-ийн нийгмийн ухааны багш нар “Бизнес судлал” хичээлийг зааж байгаа ба Монголбанкнаас энэхүү ажилд дэмжин ажиллаж байна.
- Хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, түүнд олон нийтийн анхаарлыг хандуулах зорилготойгоор жил бүр зохион байгуулагддаг “Дэлхийн мөнгөний долоо хоног” аян 2021 онд “Суралц-Хуримтлуул-Өсгө” уриан дор 3 дугаар сарын 22-оос 4 дүгээр сарын 12-ны өдрийн хооронд зохион байгуулагдлаа. Тус аянд Монголбанк БШУЯ, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын банкны холбоо, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Насан туршийн боловсролын үндэсний төв, ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сан болон арилжааны банкууд хамтран оролцсон бөгөөд нээлтийн үйл ажиллагааг цар тахалтай холбоотой

цахимаар зохион байгуулсан юм. Аяны хүрээнд Монголбанк оролцогч талуудын хамт “Монгол Улс дахь санхүүгийн боловсролын өнөөгийн байдал ба цаашдын хандлага” сэдэвт хэлэлцүүлэг хийв. Мөн орон даяар хүүхэд багачуудын дунд хуримтлалын ач холбогдлыг таниулах тик-ток, гар зураг, эсээ бичлэг зэрэг нийтдээ 20,000 бүтээлийг хамарсан 80 гаруй уралдаан тэмцээн, “Мөнгөө хэрхэн удирдах вэ?”, “Хувь хүний санхүү ба өрхийн төсөв”, “Зардал ба хуримтлал”, “Цахим мөнгө” зэрэг сэдвээр 117 мянган ЕБС-ийн сурагч, залуучуудад сургалт, уулзалтыг зохион байгууллаа.

- Хуримтлалын өдрийг угтаж Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпораци, ХБНГУ-ын Шпаркассэ банкны сан, Монголын банкны холбоо хамтран “Дэлхийн хуримтлалын өдөр-2021” аяныг “Бүгдээрээ хуримтлуулъя” уриатайгаар Төв аймгийн Зуун мод хотод нээлтийн арга хэмжээг зохион байгуулав. Энэ жилийн хувьд тус аяны нээлтийн арга хэмжээ анх удаа орон нутагт болсноороо ихээхэн онцлогтой юм. Нээлтийн арга хэмжээний үеэр арилжааны банкууд хүүхэд, багачуудад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулж, газар дээр нь хуримтлалын данс нээж ажилласны дээр хуримтлалын ач холбогдол, олон улсын туршлагыг таниулах илтгэлүүдийг оролцогчдын зүгээс танилцууллаа. Уг аяны хүрээнд хамтрагч байгууллагуудтай хамтран иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжих, хуримтлалыг хэвшил болгоход чиглэсэн хүүхэд залуучуудын дунд цахим орчин дахь уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулснаас гадна ЕБС-ийн 500 гаруй хүүхдүүдэд сургалт, уулзалтуудыг хийж, хуримтлалын ач холбогдлыг таниулж, сурталчлав.

#### **Залуучуудад санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:**

- Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд 3 кредит бүхий “Хувь хүний санхүү” хичээлийг магадлан итгэмжлэгдсэн 13 их, дээд сургуульд орж, тус хичээлтэй холбоотой идэвхжүүлэлтийн арга хэмжээнүүдийг тогтмол авч хэрэгжүүлж байна.
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл, Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2020 онд Монголбанк болон Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Үүний дагуу Монголбанкнаас Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын нийслэл хот, хөдөө орон нутгийн 35 ажилтанг залуучуудад санхүүгийн боловсрол олгох сургагч багшаар бэлтгэв.
- Цар тахлын улмаас халдвар хамгааллын дэглэмийг сахин танхимын болон цахим сургалтуудыг зохион байгуулж, нийт 830 орчим оюутан, залуус хамрагдлаа.
- Монголбанк, БШУЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв, Санхүүгийн зохицуулах хороо, Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран 883 санхүүгийн сургагч багш нарыг өнгөрсөн хугацаанд бэлтгэсэн ба залуучуудад мэдлэг, мэдээлэл өгөх чиглэлээр ажиллав. Эдгээр аймаг, дүүргийн насан туршийн боловсролын үндэсний төвийн сургагч багш нар нь тайлант онд санхүүгийн боловсрол олгох 1229 удаагийн танхимын болон цахим сургалт, 1363 удаагийн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулаад байна.
- Иргэдэд санхүүгийн мэдлэг олгох “Мөнгөө хэрхэн удирдах вэ?”, “Зээл”, “Өрхийн төсөв”, “Хуримтлал ба хадгаламж”, “Үнийн түвшин”, “Валютын ханш” зэрэг сэдвээр 35,000 ширхэг гарын авлагыг хэвлүүлж, түгээж ажиллав.

#### **Цахим хуудсаар санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:**

- Санхүүгийн мэдлэг олгох [www.sankhuuginbolovsrol.mn](http://www.sankhuuginbolovsrol.mn) цахим хуудсыг шинэчлэгдсэн гарын авлага, мэдээ мэдээллээр тогтмол баяжуулан ажиллалаа.
- “Санхүүгийн боловсрол” фэйсбүүк пэйжийг тогтмол хувь хүнийн санхүү төлөвлөлт, хуримтлал, хөрөнгө оруулалт, дижитал төлбөр тооцоо зэрэг агуулын хүрээнд мэдээ, мэдээллээр ханган 15000 гаруй дагагчтай болов.



- МҮОНР-гийн “Мөнгөний мод” нэвтрүүлэгт оролцож, эдийн засаг, санхүүгийн цаг үеийн асуудлаар ярилцлага, мэдээлэл өгч 11 дугаарыг шууд эфирээр болон сошиал хуудсаар олон нийтэд түгээв.
- “Санхүүгийн боловсрол” фейсбүүк пэйжийг тайлант хугацаанд 342 удаагийн мэдээ мэдээлэл, санхүүгийн боловсролын талаарх мэдлэг, инфографик, зөвлөмжүүдээр баяжуулж ажиллалаа.

#### **Бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн мэдлэг олгох ажлын хүрээнд:**

- “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд ЕСБХБ-тай хамтран Европын холбооны дэмжлэгтэйгээр “Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны төлөвлөгөө”-г боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгч, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар батлуулав. Төлөвлөгөө нь санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хувийн болон бизнесийн санхүүгээ зөв удирдахад дэмжлэг болох ач холбогдолтой бөгөөд 5 жилийн хугацаатай хэрэгжих юм.
- “Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Нийслэлийн жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төв, Насан туршийн боловсролын үндэсний төв, Зээлийн батлан даалтын сан, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Монголын банкны холбоо гэсэн оролцогч талуудыг багтаасан ажлын хэсгийг байгуулж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг гүйцэтгэж эхлэв. Тухайлбал, оролцогч талуудын төлөөллүүдийг оролцуулсан БЖДҮҮЭ-ийн санхүүгийн мэдлэг олгох 32 сургагч багшийг бэлдэх, гарын авлагыг боловсруулах, ААН-үүдэд сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

#### **Олон улсын байгууллагуудтай хамтарч ажилласан байдал**

##### *ХБНГУ-ын Шпаркассэ банкны сан*

- Монголбанк, ХБНГУ-ын Шпаркассэ банкны сан, Монголын банкны холбоо, ХБНГУ-ын “Остпригнитц-Руппины Шпаркассэ” банкттай хамтран “Монгол Улсад банкны мэргэжилтэн бэлтгэх онол, практик хослуулсан сургалт болон Дэлхийн хуримтлалын өдрийг нэвтрүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлээд 4 жил болж байна. Энэхүү хугацаанд 6 модуль бүхий сургалтад арилжааны 11 банкны нийт 255 оролцогч, сургагч багш бэлтгэх хөтөлбөрт нийт 94 багшамжилттай хамрагдсан байна. Үүнээс 2020 онд элссэн Улаанбаатар хотын нийт 11 банкны 30 мэргэжилтэн амжилттай төгсөж 2021 оны 09-р сарын 15-ны өдөр батламжаа гардаж авлаа. Цаашид төслийн үр дүн, туршлагыг илүү урт хугацаанд, тогтвортой хадгалах нөхцөлийг бүрдүүлж, ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны хамтарсан санхүүжилтээр Монгол Улсад банк, санхүүгийн салбарын ажилтнуудыг чадавхижуулах мэргэжлийн “Шинэ институт” байгуулах ажлын хүрээнд МБХ-ны дэргэдэх “Банк санхүүгийн академи”-ийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна.
- Монголбанк, Монголын банкны холбоо, ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сан, Монголын Банк санхүүгийн академи хамтран “Монгол Улсын банкны салбарт ажиллахад тавигдах банкны ажилтны суурь шаардлагын жишиг”-ийг дагалдах “Шинэ банкирын онол, практик хосолсон болон мэргэшсэн банкирын сургалтын жишиг журам”, “Банкны ажилтны суурь шаардлагын жишгийг хангуулах шинэ банкирын сургалтын хөтөлбөр”-ийн хамт боловсруулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 11-р сарын 25-ны өдрийн А-313 тоот тушаалаар батлуулав.



*Европын сэргээн босголт, хөгжлийн банк /EBRD/*

Монголбанкнаас ЕСБХБ-тай хамтран Европын холбооны дэмжлэгтэйгээр “БЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох хөтөлбөр боловсруулах” төслийг хэрэгжүүлж байгаа ба төслийн талаар дүгнэх Олон Улсын Бага хурлыг 3-р сарын 22-ны өдөр цахимаар зохион байгууллаа. Уг хурлыг нээж Монголбанкны дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван, ЕСБХБ-ны Монгол дахь салбарын дэд захирал Ханнес Такакс, ЕХ-оос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газрын хамтын ажиллагааны газрын дарга Пиер Ив-Лукас, Санхүүгийн боловсролын группийн ахлах Дэд Ерөнхийлөгч Шон Мунди, ЭЗХАХБ/СБОУС (OECD/INFE)-ний Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Флоре-Энн Месси нар үг хэлсэн. Хурлын үеэр төслийг хэрэгжүүлсэн зөвлөх багийн зүгээс “БЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн боловсролын хэрэгцээ” судалгааны үр дүн, сургагч багш бэлтгэх сургалт, БЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох стратеги, бизнес эрхлэгчдэд сургалт орсон үйл явц сэдэвт танилцуулгуудыг хийв.

*OECD/INFE Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагын Олон улсын санхүүгийн боловсролын сүлжээ*

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Санхүүгийн боловсролын олон улсын сүлжээ (OECD/INFE)-ний техник тусламжийн хүрээнд зохион байгуулдаг “Дэлхийн Мөнгөний Долоо Хоног” аяныг хамтрагч байгууллагуудын хүрээнд “Суралц-Хуримтлуул-Өсгө” уриан дор улс орон даяар зохион байгууллаа. Аяныг Монголбанк, БШУЯ, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын Банкны Холбоо, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Насан туршийн боловсролын үндэсний төв, ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сан болон арилжааны банкууд хамтран 3 дугаар сарын 22-оос 4 дүгээр сарын 12-ны өдөр хүртэл хэрэгжүүлсэн. Энэ үеэр оролцогч талууд “Монгол Улс дахь санхүүгийн боловсролын өнөөгийн байдал ба цаашдын хандлага” сэдэвт хэлэлцүүлгийг хийв.



## 3.1 НЭЭЛТТЭЙ ЗАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Төв банкны үнэт цаас

Нээлттэй захын үйл ажиллагаа буюу Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь банк хоорондын захын богино хугацаатай хүү болон нөөцийн хэлбэлзлийг удирдах замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл юм.


Монголбанк 2021 онд хугацаа, хүү, арилжаалагдах хэлбэрээр ялгаатай дараах 2 төрлийн ТБҮЦ-ыг тогтмол арилжааллаа. Үүнд:

- 28 хоногтой ТБҮЦ-ыг тогтмол хүүтэй, хэмжээ хязгаарлаагүй хэлбэрээр Даваа гараг бүр арилжааллаа. Энэ төрлийн үнэт цаасны хүү нь бодлогын хүү болох бөгөөд банк хоорондын захын хөтөч хүүний үүргийг гүйцэтгэж, системийг илүүдэл нөөцийг татах, банкуудын нөөцийг удирдахад чухал үүрэгтэй.
- 196 хоногтой ТБҮЦ-ыг хүүгээр өрсөлдөх, хэмжээ хязгаарласан хэлбэрээр 2 долоо хоног тутам Лхагва гарагт зохион байгууллаа. Банк хоорондын захын байнгын шинжтэй бүтцийн илүүдэл нөөцийг бууруулах, урт хугацаат хэлцлийн идэвхийг нэмэгдүүлэх, төгрөгийн өгөөжийн муруйн эхлэлийг бүрдүүлэх, мөнгөний бодлогын шилжих механизмыг сайжруулах зорилгоор энэ төрлийн үнэт цаасыг арилжаалсан.

2021 оны эцэст ТБҮЦ-ны нийт үлдэгдэл нэрлэсэн дүнгээр 8,644.96 тэрбум төгрөгтэй тэнцүү байна. Энэ нь 2020 оны эцсээс 8.38 хувиар буюу 669.76 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Тус өөрчлөлтөд Монголбанкны алт худалдан авалтаар нийлүүлсэн 2,838.5 тэрбум төгрөг, Засгийн газрын ТСНД-аар нийлүүлсэн 501.9 тэрбум төгрөг Монголбанкны гадаад валютын интервенцээр банк хоорондын захаас цэвэр дүнгээр 3,321.1 тэрбум төгрөгийг татсан нь гол нөлөөг үзүүлсэн байна (Зураг 3.1).

Түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А-114 дүгээр тушаалаар Төв банкны хүүгээр өрсөлдөх арилжааны хүүний дээд хязгаарыг Төв банкны бодлогын хүүний хувь хэмжээн дээр +0 хувь болгож өөрчилснөөр 196 хоногтой ТБҮЦ буюу хүүгээр өрсөлдөх, хэмжээ хязгаарласан арилжаанд банкуудын оролцоо буурав. Улмаар 2021 оны эцэст банкуудын эзэмшиж буй ТБҮЦ-ыг зөвхөн 28 хоногийн хугацаатай ТБҮЦ бүрдүүлээ.

Зураг 3.1. ТБҮЦ-ны үлдэгдэл (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Монголбанк

## Репо арилжаа

Төв банкны репо арилжаа нь банкны эзэмшиж буй үнэт цаасыг хугацааны эцэст урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдах нөхцөлтэй худалдан авах хэлцэл юм. Монголбанкнаас зээлийн хүүг бууруулах стратеги болон коронавируст цар тахлын эсрэг хийгдэх ажлын хүрээнд репо арилжааны хугацааг 2 жил хүртэл сунгаж, барьцаа хөрөнгийн жагсаалтыг өргөжүүлсэн. Ингэхдээ хүртээмжтэй өсөлтийг бий болгох, эдийн засгийг төрөлжүүлэх ач холбогдлыг харгалзан өмнө батлагдсан ЖДҮ, уул уурхайн бус экспортын салбар дээр үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, 200 болон түүнээс дээш ажилтантай бөөний болон жижиглэн худалдааны салбарыг хамруулж, өрийн дарамтыг бууруулах зорилгоор репо арилжааны эх үүсвэрийг уг салбарын аж ахуй нэгж, иргэнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-89, А-185 болон А-247 дугаар тушаалаар батлагдсан нөхцөлийн дагуу олгож эхлэв. Дээрх өөрчлөлтийг хийснээр (1) Эдийн засгийн уналт, санхүүгийн зуучлалд бий болох сөрөг нөлөөллийг саармагжуулах; (2) Эдийн засгийг төрөлжүүлэх, экспортлогч аж ахуй нэгжийг дэмжих; болон (3) Санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн гаргах боломж бүрдлээ. Тайлант онд Монголбанкнаас репо арилжаагаар банкуудад 825.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгов. Уг олгосон санхүүжилтээр банкууд зээл олгож, олгосон зээлээ үнэт цаасжуулан, Монголбанкнаас санхүүжилт авах схемийг зураг 3.2-т дүрслэн харууллаа.

Зураг 3.2. Хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаасаар урт хугацаат санхүүжилтийн схем




Эх сурвалж: Монголбанк

**Шигтгээ 3.1. Урт хугацаат репо арилжаагаарх зээл олголтын мэдээлэл**

Монголбанкны Ерөнхийлөгчийн А-425 тушаалын дагуу Мөнгөний бодлогын хороо нь урт хугацаат репо арилжааны хугацаа, хэмжээ, нэмэлт нөхцөлийг улирал бүр тогтоохоор шийдвэрлэсэн. Мөнгөний бодлогын хороо нь 2021 онд 950.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталсан бөгөөд үүнээс Монголбанк 825.0 тэрбум төгрөгийг арилжааны банкуудад олгосон (Зураг 3.3). Урт хугацаатай репо арилжаагаар олгох зээлийн нэмэлт нөхцөлийг 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдрөөр шинэчлэсэн бөгөөд одоо байгаа уул уурхайн бус экспорт болон ЖДҮ салбарууд дээр үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, 200 болон түүнээс дээш ажилтантай бөөний болон жижиглэн худалдааны салбарыг хамруулахаар шийдвэрлэсэн. Энэ оны эцсийн байдлаар арилжааны банкуудаар нийт 834.9 тэрбум төгрөгийн зээл олголт хийгдээд байна (Зураг 3.4).


Мөн хэвийн зээлийг үнэт цаасжуулах ажлыг гүйцэтгэж буй “ҮЦСК актив нэг ТЗК” нь 40.5 тэрбум төгрөг, “ҮЦСК актив хоёр ТЗК” нь 160.4 тэрбум төгрөгийн үнэт цаасыг тус тус гаргалаа. Монголбанкнаас анх барьцаалсан үнэт цаасыг уг үнэт цаасаар солих ажлыг зохион байгуулж байна.

Зураг 3.3. Урт хугацаат репо арилжаатай холбоотой гаргасан шийдвэрүүд



Эх сурвалж: Монголбанк

Зураг 3.4. Урт хугацаат репо арилжаагаарх зээл олголт, салбараа




Эх сурвалж: Монголбанк

Түүнчлэн Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 4 дүгээр тогтоолд урт хугацаат репо санхүүжилтийн зориулалтыг өргөтгөн шатахуун болон хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийг шаардлагатай түвшинд хүртэл бүрдүүлэхэд ашиглаж болохоор шийдвэрлэсний дагуу 2022 оны 12 дугаар сард Монголбанкнаас шатахууны нөөц бүрдүүлэх зорилгоор банкуудад нийт 297 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 12 хүртэл сарын хугацаатай олгов.

### Банк хоорондын захын арилжаа

Монголбанкнаас банк хоорондын захын тогтвортой үйл ажиллагааг өдөр бүр хангаж ажиллаж байгаа бөгөөд тайлант оны хугацаанд сард дунджаар 38.9 тэрбум төгрөгийн овернайт арилжаа, 400.5 тэрбум төгрөгийн репо хэлцэл, 330.8 тэрбум төгрөгийн ТБҮЦ-ны шууд худалдан авалтыг хийсэн байна. Мөн банк хоорондын захын хэлцлийн дундаж хугацаа 9.9 хоног болж, өмнөх оноос 2.7 хоногоор буурчээ (Зураг 3.5).

Зураг 3.5. Банк хоорондын захын арилжаа (тэрбум төгрөг, хугацаагаар)




Эх сурвалж: Монголбанк

## Заавал байлгах нөөцийн шаардлага

Төв банкны тухай хуулийн 11.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Монголбанк төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ банкны заавал байлгах нөөцийн арга хэрэгслийг ашиглаж болохоор заасан. Үүний дагуу Төв банкны тухай хуулийн 27.3 дугаар зүйлийн 4.3-т заасны дагуу Монголбанкны Мөнгөний бодлогын хороо заавал байлгах нөөцийн хэмжээг хэлэлцэж шийдвэрлэдэг. Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор банкны гадаад валютын заавал байлгах нөөцийн хувийг 3 нэгж хувиар буюу 15 хувиас 18 хувь болгон нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан. Ингэснээр 2021 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2022 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийг дуустал банкны системийн валютын ЗБН-ийн хэмжээ 1,423.4 тэрбум төгрөгөөр тогтоогдсон бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 144.9 тэрбум төгрөгөөр буюу 11.3 хувиар нэмэгдсэн үзүүлэлт байна. Төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг хамгийн сүүлд Мөнгөний бодлогын хороо 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаар 8.5 хувиас 6 хувь болгон бууруулсан бөгөөд тус хувь хэмжээ 2021 онд өөрчлөгдөөгүй байна (Зураг 3.6).

Зураг 3.6. Төгрөгийн заавал байлгах нөөцийн шаардлага, түүний хангалт (2020/01/01-2022/01/11, тэрбум ₮)



Эх сурвалж: Монголбанк



### 3.2 ТӨВ БАНКНЫ САНХҮҮЖИЛТ

Монголбанк нь банкны системийн түр зуурын шинжтэй илүүдэл нөөцийг шингээх, шаардлагатай тохиолдолд нөөц нийлүүлэх замаар банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүний хэлбэлзлийг бууруулах зорилгоор байнгын хэрэгслүүдийг ашигладаг. Байнгын хэрэгсэлд нөөцийг татах буюу овернайт хадгаламж, нөөцийг нийлүүлэх буюу репо санхүүжилтийн хэрэгсэл багтана.

Түүнчлэн Монголбанк хүүний нэгдсэн бодлогын хүрээнд репо санхүүжилтийн хүү нь Төв банкны хүүний коридорын дээд хязгаар (бодлогын хүү + 1 нэгж хувь), овернайт хадгаламжийн хүү нь Төв банкны хүүний коридорын доод хязгаар (бодлогын хүү - 1 нэгж хувь) болж, банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүний хэлбэлзлийг хязгаарладаг.

Тайлант онд Монголбанк давхардсан тоогоор 39 удаагийн хэлцлээр нийт 2,787 тэрбум төгрөгийн репо санхүүжилтийг 7 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр банкуудад олгожээ. Харин Монголбанк давхардсан тоогоор 674 удаагийн хэлцлээр нийт 41,270.5 тэрбум төгрөгийн овернайт хадгаламжийг 5 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр банкуудаас татан төвлөрүүлжээ.

### 3.3 БУСАД САНХҮҮЖИЛТ

#### Өдрийн зээл

Өдрийн зээл нь төлбөр тооцооны хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Монголбанкнаас банканд олгож буй санхүүжилтийн хэрэгсэл бөгөөд тухайн өдөрт багтан эргэн төлөгдөх нөхцөлтэй, хүүгүй зээл юм. Тайлант онд Монголбанкнаас банканд өдрийн зээл олгоогүй байна.

#### Барьцаат зээл

Монголбанк эцсийн зээлдүүлэгчийн үүргийн хүрээнд банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор “Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн А-174 тоот тушаалаар батлагдсан “Монголбанкнаас банканд олгох барьцаат зээлийн журам”-ын дагуу банканд барьцаат зээл олгодог. Тус журмын дагуу тайлант онд банканд барьцаат зээл олгоогүй байна.

Харин Коронавируст халдварын цар тахлын үед нийгэм, эдийн засагт үүссэн нөхцөл байдлыг харгалзан банкны санхүүгийн байдлыг сайжруулж, банкны салбарын тогтвортой байдлыг хадгалах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн А-192 тоот тушаалаар баталсан “Монголбанкнаас банкинд олгох зээлийн түр журам”-ын хүчинтэй хугацааг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл нэг жилээр сунгасан. Тус журмын дагуу банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах зорилгоор банканд 14.3 тэрбум төгрөгийн барьцаат зээлийг олгов.

#### Ипотекийн санхүүжилт


Монголбанк Засгийн газартай хамтран 2013 оноос “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн 2 дахь хэсэг болгон “Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлсэн. Орон сууцны ипотекийн хөтөлбөрийн гол зорилго нь бага, дундаж орлоготой өрхүүдийн орон сууцны нөхцөлийг сайжруулах, агаар болон хөрсний бохирдлыг бууруулах, орон нутгийн шилжилт хөдөлгөөнийг саармагжуулахад оршиж байна.

Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 2021 оны эцсийн байдлаар нийт 6.2 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийг 103.9 мянган өрхөд Монголбанк, Засгийн газар, банкуудын эх үүсвэрээр олгоод байна (Зураг 3.7).

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоол, Засгийн газраас

хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд 2024 он хүртэл нийт 2 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн хөтөлбөрийн зээлийг олгохоор тусгагдсан. Үүнээс 2021 онд нийт 1.0 их наяд төгрөгийн зээлийг 13.4 мянган өрхөд олгосоноор 2022, 2023 онуудад нийт 1.0 их наяд төгрөгийн зээлийг олгох төлөвлөгөөтэй байна.


Зураг 3.7. Ипотекийн зээл олголт, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголбанк

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолын дагуу хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээлийн эргэн төлөлтийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлуулах арга хэмжээг 4 удаа авч хэрэгжүүлсэн. Үр дүнд нь давхардсан тоогоор нийт 214 мянга гаруй өрхийн зээлийн төлбөр хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр нийт 25 сарын турш хойшлуулсан байна. Энэ хугацаанд ойролцоогоор нийт 783 тэрбум төгрөгийн төлбөр (341 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 442 тэрбум төгрөгийн хүүний төлбөр)-өөс чөлөөлөгдсөн буюу хойшлуулжээ (Зураг 3.8).

Зураг 3.8. Ипотекийн төлбөр хойшлуулалт



Эх сурвалж: Монголбанк

Цаашид буюу 2024 оноос эхлэн хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газарт шилжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хүрээнд Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 285/А-334 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Монголбанкныг Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоо бүрдүүлэх хөтөлбөрөөс гаргах төлөвлөгөө”-нд нэмэлт, өөрчлөлтийг Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 163/А-136 дугаар хамтарсан тушаалаар оруулсан. Ийнхүү Монголбанк холбогдох байгууллагуудтай хамтран хөтөлбөрийг тогтвортой, урт хугацаанд хэрэгжих боломжтой болгож Засгийн газарт хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.


## Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондын санхүүжилт

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хуулийн 10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолын 2.6-д заасны дагуу НОСК ХК-ийн хэрэгжүүлж буй Түрээслээд өмчлөх орон сууцны хөтөлбөр нь цар тахлын эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчдад зориулсан онцгой нөхцөлтэй хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор НОСК ХК-иас үүсгэн байгуулсан Тусгай зориулалтын компаний гаргасан 100 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондыг нэрлэсэн үнээр худалдан авах тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-417 дугаар тушаалыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд баталсан. Уг тушаалын дагуу 2020 онд нийт 34.4 төгрөг, 2021 онд 65.6 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондыг тус тус худалдан авч, хөтөлбөрийг санхүүжүүлснээр нийт 1,177 төрийн албан хаагчийн орон сууцны хэрэгцээг хангасан байна.

## 3.4 ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС (ЗГҮЦ)

Засгийн газрын санхүүгийн удирдлагыг сайжруулах, мөнгөний бодлогын арга хэрэгслийг нэмэгдүүлэх зорилгоор 2012 оны 10 дугаар сараас эхлэн Засгийн газар Монголбанкаар дамжуулан Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ыг анхдагч зах зээл дээр гарган, арилжаасан. ЗГҮЦ нь санхүүгийн зах зээл дэх хамгийн эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хэрэгсэл бөгөөд хүүний орлого нь албан татвараас чөлөөлөгддөг давуу талтай. Иймд ЗГҮЦ-ны тогтмол арилжаа нь эрсдэлгүй хүүний жишгийг санхүүгийн захад тогтоох буюу өгөөжийн муруйг бүрдүүлэх, богино хугацаат хүүний урт хугацаат хүүнд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох, санхүүгийн захын идэвхийг нэмэгдүүлэх зэргээр санхүүгийн захын хөгжлийг олон талаар дэмждэг. Гэвч Сангийн яамны шийдвэрийн дагуу 2017 оны 11 дүгээр сараас хойш ЗГҮЦ-ны анхдагч захын арилжаа нээлттэй зарлагдаагүй байна.

Зураг 3.9. Монголбанкаар дамжин арилжаалагдсан ЗГҮЦ-ны үлдэгдэл (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Монголбанк

Монголбанкаар дамжин арилжаалагдсан ЗГҮЦ-ны үлдэгдэл 2021 оны эцэст 22.5 тэрбум төгрөг байгаа бөгөөд эдгээр нь бүгд 10 жилийн хугацаатай байна (Зураг 3.9). Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 77-р тогтоолоор батлагдсан “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам” хүчин төгөлдөр үйлчилж байгаа хэдий ч 2021 онд ЗГҮЦ-ны хоёрдогч зах дээр арилжаа хийгдээгүй байна. Улмаар зах зээлд ТБҮЦ-наас өөр эрсдэлгүй үнэт цаас байхгүй байгаа тул ТБҮЦ-ны эрэлт нэмэгдэх болсон бөгөөд ТБҮЦ-ны үлдэгдэл 2020 онд 8.0 их наяд, 2021 онд 8.6 их наяд болж өсчээ.


### 3.5 МОНГОЛБАНКНЫ ВАЛЮТЫН ЗАХЫН ОРОЛЦОО

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлд нийцтэй, уян хатан тогтох зарчмыг баримтлан эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүүнээс үүсэх ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцож ирлээ. Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 2021 оны эхэнд хөл хорио тогтоож бизнесийн үйл ажиллагааг хумиснаар гадаад валютын дотоодын захын идэвхжил харьцангуй сул байв. Харин вакцинжуулалт нэмэгдэж, хатуу хөл хорио цуцлагдсанаар гадаад валютын эрэлт өсч, төгрөгийн ханш сулрах дарамт нэмэгдэх хандлагатай болов.

Тээвэр, логистикийн салбарын үйл ажиллагааны доголдол нь олон улсын худалдааг бууруулж, нийлүүлэлтийн хомсдолоос шалтгаалан түүхий эдийн үнэ өссөнөөр 2021 оны эцэст Монгол Улсын экспортын дүн өмнөх оны мөн үеэс 22% өслөө. Гэвч БНХАУ-аас баримталж буй халдвар хамгааллын дэглэмээс шалтгаалан Монгол Улсаас БНХАУ-руу зэсээс бусад төрлийн экспортын гарц буурсан, шатахуун болон хүнсний бараа үнэ, зарим төрлийн тоног төхөөрөмжийн импортын хэмжээ, мөн анхдагч орлогын дансны алдагдал өссөн зэрэг нь урсгал тэнцлийн дарамтыг нэмэгдүүллээ.

Улмаар Монголбанк 2021 онд төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид огцом хэлбэлзэл үүсгэхгүй байх зорилгоор цэвэр дүнгээр нийт 1043.3 сая ам.долларыг валютын захад нийлүүлжээ.

Зураг 3.10. Монголбанкны валютын захын цэвэр оролцооны дүн 2012-2021 он /сая ам.доллар/



Эх сурвалж: Монголбанк

Тухайлбал, Монголбанкнаас 2021 онд нийт 102 удаа гадаад валютын дуудлага худалдаа зохион байгуулж, дуудлага худалдаа болон цахим талбараар дамжуулан цэвэр дүнгээр 3,607.9 сая ам.долларыг валютын захад нийлүүлэв. Өмнөх онтой харьцуулахад уг дүн нь 44.1 хувиар буюу 1104.8 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Харин Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, ЗГХЭГ-ын дарга нарын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 03/3/А-5 дугаар хамтарсан тушаалын дагуу төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдээс тайлант хугацаанд нийт 2,564.5 сая ам.долларыг худалдан авахын зэрэгцээ Төв банкны тухай хуулинд заасан Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн гүйцэтгэх үүргийн дагуу цэвэр дүнгээр 566.4 сая ам.доллартай тэнцэх гадаад зээл, бондын үндсэн ба хүүгийн төлбөрийг хийж гүйцэтгэжээ.

Зураг 3.11. Ам.доллар, юанийн дуудлага худалдаа /сая ам.доллар/



Эх сурвалж: Монголбанк

### Банк хоорондын цахим талбар

Банк хоорондын валют арилжааны цахим талбар нь банк хооронд валют арилжаа хийх үйл явцыг хялбаршуулаад зогсохгүй мэдээллийн тэгш байдлыг бий болгосноор зах зээл дэх арилжааны спот ханш бүрэлдэх үйл явцыг сайжруулах болгох, арилжаа хийхэд тулгарч буй харилцагчийн болон төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах, өндөр дүнтэй валютын арилжаа хийх иргэн, аж ахуйн нэгжүүд уг талбараас ханшийн мэдээлэл авах зэрэг ач холбогдолтой юм.

Зураг 3.12. БХВАЦТ-г хийгдсэн арилжаа /сая ам.доллар/




Эх сурвалж: Монголбанк

Тайлант онд банкууд БХВАЦТ-аар дамжуулан нийт 33.1 сая ам.долларын дүн бүхий 50 удаагийн арилжаа хийсэн бол Монголбанк цэвэр дүнгээр 119 сая ам.долларыг БХВАЦТ-аар дамжуулан банкуудаас худалдаж авсан байна.

## Санхүүгийн үүсмэл хэрэгсэл

Монголбанк банкуудын богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх, ханшийн эрсдэл, спот захын дарамтыг бууруулах, дотоодын зах зээл дэх долларжилтыг бууруулах, бодит эдийн засгийг дэмжих зорилгоор банкуудтай богино хугацааны санхүүгийн үүсмэл хэрэгслийг 2010 оноос, урт хугацаат своп хэлцлийг 2014 оноос тус тус байгуулж эхэлсэн. Гадаад болон дотоод зах зээлийн нөхцөл байдал, банкуудын гадаад эх үүсвэрийн өртөг зэргийг харгалзаж, урт хугацаат своп хэлцлийн журмыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А-162 дугаар тушаалаар шинэчлэн батлав. Ингэснээр Ковид-19 цар тахлын үед бага хүүтэй, урт хугацаат эх үүсвэрээр бодит эдийн засгийг дэмжиж, дотоодын зах зээлд ханшийн эрсдэлээс хамгаалах тогтолцоог бүрдүүлэх боломжийг нэмэгдүүллээ.

Зураг 3.13. Банкуудтай байгуулсан урт хугацаат своп хэлцлийн хэмжээ /сая ам.доллар/



Эх сурвалж: Монголбанк

Монголбанкнаас тайлант онд богино хугацаат своп хэлцлийг арилжааны банкуудтай байгуулаагүй байна. Харин урт хугацаат своп хэлцлийн хүрээнд банкуудын гадаад зах зээлээс татсан нэг жилээс дээш хугацаатай гадаад валютын эх үүсвэрээр ам.долларын урт хугацаат своп хэлцэл байгуулж байгаа бөгөөд 2021 онд нийт 223.7 сая ам.долларын дүнтэй урт хугацаат своп хэлцлийг банкуудтай байгуулснаас бодит 3.2 сая, бодит бус 220.4 сая ам.долларын хэлцлийн төрөлд хамаарч байна. Нийт байгуулсан хэлцлийн дүн өмнөх оны мөн үеэс 37.3 хувиар буюу 138.8 сая ам.доллараар буурчээ. Мөн тайлант онд нийт 255.8 сая ам.долларын урт хугацаат своп хэлцлийн хугацаа дуусаж, төлбөр тооцоог гүйцэтгэсэн бөгөөд урт хугацаат своп хэлцлийн үлдэгдэл 32.1 сая ам.доллараар буурч, 1,625.7 сая ам.долларт хүрэв.

## 3.6 АЛТНЫ САНХҮҮЖИЛТ, ҮНЭТ МЕТАЛЛЫН ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолыг үндэслэн Монголбанкнаас гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, Алт-2 үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор 2020 оны 6 дугаар сараас эхлэн алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийг олгож эхэлсэн.

Урьдчилгаа төлбөрийн санхүүжилт нь 6 хүртэлх сарын хугацаатай бөгөөд энэхүү санхүүжилтээр аж ахуй нэгжийн уулын ажлын төлөвлөгөөгөөр батлагдсан тухайн жилд олборлох үнэт металлыг урьдчилж худалдаж авч байгаа бөгөөд арилжааны банк 3 хувийн хүүтэйгээр алт олборлогч аж ахуй нэгжид олгож байна.

Харин Урт хугацаат санхүүжилт нь 36 хүртэлх сарын хугацаатай бөгөөд уг санхүүжилт нь алт олборлогч аж ахуй нэгжүүдийн үнэт металл олборлох хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой юм. бөгөөд Урт хугацаат санхүүжилтийг Монголбанк бодлогын хүүгээр арилжааны банканд олгож, арилжааны

банк бодлогын хүү + 3% буюу 9 хувийн хүүтэйгээр алт олборлогч аж ахуйн нэгжид санхүүжилтийг дамжуулан зээлдүүлж байна.

Тайлант онд нийт 15 алт олборлогч аж ахуй нэгжид урьдчилгаа төлбөрийн 23.5 тэрбум төгрөг, урт хугацаат санхүүжилтийн 309.7 тэрбум төгрөг, нийт 333.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг арилжааны 4 банкаар дамжуулан олгоод байна. Санхүүжилт авсан 15 алт олборлогчоос 2021 оны эцсийн байдлаар Монголбанк нийт 4.36 тн үнэт металл худалдаж авсан нь тайлант оны худалдан авалтын 21%-г эзэлж байна.

Монголбанк нь Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 7, 8 дугаар зүйлийн дагуу гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын зах зээлээс худалдан авсан үнэт металлыг гадаадад цэвэршүүлэх ажлыг эрхэлдэг бөгөөд 2021 онд нийт 21 тн үнэт металлыг 118 алт олборлогч аж ахуй нэгж, 73 үнэт металлын худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий иргэдээс худалдан авч гадаад валютын улсын нөөцийг 800 орчим сая ам.доллараар нэмэгдүүлжээ.

**Зураг 3.14. Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ**



Эх сурвалж: Монголбанк



## 4.1. МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, ОРОН ТОО

Монголбанк нь 13 газар, 1 төв, 1 хүрээлэн, 3 бие даасан алба, орон нутаг дахь 5 хэлтэс, 12 салбар, 1 төлөөлөгчийн газартайгаар мөн Төв аппаратад 520, орон нутаг дахь хэлтэс, салбарт 121, нийт 641 батлагдсан орон тоотойгоор үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Монголбанк 2021 онд дэвшүүлсэн үйл ажиллагааны шинэчлэлийн дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, хүний нөөцийн чадавхи болон хууль, эрх зүйн орчинг сайжруулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх, дэвшилтэт технологи, арга ажиллагааг нэвтрүүлэх чиглэлээр багагүй ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

2021 онд Монголбанкны бүтэц, зохион байгуулалтын хүрээнд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар Тамгын газрыг чиг үүргийн хувьд 2 хувааж, Тамгын газар, Удирдлага төлөвлөлтийн газар болгон өөрчлөн зохион байгуулж, Мэдээллийн технологийн газрын Мэдээллийн аюулгүй байдлын албыг Удирдлага төлөвлөлтийн газрын бүтцэд оруулсан. Олон нийтийн боловсрол мэдээллийн төвийг чиг үүргийн хувьд 2 хувааж, Олон нийтийн санхүүгийн боловсролын төв, Хэвлэлийн алба болгон өөрчлөн зохион байгуулж, Хэвлэл мэдээллийн албыг Удирдлага төлөвлөлтийн газрын бүтцэд оруулсан. Хууль, эрх зүйн газрын бүтэц, чиг үүргийг шинэчлэн баталсан.

Хүний нөөцийн чадавхийг сайжруулах, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, өндөр мэдлэг чадвартай чадварлаг боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого баримталж, ажилтнуудаа тасралтгүй сурган хөгжүүлэх, тэдний ажиллах нөхцөл, цалин урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэн ажилласан.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар Монголбанкны Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан.

Сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар Монголбанкны ажилтнуудыг цахим орчинд үр ашигтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажлын хэрэгцээнд цуглуулсан бүх төрлийн мэдээллийг цахим хэлбэрээр хадгалах, түгээх, ашиглах, түүнд үндэслэн шинжилгээ хийхэд чиглэсэн мэдээллийн технологийн шинэчлэлийг үе шаттайгаар хийлээ.

Монголбанкны үйл ажиллагааг илүү тодорхой болгох, шийдвэр гаргах хэлбэр, үйл явцыг ил тод болгох, хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө болон Монголбанкны дотоод ажлын төлөвлөгөөг гарган баталсан.

## 4.2 ГАДААД ХАРИЛЦАА

Монголбанкны гадаад харилцаа, хамтын ажиллагаанд гарсан онцлох үйл явдлууд:

Монголбанк Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын Төв банк хооронд 2011 оны 8 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд тус банкнаас хэрэгжүүлдэг “Мэдлэгийн түншлэлийн хөтөлбөр”-т Монголбанк тав дахь жилдээ хамрагдаж, БНСУ-ын Төв банк, Санмёнг их сургуультай хамтран “Төвлөрсөн том өгөгдлийн мэдээлэл боловсруулах, нэгдсэн системийг бий болгох (Establishing a centralized big data processing and integration system)” сэдвээр хамтарсан судалгааны ажил хийж, үр дүнг харилцан тайлагнах, эцсийн судалгаа, тайланг хэвлүүлэх ажлыг БНСУ-ын Төв банктай хамтран зохион байгуулж дууслаа.

Монгол Улс Олон улсын валютын сангийн Дүрмийн 4-р заалтын дагуу хоёр талын зөвлөлдөх хэлэлцүүлэг явууллаа. Энэ хүрээнд ОУВС, Монголбанк, Сангийн яам гэсэн гурван талт уулзалт хийгдсэнээс гадна Монголбанк-ОУВС-ийн ганцаарчилсан уулзалтаар Монгол Улсын Банкны тухай хууль, санхүүгийн тогтвортой байдал, санхүүгийн бодлого, гадаад өр, гадаад секторын үнэлгээ гэх өргөн хүрээний сэдвээр мэдээлэл өгч ажиллав. Цаашид цар тахлын дараах хүндрэлийг даван туулах, их сэргэлтэд бэлтгэх, далайцтай шинэчлэл хийхийн тулд төр, хувийн хэвшлийн тэнцвэрт байдлыг илүү сайжруулж, макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангаж ажиллах нь чухал талаарх байр суурийг ажлын хэсгийн талаас илэрхийлэв. Хэлэлцүүлгийн хүрээнд Монгол Улсад байрлах суурин төлөөлөгчийн газартай нягт уялдаа холбоотой ажиллаж, шаардлагатай хурал, уулзалтуудыг зохион байгуулж, хэрэгцээт мэдээллээр цаг тухайд нь ханган ажиллалаа.

Монголбанкны гадаад харилцааг өргөжүүлж, шинэ хамтын ажиллагааг эхлүүлэх зорилгоор 2021 оны 8 сарын 6-ны өдөр Швейцарын Холбооны Улсын Эдийн Засгийн Газар-тай харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа. Санамж бичгийн хүрээнд тус газраас санхүүжүүлэн хэрэгжүүлдэг Төв банкуудын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр (BCC)-т Монголбанкны төлөөлөл оролцох боломж бий болов. Энэхүү хөтөлбөр нь Монголбанкны мөнгөний бодлогын шинжилгээ, макро-эдийн засгийн судалгаа, статистикийн чиглэлийн чадавхыг бэхжүүлж, олон улсын жишигт улам ойртуулахад жинтэй хувь нэмэр оруулах юм. Швейцарын Холбооны Улсын Эдийн Засгийн Газрын BCC хөтөлбөр нь 2013 оноос хэрэгжиж байгаа ба хөгжиж буй улс орнуудын Төв банкуудын аналитик болон техник экспертиз хөгжүүлэхэд чиглэдэг.

Мөн хамтын ажиллагааны хүрээнд Азийн хөгжлийн банк, Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Олон улсын санхүүгийн корпорацийн дэмжлэгтэйгээр Монголбанканд шаардлагатай техник тусалцааг онлайн хэлбэрээр хэрэгжүүлж ирлээ.

БНСУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хойд бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөл, Олон улсын худалдааны ассоциаци, Экспорт-Импорт банк, БНСУ-ын Төв банк хамтран 2021 оны 11 сарын 18-нд Сөүл хотноо Хойд бүсийн эдийн засгийн олон улсын чуулганыг зохион байгуулж, Монголбанкны Дэд Ерөнхийлөгч оролцлоо. 2021 оны чуулга уулзалтаар Хойд бүсийн буюу байгалийн баялаг ихтэй улс орнууд болох ОХУ, БНХАУ, Казакстан, Монгол, Киргиз, Туркменистан, Украин, Беларусь зэрэг улс орны санхүүгийн бодлого, эдийн засгийн уялдаатай хөгжилд хүрэх арга замын тухай хэлэлцүүлгийг зохион байгуулж Дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван Монгол Улсын цахим шилжилтийн талаар танилцуулга хийв. Мөн форумын хүрээнд Дэд Ерөнхийлөгч нь БНСУ-ын Төв банкны гадаад хамтын ажиллагаа хариуцсан Дэд Ерөнхийлөгч Мин Жва Хонг-той хоёр талт уулзалт хийж, хоёр орны банкны салбарт тулгамдаж буй асуудал, хамтын ажиллагаа, хамтарсан судалгаа зэрэг сэдвийн хүрээнд санал солилцлоо.

Монголбанк нь Бүгд Найрамдах Турк улсын төв банктай 2011 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд тус банкны дэргэдэх Төв банкны Стамбул сургууль (Istanbul School of Central Banking) дээр хоёр талт хөтөлбөр (customized bilateral program)-т цахимаар оролцлоо. 2021 оны хөтөлбөрт Судалгаа, статистикийн газар “Хэрэглээний зээлийн мэдээлэл нэгтгэх, түгээх” сэдвээр хамрагдлаа.

ОУВС-ийн Кавказ, Төв Ази, Монголын бүсийн сургалтын төв (ССАМТАС)-ийн Удирдах хороонд Монголбанк томилогдож, зөвлөлийн шийдвэрлэх уулзалтуудад оролцож, Монголбанкны чадавхыг бэхжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө, хэрэгцээ шаардлагыг танилцуулж ажилласанаас гадна Монголын банкны тогтолцооны онцлогоос хуваалцлаа. Мөн тус төвөөс зохион байгуулсан цахим сургалтад Монголбанкны газар, хэлтсийн захирлууд туршлагаа хуваалцан танилцуулга хийж оролцлоо.

Зүүн Өмнөд Азийн Төв Банкуудын Холбоо (SEACEN) төвөөс тухайн жилд олгодог сургалтаас Монголбанк нь аль нэг сонгосон сэдвээрх сургалтыг зохион байгуулж, хөтлөх үүргийг гишүүн байгууллагын хувьд хүлээдэг хүрээнд Analysis and Modelling of Macro-Financial Linkages ба лекц, дасгал/семинарын хосолсон хэлбэрээр 9 дүгээр сарын 27-ны өдрөөс 10 дугаар сарын 1-ний хооронд цахим хэлбэрээр зохион байгууллаа. Арга хэмжээг нээж Дэд Ерөнхийлөгч үг нэлсэн ба Монголбанкнаас МБГ, ССГ-ын 8 ажилтан хамрагдсан.

Монголбанк 2021 онд Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Зүүн өмнөд Азийн Төв банкуудын холбооны судалгаа, сургалтын төвийн жилийн ээлжит болон удирдах зөвлөлийн хурлуудад онлайнаар тогтмол оролцож, тулгамдсан асуудал хэлэлцүүлэгт илтгэл тавин оролцсон.

Зүүн өмнөд Азийн Төв банкуудын холбооны судалгаа, сургалтын төв, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундесбанк, Бүгд Найрамдах Польш Улсын Төв банк, Швейцарийн Холбооны Улсын Үндэсний Банкны Герзенсий дэх сургалтын төв, Бүгд Найрамдах Франц Улсын Төв банкны Олон улсын банк, санхүүгийн институт, Олон улсын төлбөр тооцооны банкны Санхүүгийн тогтвортой байдлын институт, Олон улсын валютын сангийн Сингапур Улс дахь сургалтын институт, Дэлхийн банкны Нөөцийн зөвлөгөө, удирдлагын түншлэл хөтөлбөр хийгээд бусад орны Төв банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран Ковид-19 цар тахлын үед хүний нөөцийн чадавхийг сайжруулах, хөгжүүлэх чиглэлээр нягт холбоотой ажиллаж, онлайн сургалтуудад Монголбанкны ажилтнуудыг тогтмол хамруулж ажиллав.

#### 4.3 ТӨВ БАНКНЫ ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА

##### *Олон улсын чиг хандлага*

Төв банкны олон нийттэй харилцах харилцаа нь (i) төв банканд хуулиар ногдсон зорилт, (ii) зорилтдоо хүрэх стратеги, арга хэлбэр, (iii) төв банкны бодлогын шийдвэр, түүний үндэслэл, (iv) төв банкнаас цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг эдийн засагт оролцогчдод тайлбарлах үйл ажиллагааны цогц юм. Энэ нь зах зээл дээрх мэдээллийн тэгш бус байдлыг бууруулж, эдийн засагт оролцогчдын хүлээлтийг үр дүнтэй удирдах, эдийн засагт тогтвортой байдлыг бий болгох чухал ач холбогдолтой бодлогын хэрэгсэл болон олон улсад хөгжиж байна. Тус хэрэгсэл нь төв банкны бодлогын үр нөлөөг дээшлүүлэх, институцын ил тод, нээлттэй байдлыг хангах, хараат бус байдлыг бэхжүүлэх зэрэг ач холбогдолтой байдаг. Олон улсад төв банкууд 1990-ээд оноос инфляцыг онилох бодлого эрчимтэй хэрэгжүүлж эхэлснээс хойш зах зээлийн хүлээлтийг удирдах зорилгоор олон нийттэй харилцаанд чухал ач холбогдол өгч иржээ. Ялангуяа 2008-09 оны Дэлхийн санхүүгийн хямралаас хойш олон нийттэй харилцаа нь төв банкны бодлогын чухал арга хэрэгсэл болжээ. Хямралын үед ил тод, нээлттэй байдлаар хэрэгжүүлж буй бодлогоо тайлбарлах нь төв банкуудад итгэх итгэлийг нэмэгдүүлж, бодлогын үр дүнг сайжруулах гарц зам байв. Түүнчлэн, 2020 оноос дэлхийн нийтэд нүүрлээд буй Ковид-19 цар тахлын үеийн эдийн засгийн шокиг зөөлрүүлж, зах зээлийг тогтвортой байлгахад төв банкуудын олон нийттэй харилцаа чухал үүрэг гүйцэтгэсээр байна. Цар тахлын дараах эдийн засгийн сэргэлт нь хэрэглэгчид, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид болон санхүүгийн зах зээлийн оролцогчдын хүлээлтээс ихээхэн шалтгаалах тул үр дүнтэй олон нийттэй харилцаа өндөр ач холбогдолтой хэвээр байна.

*Монголбанкны ил тод байдал, олон нийттэй харилцах харилцаа*

Монголбанк Ковид-19-ийн үеийн тодорхой бус байдал дунд макро эдийн засгийн тогтвортой байдал, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн бодлогын багц арга хэмжээг хэрэгжүүлж, бодлого шийдвэрийн үндэслэлээ олон нийтэд нээлттэй, ил тодоор тайлбарлаж байна. Цар тахлын шокын үед санхүүгийн зах зээлд савлагаа үүсэхээс сэргийлэх, эдийн засгийн хүндрэлийг хохирол багатай даван туулж, цаашдын сэргэлтийг дэмжихэд олон нийттэй харилцаа чухал үүрэгтэй хэрэгсэл болсоор ирлээ. Монголбанк олон нийттэй харилцах сувгуудаа хөгжүүлж, мэдээллийн агуулга чанарыг сайжруулан илүү оновчтой арга хэлбэрээр түгээхэд анхаарч дараах байдлаар ажиллалаа. Үүнд:

- **Бодлогын шийдвэр:** Мөнгөний бодлогын хорооны хурлын товыг олон нийтэд урьдчилан зарлаж, хурлын шийдвэр болгоныг мөнгөний бодлогын мэдэгдэл болон хэвлэлийн хурлаар нээлттэй танилцуулж байна.
- **Тайлан, судалгааны товхимол, статистик мэдээлэл:** Мөнгөний бодлогын шийдвэрийн үндэслэл болсон тооцоолол, эдийн засгийн шинжилгээ, төсөөллийг агуулсан Инфляцын тайлан болон Төв банкнаас нийтэлдэг бусад тайлан эмхэтгэл, судалгааны товхимол, статистик мэдээллүүдийг тогтсон хуваарийн дагуу олон нийтэд түгээж, агуулга болон чанарыг тасралтгүй сайжруулж байна.
- **Мэдээллийн хүртээмж, зорилтот бүлгүүд:** Төв банкнаас түгээж буй мэдээллийн агуулгыг товч контент, инфографик, постер, видео шторк хэлбэрт шилжүүлэн илүү энгийн, ойлгомжтой байдлаар олон нийтэд түгээхэд анхаарч ажиллаж байна. Түүнчлэн, мэдээлэл түгээхдээ зах зээлийн мэргэжлийн оролцогчид, төрийн шийдвэр гаргах байгууллагууд, олон улсын байгууллагууд, судалгааны байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд болон иргэд, аж ахуйн нэгжүүд тус бүрийн онцлог, хэрэгцээ шаардлагад тохирсон арга хэлбэрийг сонгож байна.
- **Төв банкны олон нийттэй харилцах сувгууд:** Монголбанкны цахим хуудас (албан вебсайт), нийгмийн цахим сүлжээ (сошиал нетворк)-ний хуудсуудыг өдөр тутам хөгжүүлж, хэвлэмэл бүтээгдэхүүнүүдийн агуулга, чанарыг сайжруулав. Цар тахлын үеийн эрсдэлийг удирдах зорилгоор 2021 онд хэвлэлийн хурал, уулзалт семинар, сургалт болон олон нийтийг цуглуулах бусад арга хэмжээнүүдийг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар цахим хэлбэрээр зохион байгуулав.

*Монголбанкны ил тод байдал, олон нийттэй харилцааны үнэлгээ*

Монголбанкны олон нийттэй харилцах үйл ажиллагаанд олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэхийн зэрэгцээ цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сайжруулж ирлээ. Үүний үр дүнд Төв банкны бодлого, үйл ажиллагааны олон нийтэд танигдсан байдал харьцангуй нэмэгдсэн болох нь “Монголбанкны ил тод байдал, олон нийттэй харилцааны үнэлгээ” (ДоБиЧи Консалтинг, 2021)-ээс тодорхой байна. Хөндлөнгийн мэргэжлийн байгууллага хийж, Улаанбаатар хотын 9 дүүрэг, 158 байгууллагын төлөөлөл нийт 1056 түүврээс авсан тус түүвэр судалгаа нь дараах үр дүнг харуулж байна. Үүнд:

**1) Танигдсан байдлын матрицын үнэлгээ нэмэгдсэн**

Судалгаанд оролцсон нийт иргэдийн итгэл, танигдсан байдал (51%, 42%) нь матрицын үнэлгээ дундаж утгад ойр, мөн алслагдсан хороодын иргэдийн матрицын үнэлгээ (50%, 42%) нь түүврийн дундаж утгаас ялгаагүй гарсан байна. Иргэдийн түүвэртэй харьцуулахад судлаачид Монголбанкны үйл ажиллагааг илүү мэддэг, танигдсан байгаа нь харагдаж байна. Хувийн хэвшил болон төрийн байгууллагад ажиллаж буй оролцогчид илүү итгэлтэй, илүү мэдлэг, мэдээлэлтэй байдаг бол мэргэжлийн байгууллагын төлөөлөл, судлаачид болон зохицуулагч байгууллагын төлөөлүүд дундаас дээгүүр итгэлтэй байна. Энэхүү судалгааны үр дүн нь 2017 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад харьцангуй сайжирсан, дундаас дээш түвшинд ирснийг тодорхой харж болохоор байна.

## 2) EG-индексийн үнэлгээ сайжирсан

Олон улсад төв банкны ил тод байдлыг үнэлэхдээ EG-индексийг / Eijffinger and Geraats index (2002)/ хэрэглэдэг. EG-индекс нь 5 бүлэг дотроо 3 дэд нийт 15 асуултуудтай. Асуултууд нь 2 болон 3 сонголттой хариултуудтай. Хариултуудад 0, 0.5, 1 гэсэн оноогоор харгалзан дүгнэх бөгөөд индексийг эдгээр оноонуудын нийлбэрээр тооцно. EG-индекс хамгийн багадаа 0, хамгийн ихдээ 15 гэсэн утга авна. Индексийн утга 15 уруу тэмүүлэх тусам тухайн төв банкны ил тод байдал сайн байгааг харуулна.

Монголбанкны ил тод байдлыг EG индексийн түвшингээр нийт судлаачдын 37% нь 12-15 оноо, 35% нь 9-12 оноо, 20% нь 6-9 оноо, 7% нь 3-6 оноо, 1% нь 0-3 оноо гэж үнэлсэн ба EG индекс дунджаар 10.4 оноо буюу 69.3%-тай байна. Монголбанкны итгэлтэй байдал дундаас дээгүүр үнэлэгдсэн бөгөөд иргэд илүү их итгэлтэй байдаг бол байгууллагуудын хувьд дунд зэргийн итгэлтэй байна. Монголбанкны олон нийттэй харилцах үйл ажиллагааг нийт түүвэр дундаас дээгүүр үнэлсэн бөгөөд байгууллагууд дундаас доогуур гэж үнэлж байна. Үүнээс харахад Монголбанкнаас танилцуулж буй мэдээ, мэдээлэл, үйл ажиллагаа нь 2016 оноос хойш олон нийтэд хүрч, сайжирсан, Монголбанкинд итгэх итгэл нэмэгдсэн, олон нийттэй харилцах үйл ажиллагаа үр дүнгээ өгч буйг харж болохоор байна.

### *Эрдэм шинжилгээний бага хурал*

Монголбанкны нэрэмжит эрдэм шинжилгээний бага хурлыг цар тахлын нөхцөл байдлаас хамаарч зайнаас цахимаар зохион байгуулсан нь халдвар хамгааллын дэглэмийг сахихын хамт оюутан, судлаачдын эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх судалгааг дэмжсэн, оролцогчдын хүртээмжийг хангасан арга хэмжээ боллоо. Энэ удаагийн хурал нь Монгол Улсад хоёр шатлалт банкны тогтолцоо үүсч хөгжсөний 30 жилийн ойтой давхцсанаараа онцлог болов. Түүнчлэн, Монголбанкнаас хийж байгаа судалгаа, мэдээллийн хүртээмжийг сайжруулах, глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд гарч буй өөрчлөлтүүдийг мэдээлэх зорилгоор хоёр долоо хоног тутмын гадаад орчны тойм мэдээллийн 20 дугаарыг бэлтгэн хүргэв.

### *Монголбанкны мэдээлэл*

“Монголбанкны мэдээлэл” товхимол бэлтгэж түгээх ажлын хүрээнд тайлант хугацаанд нийт 6 дугаар эрхлэн гаргаж, 2800 хувийг хэвлүүлэн дугаар бүрийг МУЕТГ, УИХ, ЗГ, арилжааны банкууд, Монголбанкны газар нэгжүүд, орон нутаг дахь хэлтэс салбар, аймаг, сумын ЗДТГ, номын сан, их, дээд сургуулиудад түгээж ажиллалаа.

Монголбанк, Цагдаагийн Ерөнхий газар, Монголын банкны холбоо хамтран иргэд, олон нийтэд чиглэсэн санхүүгийн залилан, луйвраас сэрэмжлүүлэх зорилго бүхий “Ятгах тусам нягтал” 4 дэх удаагийн аяныг 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс 10-р сарын 31-ний өдрийг дуустал хамтран зохион байгууллаа.

### *Сэтгүүлчдэд эдийн засаг, санхүүгийн суурь мэдлэг олгох сургалт*

Сэтгүүлчдэд эдийн засаг, санхүүгийн суурь мэдлэг олгох анхан шатны сургалтыг 2021 оны I улиралд хэвлэл мэдээллийн байгууллагын 30 сэтгүүлчдийг хамруулан 4 өдрийн турш зохион байгуулж, амжилттай хамрагдсан сэтгүүлчдэд гэрчилгээг олгов. Цаашлаад анхан шатны мэдлэг олгох сургалтад хамрагдсан сэтгүүлчдийг ахисан түвшний сургалтад хамруулахаар төлөвлөөд байсан ч цаг үеийн онцгой нөхцөл байдалтай холбоотой хойшлогдов. Мөн сар бүр тогтмол сэтгүүлчдэд эдийн засгийн талаар цаг үеийн мэдээлэл өгөх өглөөний уулзалт, сургалтыг зохион байгуулдаг. Уулзалтад Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн Дэд Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч болон газар, хэлтсийн захирлууд мэдээлэл өгч оролцдог бөгөөд 2021 онд нийт 12 удаагийн сургалтад давхардсан тоогоор 180 орчим сэтгүүлчид хамрагдаж мэдээлэл авсан.



#### 4.4 МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-наас Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлд тусгасан Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах хүрээнд дараах шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэв.

##### 1. Үндэсний хөтөлбөр

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргасан 40 Зөвлөмжийн Зөвлөмж 1-т улс орнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ үнэлэх, Зөвлөмж 2-т эрсдэлийн үнэлгээний үр дүнд суурилсан үндэсний бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөсөн байдаг. Түүнчлэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх, уг үнэлгээний үр дүнд суурилсан үндэсний бодлого, хөтөлбөр боловсруулж батлуулахаар заасан.

Энэ хүрээнд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг 2020-2021 онд хийж гүйцэтгэсэн бөгөөд төр, хувийн хэвшлийн 52 гаруй байгууллагын 128 төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг Сангийн сайдын тушаалаар байгуулсан. Ажлын хэсгээс банк, үнэт цаас, даатгал, санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид зэрэг зохицуулалттай салбар тус бүрийн хувьд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлсэн. Улмаар Санхүүгийн мэдээллийн албанаас ФАТФ-ын 40 Зөвлөмж болон Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн “Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр” болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох нийтлэг журам, аргачлалын дагуу боловсруулав. Мөн хөтөлбөрийн төслийг боловсруулах чиглэлээр Дэлхийн банкны төслийн хүрээнд олон улсын зөвлөхтэй хамтран ажиллаж, олон улсын жишигт нийцүүлсэн.

“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр” нь нийт 8 зорилго, 50 гаруй зорилтоос бүрдсэн бөгөөд олон улсын стандартын шаардлагыг хангах, Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлж сайжруулах арга хэмжээг багтаасан. Уг хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2021 онд Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл болон Терроризмтой тэмцэх зөвлөлийн хуралдаанд нийт 6 удаа танилцуулан хэлэлцүүлснээс гадна албан бичгээр санал авч, нэг өдрийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж, “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газраар батлуулах байсныг өөрчилж, УИХ-аар батлуулахаар болсон. Иймд Санхүүгийн мэдээллийн албанаас Үндэсний хөтөлбөрийг батлуулах чиглэлээр хууль тогтоомжид заасны дагуу холбогдох судалгааг Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудтай хамтран хийж гүйцэтгэж байна.

Энэхүү Үндэсний хөтөлбөрөөр дамжуулан УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ач холбогдолтой юм.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд төр, хувийн хэвшлийн байгууллагуудын гадаад, дотоод хамтын ажиллагаа чухал үүрэгтэй. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэдэг бөгөөд эдгээр зөвлөлд төрийн 17 гаруй байгууллагын төлөөлөл ажилладаг. Санхүүгийн мэдээллийн албанаас 2021 онд олон улсын байгууллагууд болон Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд, хувийн хэвшилтэй тогтмол хамтран ажиллав.

|                                                                                    |                                                                                                                               |                                                                                                         |                                                                                    |                                                                                      |                                                                                     |
|------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------|
|   | <br><b>ХУУЛЬ ЗҮЙ,<br/>ДОТООД ХЭРГИЙН ЯАМ</b> | <br><b>САНГИЙН ЯАМ</b> |   |    |  |
| Монголбанк                                                                         | Хууль Зүй,<br>Дотоод Хэргийн Яам                                                                                              | Сангийн Яам                                                                                             | Улсын Ерөнхий<br>Прокурорын Газар                                                  | Санхүүгийн Зохицуулах<br>Хорлоо                                                      | Улсын Дээд Шүүх                                                                     |
|   |                                              |                        |   |   |  |
| Авлагтай Тэмцэх<br>Газар                                                           | Тагнуулын Ерөнхий<br>Газар                                                                                                    | Терроризмтой Тэмцэх<br>Зөвлөл                                                                           | Цагдаагийн Ерөнхий<br>Газар                                                        | Гаалийн Ерөнхий Газар                                                                | Улсын бүртгэлийн<br>Ерөнхий Газар                                                   |
|  |                                             |                       |  |  |                                                                                     |
| Шүүхийн Ерөнхий<br>Зөвлөл                                                          | МОНГОЛ УЛСЫН<br>ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ                                                                                         | Шүүхийн Шийдвэр<br>Гүйцэтгэх Ерөнхий Газар                                                              | Таваарын Ерөнхий<br>Газар                                                          | Засгийн Газрын Хэрэг<br>Зэрлэх Газар                                                 |                                                                                     |

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл 2021 онд нийт 2 удаа, Хамтын ажиллагааны зөвлөл 3 удаа дараах байдлаар хуралдсан байна.

Үндэсний зөвлөд, Хамтын ажиллагааны зөвлөлийн хуралдсан байдал  
/2021 он/

```
graph TD; A[Үндэсний зөвлөд, Хамтын ажиллагааны зөвлөлийн хуралдсан байдал /2021 он/] --- B[ХАЗ]; B --- C[ХАЗ]; C --- D[5 дугаар сарын 13]; C --- E[9 дүгээр сарын 7]; C --- F[12 дугаар сарын 23]; D --- G[7 дугаар сарын 9]; E --- H[10 дугаар сарын 25];
```

| Хуралдсан байдал   | Хуралдсан өдөр |
|--------------------|----------------|
| 5 дугаар сарын 13  | ХАЗ            |
| 7 дугаар сарын 9   | ХАЗ            |
| 9 дүгээр сарын 7   | ҮЗ             |
| 10 дугаар сарын 25 | ХАЗ            |
| 12 дугаар сарын 23 | ҮЗ             |

МОНГОЛБАНК ЖИЛИЙН ТАЙЛАН 2021 | 75



Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн 2021 онд зохион байгуулсан ээлжит хурлуудаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэв. Үүнд:

- Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайлан;
- Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл;
- Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлэх ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээг ахиулах Монгол Улсын 2021, 2022 оны явцын тайлан;
- ФАТФ-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт тайлагнах шаардлагын тухай;
- Виртуал хөрөнгийн салбарын зохицуулалт, цаашдын зорилтууд, салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр баталсан “Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө” болон түүний хэрэгжилт;
- Дотоодын их, дээд сургуулиудтай Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллах тухай.

Хамтын ажиллагааны зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 5 дугаар сарын 04-ны өдрийн А-110 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Улмаар 17 төрийн байгууллагын 27 төлөөллөөс бүрдсэн Зөвлөлийн шинэ бүрэлдэхүүнийг Монголбанкнаас даргалахаар болсон. Мөн Зөвлөлийн дэргэд Судалгаа, дүн шинжилгээ хийх, Хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Хууль сахиулах, Хяналт шалгалтын болон Хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр 5 ажлын хэсгийг байгуулж, ажлын төлөвлөгөөг батлуулан ажилласан.

Түүнчлэн Хамтын ажиллагааны зөвлөлөөс Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх чиглэлээр 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Дотоод хэргийн их сургуультай “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулсан. Санамж бичгийн хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй боловсон хүчнийг чадавхжуулах, сургагч багш нарыг бэлтгэх, судалгаа шинжилгээ хийх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах юм.

Гадаад хамтын ажиллагааны хувьд Санхүүгийн мэдээллийн албанаас 2021 онд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллав. Тухайлбал, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, АНУ-ын Сангийн яам зэрэг олон улсын донор байгууллагуудтай хамтран техник туслалцааны төсөл хэрэгжүүлсэн. Мөн ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Эгмонт бүлэг зэрэг олон улсын байгууллагуудад холбогдох судалгаа, мэдээллийг хүргүүлж ажилласнаас гадна цахим сургалт семинаруудыг 2021 онд идэвхтэй зохион байгуулав. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс нийт 15 гаруй олон улсын хэмжээний семинар, сургалт, хуралд Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл болон хувийн хэвшлийн давхардсан тоогоор 575 орчим төлөөллийг хамруулав.

### III. Хяналт шалгалт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас хяналт шалгалтын зохицуулагч байгууллагууд болох Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон мэргэжлийн холбоодтой тогтмол хамтран ажиллав. Тухайлбал, 2021 онд мэдээлэх үүрэгтэй этгээдийн хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих чиглэлээр мэргэжлийн холбоод болох Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын нотариатчдын танхим, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллав.

Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд мэргэжлийн холбоодод зориулан санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хяналт шалгалт хийх гарын авлагыг боловсруулсан. Мөн зохицуулагч байгууллагуудын хянан шалгагчдыг эрсдэлд суурилсан хяналт шалгалт, хамтын ажиллагаа, мэдээлэл солилцооны талаарх олон улсын байгууллагуудын цахим сургалт, семинарт хамруулснаас гадна мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд зориулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргийг таниулах, эрсдэлийг ойлгуулах сургалтуудыг зохион байгууллаа.

Санхүүгийн мэдээллийн алба нь хяналт шалгалтын зохицуулагч байгууллагуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн хяналт шалгалтын талаарх нэгдсэн статистик мэдээллийг гаргадаг. Дараах хүснэгтэд нийт мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийсэн хяналт шалгалт болон авсан арга хэмжээний талаар харуулав (Хүснэгт 4.1).

**Хүснэгт 4.1 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа**

| Үзүүлэлт                                                                            | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|-------------------------------------------------------------------------------------|------|------|------|------|
| Банканд хийсэн хяналт шалгалт                                                       | 14   | 24   | 19   | 17   |
| Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийсэн хяналт шалгалт                     | 1025 | 269  | 146  | 5897 |
| Банк болон банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавигдсан актын тоо            | 4    | -    | 1    | 47   |
| Банк болон банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд өгсөн хугацаат үүрэг даалгавар | 272  | 245  | 444  | 261  |

Эх сурвалж: Монголбанк, СМА.

### IV. Мэдээлэл цуглуулах

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдээс 20 сая төгрөгөөс дээш дүнтэй Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан болон Сэжигтэй гүйлгээний тайланг хүлээн авдаг. Мөн хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлсэн 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгөний гаалийн мэдүүлгийг гаалийн байгууллагаас сар бүр хүлээн авч ажиллаж байна (Хүснэгт 4.2).

Түүнчлэн ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой Харилцан үнэлгээ, Үндэсний эрсдэлийн үнэлгээ болон бусад тайлан, мэдээнд шаардагдах статистик мэдээллийг нарийвчлан, задаргаатай гаргахад цаг хугацаа шаардаж байсан тул мэдээлэл цуглуулах маягыг сайжруулах хэрэгцээ үүссэн. Энэ хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А-93 дугаар тушаалаар “Санхүүгийн мэдээллийн албаны статистикийн мэдээлэл гаргах журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд шинэ маягтууд нь мэдээлэх үүрэгтэй этгээд тус бүрээр статистик мэдээллийг ялгаж, тоон болон чанарын шинж чанараар нь нарийвчлан задалж, тусгахаар болсон.

**Хүснэгт 4.2 Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн гүйлгээний тоо /2018-2021/**

| Үзүүлэлт                              | 2018    | 2019    | 2020    | 2021    |
|---------------------------------------|---------|---------|---------|---------|
| Бэлэн мөнгөний гүйлгээний тоо         | 669,910 | 562,926 | 402,496 | 336,518 |
| Сэжигтэй гүйлгээний тоо               | 1,596   | 2,385   | 3,014   | 1,801   |
| Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тоо | 126,944 | 131,715 | 143,191 | 211,176 |
| Гаалийн мэдүүлгийн тоо                | 1,413   | 11,870  | 5,520   | 2,660   |


Эх сурвалж: Монголбанк, СМА

2021 онд нийтдээ 1,801 сэжигтэй гүйлгээний тайлан хүлээн авсан нь өмнөх онтой харьцуулахад 41 хувиар, гаалийн мэдүүлгийн тайлангийн тоо 52 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь Ковид-19 цар тахлын нөлөөллөөс үүдэн зорчих хөдөлгөөн, хил, гаалийн хөдөлгөөнийг хязгаарласантай холбоотой. Харин гадаад төлбөр тооцооны гүйлгээ өмнөх онтой харьцуулахад 32 хувиар өссөн байна.

**V. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх**

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18.1.1 дэх хэсэгт заасны дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх үндсэн чиг үүргийнхээ хүрээнд 2021 онд дараах байдлаар сэжигтэй гүйлгээний тайланд дүн шинжилгээ хийв (Хүснэгт 4.3).

**Зураг 4.3 Сэжигтэй гүйлгээний тоо болон дүн шинжилгээ хийгдсэн, хийгдэж буй сэжигтэй гүйлгээний тоо /2018-2021/**



Эх сурвалж: Монголбанк, СМА

**Хүснэгт 4.3. Сэжигтэй гүйлгээний тоо болон дүн шинжилгээ хийгдсэн, хийгдэж буй сэжигтэй гүйлгээний тоо /2018-2021/**

| Үзүүлэлт                                                         | 2018  | 2019  | 2020  | 2021  |
|------------------------------------------------------------------|-------|-------|-------|-------|
| Сэжигтэй гүйлгээний тоо                                          | 1,596 | 2,385 | 3,014 | 1,801 |
| Дүн шинжилгээ хийгдсэн болон хийгдэж буй сэжигтэй гүйлгээний тоо | 151   | 84    | 509   | 551   |

Эх сурвалж: Монголбанк, СМА

Мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлэх сэжигтэй гүйлгээний тоо өмнөх онтой харьцуулахад буурсан байгаа ч, ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тайланд Санхүүгийн мэдээллийн албанаас хийж байгаа дүн шинжилгээний тоо өмнөх оноос 7.6 хувиар өссөн байна. Энэ нь Санхүүгийн мэдээллийн албаны шинжээчид холбогдох сургалт, семинарт тогтмол хамрагдаж, ур чадвар, чадавхаа бэхжүүлж ажилласантай холбоотой.

## VI. Мэдээлэл солилцох

### VI.a Дотоодын байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах

Дотоод хамтын ажиллагааны хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18.6 дахь хэсэгт зааснаар эрх бүхий байгууллагуудтай мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл солилцон хамтран ажиллаж, гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлж ажилладаг. Энэ хүрээнд 2021 онд дараах байдлаар мэдээлэл солилцож ажиллав (Хүснэгт 4.4).

**Хүснэгт 4.4. Санхүүгийн мэдээллийн албаны дотоодын эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцсон байдал**

| Үзүүлэлт                                                                                         | 2018  | 2019  | 2020  | 2021  |
|--------------------------------------------------------------------------------------------------|-------|-------|-------|-------|
| СМА-наас дотоодын хууль сахиулах байгууллагуудад шалгуулахаар шилжүүлсэн сэжигтэй гүйлгээний тоо | 181   | 48    | 505   | 539   |
| Мэдээлэл авах зорилгоор дотоодын хууль сахиулах байгууллагуудаас СМА-д ирүүлсэн хүсэлт           | 2,510 | 2,396 | 3,336 | 3,665 |
| Хууль сахиулах байгууллагуудаас СМА-д ирүүлсэн хүсэлтийн дагуу явуулсан хариу                    | 2,300 | 2,634 | 3,310 | 3,834 |

Эх сурвалж: Монголбанк, СМА

Санхүүгийн мэдээллийн алба нь дотоодын эрх бүхий байгууллагуудтай холбогдох хуулийн хүрээнд харилцан мэдээлэл солилцдог бөгөөд 2020 оноос эхлэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн санд цахимаар хандах эрх авч гэрээ байгуулсан бөгөөд мэдээлэл солилцон хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлж, иргэн, хуулийн этгээдийн анхан шатны бүртгэлийн лавлагаа, мэдээллийг цахимаар авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зөвхөн төрийн байгууллагаар хязгаарлагдахгүй, мөн хувийн хэвшил түүн дотроо банк, банк бус санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн хамтын ажиллагаа, уялдаа холбоо чухал юм. Иймд цаашид Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хоорондох мэдээлэл солилцоог сайжруулах, мэдээлэл солилцох үйл явцыг хялбарчлах талаар олон улсын туршлагыг судлан ажиллаж байна.

### VI.б Гадаадын эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцох

ФАТФ-ын Зөвлөмж 29-т зааснаар Санхүүгийн мэдээллийн алба нь Эгмонт бүлэг болон бусад улсын Санхүүгийн мэдээллийн албатай мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйлдэлтэй холбоотой мэдээлэл солилцон хамтран ажилладаг бөгөөд энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь сүүлийн жилүүдэд дараах байдлаар Эгмонт сүлжээгээр мэдээлэл солилцон, хамтран ажиллав (Хүснэгт 4.5).

**Хүснэгт 4.5. Эгмонт сүлжээгээр мэдээлэл солилцсон байдал**

| Үзүүлэлт                                                                                     | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|----------------------------------------------------------------------------------------------|------|------|------|------|
| СМА-аас гадаадын СМА-д явуулсан хүсэлтийн тоо                                                | 231  | 238  | 353  | 140  |
| Гадаадын СМА-д явуулсан хүсэлтийн дагуу ирүүлсэн хариуны тоо                                 | 193  | 202  | 247  | 165  |
| Гадаадын СМА-аас мэдээлэл авах чиглэлээр СМА-д ирүүлсэн хүсэлтийн тоо                        | 126  | 133  | 123  | 149  |
| Гадаадын СМА-аас мэдээлэл авах чиглэлээр СМА-д ирүүлсэн хүсэлтийн дагуу явуулсан хариуны тоо | 126  | 144  | 112  | 129  |

Эх сурвалж: Монголбанк, СМА

Санхүүгийн мэдээллийн алба нь Эгмонт сүлжээгээр дамжуулан мэдээлэл солилцохоос гадна хоёр талын хооронд байгуулсан Харилцан, ойлголцлын санамж бичгийн дагуу мэдээлэл солилцож, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр туршлага судлах, сургалт, семинар зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллах боломжтой. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь хамтран ажиллах гадаад улсын ижил төрлийн байгууллагын цар хүрээг өргөжүүлэх зорилгоор БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Макао, Бүгд Найрамдах Ардчилсан Зүүн Тимор Улс болон Камбожийн Хаант улсын Санхүүгийн мэдээллийн албатай санамж бичиг байгуулах ажлыг эхлүүлсэн бөгөөд 2021 оны 11 дүгээр сард Бүгд Найрамдах Ардчилсан Зүүн Тимор Улсын Санхүүгийн мэдээллийн албатай Харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа.

## VII. Мэдээллийн систем, програм хангамж

Санхүүгийн мэдээллийн албанаас хуульд заасан мөнгө угаах, түүнд холбогдох гэмт хэрэг зөрчил, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээлэл болон мэдээлэх үүрэгтэй этгээдээс тайлан мэдээг хүлээн авах, түүнд дүн шинжилгээ хийх, үр дүнд шаардлагатай мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүргийн хэрэгжилтийн үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх хүрээнд goAMLJ (goAML) програмыг 2019 оны 12 дугаар сараас үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байгаа билээ.

Санхүүгийн мэдээллийн алба нь 2020-2021 онуудад goAMLJ програмыг ашиглалтад оруулж, нэвтрүүлэхэд анхааран ажиллаж, банкуудтай хамтран тэдгээрийн дотоод системд нийцүүлэн goAMLJ програмыг мэдээллийн схемийг боловсруулах, банкуудаас хуульд заасан 3 төрлийн тайлан мэдээллийг тус програмаар дамжуулан илгээх, хүлээн авах үйл ажиллагаанд зааварчилгаа өгч, илэрсэн алдааг цаг тухай бүрт тодорхойлж, залруулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

2021 оны 1 болон 2 дугаар улиралд мэдээлэх үүрэгтэй этгээд болон хэрэглэгчдэд зориулан goAMLJ програмыг ашиглах гарын авлагыг орчуулан мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд хүргүүлж, 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн goAMLJ програмын тайлан хүлээн авах порталын туршилтыг банкуудтай хийж эхэлсэн. Мөн сэжигтэй гүйлгээний тайланд нэмэлт мэдээлэл хүссэн загвар файлыг үүсгэж, холбогдох саналуудыг тусган туршилтыг амжилттай гүйцэтгэлээ. Цаашлаад 2021 оны 3 дугаар улиралд 2 удаа банкуудын холбогдох ажилтнуудтай цахим уулзалт хийж, програм ашиглалт, гарч буй алдаа, түүнийг залруулах чиглэлээр хэлэлцүүлэг хийв. Мэдээлэх үүрэгтэй этгээдүүдээс гадна албаны шинжээч нарыг сурган дадлагажуулах, програмын ашиглалт, тайлан мэдээлэл хүргүүлэх үед гарсан алдаа дутагдлыг арилгах ажлууд 2021 оны турш үргэлжилжээ.

Улмаар бүх банкуудад урьдчилсан байдлаар goAMLJ програм хангамжийг нэвтрүүлж, тайлан мэдээлэл хүлээн авч эхлээд байна. Цаашид Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс 2022 онд банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдийг goAMLJ порталд холбох, албан ёсоор бүх мэдээлэх үүрэгтэй этгээдээс тайлан хүлээж авах үйл ажиллагааг эхлүүлэхээр зорин ажиллаж байна.

## VIII. Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа

Санхүүгийн мэдээллийн албанаас 2021 онд мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд зориулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн соён гэгээрүүлэх, мэдлэгийг дээшлүүлэх баримт бичгүүдийг боловсруулж, олон нийтэд түгээв. Тухайлбал:

- Стратегийн дүн шинжилгээний 2020 оны тайлан;
- Санхүүгийн мэдээллийн албаны 2020 оны жилийн тайлан;
- Виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх ФАТФ-ын гарын авлагын орчуулга;

- Виртуал хөрөнгийн ерөнхий ойлголт, зах зээл ба зохицуулалтын нөхцөл байдлын гарын авлагыг зохицуулагч байгууллага болон ажлын хэсгийн гишүүдэд зориулан боловсруулж, холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн;
- Банк бус санхүүгийн байгууллага, Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, Үнэт цаасны зах зээлд оролцогч, Хадгаламж зээлийн хоршоо, Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд зориулсан “Сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэх гарын авлага” болон “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүдийн талаарх гарын авлага”-ууд;
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулан “Виртуал хөрөнгийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээний шинж тэмдгүүд”.


Дээрх гарын авлага, заавар зөвлөмжүүдийг Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудас [fiu.mongolbank.mn](http://fiu.mongolbank.mn) дээр байршуулав.

### IX. Чадавхыг бэхжүүлэх, нөөц бололцоог сайжруулах

Санхүүгийн мэдээллийн алба нь АНУ-ын Сангийн яамны техник туслалцааны хөтөлбөрөөр дамжуулан ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, сүүлийн үеийн чиг хандлагын талаар мэдлэгээ дээшлүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн хамтран ажиллаж байна. Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнууд гадаад, дотоод хамтын ажиллагааны хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мэргэжлийн сургалт, семинарт байнга хамрагдахаас гадна гадагшаа чиглэсэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх тухай соён гэгээрүүлэх ажлуудыг тогтмол зохион байгуулав.

Тухайлбал, Санхүүгийн мэдээллийн албанаас 2021 онд нийт 34 сургалтыг дангаар болон холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Эдгээр сургалтад төр, хувийн хэвшлийн байгууллагын 2700 гаруй төлөөлөл оролцсон бөгөөд виртуал хөрөнгийн салбарын зохицуулалтын орчин, эцсийн өмчлөгчийг тодорхойлох аргачлал, цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа, холбогдох сэжигтэй гүйлгээний шинж чанар, цахим луйврын гүйлгээнээс урьдчилан сэргийлэх, ФАТФ-ын 40 Зөвлөмж, олон улсын туршлага, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зэрэг голлох сэдвийг хамруулсан.

Зураг 4.4. Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинар болон оролцогчдын тоо /2018-2021/





| Үзүүлэлт                                                                           | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|------------------------------------------------------------------------------------|------|------|------|------|
| Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан сургалт, семинарын тоо            | 1    | 7    | 4    | 15   |
| Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан сургалт, семинарт оролцогчдын тоо | 40   | 444  | 136  | 1377 |
| Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинарын тоо              | 13   | 21   | 20   | 19   |
| Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинарт оролцогчдын тоо   | 543  | 1081 | 886  | 1387 |

Эх сурвалж: Монголбанк, СМА

## 4.5 ДОТООД АУДИТ

Дотоод аудитын газар нь Монголбанкны бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд газар дээрх аудит, шалгалт хийх, зайны болон дараалсан хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр хангах, аудит, хяналт шалгалтын үр дүнгээр шийдвэр гаргуулж, биелэлтийг хангаж ажиллах замаар байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан аудитын төлөвлөгөө, удирдамжийн дагуу 13 нэгжийн үйл ажиллагаанд иж бүрэн, 7 нэгжийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн аудит хийж, үр дүнг удирдлагад танилцуулж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг батлуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллалаа.

Монголбанкны 2020 оны санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулах ажлыг удирдан зохион байгуулж, хөндлөнгийн аудитын компанитай хамтран ажиллаж, тайланг төлөвлөсөн хугацаанд дуусгасан.

Дотоод аудитын газрын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан аудит хийх аргачлалыг нэвтрүүлэх зорилгоор Дэлхийн банкнаас Монгол Улсад хэрэгжүүлж буй “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-д хамрагдаж, зөвлөх үйлчилгээ авч ажилласан. Зөвлөхтэй хамтран ажиллах 2021 оны ажлын төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, төлөвлөгөөний дагуу зөвлөхийн ирүүлсэн холбогдох материал болон бусад орны мэдээллийн технологийн аудит хийх аргачлалууд, КОБИТ тогтолцоог харьцуулан судалсны үндсэн дээр “Монголбанкны мэдээллийн технологийн аудит хийх ерөнхий заавар”-ын төсөл, эрсдэлийн үнэлгээтэй холбоотой олон улсын стандартуудыг судалж “Аудитын эрсдэлийн үнэлгээ хийх, аудитын төлөвлөгөө боловсруулах заавар”-ын төслийг тус тус боловсруулсан. Мөн “Монголбанкны дотоод аудитын дүрэм”-ийг олон улсын стандартад нийцүүлэн шинэчилэн боловсруулсан бөгөөд Монголбанкны онцлогт хэрхэн нийцүүлэх талаар судлан, дүрмийн төслийг сайжруулж байна.

“Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-д хамрагдах хугацааг сунгаж, үргэлжлүүлэн хамтран ажиллах хүсэлтээ Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн зохицуулагчид хүргүүлж, Монголбанкны дотоод аудитын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн сайжруулах чиглэлээр Дэлхийн банкны зөвлөхтэй үргэлжлүүлэн хамтран ажиллаж байна.

## 4.6 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Монголбанк гадаад валютын улсын нөөцийн удирдлага, төв банкны зээл, санхүүжилтийн үйл ажиллагаанд учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийн удирдлагын хүрээнд гадаад валютын улсын нөөцийн дунд болон богино хугацаанд баримтлах хөрөнгө оруулалтын бүтэц, бенчмарк, лимитийг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлд нь хяналт тавих, тайлагнах, төв банкны зээл, санхүүжилтийн барьцаа хөрөнгийн шалгуурыг тодорхойлох, хөрөнгийн жагсаалтыг боловсруулах,



санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийг тооцох аргачлалыг боловсруулах, эрсдэлийг хямдруулалтын хувь хэмжээг тогтоох, гүйцэтгэлд нь хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа. Түүнчлэн үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хүрээнд төв банканд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж үнэлэх, хяналт тавих, тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлж, үүсэх эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгахад удирдан ажиллав.

## **Санхүүгийн эрсдэлийн удирдлага**

### ***Зээлийн эрсдэл***

Зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд гадаад валютын улсын нөөцийг хөрөнгө оруулалтын төрлөөр, харилцагч банк, санхүүгийн байгууллагаар, зээлжих зэрэглэл болон улс орноор хадгаламжийн лимит тогтоож ажилласан бөгөөд Ковид-19 цар тахлаас үүдэлтэй дэлхийн засаг, санхүүгийн зах зээлийн тодорхой бус байдал өндөр хэвээр байсан тул учирч болзошгүй зээлийн эрсдэлээс сэргийлэх үүднээс нөөцийг хөгжингүй орнуудын төв банкууд, засгийн газрын баталгаатай байгууллага, олон улсын санхүүгийн байгууллагуудад түлхүү байршуулсан байна. Түүнчлэн зээлийн эрсдэлийг хязгаарлах зорилгоор гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулах хадгаламжийн дээд хувь хэмжээг багцын оновчлолын аргаар тодорхойлон стратегийн хөрөнгө оруулалтын бүтцийг баталж, хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллалаа.

Тайлант хугацаанд төвлөрлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд бусад улсын төв банк, олон улсын санхүүгийн байгууллагын тухайн нэг харилцагч банк, санхүүгийн байгууллагад олгох лимитийг тогтоохдоо ашигладаг зээлийн эрсдэлийн загвар, аргачлал болон практикийг үйл ажиллагаандаа ашигласны зэрэгцээ зах зээлд суурилсан хэмжүүрүүдийг зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд шинээр ашиглаж эхэллээ. Цаашид зээлийн эрсдэлийн удирдлагыг сайжруулах ажлын хүрээнд үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байгаа зээлийн эрсдэлийн загваруудыг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөөд байна.

Дотоод захын үйл ажиллагааны зээлийн эрсдэлийн удирдлагын хувьд санхүүгийн тайлагналын олон улсын 9 дүгээр стандартад нийцүүлэн гаргасан “Санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн үнэлгээний заавар”-ын дагуу Монголбанкны эзэмшиж буй зарим төрлийн санхүүгийн хөрөнгөөс хүлээж болзошгүй алдагдлыг урьдчилан тооцоолж, түүнд тохирсон эрсдэлийн нөөц санг байгуулах замаар бодит эрсдэл учирсан тохиолдолд эрсдэлийг зохистой удирдах боломжийг бий болгож ажиллалаа. Түүнчлэн барьцаа хөрөнгийн нэр төрлийг нэмэгдүүлэх, тэдгээрийн бодит үнэ цэнийг тооцох аргачлал болон эрсдэлийн хямдруулалтын хувь хэмжээг тогтоохтой холбоотой судалгааг гүйцэтгэж, улмаар “Монголбанкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон худалдан авах үнэт цаасны жагсаалт”-ыг шинэчлэн баталлаа. Цаашилбал, Монголбанкны барьцаа хөрөнгийн бодлогын судалгааг гүйцэтгэж, Монголбанкны эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө болон олгосон санхүүжилтийн барьцаа хөрөнгө болон баталгаанд шинжилгээ хийж, Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан ажлын төлөвлөгөөний дагуу эрсдэлийн удирдлагын хүрээнд холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. Түүнчлэн санхүүгийн хөрөнгийг дахин үнэлэх аргачлалыг улам бүр сайжруулах зорилгоор судалгаа шинжилгээг тогтмол хийж, бусад орны төв банкуудын туршлагыг судалж үр дүнг холбогдох журам, зааварт тусган ажиллав. Мөн банк хоорондын валютын арилжааны системд оролцогчдын арилжааны өдрийн лимитийг тооцож, валютын арилжааны системийн үндсэн дилерийг улирал тутам сонгох, хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг гүйцэтгэлээ. Түүнээс гадна дотоодын банкуудтай байгуулдаг санхүүгийн үүсмэл хэлцлийн үнэлгээг уг системээр тооцохоор холбогдох судалгааг хийлээ.

### ***Зах зээлийн эрсдэл***

Гадаад валютын нөөцийн удирдлагын хүрээнд Монголбанкны төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн талаар баримтлах бодлого, гадаад өр төлбөрийн бүтэц, импортын валютын бүтэц, банкуудын гадаад гүйлгээний гадагшлах урсгал болон дотоодын валютын захын бүтцэд үндэслэн ханшийн

эрсдэлийг хамгийн бага байлгах, гадаад төлбөрийг гүйцэтгэхэд шаардлагатай валютын төрөл, хэмжээг тодорхойлж, стратегийн хөрөнгө оруулалтын бүтцийг тодорхойлон, үүний дагуу нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэн, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллав. Үүний зэрэгцээ зах зээл дэх хүүний өөрчлөлтөөс шалтгаалж хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн үнэ цэнэ буурах эрсдэлийг хамгийн бага байлгах үүднээс нөөцийн дэд багц тус бүрийн хувьд үргэлжлэх хугацаа болон түүний хазайлтын оновчтой хэмжээг тогтоох замаар хүүний хэлбэлзлээс үүсч болзошгүй эрсдэлийг удирдан ажиллалаа.

Түүнчлэн Ковид-19 цар тахлын дэлхийн эдийн засагт үзүүлсэн сөрөг нөлөөллийн эсрэг дэлхийн голлох улсуудын засгийн газар болон төв банкуудаас явуулсан бодлогын үр дүнд бий болсон нам дор хүүний орчин болон дэлхийн даяар үргэлжилж буй нийлүүлэлтийн сүлжээний доголдол, дэлхийн эдийн засгийн сэргэлт зэргээс үүдэлтэйгээр таваарын зах тэр дундаа алтны зах зээлийн үнийн хэлбэлзэл өндөртэй байсан зэрэг нь зах зээлийн эрсдэлийг илүү нарийвчлан тооцох хэрэгцээ шаардлагыг үүсгэж байсан. Иймээс гадаад валютын нөөцийн зах зээлийн эрсдэлийн хэмжүүрүүдийн тооцоололд ашиглах програм хангамжийг сайжруулан, үйл ажиллагаанд өдөр тутам ашиглаж эхэлсний зэрэгцээгээр хүүний нам дор хүүний түвшинд цаашид огцом өөрчлөлт гарах үед нөөцийн бүтцийг тогтооход шаардагдах төсөөлөл, тооцооллын шинэ арга, аргачлалыг судалж, стратегийн хөрөнгө оруулалтын бүтцийн тооцоололд ашиглаж эхэллээ.

“Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-т заасны дагуу дотоод актив чанаргүйдэх эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд эзэмшиж буй санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж, үүсч болзошгүй зах зээлийн эрсдэлийг тухай бүр тайлан тэнцэлд тусган ажилласны зэрэгцээгээр уг санхүүгийн хөрөнгүүдийн барьцаа хөрөнгүүдийн бодит үнэ цэнийг шинэчлэн тооцоолоо. Түүнчлэн валютын ханшийн эрсдэлээс хамгаалах, гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэх, зээлийн хүү, гадаад валютын зээлийн өсөлтийг бууруулах зорилгоор дотоодын банкуудтай байгуулсан урт хугацаат своп хэлцлийн дахин үнэлгээг долоо хоног тутам гүйцэтгэж санхүүгийн тайлан тэнцэлд тусгаж байна.

### ***Хөрвөх чадварын эрсдэл***

Гадаад валютын нөөцийн удирдлагын хүрээнд хөрвөх чадварыг хангах зорилгоор нийт нөөцийг богино хугацаат болон урт хугацаат хөрөнгө оруулалтын багцад хуваан удирдав. Хэдийгээр 2021 онд нөөцийг байршуулдаг ихэнх хөгжингүй орнуудын эдийн засаг Ковид-19 цар тахлаас үүдсэн зогсонги байдлаас гарч сэргэж эхэлсэн ч дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн тодорхой бус байдал өндөр хэвээр байсан тул богино хугацаат багцыг олон улсын байгууллага болон төв банкуудад түлхүү тархаан байршуулав. Нөөцийн хүрэлцээт байдлыг тодорхойлоход түгээмэл ашиглагддаг ОУВС болон бусад төв банкуудаас гаргасан аргачлалуудын дагуу богино хугацаат хөрвөх чадвартай өндөртэй багцын оновчтой хэмжээг Монгол Улсын нийт богино болон урт хугацаат гадаад өр төлбөрийн бодит гүйцэтгэл болон ирэх оны төсөөлөл болон экспорт, импортын ирэх оны төсөөлөл зэрэг макро үзүүлэлтүүдэд үндэслэн тодорхойлж, үр дүнг нөөцийн удирдлагад ашигласан. Түүнчлэн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор нөөцийг харилцах, богино хугацаат хадгаламж, гадаадын засгийн газрын болон олон улсын байгууллагын богино хугацаат үнэт цаас зэрэг хөрвөх чадвар өндөртэй хэрэгслүүдэд байршуулж удирдлаа.

### ***Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын хяналт, тайлагнал***

Гадаад валютын улсын нөөцийн хөрөнгө оруулалтын хэрэгслийн зах зээлийн үнэлгээ, эрсдэл болон үр өгөөжийн тооцооллыг өдөр тутам гүйцэтгэж, тогтоосон бүтэц, лимитийн гүйцэтгэлийг тооцон, хяналт тавьж ажиллав. Цаашилбал, гадаадын харилцагч банк санхүүгийн байгууллагуудын санхүүгийн үзүүлэлт, зээлжих зэрэглэл, хувьцааны үнийн динамик болон тэдгээр байгууллагын талаарх онцгойлох мэдээллүүдийг багтаасан тайланг улирал тутам гаргаж удирдлагуудад тухай бүр танилцуулж ажиллалаа. Түүнчлэн бусад улсын төв банк болон олон улсын санхүүгийн байгууллагын гадаад валютын нөөцийн удирдлагын тайлагналын зарчим, практикийг судалж, тэргүүн туршлагыг нөөцийн удирдлагын тайлагналд нэвтрүүлээ.

## Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Тайлант онд үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах зорилгоор Дэлхийн банктай хамтран ажилласны зэрэгцээгээр онолын судалгааны ажлууд, бусад улс орны төв банкуудын тэргүүн туршлагыг судалж, улмаар эрсдэлийн засаглалын тогтолцоог бэхжүүлж, эрсдэлийг үнэлж, тодорхойлох арга хэрэгслүүдийг амжилттайгаар хэрэгжүүлэн ажиллалаа.

2020 онд баталсан “Гоц халдварт өвчний гамшгийн үед Монголбанкны үйл ажиллагааны хэвийн, аюулгүй, тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө”-г илүү нарийвчлан, бэлэн байдлыг хангах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Ковид-19 халдварт өвчний тохиолдол гарсан үед Монголбанкны үндсэн үйл ажиллагааны аюулгүй, тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө”-г шинээр боловсруулж, баталсан. Түүнчлэн үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагад зардал-үр ашгийн шинжилгээ хийх аргачлалыг судлан шинээр нэвтрүүлж, “Зардал-үр ашгийн шинжилгээ хийх заавар”-ыг шинээр боловсруулан баталлаа.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагад түгээмэл ашиглагддаг үнэлгээний хэрэгсэл болох “Өөрийн үнэлгээ” (Risk Control and Self-Assessment)-г зургаа дахь жилдээ бүх ажилтнуудаар хийлгэж, үр дүнд үндэслэн холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. Өмнөх жилүүдэд дээрх үнэлгээг цахим хэлбэрээр авч байсан бол тайлант онд үнэлгээний програмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн нь үйл ажиллагааны эрсдэлийн өөрийн үнэлгээг ажилтнуудаар хийлгэх, нэгтгэх, дүгнэх үйл явцтай холбоотой гар ажиллагааг багасгаж хүнээс хамаарсан алдааг бууруулах, ажилтнуудын хийсэн үнэлгээний мэдээллийг өгөгдлийн санд хадгалах, ингэснээр эрсдэлийн үнэлгээний хувьд динамик шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх зэрэг ач холбогдолтой ажил болсон. Үүнээс гадна эрсдэлтэй тохиолдол гарах, үүсэх бүр эрсдэлийн мэдээллийн санд мэдээллийг оруулж баяжуулах, мөн үйл ажиллагааны эрсдэлийн гол үзүүлэлт (KRIs)-үүдийн гүйцэтгэлд нь тухай бүр хяналт тавьж, удирдлагад тайлагнан ажиллав. Энэ нь үйл ажиллагааны эрсдэлийг бодит хэмжүүрээр хэмжиж, эрсдэл үүсгэж буй хүчин зүйлийн гол шалтгааныг олж тодорхойлон тохирсон арга хэмжээ авахад чухал хувь нэмэр оруулж байна. Тайлант хугацаанд Монголбанкны цалин, урамшуулал, ээлжийн амралтын олговрын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд эрсдэлийн зураглалын үнэлгээг хийж, үр дүнд үндэслэн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Монголбанкны бүх нэгжүүдэд үйл ажиллагааны эрсдэл хариуцсан ажилтан томилогдон ажилдаг бөгөөд ЭУА нь эдгээр ажилтнуудад зориулж сургалт, хурал уулзалтыг тогтмол зохион байгуулдаг. Тайлант онд үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын талаар сургалтыг цар тахлын нөхцөлтэй уялдуулан видео бичлэг хэлбэрээр боловсруулан бүх нэгжүүдэд хүргүүлсэн. Энэ нь байгууллагын хэмжээнд эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг, мэдээллийг түгээж, үйл ажиллагааны эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх, нөгөө талаар нэгж тус бүр хоорондоо нягт уялдаа, холбоотой хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж байна.

## 4.7. БЭЛЭН МӨНГӨНИЙ УДИРДЛАГА

Монголбанк нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасны дагуу Монгол Улсын мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах онцгой эрхийн хүрээнд мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, гүйлгээнээс татах, гүйлгээнд байгаа мөнгөн тэмдэгтийн зохистой бүтцийг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

### Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний өөрчлөлт

2021 оны эцсийн байдлаар гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ мөнгөн дүнгээр 1.105 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.5 хувь буюу 114.1 тэрбум төгрөгөөр өсжээ. Харин гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний тоо ширхэг өмнөх оноос 5.5 хувь буюу 27.3 сая ширхгээр өсөж, 526.4 сая ширхэгт хүрсэн байна.

## Хүснэгт 4.6. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ


| №    | Мөнгөн дэвсгэрт | Мөнгөн дүн (сая төгрөгөөр) |           | Тоо ширхэг (сая ширхгээр) |       |
|------|-----------------|----------------------------|-----------|---------------------------|-------|
|      |                 | 2021                       | 2020      | 2021                      | 2020  |
| 1    | 1 төгрөг        | 33.6                       | 33.2      | 33.6                      | 33.2  |
| 2    | 5 төгрөг        | 152.6                      | 150.7     | 30.5                      | 30.1  |
| 3    | 10 төгрөг       | 1,072.2                    | 1,025.2   | 107.2                     | 102.5 |
| 4    | 20 төгрөг       | 1,800.1                    | 1,715.1   | 90.0                      | 85.8  |
| 5    | 50 төгрөг       | 3,817.8                    | 3,532.8   | 76.4                      | 70.7  |
| 6    | 100 төгрөг      | 7,460.7                    | 6,993.9   | 74.6                      | 69.9  |
| 7    | 200 төгрөг      | 36.7                       | 36.6      | 0.2                       | 0.2   |
| 8    | 500 төгрөг      | 8,665.8                    | 8,240.0   | 17.3                      | 16.5  |
| 9    | 1000 төгрөг     | 20,588.0                   | 20,490.8  | 20.6                      | 20.5  |
| 10   | 5000 төгрөг     | 79,927.1                   | 77,617.8  | 16.0                      | 15.5  |
| 11   | 10000 төгрөг    | 218,555.0                  | 211,975.6 | 21.9                      | 21.2  |
| 12   | 20000 төгрөг    | 763,441.3                  | 659,619.7 | 38.2                      | 33.0  |
| Нийт |                 | 1,105,550.9                | 991,431.3 | 526.4                     | 499.1 |

Эх сурвалж: Монголбанк


Сүүлийн нэг жилийн хугацаанд мөнгөн дэвсгэртүүд бүх төрлийнхөө хувьд дүн болон тоо ширхгээрээ өссөн бөгөөд тэр дундаа 20000-тын дэвсгэрт хамгийн өндөр буюу 15.7 хувийн өсөлттэй байв.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний бүтцийг мөнгөн дүнгээр нь авч үзвэл өндөр нэрлэсэн дүнтэй дэвсгэртүүд дийлэнх хэсгийг бүрдүүлж байна. Тодруулбал, 2021 онд 10000 болон 20000 төгрөгийн дэвсгэртүүд мөнгөн дүнгийн 88.9 хувийг, үүнээс 69.1 хувийг нь 20000-тын дэвсгэрт дангаараа бүрдүүлжээ. Харин бусад дэвсгэртүүдийн гүйлгээнд байгаа бэлэн мөнгөнд эзлэх хувь өмнөх оноос 0.9 нэгж хувиар буурч 11.2 хувьд хүрсэн байна. Энэ нь өндөр нэрлэсэн дүнтэй мөнгөн дэвсгэртүүдийн эрэлт жил бүр нэмэгдсээр байгаатай холбоотой юм.

Зураг 4.5. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний бүтэц, мөнгөн дүнгээр



Зураг 4.6. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний бүтэц, тоо ширхгээр дүнгээр



Эх сурвалж: Монголбанк

Тайлант оны эцсийн байдлаар 1-тээс 100-т хүртэлх бага нэрлэсэн дүнтэй мөнгөн дэвсгэртүүд тоо ширхгээрээ гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний 78.3 хувийг, үлдсэн дэвсгэртүүд нийлээд 21.7 хувийг бүрдүүлжээ. Энэ нь бага дүнтэй дэвсгэртүүд төлбөр тооцоонд хэрэглэгдэх нь багасаж, улмаар банкнаас гадуур иргэдийн гар дээр үлдэж, гүйлгээнээс буцан татагдахгүй байгаатай холбоотой юм.

## Мөнгөн тэмдэгтийн нөөцийн бүрдүүлэлт

Монголбанк нь мөнгөн тэмдэгт үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, түүний нөөцийг бий болгох үйл ажиллагааныхаа хүрээнд үндэсний мөнгөн тэмдэгтийн найдвартай байдлыг хангах, хуурамчаар үйлдэх явдлыг багасгах, зогсоох зорилгоор мөнгөн тэмдэгтийн хамгаалалтын элементүүдийг сүүлийн үеийн шинэ дэвшилтэт технологиор сайжруулахад анхааран ажиллаж байна.

### *Шинэчлэгдсэн хамгаалалтын элемент бүхий мөнгөн дэвсгэртүүд*

2020 онд нөөцийг нь дахин бүрдүүлсэн 100-т, 500-т, 1000-тын шинэчлэгдсэн мөнгөн дэвсгэртүүдийг 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн гүйлгээнд гаргав. Эдгээр дэвсгэртүүд нь өндөр нууцлал бүхий хамгаалалтын элементүүд болох 3 хэмжээст хөдөлгөөнтэй, хазайлгахад өнгө нь хувирагч элемент, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан товгор элементүүдээр шинэчлэгдсэн болно.

### *Дурсгалын мөнгөн дэвсгэрт*

Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан Монголбанк дурсгалын 10000 төгрөгийн мөнгөн дэвсгэртийг орчин үеийн шинэ технологи бүхий өндөр түвшний хамгаалалтын элементүүдийг оруулан бүтээж, 2021 оны 7 дугаар сарын 10-ны өдрөөс нийтийн хүртээл болгов.

Уг дурсгалын мөнгөн дэвсгэрт нь дараах онцлог хамгаалалтын элементүүдтэй. Үүнд:

- Ардын хувьсгалын 100 жилийн ойн лого дээрх судал нь ногоон болон шар өнгөөр ээлжлэн солонгорч харагддаг 3 хэмжээст, өнгө нь хувирагч элемент;
- Морьтон баатрын дүрс дээрх 2 цагираг нь ногоон болон шар өнгөөр ээлжлэн солонгорч харагддаг 3 хэмжээст, өнгө нь хувирагч элемент;
- Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан 7 ширхэг ташуу зураас бүхий товгор элемент;
- “Ардын хувьсгал 100 жил” гэсэн бичвэртэй тасалдаж харагдах металл утас;
- Хэт ягаан туяаны гэрэлд тодорч харагддаг Соёмбо.

Түүнчлэн дурсгалын 10000-тын дэвсгэртийн ар талд Д.Сүхбаатар жанжны хөрөг болон Ардын хувьсгалыг тунхаглан зарлах үедээ ард олонд хандаж хэлсэн алдарт үг, хэт ягаан туяаны гэрэлд тодорч харагддаг Монгол Улсын газрын зургийг тус тус байрлууллаа. Гэрэлтэн харагддаг тэрхүү Монгол Улсын газрын зураг дээр хатуу металаар бага зэрэг үрэхэд тухайн үрсэн хэсгийн өнгө нь хэт ягаан туяаны гэрэлд цэнхрээс шар өнгөнд хувирч, хэсэг хугацааны дараа аажмаар хэвэндээ орох бөгөөд энэ нь далд хэлбэрийн интерактив цоо шинэ хамгаалалтын элемент юм.

## Мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдэхтэй тэмцэх

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Монголбанк нь мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдэхтэй тэмцэх, мөнгөн тэмдэгтийн хуурамч эсэхийг тогтоох, хуурамч мөнгөн тэмдэгтийг устгах үйл ажиллагааг эрхэлдэг.

Монгол Улсын хэмжээнд 2010 оноос хойш илэрсэн 500-таас дээш нэрлэсэн дүнтэй хуурамч мөнгөн дэвсгэртүүдийн 88.4 хувийг 20000-т, 9 хувийг 10000-т, үлдсэн 2.7 хувийг 500-т, 1000-т, 5000-тын хуурамч дэвсгэрт тус тус эзэлж байна.

Мөнгөн тэмдэгтийг хуурамчаар бэлтгэсэн, ашигласан тохиолдолд Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.7 буюу “Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах” гэсэн зүйлийн дагуу хариуцлага тооцдог бөгөөд мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдсэн, хуурамчаар үйлдсэнийг мэдсээр байж хадгалсан, ашигласан, зөөвөрлөсөн, тараасан бол 2 жилээс 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэдэг.

Монголбанк мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдэхтэй тэмцэх үйл ажиллагааныхаа хүрээнд үндэсний мөнгөн тэмдэгтийн чанар, үзэмж, хамгаалалтын таних тэмдгийг олон улсын шинэ дэвшилтэт технологи, дэлхий нийтийн хөгжил дэвшилтэй уялдуулан тогтмол сайжруулж, боловсронгуй болгосоор байна. Тодруулбал, 2018 оноос хойш 50-т, 100-т, 500-т, 1000-т, 5000-т, 20000-тын дэвсгэртүүдийг өндөр нууцлал бүхий хамгаалалтын элементүүдээр шинэчлэн сайжруулаад байна.


Түүнчлэн, олон нийтэд мөнгөн тэмдэгтийн хамгаалалтын элементүүдийг танилцуулах, хуурамч мөнгөний гэмт хэргээс сэргийлэх зорилгоор холбогдох сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгээс зохион байгуулсан арилжааны банкны ажилтнуудад зориулсан семинарт “Монгол Улсын Мөнгөн тэмдэгт тэдгээрийн хамгаалалтын элементүүд болон хуурамч мөнгөн тэмдэгт” сэдвээр цахим сургалт хийв. Мөн хамгаалалтын элемент нь шинэчлэгдэн гарсан 100, 500, 1000 төгрөгийн мөнгөн дэвсгэртүүдийн хамгаалалттай холбоотой зурагт хуудас болон тараах материалуудыг хэвлүүлэн арилжааны банкууд, олон нийтийн газруудаар байршуулахад бэлэн болгохын зэрэгцээ дурсгалын 10000 төгрөгийн хамгаалалтын элементүүдийг танилцуулсан видео бичлэгийг Монголбанкны цахим хуудсанд байршуулан олон нийтэд хүргэв.

### Ковид-19 цар тахлын бэлэн мөнгөний эрэлтэд үзүүлсэн нөлөө

Гүйлгээнд эргэлдэж байгаа бэлэн мөнгөний хэмжээ ердийн тохиолдолд ихэвчлэн эдийн засгийн өсөлтийн хөдөлгөөнийг дагаж өөрчлөгддөг боловч гэнэтийн шок, аливаа төрлийн хямралаас үүдсэн тодорхой бус байдал үүсэх үед иргэд бэлэн мөнгөнд илүү итгэж, бэлэн мөнгөний эрэлт нэмэгддэг болох нь 2020-2021 оны ковид-19 цар тахлын хугацаанд харагдаж байна.

Тухайлбал, 2019 онд гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөний хэмжээ өмнөх онтой харьцуулахад 7 хувиар буурч, 897.4 тэрбум төгрөгт хүрсэн нь бэлэн мөнгөний эрэлт цаашид буурч болзошгүй гэж үзэхэд хүргээд байв. Гэвч 2020 онд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин хатуу хөл хорио тогтоосонтой холбоотойгоор эдийн засаг 5.3 хувиар агшсан боловч гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ оны эцэст 10 хувиар өсөж, 991.4 тэрбум төгрөгт хүрсэн. Энэ нь цар тахлын үед тодорхой бус байдал нэмэгдэхэд иргэд гар дээрээ бэлэн мөнгөтэй байхыг илүүд үзэж, бэлэн мөнгө нөөцөлсөнтэй холбоотой юм.

Зураг 4.7. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний өсөлт (мөнгөн дүнгээр)



Зураг 4.8. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний өсөлт (тоо ширхэгээр)



Эх сурвалж: Монголбанк

2021 онд эдийн засаг алгуур сэргэж, цар тахлын эрсдэл буурахтай зэрэгцээд гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ 1.1 их наяд төгрөг буюу түүхэн дээд хэмжээндээ хүрэв. Энэхүү өсөлт нь 2020 онтой харьцуулахад 12 нэгж хувиар өссөн үзүүлэлт бөгөөд 2017 оноос хойш ажиглагдсан гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хамгийн өндөр өсөлт юм. Ийнхүү ковид-19 цар тахалтай жилүүдэд манай улсад бэлэн мөнгөний эрэлт өссөн чиг хандлага харагдлаа.



## 4.8 МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Монголбанкны Мэдээллийн технологийн газар нь 2021 онд банк хоорондын төлбөр тооцооны систем, банк хоорондын валют арилжааны цахим талбар, зээлийн мэдээллийн сан болон байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглаж буй цахим мэдээллийн системүүдийн аюулгүй, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж ажиллалаа.

Мөн одоо ашиглагдаж байгаа системүүдийг сайжруулах, боловсронгуй болгохын зэрэгцээ шинэ техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

- Банк хоорондын валют арилжааны цахим талбарт урт хугацаат своп хэлцлийн програмыг шинээр хөгжүүлж ашиглалтанд орууллаа. Өмнө нь энэхүү үйл ажиллагаа 100 хувь гараар хийгддэг байсан ба үүнээс шалтгаалан механик алдаа гарах магадлал өндөр байсныг арилгаж, банкууд шинэ хэлцэл хийхээс гадна өмнө байгуулсан болон идэвхтэй байгаа хэлцлүүд, хэлцлийн шинэчилсэн хүүг хянах боломжтой болсон.
- Монголбанкнаас аж ахуйн нэгж байгууллагатай валютын арилжаа хийх шинэ системийг хөгжүүллээ. Банк болон гадаад валютын орлоготой том аж ахуйн нэгжүүдтэй хийх гадаад валютын арилжаа нь тогтмол, өндөр давтамжтай цаасан хэлбэрээр хийхэд цаг хугацаа болон хүн хүчний зардал их шаарддаг. Энэхүү нэн чухал үйл ажиллагааг автоматжуулж, алдаа гарах эрсдэлээс сэргийлэх, цаг хугацаа, зардлыг бууруулах боломжийг бүрдүүллээ.
- Иргэн, аж ахуйн нэгж нь өөрийн санхүүгийн байгууллагаас авсан зээлийн мэдээллийг e-Mongolia системээс шууд авах боломжтой болголоо. Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн системийг Үндэсний дата төвийн e-Mongolia системтэй холбож, иргэн, аж ахуйн нэгжүүд өөрийн зээлийн мэдээллийг үнэ төлбөргүй авах боломжийг бий болгосон програм хангамжийг шинээр хөгжүүлж, ашиглалтад орууллаа.
- Монголбанкны дотоод системүүдийг Үндэсний дата төвийн ХУР системтэй холбох програм хангамжийг хөгжүүлж, ашиглалтад орууллаа. Ингэснээр Монголбанкны газар, албад ХУР системээр дамжуулан өөрийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн үнэн зөв байдлыг тулгаж, шалгах боломжтой болсон.
- Зээлийн мэдээллийн сангаас 44612 иргэн, аж ахуй нэгжийн зээлийн мэдээллийг лавлагаанд тусгахгүй болголоо. Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалын дагуу нэгээс дээшгүй хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн түүхтэй, тухайн зээл нь 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө бүрэн төлөгдөж дууссан байх гэсэн шаардлагуудыг хангасан иргэн, аж ахуй нэгжийн зээлийн мэдээллийг лавлагаанд тусгахгүй болгох ажлыг богино хугацаанд хийж гүйцэтгэлээ.
- Санхүүгийн мэдээллийн албаны хэрэгцээнд goAML системийг ашиглалтанд орууллаа. Энэхүү шинэ системийн үндсэн болон тэстийн орчин, програм хангамж, өгөгдлийн сан, сүлжээний хамгаалалтыг цогцоор нь хийж гүйцэтгэж, бүрэн ашиглалтад орууллаа.
- Түүнчлэн мэдээллийн технологийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, мэдээллийн аюулгүй байдлыг дээшлүүлэх, вирусын болон аливаа цахим халдлагаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч ажиллалаа.



#### 4.9 МОНГОЛБАНКНААС 2021 ОНД БАТАЛСАН ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ХУРААНГУЙ

|    |                                                                                                                                                                                                  |            |                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|---------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1  | Улсын байцагчийн дүрэм                                                                                                                                                                           | 2021.02.01 | A-37                            | Монголбанкны Улсын байцаагч эрх зүйн байдлыг тодорхойлох, түүний үйл ажиллагааны үндсэн зарчмыг шинэчлэн тогтоов.                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
| 2  | Аюулгүй байдлын албаны хяналтын операторын үйл ажиллагааны заавар                                                                                                                                | 2021.02.03 | A-41                            | Цахим гүйлгээний төвийн аюулгүй байдлыг хангах тухай.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| 3  | Сэндбокс зохицуулалтын орчны журам                                                                                                                                                               | 2021.03.01 | <a href="#">A-63/64/32/A-27</a> | Санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хязгаарлагдмал хүрээг хамарсан бодит орчинд, тодорхой цаг хугацаанд турших боломжийг олгох тухай                                                                                                                                                                                                                                               |
| 4  | Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам                                                                                                    | 2021.03.22 | <a href="#">2021\A-86</a>       | Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх тухай                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| 5  | Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам | 2021.03.26 | <a href="#">A-90/85</a>         | 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 3 дугаар зүйлд заасан “Банкийг нээлттэй хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг энэ хуульд нийцүүлэн өөрчлөх, энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах хянах түр журмыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална.” |
| 6  | Санхүүгийн мэдээллийн албаны статистикийн мэдээлэл гаргах журам                                                                                                                                  | 2021.03.31 | <a href="#">2021\A-93</a>       | Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан авч байгаа арга хэмжээ, хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалт, хариуцлагын талаар нэгдсэн статистикийн мэдээлэл гаргах, олон нийтэд мэдээлэх тухай                                                                                                                                                                                                          |
| 7  | Банкнаас цахим хэлбэрээр зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах тухай түр журам                                                                                                                        | 2021.04.12 | <a href="#">A-100</a>           | Орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээл, бусад зээлийн гэрээнд төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хойшлуулах, хугацааг сунгах нөхцөлөөр цахим хэлбэрээр өөрчлөлт оруулахад банк эзэлдэгчийн саналыг хүлээн авах, зээлийн гэрээнд өөрчлөлтийг тусгаж гэрээ байгуулах, эзэлдэгчид мэдэгдэх харилцааг зохицуулах тухай                                                                                                                                         |
| 8  | Банкны системд нөлөө бүхийн банкныг тогтоох аргачлал                                                                                                                                             | 2021.04.19 | <a href="#">A-104</a>           | Банкны тухай хуулийн 3.1.20-ийн хэрэгжилтийн хангах, Банкны системд нөлөө бүхийн банкныг тодорхойлох тухай                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| 9  | Автомат клиринг хаусын системийн дүрэм                                                                                                                                                           | 2021.05.25 | <a href="#">A-128</a>           | АСН-ы оролцогчдын эрх, үүргийн тодорхойлох тухай                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
| 10 | Банкны тогтворжуулалтын сангийн журам                                                                                                                                                            | 2021.06.25 | <a href="#">A-155</a>           | Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай мөнгөн хөрөнгийн сангийн үйл ажиллагааны тухай                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
| 11 | Урт хугацаат своп хэлцлийн журмыг шинэчлэн батлах тухай                                                                                                                                          | 2021.06.30 | <a href="#">A-162</a>           | Гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэх, зээлийн хүү, гадаад валютын зээлийн өсөлтийг бууруулах, гадаад валютын ханшийн эрсдэлээс хамгаалах тогтолцоог бий болгохын тулд банкууд урт хугацаат гадны эх үүсвэрээр Монголбанктэй своп хэлцэл байгуулах үйл ажиллагаанд баримтлах зарчим, талуудын эрх, үүргийн тухай                                                                                                                                                 |
| 12 | Үйлчилгээний хөлс шимтгэлийн ерөнхий нөхцөл батлах тухай                                                                                                                                         | 2021.07.21 | <a href="#">A-192</a>           | Монголбанкны үйлчилгээний хөлс, шимтгэлийн ерөнхий нөхцөлийг шинэчлэн тогтоох тухай                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| 13 | Банкнаас цахим хэлбэрээр зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах түр журамд өөрчлөлт оруулах тухай                                                                                                      | 2021.07.08 | <a href="#">A-188</a>           | Банкнаас цахим хэлбэрээр зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах тухай                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| 14 | Банкийг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжүүлэх журам                                                                                                                         | 2021.09.06 | <a href="#">A-226</a>           | Банкны төлбөрийн чадварыг хадгалах Банкныг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах тухай                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |

|    |                                                                                                                                    |            |                           |                                                                                                                                                                                                                                                                                      |
|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|---------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 15 | Санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцлийн бодит үнэ цэнийг тооцох заавар                                                               | 2021.09.09 | <a href="#">A-229</a>     | Олон улсын санхүүгийн байгууллагуудтай байгуулсан урт болон богино хугацаат санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцлийн бодит үнэ цэнийг тооцох ерөнхий аргачлал, үнэлгээнд ашиглах өгөгдлийн эх сурвалжуудыг тодорхойлох тухай                                                            |
| 16 | Сэндбоксын зөвлөлийн дүрэм                                                                                                         | 2021.09.24 | <a href="#">A-251/252</a> | Санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хязгаарлагдмал хүрээг хамарсан бодит орчинд, тодорхой цаг хугацаанд турших боломжийг олгох ажлыг зохион байгуулах, зохицуулах, хянах зөвлөлийг үйл ажиллагааны тухай |
| 17 | Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам | 2021.10.05 | <a href="#">A-262/262</a> | Монголбанкнаас Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл авах, мэдэгдэх харилцааг зохицуулах тухай                                                                                                  |
| 18 | Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам          | 2021.10.08 | <a href="#">A-266</a>     | Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн дагуу төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих тухай                                                                                                           |
| 19 | Их дүнтэй төлбөрийн системийн дүрэм                                                                                                | 2021.10.08 | <a href="#">A-267</a>     | Банксүлжээ системийн үйл ажиллагаанд хяналт тавих тухай                                                                                                                                                                                                                              |
| 20 | Монголбанкны хяналт шалтгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтан, хянан шалгагчин нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам             | 2021.10.13 | <a href="#">A-272</a>     | Монголбанкны хяналт шалтгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтан, хянан шалгагчин нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, түүнийг хүлээн авч хянах тухай                                                                                                                                     |
| 21 | Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тооцож, зарлах заавар                                                                       | 2021.10.18 | <a href="#">A-275</a>     | “Гадаад валютын арилжааны мэдээ гаргах журам”-ын дагуу хүлээн авсан мэдээллийг боловсруулах, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тооцох, батлах, олон нийтэд зарлах үйл ажиллагааны тухай                                                                                      |
| 22 | Гадаад валютын арилжааны мэдээ гаргах журам                                                                                        | 2021.10.18 | <a href="#">A-276</a>     | Банкууд гадаад валютын арилжааны мэдээ гаргах, түүнийг хүлээн авах, оролцочдын эрх үүргийг тодорхойлох тухай                                                                                                                                                                         |
| 23 | Өр, орлогын харьцааг тооцох аргачлалыг шинэчлэн батлах тухай                                                                       | 2021.10.20 | <a href="#">A-277</a>     | Банкнаас иргэнд хэрэглээний зээлийг шинээр олгох, өмнө нь олгосон зээлийн нөхцөлийг нь өөрчлөхөд хэрэглэх аргачлалын тухай                                                                                                                                                           |
| 24 | Монголбанкны зөвшөөрлийн хураамжийн ерөнхий нөхцөл                                                                                 | 2021.11.09 | <a href="#">A-295</a>     | Банкуудад олгох Монголбанкны зөвшөөрлийн хураамжийн тухай                                                                                                                                                                                                                            |
| 25 | Банкны ажилтны суурь шаардлагын жишгийг батлах тухай                                                                               | 2021.11.25 | <a href="#">A-313</a>     | Банкны салбарт шинээр ажилд орсон, ажиллаж буй ажилтны суурь шаардлага, ажлын нөхцөлийн тухай                                                                                                                                                                                        |
| 26 | Гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлах зөвшөөрөл олгох үйл ажиллагааны заавар      | 2021.11.30 | <a href="#">A-314</a>     | Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1-т заасан зөвшөөрлийг Монголбанкнаас олгох тухай                                                                                                                                                                |
| 27 | Үндэсний цахим гүйлгээний төвийн логоны загвар                                                                                     | 2021.12.06 | <a href="#">A-322</a>     | Үндэсний төлбөрийн Т картын загвар, лого, холограм”, “Үндэсний цахим гүйлгээний төвийн логоны загварыг батлах тухай                                                                                                                                                                  |

## 4.10 ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

### *Судалгааны ажил*

ЭЗССХ нь 2021 онд Монгол улсын хөгжил, эдийн засгийн болон санхүүгийн бодлогын шийдвэрт дэмжлэг болох чиг үүргийн хүрээнд дараах судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Мөнгөний эрэлт, нийлүүлэлтийн дүн шинжилгээ, түүн дээр суурилсан бодлогын зөвлөмж,
- Монголын эдийн засаг дахь инфляцыг тайлбарлах нь,
- Малчин өрхүүдийн амьжиргааны түвшинг хөрөнгийн үнэлгээн дээр суурилж тооцох нь,
- Сектор хоорондын хөрөнгийн урсгалын матриц, түүнд хийсэн дүн шинжилгээ,
- Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн түрүүлэгч индикаторыг Монголын нөхцөлд тооцоолох нь,
- Цар тахал ба үйлчилгээний сектор,
- Инфляцын хүлээлтийн аргамжаа, түүнийг тодорхойлох нь,
- Монголын эдийн засаг дахь зээлийн төвлөрлийг хэмжих нь.

### *Сургалт*

Санхүүгийн салбарын мэргэжилтнүүд болон Монголбанкны ажилтнуудад холбогдох газруудтай хамтран сургалт, арга хэмжээг зохион байгуулав.

Монголбанкны ажилтнуудад үйлчилгээний ажилтны сургалт, удирдах ажилтны семинарыг тус тус зохион байгуулав.

Арилжааны банкны ажилтнуудад чиглэсэн сургалт зохион байгуулахаар тэдгээрээс сэдвийн санал авч “Банкны ажилтны семинар”-ыг 2021 оны 06 дугаар сараас 2021 оны 12 дугаар сарын хооронд нийт 31 удаа зохион байгуулав. Тус сургалтад нийт 11 арилжааны банкны давхардсан тоогоор 4556 ажилтан хамрагдсан. Сургалтуудыг Монголбанкнаас баримталж буй бодлого, журам, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, эрсдэлийн удирдлага, санхүүгийн тайлангийн стандартууд, банкны хяналт шалгалт зэрэг сэдвүүдийн хүрээнд зохион байгуулав.

Монголбанкны нийт газар, албадуудын сургалтын хэрэгцээний үнэлгээг хийж, хөтөлбөр боловсруулав.

Мөн сургалтын зарим үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэв.

### *Хамтын ажиллагаа*

Төрийн бусад байгууллагууд, яам, тамгын газар, агентлагуудтай нягт хамтран ажиллах орчныг бүрдүүлэх чиг үүргийн хүрээнд Швейцар дахь Элчин сайдын яам болон Швейцарын Эдийн засгийн яамтай хамтран хөгжиж буй орнуудын Төв банкуудад зориулсан хоёр талын тусламж, чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрт оролцох ажлыг санаачилсан ба Монголбанкны гурван газарт дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд Мөнгөний бодлогыг хэрэгжилт, Макро эдийн засгийн статистик, Санхүүгийн тогтвортой байдал болон хяналт, шалгалт зэрэг сэдвүүдээр техникийн туслалцаа авч байна.

**МОНГОЛБАНК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОЛОН УЛСЫН  
СТАНДАРТЫН ДАГУУ БЭЛТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН  
БОЛОН ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## АГУУЛГА

|                                                                                                               |            |
|---------------------------------------------------------------------------------------------------------------|------------|
| <b>ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ</b>                                                     | <b>95</b>  |
| <b>ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН</b>                                                                            | <b>96</b>  |
| <b>САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД</b>                                                                                  | <b>100</b> |
| Санхүүгийн байдлын тайлан                                                                                     | 100        |
| Орлогын үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайлан                                                     | 101        |
| Өмчийн өөрчлөлтийн тайлан                                                                                     | 102        |
| Мөнгөн гүйлгээний тайлан                                                                                      | 103        |
| <b>САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД</b>                                                                      | <b>105</b> |
| 1 Танилцуулга болон банкны үйл ажиллагааны орчин                                                              | 105        |
| 2 Санхүүгийн тайлагналын тогтолцоо, тайлан бэлтгэх үндэслэл болон толилуулга                                  | 107        |
| 3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд                                                                   | 108        |
| 4 Нягтлан бодох бүртгэлд ашигласан ач холбогдол бүхий таамаглал болон үндэслэлийн талаар тайлангийн тодруулга | 124        |
| 5 Шинэ буюу өөрчлөлт орсон стандартуудын тайлбар, хэрэгжилт                                                   | 133        |
| 6 Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан мэдэгдлүүд                                                       | 135        |
| 7 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө                                                                           | 136        |
| 8 Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө                                                     | 137        |
| 9 Дотоодын банкуудад олгосон зээл                                                                             | 139        |
| 10 Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт                                                                       | 145        |
| 11 Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт                                                                      | 151        |
| 12 Урвуу буцаан худалдан авах хэлцэл                                                                          | 152        |
| 13 Алт, үнэт металл                                                                                           | 154        |
| 14 Эрдэнэсийн сан                                                                                             | 155        |
| 15 Санхүүгийн үүсмэл хэрэгсэл                                                                                 | 156        |
| 16 Засгийн газрын үнэт цаас                                                                                   | 157        |
| 17 Бусад хөрөнгө                                                                                              | 159        |
| 18 Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгө                                                                         | 165        |
| 19 Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө                                                                             | 167        |
| 20 Төв банкны үнэт цаас                                                                                       | 167        |
| 21 Засгийн газрын хөрөнгө                                                                                     | 168        |
| 22 Дотоодын банкуудын хөрөнгө                                                                                 | 168        |
| 23 Гадаад өр төлбөр                                                                                           | 170        |
| 24 Бусад өр төлбөр                                                                                            | 172        |
| 25 Дүрмийн сан болон бусад нөөц сангууд                                                                       | 173        |
| 26 Хүүгийн орлого ба зардал                                                                                   | 174        |
| 27 Алт, үнэт металлын арилжааны ашиг/алдагдал                                                                 | 175        |
| 28 Үйл ажиллагааны бусад орлого                                                                               | 175        |
| 29 Үйл ажиллагааны болон бусад зардал                                                                         | 176        |
| 30 Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага                                                                    | 176        |
| 31 Холбоотой талуудын ажил гүйлгээ                                                                            | 179        |
| 32 Санхүүгийн эрсдэлийн удирдлага                                                                             | 183        |
| 33 Бодит үнэ цэнийн тодруулга                                                                                 | 206        |
| 34 Санхүүгийн хэрэглүүрийн хэмжилтийн ангиллаарх тодруулга                                                    | 217        |
| 35 Капиталын удирдлага                                                                                        | 219        |
| 36 Тайлагналын өдрийн дараах үйл явдлууд                                                                      | 220        |
| 37 Монгол хэл дээрх орчуулга                                                                                  | 220        |

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## Монголбанк

## ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Санхүүгийн тайланг бэлтгэх нь Монголбанкны Захирлуудын Зөвлөлийн үүрэг байна.

Монголбанк (цаашид "Банк")-ны санхүүгийн тайлангууд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн болно. Банкны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг эдгээр санхүүгийн тайлангуудад үнэн зөв бодитой илэрхийлэгдсэнийг Захирлуудын зөвлөл баталгаажуулах үүрэгтэй.

Мөн Захирлуудын зөвлөл нь нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв, зохистой хөтөлж явуулахыг хариуцах ба энэ нь Тодруулга 3-т тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу Банкны санхүүгийн байдлыг үнэн зөв тайлагнах үүргийг биелүүлэх боломжийг олгодог.

Үүнээс гадна, Банкны хөрөнгийг хамгаалах, залилан, бусад зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг өөрийн эрх мэдлийн хүрээнд авч хэрэгжүүлэх нь Захирлуудын зөвлөлийн үндсэн үүрэг болно.

Захирлуудын зөвлөл нь (1-ээс 102 дугаар хуудсанд тодруулсан) санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогыг тууштай баримталж, үндэслэлтэй бөгөөд оновчтой үнэлэлт, тооцооллыг ашиглаж, нягтлан бодох бүртгэлийн бүхий л холбогдох стандартуудыг дагаж мөрдсөн гэж үзэж байна.

Захирлуудын зөвлөлийг төлөөлөн гарын үсэг зурсан:





## Хараат бус аудиторын тайлан

Монголбанкны Захирлуудын Зөвлөлд

### Хязгаарлалттай дүгнэлт

Бидний дүгнэлтээр, хараат бус аудиторын тайлангийн Хязгаарлалттай дүгнэлт гаргах үндэслэл хэсэгт дурдагдсан эдгээр санхүүгийн тайлангуудад нөлөөлж болзошгүй байдлыг эс тооцвол, Монголбанк ("Банк" гэх)-ны санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд мөн тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

### Бид юунд аудит хийсэн талаар

Дараах бүрэлдэхүүн бүхий Банкны санхүүгийн тайлангуудад бид аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн орлого үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн өмчийн өөрчлөлтийн тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн мөнгөн гүйлгээний тайлан; болон
- нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд болон бусад тайлбар мэдээллээс бүрдсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд.

### Хязгаарлалттай дүгнэлт гаргах үндэслэл

Санхүүгийн тайлангуудын тодруулга 4 болон 14-т тусгагдсан Эрдэнэсийн сан нь түүх, соёлын болоод өв уламжлалын хосгүй үнэт зүйлс болон 1925 онд гүйлгээнд гаргасан зоос зэрэг үнэт зүйлсээс бүрдэх ба НББОУС 16-ын дагуу дахин үнэлгээний аргачлалыг ашиглан хэмжигддэг. Эрдэнэсийн санд банкны эрх залгамжлагч Монголбанкны 1925 онд гүйлгээнд гаргасан Монголын мөнгөн болон зэс зооснууд ("Зооснууд") хадгалагдаж байгаа бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 908,476 сая төгрөг (2020: 908,476 сая төгрөг)-ийн дансны үнэтэй байна. Эдгээр зоосыг дахин үнэлэх болсон үндсэн зорилго нь түүхэн цуглуулгын үнэ цэнийг тусгах явдал байсан бөгөөд мөнгөн болон зэс үнэт металын орцын үнэ цэнээс илт давуу байна гэж үзсэн.

Санхүүгийн тайлангуудын тодруулга 3-т тусгагдсан Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу Банкнаас зоос болон мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах үед нэрлэсэн өртгөөр өр төлбөр хэсэгт бүртгэх бөгөөд гүйлгээнээс татсан зоос болон мөнгөн тэмдэгтийг хөрөнгөөр хүлээн зөвшөөрдөггүй. Санхүүгийн тайлангуудын тодруулга 4 болон 14-т тодруулсанчилан Банк нь Монголбанкны хууль ёсны эрх залгамжлагчийн хувьд Зоосуудыг гүйлгээнд гаргасан хэдий ч Банкны удирдлага эдгээр Зоосыг Засгийн газраас Эрдэнэсийн санд хандивласан учир тэдгээрийг хөрөнгөөр хүлээн зөвшөөрч болно гэж дүгнэсэн.



## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

**Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл (үргэлжлэл)**

1938 оноос хойш зоосыг гүйлгээнээс татахад тэдгээрийг гуравдагч тал эзэмшиж байсан бөгөөд СТОУС 3-ын дагуу гуравдагч тал Эрдэнэсийн санд Зоосыг хөрөнгө байдлаар шилжүүлэн, СТОУС-руу шилжих үед Банкны хөрөнгөөр хүлээн зөвшөөрөхөд шаардлагатай хууль ёсны нотолгоог Банкны удирдлага бидэнд өгч чадаагүй. Иймд, Зоос нь СТОУС-ын дагуу санхүүгийн байдлын тайланд үнэн зөв хүлээн зөвшөөрөгдсөн эсэхэд холбогдох итгэл үнэмшлийг олж чадаагүйгээс шалтгаалан Зоосны бодит үнэ цэнийн дахин үнэлгээний дүн болох 906,788 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг 2021 оны 12 дугаар сарын 31 болон 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны Өөрийн хөрөнгөнд дахин үнэлгээний нөөц сан байдлаар хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бид олж авч чадаагүй болно.

Бид Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар тус тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторовн хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

**Хараат бус байдал**

Нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЁСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЁЗД)-ийн (Хараат бус байдлын олон улсын стандартыг оруулан) дагуу Банкнаас бид хараат бус болно. Бид НБОУЁСЗ-ийн МНБЁЗД-ийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

**Бусад мэдээлэл**

Бусад мэдээллийн хүрээнд Банкны удирдлагууд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь Банкны 2021 оны Жилийн тайлангаас бүрдэнэ (санхүүгийн тайлангууд болон бидний аудитын тайланг агуулаагүй байдаг).

Бидний санхүүгийн тайлангуудад өгөх дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй тул бид бусад мэдээлэлд аливаа төрлийн баталгаа дүгнэлт өгдөггүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой үүрэг хариуцлагынхаа хүрээнд бид, дээр дурдсан бусад мэдээллийг уншиж уг мэдээлэл нь санхүүгийн тайлангууд болон бидний аудитын явцад олж авсан мэдэгдэхүүнтэй материаллаг байдлын түвшинд зөрүүтэй эсвэл буруу илэрхийлэл агуулж буй эсэхийг хардаг.

Хэрэв бусад мэдээлэлд бидний зүгээс хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнд материаллаг хэмжээний алдаа байна гэж дүгнэвэл бид үүнийг мэдэгдэх үүрэгтэй. Дээрх хязгаарлалттай дүгнэлт гаргах үндэслэлд тайлбарласны дагуу 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Зоосны дахин үнэлгээ болон түүний хүлээн зөвшөөрөлттэй холбоотойгоор хангалттай бөгөөд зохистой нотолгоог бид олж авч чадаагүй. Тиймээс, энэ асуудлын хувьд бусад мэдээлэл материаллаг хэмжээгээр буруу илэрхийлэгдсэн эсэхэд бид дүгнэн хэлэх боломжгүй байна.

**Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор засаглал хариуцсан эрх бүхий этгээд болон удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага**

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, бодитойгоор тайлагнах болон залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлангууд бэлтгэхэд шаардлагатай гэж удирдлага тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага байна.

### Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор засаглал хариуцсан эрх бүхий этгээд болон удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад удирдлага Банкны үйл ажиллагааг цаашид тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх, тухайн чадамжид нөлөөлөх нөхцөл байдлын талаар зохистой үед тодруулах болон Банкны үйл ажиллагааг татан буулгах, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл зогсоохоос өөр сонголтгүй болсноос бусад тохиолдлуудад нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Банкны засаглал хариуцсан эрх бүхий этгээд нь санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

### Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгааг олж авах мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл байх тохиолдол бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх боломжтой ба энэ нь санхүүгийн тайланг хэрэглэгчдийн эдгээр тайланд үндэслэн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц байвал материаллаг буруу илэрхийлэл болно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандах, мэргэжлийн холбогдох итгэл үнэмшил бүхий үнэлэлтүүдийг хийдэг. Мөн бид:

- Залилан болон алдааны улмаас санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг илрүүлэн үнэлэх, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг тодорхойлон гүйцэтгэх, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Залилан нь нууцаар үгсэн тохирох, хуурамч бичиг баримт үйлдэх, санаатайгаар орхигдуулах, хуурамч батламж гаргах эсвэл эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотойгоор үүсдэг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас шалтгаалж үүсэх материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэлээс илүү өндөр байдаг.
- Банкны дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг тодорхойлох зорилгын хүрээнд дотоод хяналтын тогтолцооны ойлголтуудыг аудитын явцад олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Банк нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадварт томоохон хэмжээний эргэлзээ үүсч болох нөхцөл байдал, тухайн үйл явдлуудтай холбоотойгоор материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэх болон удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр хангахад зөв зохистой нягтлан бодох бүртгэлийн суурийг сонгосон эсэхийг аудитын туршид бүрдүүлсэн нотолгоонд үндэслэн дүгнэдэг. Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжид материаллаг тодорхойгүй байдал оршин байгаа гэж үзсэн тохиолдолд санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг аудиторын тайланд тусгах, анхааруулах мөн эдгээр тодруулгууд хангалтгүй гэж үзсэн тохиолдолд дүгнэлтээ өөрчилдөг. Бид дүгнэлтээ аудиторын тайланг гаргах өдрийг хүртэл олж авсан аудитын нотолгоонуудад үндэслэн гаргадаг боловч ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлуудаас шалтгаалан Банкны үйл ажиллагаа зогсох нөхцөл байдал үүсч болно.

## МОНГОЛБАНК


## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд багтдаг.

Гарын үсэг зурсан:



Даваагийн Баярмаа  
Гүйцэтгэх захирал  
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Баталсан:

Шаукат Тапиа  
Партнер  
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

2022 оны 6 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот, Монгол Улс

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Монголбанк  
Санхүүгийн Байдлын Тайлан

| Сая төгрөгөөр                                           | Тодруулга | 2021 оны 12<br>дугаар сарын 31 | 2020 оны 12<br>дугаар сарын 31 |
|---------------------------------------------------------|-----------|--------------------------------|--------------------------------|
| <b>ХӨРӨНГӨ</b>                                          |           |                                |                                |
| Бэлэн мөнгө                                             | 7         | 177,591                        | 233,373                        |
| Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө | 8         | 4,473,789                      | 4,517,392                      |
| Дотоодын банкуудад олгосон зээл                         | 9         | 1,487,308                      | 461,314                        |
| Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт                      | 10        | 6,393,822                      | 5,275,129                      |
| Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт                     | 11        | 6,533                          | 6,595                          |
| Урвуу буцаан худалдан авах хэлцэл                       | 12        | 4,522,220                      | 4,816,068                      |
| Алт ба үнэт металл                                      | 13        | 1,685,633                      | 1,785,857                      |
| Эрдэнэсийн сан                                          | 14        | 1,115,085                      | 1,071,665                      |
| Санхүүгийн үүсмэл хэрэгсэл                              | 15        | 77,103                         | 156,419                        |
| Засгийн газрын үнэт цаас                                | 16        | 231,778                        | 227,407                        |
| Бусад хөрөнгө                                           | 17        | 319,721                        | 423,673                        |
| Үндсэн ба биет бус хөрөнгө                              | 18        | 116,024                        | 115,201                        |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө                 |           | 6,097                          | 6,280                          |
| <b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>                                     |           | <b>20,612,704</b>              | <b>19,096,373</b>              |
| <b>ӨР ТӨЛБӨР</b>                                        |           |                                |                                |
| Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө                          | 19        | 1,105,589                      | 991,470                        |
| Төв банкны үнэт цаас                                    | 20        | 8,622,184                      | 7,952,438                      |
| Засгийн газрын хөрөнгө                                  | 21        | 1,734,116                      | 2,132,025                      |
| Дотоод банкуудын хөрөнгө                                | 22        | 4,471,877                      | 3,871,397                      |
| Санхүүгийн үүсмэл хэрэгсэл                              | 15        | 469,758                        | 303,501                        |
| Гадаад өр төлбөр                                        | 23        | 6,914,005                      | 5,789,508                      |
| Бусад өр төлбөр                                         | 24        | 667,231                        | 365,317                        |
| <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                                   |           | <b>23,984,760</b>              | <b>21,405,656</b>              |
| <b>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>                                   |           |                                |                                |
| Дүрмийн сан                                             | 25        | 60,000                         | 60,000                         |
| Хуримтлагдсан алдагдал                                  | 25        | (5,359,185)                    | (4,327,545)                    |
| Бусад нөөц                                              | 25        | 1,927,129                      | 1,958,262                      |
| <b>НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>                              |           | <b>(3,372,056)</b>             | <b>(2,309,283)</b>             |
| <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>                 |           | <b>20,612,704</b>              | <b>19,096,373</b>              |

2022 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Захирлуудын зөвлөлийг төлөөлж энэхүү тайланг нийтлэхийг хүлээн зөвшөөрөв.

Б.Лхагвасүрэн  
Монголбанкны Ерөнхийлөгч

Ц.Гарьд  
Санхүү бүртгэлийн газрын захирал

Хуудас 8-аас 102-д тусгасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## МОНГОЛБАНК

## ОРЛОГЫН ҮР ДҮНГИЙН БОЛОН БУСАД ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

| Сая төгрөгөөр                                                                                                            | Тодруулга | 2021               | 2020             |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|--------------------|------------------|
| Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого                                                                           | 26        | 286,227            | 234,362          |
| Бусад адилтгах орлого                                                                                                    | 26        | 22,165             | 42,810           |
| Хүүгийн зардал                                                                                                           | 26        | (886,262)          | (816,411)        |
| <b>Хүүгийн цэвэр зардал</b>                                                                                              |           | <b>(577,870)</b>   | <b>(539,239)</b> |
| Эрсдэлийн алдагдлын сангийн зардал                                                                                       |           | (95,118)           | (81,355)         |
| <b>Эрсдэлийн сангийн зардлын дараах хүүгийн цэвэр зардал</b>                                                             |           | <b>(672,988)</b>   | <b>(620,594)</b> |
| Алт, үнэт металын арилжааны (алдагдал)/ашиг                                                                              | 27        | (68,539)           | 728,315          |
| Алт, үнэт металын ханшийн тэгшитгэлийн (алдагдал)/ашиг                                                                   |           | (12,432)           | 151,293          |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслийн дахин үнэлгээний алдагдал                                                                   |           | (219,426)          | (242,925)        |
| Гадаад валютын арилжааны алдагдал                                                                                        |           | (4,017)            | (1,356)          |
| Гадаад валютын хөрвүүлгийн алдагдал                                                                                      |           | (88,878)           | (457,735)        |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгддэг өрийн хэрэгслийг данснаас хассаны (алдагдал)/ашиг |           | (1,335)            | 3,262            |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгддэг өмчийн хэрэгслийг данснаас хассаны алдагдал       |           | -                  | (84)             |
| Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалалтын арилжааны ашиг/(алдагдал)                                                       |           | 554                | (6)              |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар илэрхийлэгддэг санхүүгийн хөрөнгийн ашиг/(алдагдал)                         |           | 59,638             | (27,707)         |
| Үйл ажиллагааны бусад орлого                                                                                             | 28        | 29,368             | 29,623           |
| Захиргааны ба үйл ажиллагааны бусад зардал                                                                               | 29        | (66,017)           | (65,464)         |
| <b>ТАЙЛАНТ ЖИЛИЙН АЛДАГДАЛ</b>                                                                                           |           | <b>(1,044,072)</b> | <b>(503,378)</b> |
| <b>Бусад дэлгэрэнгүй (алдагдал)/орлого:</b>                                                                              |           |                    |                  |
| <i>Орлого зарлагад дахин ангилагдаж болзошгүй зүйлс:</i>                                                                 |           |                    |                  |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгддэг өрийн хэрэгсэл:                                   |           |                    |                  |
| - Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн (гарз)/олз                                                                                | 25        | (20,036)           | 95,661           |
| - Борлуулах үед орлогын тайланд шилжүүлсэн олз/(гарз)                                                                    | 25        | 1,335              | (3,262)          |
| <b>Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй (алдагдал)/орлого</b>                                                                |           | <b>(18,701)</b>    | <b>92,399</b>    |
| <b>ТАЙЛАНТ ЖИЛИЙН НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ АЛДАГДАЛ</b>                                                                          |           | <b>(1,062,773)</b> | <b>(410,979)</b> |

## МОНГОЛБАНК

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Сая төгрөгөөр                                            | Тодруулга | Дүрмийн сан   | Бусад нөөц       | Хуримтлагдсан алдагдал | Нийт өөрийн хөрөнгө |
|----------------------------------------------------------|-----------|---------------|------------------|------------------------|---------------------|
| <b>2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн үлдэгдэл</b>     | 25        | <b>60,000</b> | <b>1,739,806</b> | <b>(3,698,110)</b>     | <b>(1,898,304)</b>  |
| Тайлант жилийн алдагдал                                  |           | -             | -                | (503,378)              | <b>(503,378)</b>    |
| Бусад дэлгэрэнгүй орлого                                 |           | -             | 92,399           | -                      | <b>92,399</b>       |
| 2020 оны нийт дэлгэрэнгүй алдагдал                       |           | -             | 92,399           | (503,378)              | <b>(410,979)</b>    |
| Хуримтлагдсан алдагдлаас бусад нөөцөд шилжүүлсэн         | 25        | -             | 126,057          | (126,057)              | -                   |
| <b>2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл</b>   |           | <b>60,000</b> | <b>1,958,262</b> | <b>(4,327,545)</b>     | <b>(2,309,283)</b>  |
| Тайлант жилийн алдагдал                                  |           | -             | -                | (1,044,072)            | <b>(1,044,072)</b>  |
| Бусад дэлгэрэнгүй алдагдал                               |           | -             | (18,701)         | -                      | <b>(18,701)</b>     |
| 2021 оны нийт дэлгэрэнгүй алдагдал                       |           | -             | (18,701)         | (1,044,072)            | <b>(1,062,773)</b>  |
| Бусад нөөц сангаас хуримтлагдсан алдагдал руу шилжүүлсэн | 25        | -             | (12,432)         | 12,432                 | -                   |
| <b>2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл</b>   |           | <b>60,000</b> | <b>1,927,129</b> | <b>(5,359,185)</b>     | <b>(3,372,056)</b>  |

2020 болон 2021 онд хуримтлагдсан алдагдлаас бусад нөөц санд шилжүүлсэн дүн нь алт, үнэт метал болон гадаад валютын ханшийн тэгшитгэлийн бодит бус ашиг, алдагдлын зөрүүг шилжүүлсэнтэй холбоотой (Тодруулга 25).

## МОНГОЛБАНК

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Сая төгрөгөөр                                                                                                            | Тодруулга | 2021               | 2020             |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|--------------------|------------------|
| <b>Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>                                                                                    |           |                    |                  |
| <b>Тайлант жилийн алдагдал:</b>                                                                                          |           | <b>(1,044,072)</b> | <b>(503,378)</b> |
| <i>Тохируулгууд:</i>                                                                                                     |           |                    |                  |
| Эрсдэлийн алдагдлын сангийн зардал                                                                                       |           | 95,118             | 81,355           |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгддэг өрийн хэрэгслийг данснаас хассаны алдагдал/(ашиг) |           | 1,335              | (3,262)          |
| Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалалтын арилжааны (ашиг)/алдагдал                                                       |           | (554)              | 6                |
| Алт ба үнэт металын ханшийн тэгшитгэлийн алдагдал/ (ашиг)                                                                |           | 12,432             | (151,293)        |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслийн дахин үнэлгээний алдагдал                                                                   |           | 219,426            | 242,925          |
| Гадаад валютын хөрвүүлгийн алдагдал                                                                                      |           | 94,437             | 584,891          |
| Үндсэн болон биет бус хөрөнгийн элэгдэл                                                                                  | 29        | 7,568              | 6,090            |
| Данснаас хассан үндсэн хөрөнгө                                                                                           |           | 3                  | 5                |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар илэрхийлэгддэг санхүүгийн хөрөнгийн (ашиг)/алдагдал                         |           | (59,638)           | 27,707           |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгддэг өмчийн хэрэгслийг данснаас хассаны алдагдал       |           | -                  | 84               |
| Мөнгөн бус хандивын орлого                                                                                               |           | -                  | (111)            |
| Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого                                                                           | 26        | (286,228)          | (234,362)        |
| Бусад адилтгах орлого                                                                                                    | 26        | (22,165)           | (42,810)         |
| Хүүгийн зардал                                                                                                           | 26        | 886,262            | 816,411          |
| <b>Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>                            |           | <b>(96,076)</b>    | <b>824,258</b>   |
| <i>Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтүүд:</i>                                                                |           |                    |                  |
| Алт, үнэт металын цэвэр бууралт                                                                                          |           | 87,792             | 1,474,120        |
| Урвуу буцаан худалдан авах хэлцлийн цэвэр бууралт/(өсөлт)                                                                |           | 337,273            | (1,546,820)      |
| Дотоодын банкуудын хөрөнгийн цэвэр (өсөлт)                                                                               |           | (1,038,737)        | (25,233)         |
| Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгийн цэвэр бууралт/(өсөлт)                                          |           | 2,070              | (1,698)          |
| Бусад хөрөнгийн цэвэр бууралт                                                                                            |           | 397,143            | 442,124          |
| Төв банкны үнэт цаасны цэвэр өсөлт                                                                                       |           | 676,302            | 3,316,148        |
| Засгийн газрын хөрөнгийн цэвэр (бууралт)                                                                                 |           | (370,287)          | (166,179)        |
| Дотоодын банкуудын хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)                                                                       |           | 620,756            | (2,310,184)      |
| Бусад өр төлбөрийн цэвэр өсөлт/(бууралт)                                                                                 |           | 9,950              | (470,042)        |
| <b>Үйл ажиллагаанаас олсон хүүгийн өмнөх цэвэр мөнгөн гүйлгээ</b>                                                        |           | <b>626,187</b>     | <b>1,536,494</b> |
| Хүлээн авсан хүү                                                                                                         |           | 270,056            | 215,185          |
| Төлсөн хүү                                                                                                               |           | (891,510)          | (815,171)        |
| <b>Үйл ажиллагаанаас олсон нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                                                                 |           | <b>4,733</b>       | <b>936,508</b>   |
| <b>Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ</b>                                                                                 |           |                    |                  |
| Үндсэн болон биет бус хөрөнгийн худалдан авалт                                                                           | 18        | (14,078)           | (44,069)         |



## МОНГОЛБАНК

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ҮРГЭЛЖЛЭЛ

|                                                                                                        |                  |                    |                    |
|--------------------------------------------------------------------------------------------------------|------------------|--------------------|--------------------|
| Үндсэн хөрөнгийн борлуулалтын олз                                                                      |                  | 5,867              | 11,756             |
| Эрдэнэсийн сангийн цэвэр өсөлт                                                                         | 14               | (43,420)           | (2,805)            |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгддэг өмчийн хэрэгслийн цэвэр бууралт |                  | -                  | 5,055              |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгддэг өрийн хэрэгслийн худалдан авалт |                  | (4,986,979)        | (1,882,039)        |
| Хорогдуулсан өртгөөр хэмжих өрийн хэрэгслийн худалдан авалт                                            |                  | (763,232)          | (751,163)          |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгддэг өрийн хэрэгслийн борлуулалт     |                  | 4,262,051          | 1,056,258          |
| Хорогдуулсан өртгөөр хэмжих өрийн хэрэгслийн борлуулалт                                                |                  | 343,677            | 243,880            |
| <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ</b>                              |                  | <b>(1,196,113)</b> | <b>(1,363,127)</b> |
| <i>Сая төгрөгөөр</i>                                                                                   | <b>Тодруулга</b> | <b>2021</b>        | <b>2020</b>        |
| <b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>                                                       |                  |                    |                    |
| Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөний өсөлт                                                                | 19               | 114,119            | 94,053             |
| Гадаад өр төлбөрийн өсөлт                                                                              | 23               | 2,237,184          | 284,364            |
| Гадаад өр төлбөрийн эргэн төлөлт                                                                       | 23               | (1,231,344)        | (45,766)           |
| <b>Санхүүгийн үйл ажиллагаанаас олсон цэвэр мөнгөн гүйлгээ</b>                                         |                  | <b>1,119,959</b>   | <b>332,651</b>     |
| <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө</b>                             |                  | <b>(27,962)</b>    | <b>171,961</b>     |
| <b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт)/өсөлт</b>                                       |                  | <b>(99,383)</b>    | <b>77,993</b>      |
| <b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                                              | <b>7</b>         | <b>4,750,573</b>   | <b>4,672,580</b>   |
| <b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>                                             | <b>7</b>         | <b>4,651,190</b>   | <b>4,750,573</b>   |

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 1 ТАНИЛЦУУЛГА БОЛОН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИН

**Танилцуулга.** Монголбанк (цаашид “Банк”) нь Монгол Улсын Төв банк бөгөөд Үндсэн хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон бусад холбогдох хуулиудын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Монгол Улсын Засгийн газрын 1924 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн тогтоолоор анх байгуулагдсан.

Банк нь бүхий л үйл ажиллагаагаа Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулдаг болно. Монголбанкны системд орон нутгийн нийт 17 хэлтэс, салбар болоод Их Британийн Лондон хот дахь төлөөлөгчийн газар багтдаг.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд зааснаар Банкны үндсэн зорилго нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээл болон банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн хөгжилд тэнцвэртэй дэмжлэг үзүүлэх явдал юм.

Банк нь ашгийн төлөө ажилладаггүй. Төрөөс үүсгэн байгуулсан тусгай хуулийн этгээдийн хувьд Банкны үйл ажиллагааны санхүүгийн үр дүн болон хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүтэц нь Банкны үйл ажиллагаагаар тодорхойлогддог.

Банк нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу дараах үндсэн үйл ажиллагааг явуулдаг. Үүнд:

- Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах;
- Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах замаар мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэх (“Засгийн газар” эсвэл “Төрийн”);
- Банкны үйл ажиллагаанд хяналт тавих;
- Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах;
- Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах;
- Эцсийн эзэлдүүлэгчийн үүргийг гүйцэтгэх болон дахин санхүүжилтийн системийг зохион байгуулах;
- Бусад хамтын ажиллагаа бүхий төв банкууд, олон улсын банк болон санхүүгийн байгууллагуудад Монгол Улсыг төлөөлөх;

Санхүү, зээлтэй холбоотой бусад чиг үүргүүдийг хуульд тодорхойлсон хэм хэмжээний дагуу гүйцэтгэх.

Хуульд заасны дагуу Банк нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор банкуудад зээл олгох, хоёрдогч зах зээл дээр үнэт цаас худалдах, худалдан авах, гадаад валют, үнэт метал худалдах, худалдан авах, дотоодын ба гадаадын зах зээл дээр үнэт метал болон энгийн металаар хийсэн дурсгалын зоосыг худалдах, Засгийн газрын үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах, Засгийн газар болон Сангийн яам (Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага) гэх мэт бусад төрийн байгууллагууд, Олон улсын байгууллагуудын дансыг Банкинд байршуулах болон өөрийн үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай бусад үйл ажиллагааг явуулдаг.

Банкны дүрмийн санг Монгол Улсын төр бүрэн эзэмшдэг. Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасны дагуу Захирлуудын зөвлөлийн үндсэн үүрэг нь мөнгөний бодлогын зарчмыг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавих явдал юм. Түүнчлэн, Банкны ирэх оны жилийн төсвийг батлах, түүний биелэлт гүйцэтгэлийн талаар олон нийтэд тайлагнах, тайлант жилийн ашгийн хуваарилалтыг хийх зэрэг Монгол Улсын хууль тогтоомжид заасан эрх мэдлийн хүрээнд бусад чиг үүргийг Захирлуудын зөвлөл гүйцэтгэдэг.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 1 ТАНИЛЦУУЛГА БОЛОН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИН (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Бүртгэгдсэн хаяг ба үйл ажиллагаа явуулж буй байршил.** Банкны бүртгэгдсэн албан ёсны хаяг нь: Монгол Улс, Улаанбаатар 46, Бага Тойруу 3, 15160.

**Банкны үйл ажиллагааны орчин.** Монгол улс хөгжиж буй зах зээлийн олон шинж чанарыг агуулдаг бөгөөд тэр дундаа харьцангуй өндөр инфляци, зээлийн хүүгийн түвшинтэй. Уул уурхайн салбар дахь боловсруулах үйлдвэрлэлийн түвшин бага байгаагаас шалтгаалж нүүрс, зэс зэрэг ашигт малтмалын түүхий эдийн нөөцийн экспорт нь эдийн засгийн гол орлогыг бүрдүүлдэг. Монгол Улсын эдийн засаг 2017-2019 онд дунджаар 6 орчим хувиар өссөн боловч КОВИД-19 тахлын сөрөг нөлөөллийн улмаас тус улсад орж ирж буй гадаадын хөрөнгө оруулалт удааширч, макро эдийн засгийн эмзэг байдал үүссэн бөгөөд энэ нь Монголын эдийн засагт хүчтэй сөрөг нөлөө үзүүлж 5.3%-аар буурсан. Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2021 онд 1.4 хувьтай байсан нь гадаад худалдааны таатай нөхцөл, түүхий эдийн үнийн өсөлт, экспортын эрэлт нэмэгдсэн зэрэгтэй холбоотой.

Цар тахалтай холбоотой эрсдлүүд буурч, дэлхийн эдийн засаг эрчимжиж буй тул Монгол Улсын эдийн засаг 2022 онд аажмаар сэргэх төлөвтэй байна.

Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ Стандарт энд Пүүр'с кредит рейтинг тогтоох байгууллагын 2021 оны 8 сарын 3-ны өдрийн үнэлгээгээр тогтвортой төлөвтэй, “В” түвшинд байна. Мүүди'с үнэлгээний агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2021 оны 3 сарын 16-ны өдөр «В3» тогтвортой төлөвтэй гэж зарласан.

Монгол Улсын засгийн газраас цар тахлын үед эдийн засгийг тогтворжуулах зорилгоор жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд бага хүүтэй зээл олгох, хэрэглээний болон орон сууцны зээлийн хугацааг 2021 оны 1 сараас 6 сарыг дуустал 6 сарын хугацаагаар хойшлуулах зэрэг арга хэмжээ авсан ба орон сууцны зээлийн төлбөрийг хойшлуулах хугацааг дахин 2022 оны 12 сарын 31-ний өдөр хүртэл сунгахаар шийдвэрлэсэн.

Энэхүү эдийн засгийн хямралын үед Засгийн газар нь банкны салбарын шинэчлэлтийг эхлүүлж, Улсын Их Хурлаас 2021 оны 1 сарын 28-ны өдөр Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэхүү хуулийн үр дүнд банкны хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг бууруулж, банкны бүтэц дэх өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэрийг хангах юм. Банкны системд нөлөө бүхий 5 банк нь нээлттэй хувьцаат компанид шилжих бөгөөд 2022 оны 6 сарын 30-ны өдрөөс өмнө хөрөнгийн зах зээлд хувьцаагаа олон нийтэд санал болгоно.

2022 оны эдийн засгийн өсөлтийн төлөв нь КОВИД-19 цар тахлын тархалт, хил залгаа Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эдийн засгийн сэргэлтийн хурд, түүхий эдийн экспортын өсөлт, хөрөнгө оруулалтын орчин ба хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллагуудын зээлийн өсөлтөөс хамаарна. Хүлээгдэж буй зээлийн алдагдал (ХЗА)-ийн тооцоог гаргахдаа Банк нь макро эдийн засгийн хувьсагчдын таамаглалыг багтаасан алсыг харсан мэдээллийг ашигладаг. Гэсэн хэдий ч эдийн засгийн урьдчилсан таамаглалын хувьд тэдгээр тохиолдлын биелэх магадлал, төсөөлөл нь ерөнхийдөө маш тодорхойгүй байдаг тул бодит үр дүн нь төлөвлөснөөс эрс өөр байж болно. Тодруулга 3 ба 32-т Банкны ирээдүйн талаарх мэдээллийг ХЗА загварт хэрхэн ашигласан талаарх мэдээллийг дэлгэрэнгүй харуулсан болно.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

**2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ТОГТОЛЦОО, ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ БОЛОН ТОЛИЛУУЛГА**

**Тайлан бэлтгэх үндэслэл.** Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу санхүүгийн хэрэгслийг анхлан бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх болон үндсэн хөрөнгө, Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээ, санхүүгийн хэрэгслийн дахин үнэлгээг тайлант үеийн орлого зарлагад бодит үнэ цэнийн дагуу бүртгэх мөн бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийн дагуу бүртгэхээс бусад тохиолдолд түүхэн өртгийн зарчмын дагуу бэлтгэж тайлагнасан болно. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмуудыг Тодруулга 3-т толилуулсан. Өөрөөр дурдаагүй бол, дээрх бодлогуудыг бүх толилуулсан бүх тайлагналын хугацаанд ашигласан.

**Тайлагналын мөнгөн нэгж.** Энэхүү санхүүгийн тайлангууд нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох “төгрөг”-өөр илэрхийлэгдсэн болно.

**Санхүүгийн тайланг баталгаажуулсны дараа өөрчлөлт хийх тухай** Банкны удирдлага нь санхүүгийн тайланг баталгаажуулсан өдрөөс хойш хугацаанд эдгээр санхүүгийн тайлангуудад өөрчлөлт хийх эрхтэй болно.

### 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

**Санхүүгийн хэрэгсэл** - гол хэмжилтийн нэр томьёо. *Бодит үнэ цэнэ* нь мэдээлэл бүхий холбоогүй талууд сайн дураараа хоорондоо хөрөнгө солилцох эсвэл өр төлбөр барагдуулахад бэлэн буй үнийг хэлнэ. Бодит үнэ цэнэ нь санхүүгийн хөрөнгийн хувьд идэвхитэй зах зээл дээр зарласан өнөөгийн худалдан авах үнэ, санхүүгийн өр төлбөрийн хувьд өнөөгийн худалдах үнэ болно. Идэвхитэй зах зээл гэдэг нь хөрөнгө ба өр төлбөртэй холбоотой гүйлгээ хангалттай их хэмжээгээр тогтмол гардаг, тэдгээрийн үнийн мэдээллийг хэдийд ч авах боломжтой байхыг хэлнэ. Санхүүгийн хэрэгслийн санал болгож байгаа үнэ нь хөрөнгийн зах зээл эсвэл бусад санхүүгийн байгууллагуудаас тогтмол нийгэд зарладаг буюу мэдээлэл нь нээлттэй олох боломжтой ба эдгээр үнийн дагуу зах зээл дээр холбоогүй этгээдүүдийн хооронд байнгын тогтмол гүйлгээ хийгддэг тохиолдолд санхүүгийн хэрэгслийг идэвхитэй зах зээл дээр санал болгосон гэж үздэг.

Идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй санхүүгийн үүсмэл хэрэгсэл эсвэл бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн багцыг бодит үнэ цэнээр нь буюу хэмжилт хийх өдөр тодорхой эрсдэлийн түвшинд урт позицыг (жишээ нь хөрөнгийн хувьд) арилжаалж болох цэвэр үнийн дүн эсхүл тодорхой эрсдэлийн түвшинд богино позицыг (жишээ нь өр төлбөрийн хувьд) хаахад гарах цэвэр дүнг зах зээлд оролцогчдын хооронд хийгдэж буй гүйлгээнд үндэслэн үнэлнэ. Энэхүү аргачлалыг бодит үнэ цэнээр үнэлэгдэх хөрөнгийн хувьд ашиглах бөгөөд банк нь (а) тус санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийг удирдахдаа байгууллагын өртөх магадлалтай зах зээлийн тодорхой эрсдэлд (эсхүл эрсдлүүдэд) эсхүл тодорхой харилцагч талын эрсдэлд үндэслэдэг нь байгууллагын дотоод эрсдэлийн удирдлагын баримт бичиг болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд дурдагдсан байна; (б) санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийн багцын удирдлагын талаар байгууллагын түлхүүр удирдлагад мэдээллийг хүргэх чадамжтай байх бөгөөд (в) зэх зээлийн эрсдэл болон тодорхой зах зээлийн эрсдэлд өртөх хугацаа нь санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийн хувьд ижил байна.

Удирдлагын зүгээс үнэлгээний аргачлал нь санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн үнэ цэнийг илүү нарийн тооцно гэж үзэж байна. Үнэлгээний аргачлалд ашигласан гол мэдээллийг Тодруулга 33-с харна уу.

Гадаад зах зээлийн мэдээлэл авах боломжгүй тохиолдолд санхүүгийн тодорхой хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцохдоо хорогдуулсан мөнгөн гүйлгээний загвар, сүүлийн үеийн сунгасан гарын зарчмын дагуу хийгдсэн хэлцэлд ашигласан загвар болон санхүүжигч талын санхүүгийн тайлан мэдээ зэрэг үнэлгээний аргачлалыг ашиглана. Бодит үнэ цэнийг бодит үнэ цэнийн ангилал тус бүрд үнэлэх ба эдгээр түвшин нь (i) Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан 1-р түвшинд тодорхойлно. (ii) Хөрөнгө болон өр төлбөрийн хувьд материаллаг боломжит өгөгдлийг ашиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) үнэлгээний аргачлалыг 2-р түвшинд хэрэгжүүлнэ (iii) 3-р түвшинд зах зээлийн ашиглаж болох өгөгдөлд тулгуурлахгүйгээр (зах зээлээс шууд ашиглах боломжгүй өгөгдөлийг шаарддаг) үнэлгээг тодорхойлно. Бодит үнэ цэнийн ангилал дахь түвшингүүдийн хоорондын шилжүүлгийг тайлант хугацааны эцэст хийгдсэн гэж үзнэ. Дэлгэрэнгүйг Тодруулга 33-с харна уу.

Гүйлгээний зардлууд нь санхүүгийн хэрэгслийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал нь гүйлгээг хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх зардлыг хэлнэ. Гүйлгээний зардалд зуучлагч, борлуулагч (борлуулалтын үүрэг гүйцэтгэж буй ажилтнуудын цалин), зөвлөх, брокер, дилерүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулах агентлаг, хөрөнгийн биржийн ногдуулсан хураамж төлбөрүүд, мөн шилжүүлэлтэд ногдуулсан татвар хураамжууд хамаарна. Гүйлгээний зардалд өрийн хямдруулалт болон урамшуулал, санхүүгийн зардлууд, дотоодын захиргааны буюу хадгалалтын зардлууд орохгүй.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хорогдуулсан өртөг (ХӨ) гэдэг нь санхүүгийн хэрэгслийг анхлан хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүг анх хүлээн зөвшөөрөх үед хойшлогдсон гүйлгээний зардал, мөн нэрлэсэн үнээс аливаа урамшууллын эсвэл хямдруулалтын дүнг үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт багтана. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн хорогдуулсан урамшуулал ба хямдруулалтыг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй ба тэдгээрийг санхүүгийн байдлын тайлангийн холбогдох хэсэгт дансны үнээр тусгасан болно.

Үр ашигт хүүгийн арга нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны турш дансны үнээс тооцогдох хүүгийн түвшинг тогтмол байлгах аргаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн түвшин нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын орлого, эсвэл гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэгслийн хүлээгдэж буй хугацаа эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны турш хямдруулж санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн Дансны үнэг гаргаж авах хүүгийн түвшин юм.

Үр ашигт хүүг хувьсах хүүтэй хэрэгслийн мөнгөн урсгалын хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл хямдруулах боловч уг хэрэгсэлд тусгагдсан хувьсах хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн урамшуулал болон хямдруулалтыг, мөн зах зээлийн түвшинд тохируулагдахгүй бусад хувьсах хүчин зүйлүүдээс үл хамаарна. Эдгээр урамшуулал болон хямдруулалтыг тухайн хэрэгслийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулан тооцно. Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд гэрээний талуудын хооронд төлөх эсвэл хүлээн авах бүх хураамжийг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүгийн нэг бүрэлдэхүүн хэсэг болно.

Худалдаж авсан эсвэл үүсгэсэн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө зээлийн үнэ цэнэ буурсан бол үр ашигт хүүг ч мөн үнэ цэнийн бууралтад тохируулан бүртгэнэ, жишээ нь: гэрээнд заасан эргэн төлөлтийн оронд анх хүлээн зөвшөөрсөн ирээдүйн мөнгөн урсгалд тулгуурлан тооцоолно.

**Санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөх.** Тайлант үеийн орлого зарлагад бодит үнэ цэнэ нь илэрхийлэгддэг санхүүгийн хэрэгслүүдийг анх бодит үнэ цэнээр бүртгэнэ. Бусад бүх санхүүгийн хэрэгслийг анх бодит үнэ цэнэ дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр бүртгэдэг. Анх бүртгэх бодит үнэ цэнэ нь гүйлгээ хийгдсэн үнээр баталгаажсан байдаг. Анх бүртгэх үед үүсэх олз эсвэл гарзыг бодит үнэ цэнэ болон гүйлгээний үнийн хооронд зөрүү гарсан бөгөөд үүнийг зөвхөн ижил төстэй хэрэгслийг сүүлийн үед арилжсан талаарх зах зээлийн нээлттэй мэдээллээр баталгаажуулсан эсвэл зөвхөн нээлттэй зах зээлээс авсан мэдээлэлд үндэслэж хийсэн үнэлгээний аргачлалаар тооцсон тохиолдолд хүлээн зөвшөөрнө. Анх хүлээн зөвшөөрсний дараа хүлээгдэж буй зээлийн алдагдлын (“ХЗА”) санг хорогдуулсан өртгөөр бүртгэж хэмжих санхүүгийн хөрөнгө болон бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийг бүртгэж хэмжих өрийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтад хүлээн зөвшөөрөх ба энэ нь нягтлан бодох бүртгэлийн алдагдалд хүргэдэг.

Зохицуулах байгууллагаас тогтоосон эсвэл зах зээлийн жишгээр тогтсон (“хэвийн” худалдаа болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан нийлүүлэх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л борлуулалт болон худалдан авалтыг арилжаа хийсэн өдөр буюу Банк тухайн санхүүгийн хөрөнгийг нийлүүлэх үүрэг хүлээсэн үед бүртгэнэ. Бусад бүх худалдан авалтыг Банк нь санхүүгийн хэрэгслийн гэрээний нэг тал болсон үед хүлээн зөвшөөрнө.



### 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банк идэвхтэй зах зээлд арилжаалагдаагүй урт хугацаат гадаад валютын хүүгийн СВОП хэлцлийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо хямдруулсан мөнгөн урсгалын үнэлгээний аргачлалыг ашигладаг. 3-р түвшний дахин үнэлгээний аргаарх анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнэ болон дараа үед тодорхойлсон дүнгийн хооронд зөрүү үүсч болно. Зөрүүг хөрөнгө эсвэл өр төлбөрөөр анх хүлээн зөвшөөрч урт хугацаат гадаад валютын хүүгийн СВОП хэлцлийн дуусах хугацаа хүртэл хорогдуулна.

Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - хэмжилтийн төрөл. Банк нь санхүүгийн хөрөнгийг дараах хэмжилтийн төрлүүдээр ангилна: Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаарх (“БҮЦӨАА”), Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоорх (“БҮЦӨБДО”) болон Хорогдуулсан өртөг (“ХӨ”). Санхүүгийн өрийн хэрэглүүрийн ангилал болон дараа үеийн хэмжилт нь (i) банкны холбоотой хөрөнгүүдийг удирдах бизнесийн модел (ii) хөрөнгийн мөнгөн урсгалын онцлогоос хамаарна.

**Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - бизнес модел.** Бизнес модел нь Банк хөрөнгийг мөнгөн урсгал бий болгох зорилгоор хэрхэн удирдаж байгаагаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлвэл Банкны зорилго нь (i) зөвхөн хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах эсвэл (ii) хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авахаас болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авахын аль нь вэ гэдгээс хамаарах бөгөөд хэрэв (i) ба (ii)-ын аль ч тохиолдол биш бол санхүүгийн хөрөнгийг нь «бусад» гэсэн бизнес моделд хамааруулан ангилах ба бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжинэ.

Бизнесийн загварыг үнэлгээний өдөр боломжит багцад зориулан тогтоосон зорилтондоо хүрэхийн тулд Банкны хийж буй үйл ажиллагааны талаарх бүх нотолгоонд үндэслэн Банкны хөрөнгийг (багцын түвшинд) тодорхойлно. Бизнесийн загварыг тодорхойлоход Банкны авч үздэг хүчин зүйлс нь багцын зорилго ба бүрэлдэхүүн, тухайн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хэрхэн цуглуулсан, эрсдэлийг хэрхэн үнэлж, удирдаж байсан, хөрөнгийн гүйцэтгэлийг яаж үнэлсэн, цалин хөлс, урамшууллын системд хэрхэн тусгагдсан талаар өнгөрсөн туршлагад үндэслэдэг. Санхүүгийн хөрөнгийн бизнес моделийг тодорхойлоход Банкны ашигласан үнэлэлтүүдийг тодруулга 4-өөс үзнэ үү.

**Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - мөнгөн урсгалын онцлог.** Бизнес модел нь хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах эсвэл хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авах зорилготой үед мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй (ЗХҮТ) эсэхэд үнэлгээ өгнө. Гэрээний мөнгөн урсгал нь ЗХҮТ-ийн онцлогтой нийцсэн эсэхийг тодорхойлоход нуугдмал деривативыг агуулсан санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь авч үзнэ. Энэ үнэлгээг хийхдээ гэрээний мөнгөн урсгал нь зээлийн гэрээний үндсэн тохиролцоонд тогтвортой эсэх, ялангуяа хүү нь зээлийн эрсдэл, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон зээлийн бусад эрсдэл, ашгийн түвшинг багтаасан эсэхэд үнэлгээ өгнө.

Гэрээний нөхцлүүд нь эрсдэлтэй эсвэл зээлийн үндсэн нөхцөлтэй үл нийцэх хэлбэлзлийг харуулж байвал санхүүгийн хөрөнгө нь Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэнэ. ЗХҮТ үнэлгээ нь хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед хийгдэх бөгөөд дараа үед дахин хийгдэхгүй. Санхүүгийн хөрөнгүүдэд ЗХҮТ шалгалт хийхэд Банкны ашигласан үнэлэлтүүдийг тодруулга 4-өөс үзнэ үү.

**Санхүүгийн хөрөнгө – дахин ангилал.** Багцыг удирдаж байгаа бизнес модел бүхэлдээ өөрчлөгдсөн бол санхүүгийн хэрэгслийг дахин ангилна. Дахин ангилал нь ирээдүйд нөлөө үзүүлэх бөгөөд бизнес модел өөрчлөгдсөний дараах хамгийн эхний тайлагналын үеийн эхнээс хэрэгжинэ. Банк нь өмнөх болон тайлант хугацаанд бизнес загвараа өөрчлөөгүй болон дахин ангилаагүй болно.



## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт - Хүлээгдэж буй зээлийн алдагдлын сан.** Банк нь хорогдуулсан өртөг болон Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх санхүүгийн өрийн хэрэглүүр болон зээл, баталгаатай холбоотой хүлээгдэж буй алдагдлыг ирээдүйн төсөөлсөн нөхцөл байдалд суурилан үнэлдэг. Банк нь хүлээгдэж буй зээлийн алдагдлыг (“ХЗА”) хэмжиж, алдагдлын хасагдуулгыг тайлант хугацаа бүрт хүлээн зөвшөөрдөг. Хүлээгдэж буй алдагдлын хэмжилт нь (i) олон янзын боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлсон зохистой, магадлалаар жигнэсэн дүн; (ii) Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ; болон (iii) өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хэт их өртөг, хүчин чармайлтгүйгээр олдох боломжтой үндэслэл бүхий бэлэн мэдээллүүд дээр үндэслэнэ.

Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүрийг Санхүүгийн байдлын тайланд ХЗА-ын хасагдуулгыг хассан Дансны үнэгээр тайлагнана. Зээл болон баталгааны хувьд ХЗА-ын санг санхүүгийн байдлын тайланд өр төлбөр гэж тусад нь тайлагнана. БҮЦӨБДО-ээрх өрийн хэрэглүүрийн хувьд хорогдуулсан өртгийг хассан дүн нь орлого зарлагаар хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд дансны үнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод БҮЦӨБДО-рх өрийн хэрэглүүрийн алдагдлыг хассан дүнгээр тайлагнагдана.

Банк нь анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа зээлийн чанарт үндэслэсэн үнэ цэнийн бууралтад «3 шатлал» бүхий дараах загварыг ашиглана. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш ямар нэг үнэ цэнийн бууралтгүй зээлүүд нь “1-р шатлал”-д ангилагдана. 1-р шатлалын зээлүүдийн ХЗА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдлын тайлант өдрөөс хойш 12 сарын дотор эсвэл хэрэв үүнээс богино бол гэрээний хугааа дуусах хүртэл (12 сарын ХЗА) үүсч болох санхүүгийн хэрэглүүрийн дефолтоос үүдэн гарах хүлээгдэж буй алдагдлын хэсгийн хэмжээтэй ижил дүнгээр хэмжигдэнэ. Хэрэв Банк анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн гэдгийг тогтоовол хөрөнгийг «2-р шатлал»-д ангилах бөгөөд ХЗА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэх ба энэ нь гэрээ дуусах хүртэл боловч хэрэв байгаа бол хүлээгдэж буй эргэн төлөлтүүдийг авч үзнэ (Ашиглалтын хугацааны ХЗА). Хэрэв Банк санхүүгийн хөрөнгийн зээлийн үнэ цэнэ буурсан гэж тодорхойлсон бол хөрөнгийг “3-р шатлал” руу шилжүүлэх ба ХЗА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэнэ. Банкны зээлийн үнэ цэнэ буурсан хөрөнгийн тодорхойлолт болон дефолтын тодорхойлотыг Тодруулга 32-д тайлбарласан. Худалдан авсан, шинээр гаргасан зээлийн – зээлжих чадамжаас үүдэлтэй үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд ХЗА нь үргэлж хөрөнгийн ашиглалтын хугацааны турш дах ХЗА-тай ижил хэмжигдэнэ. ХЗА-ын загварыг хэмжихэд ашиглагдсан мэдээллүүд, таамаглал болон тооцооллын аргуудыг Тодруулга 32-өөс үзнэ үү.

**Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах.** Банк санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг: (а) хөрөнгийн төлбөрийг авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн өгсөн эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн дамжуулан өгөх хэлцэлд оролцож (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлсэн, эсвэл (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлээгүй ч, өөртөө авч үлдээгүй буюу хяналтын эрхийг хадгалж үлдээгүй. Холбогдох тал хөрөнгийн борлуулалтад нэмэлт хязгаарлалт хийхгүйгээр холбоогүй гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах боломжгүй тохиолдолд хяналтын эрхийг хадгалж үлдсэн гэж үзнэ.

### 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Санхүүгийн хөрөнгө - Өөрчлөлт.** Банк нь санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлийг өөрчлөх буюу дахин тохиролцоо тохиолдол гардаг. Банк нь гэрээний мөнгөн урсгалын өөрчлөлт нь мэдэгдэхүйц эсэхийг дараах зүйлсийг харгалзан үзэж үнэлнэ; хөрөнгийн эрсдэлийн үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээр гэрээний шинэ зүйл заалт байгаа эсэх, (ялангуяа ашгийн хуваарилалт эсвэл өмчийн өгөөж), хүүгийн түвшний мэдэгдэхүйц өөрчлөлт, нэрлэсэн валютын өөрчлөлт, шинэ барьцаа эсвэл хөрөнгөтэй холбоотой зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц нөлөөлөх зээлийн өсөлт, мөн зээлдэгчийн санхүүгийн хүндрэлд ороогүй байх үе дэх зээлийн сунгалт гэх мэт.

Хэрэв өөрчлөгдсөн нөхцөлүүд нь анхны нөхцөлөөс мэдэгдэхүйц зөрүүтэй бол анхны хөрөнгийн мөнгөн урсгалыг хүчингүй болгож банк нь анхны санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч бодит үнэ цэнээр нь шинэ хөрөнгөд хүлээн зөвшөөрнө. Дахин тохиролцоо хийсэн өдөр нь дараах үеийн үнэ цэнийн бууралтыг тооцоолох зорилгоор анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр болно. Мөн зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт байгаа эсэхийг харгалзан үзнэ. Мөн банк нь шинэ зээл буюу өрийн хэрэглүүр нь үндсэн төлбөр болон зээлийн хүүгийн шалгуурт нийцэж байгаа эсэхийг үнэлж үзнэ. Үл хүлээн зөвшөөрөгдсөн анхны хөрөнгийн дансны үнэ болон мэдэгдэхүйц өөрчлөлт орсон шинэ хөрөнгийн бодит үнэ цэнийн зөрүү нь өмчлөгчидтэй хийсэн хөрөнгийн гүйлгээтэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Дахин тохиролцоо нь хамтрагчийн санхүүгийн хүндрэлтэй байдал болон анхны тохиролцсон төлбөрөө төлөх боломжгүй болсон үед хийгдэж байгаа нөхцөлд Банк нь хөрөнгийн одоогийн шинэчлэгдсэн мөнгөн гүйлгээ болон анхны мөнгөн гүйлгээг харьцуулж гэрээний өөрчлөлтөөс үүдэлтэй мэдэгдэхүйц өөрчлөгдсөн хөрөнгөд эрсдэл болон ашиг байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв эрсдэл болон ашиг өөрчлөгдөөгүй бол өөрчилсөн хөрөнгө нь анхны хөрөнгөөс мэдэгдэхүйц өөрчлөлтгүй гэх ба өөрчлөлтөөс үүдэн үл хүлээн зөвшөөрөхгүй. Банк нь анхны үр ашигт хүүгийн түвшин (эсвэл Худалдан авсан, шинээр гаргасан зээлийн – зээлжих чадамжаас үүдэлтэй үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд зээлийн тохируулгатай үр ашигт хүүгийн түвшин)-г ашиглан өөрчлөгдсөн гэрээний мөнгөн урсгалыг хорогдуулах замаар нийт дансны үнийг дахин тооцоолж, өөрчлөлтийн ашиг алдагдлыг хүлээн зөвшөөрнө.

**Санхүүгийн өр төлбөр - хэмжилтийн ангилал.** Санхүүгийн өр төлбөрүүдийг дараахиаас бусад тохиолдолд дараа үеийн хорогдуулсан өртгийн хэмжилтээр ангилна, үүнд (1) бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар бүртгэгдсэн санхүүгийн өр төлбөр: энэхүү ангилал нь дериватив, борлуулахаар эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр (үүнд богино хугацаат үнэт цаас), бизнесийн нэгдэл дэх нэгтгэгчийн хүлээн зөвшөөрсөн болзошгүй зүйлс болон анхны хүлээн зөвшөөрөлтөөрөө илэрхийлэгдсэн санхүүгийн өр төлбөр, (2) мөн санхүүгийн баталгааны гэрээ болон зээлийн амлалтуудад хамаарна.

**Санхүүгийн өр төлбөр - Үл хүлээн зөвшөөрөлт.** Санхүүгийн өр төлбөр нь төлж барагдуулснаар үл хүлээн зөвшөөрөгдөнө. (мөн гэрээгээр хүлээсэн үүрэг нь хүчингүй болсон цуцлагдсан үед үл хүлээн зөвшөөрөгдөнө.)

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Компани болон түүний анхны зээлдэгчдийн мэдэгдэхүйц өөр нөхцөл хугацаа бүхий өрийн хэрэглүүр, болон одоо буй санхүүгийн өр төлбөрийн нөхцөл, хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлт нь анхны санхүүгийн өр төлбөр үгүй болж шинэ санхүүгийн өр төлбөр бий болсонд тооцогдоно. Шинэ нөхцлөөрх мөнгөн гүйлгээний аливаа төлсөн төлбөр хураамж болон хүлээн авсан төлбөр хураамжийн Дансны үнэг багтаасан хорогдуулсан өнөөгийн үнэ цэнэ нь анхны санхүүгийн өр төлбөрийн үлдэх хугацааны мөнгөн урсгалын хорогдуулсан өнөөгийн үнэ цэнээс хамгийн багадаа 10% зөрүүтэй бол мэдэгдэхүйц өөр нөхцөлтэй гэж үзнэ. Өрийн хэрэглүүрийн нөхцөл хугацаа өөрчлөгдсөнөөр хэрэв өрийн хэрэглүүр үгүй болсон гэж үзвэл төлсөн төлбөр хураамж болон аливаа зардал нь өрийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөгдсөнөөс үүдсэн ашиг алдагдал болно. Харин эсрэг тохиолдолд төлсөн төлбөр хураамж зардал нь өр төлбөрийн дансны үнэд нэмэгдэх бөгөөд өөрчлөгдсөн өр төлбөрийн үлдэх хугацаанд ноогдуулан хорогдуулж тооцно.

Дансны өртгийн эдийн засгийн шинж чанар нь хөрөнгийн гүйлгээний шинжтэй болсоноос бусад тохиолдолд өрийн хэрэглүүр үл хүлээн зөвшөөрнө гэж үзээгүй өрийн өөрчлөлтийг орлого зарлагаар бүртгэсэн олз, гарзтай нь хамт хуримтлагдсан өөрчлөлтийн аргаар тооцооллын өөрчлөлт гэж бүртгэнэ.

**Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.** Гадаад болон дотоод хөрвөх чадварын өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд тусгах зорилгоор тодорхой хэмжээний мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай зүйлсийг багтаадаг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд бэлэн мөнгө болон богино хугацаанд зарцуулж болох гурван сараас бага хугацаатайгаар байршуулсан хугацаатай хадгаламж, хугацаагүй хадгаламж орно, мөн түүнчилэн дотоодын валютаар засгийн газрын байгууллагуудад болон дотоодын банкуудад байршуулсан хугацаагүй хадгаламжууд орно. Тодруулга 7-г харна уу. Зарцуулалтад хязгаарлалт хийсэн эсвэл хөрвөх чадвар муутайгаас шууд хөрвөдөггүй санхүүгийн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд оруулаагүй болно. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь (1) гэрээний мөнгөн урсгалыг цуглуулснаас үүссэн бөгөөд эдгээр нь Үр Ашигт хүүгийн аргыг ашиглан үндсэн төлбөр болон хүүгийн төлөлтийг багтаасан (2) бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар илэрхийлэхээр заагдаагүй тул хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдсэн.

**Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө.** Банк харилцагч банк руу мөнгө шилжүүлснээр бусад банкуудад байршуулсан хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Бусад банкуудад байршуулсан хөрөнгийг дараах тохиолдолд хорогдуулсан өртгөөр нь бүртгэнэ: (1) гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах зорилготой байршуулсан бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй, (2) бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар илэрхийлэгдэхгүй.

**Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт.** Бизнес модел болон мөнгөн урсгалын онцлогт үндэслэн Банк нь өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртгөөрх эсвэл Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоорх гэж ангилна. Хэрэв өрийн үнэт цаас нь гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах зорилготой байршуулсан бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй бол мөн хэрэв нягтлан бодох бүртгэлийн зөрүүг ихээхэн багасгахын тулд сайн дураар бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар бүртгэгдэхгүй бол хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

### 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хэрэв өрийн үнэт цаасыг гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах, зарах зорилготой байршуулсан бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй бол мөн хэрэв ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдэхгүй бол өрийн үнэт цаасыг Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоорх бүртгэнэ. Эдгээр хөрөнгүүдийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргаар тооцоолж ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Хүлээгдэж буй алдагдлын загвараар тооцоолсон болзошгүй алдагдлын хорогдуулгыг тухайн жилийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Дансны өртгийн бусад өөрчлөлтүүдийг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө. Өрийн үнэт цаасыг данснаас хасах үед бусад дэлгэрэнгүй орлогод өмнө нь хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогоос ашиг алдагдалд дахин ангилна.

**Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт.** Хувьцаа гаргагчийн хувьд өмчийн тодорхойлолтод нийцэх санхүүгийн хөрөнгийг Банкнаас гаргасан өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт гэж үзнэ, жишээ нь бэлэн мөнгө төлөх гэрээний үүрэг хариуцлагыг агуулаагүй хэрэгсэл мөн хувьцаа гаргагчийн цэвэр хөрөнгөд ашиг сонирхол нь байгаа гэдгийг нотлох хэрэгсэл. Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалтуудыг Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжинэ, учир нь эдгээр хөрөнгө оруулалтууд нь зөвхөн хөрөнгө оруулалтын үр ашгийг хүртэх гэхээсээ илүү стратегийн зорилготой байна. Бодит үнэ цэнийн олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх ба борлуулах үед ч ашиг, алдагдалд дахин ангилаахгүй. Хэрэв үнэ цэнийн бууралтын гарз үүсвэл үнэ цэнийн бусад өөрчлөлтөөс тусад нь хэмжихгүй. Банк төлбөр хүлээн авах эрхтэй болох үед ногдол ашгийг хөрөнгө оруулалтын өгөөж гэхээс илүү хөрөнгө оруулалтын буцаан төлөлт байдлаар авахаас бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

**Банкуудад олгосон зээл.** Банк нь цааш арилжаалах зорилгогүйгээр харилцагчаас хөрөнгийн зах зээл дээр бүртгэгдээгүй, үүсмэл бус авлагыг тусгайлан заасан буюу тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх мөнгө шилжүүлсэн үед, Банкууд болон бусад зээлдэгч нарт олгосон зээлийг хүлээн зөвшөөрнө.

Сайн дураар бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар илэрхийлээгүй тохиолдолд эдгээр зээлийг бизнес загварт нь үндэслэн хорогдуулсан өртгөөр ангилах бөгөөд мөнгөн урсгалын онцлог гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах зорилготой байршуулсан бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь ЗХҮТ-ээс бүрдэж буй юм. Болзошгүй алдагдлын санг ирээдүйн төсөөллийн мэдээллийг харгалзан ХЗА-ын загвараар тооцоолно. ХЗА-ын загварыг хэмжихэд ашигласан мэдээлэл, таамаглал, тооцооллын аргуудыг Тодруулга 32-с үзнэ үү.

Банкуудад олгосон зээлтэй холбоотой гүйлгээ нь Банкны үндсэн үйл ажиллагаа болох үндэсний мөнгөн тэмдэгт болон эдийн засгийн тогтвортой байдалтай (мөнгөний бодлогын үйл ажиллагаа, инфляцийн тогтворжилт, эдийн засгийн өсөлт, Монголын банкны системийн тогтвортой байдал, гэх мэт) хамааралтай тул СТОУС 13-т заасан үндсэн зах зээлийн тодорхойлолтод нийцэж байгаа. Дээрхтэй холбоотой удирдлагын гаргасан дүгнэлтүүдийг Тодруулга 4-с харна уу.

**Зээлдүүлсэн үнэт цаас ба буцаан худалдан авах хэлцлүүд.** Харилцагч этгээдэд зээлдэгч буцаан төлөхөөр олгогддог худалдах буцаан худалдан авах гэрээг (“репо хэлцэл”) баталгаажсан санхүүгийн гүйлгээ гэж үздэг. “Репо хэлцэл”-ийн дор худалдсан үнэт цааснуудыг санхүүгийн бүртгэлээс хасдаггүй. Харин хөрөнгө хүлээн авагч гэрээний дагуу тус хөрөнгийг борлуулах болон дахин барьцаанд тавих эрхтэй үед тус хөрөнгийг “Буцаан худалдан авах авлага” гэж ангилахаас бусад тохиолдолд үнэт цаасыг санхүүгийн байдлын тайланд дахин ангилдаггүй.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зээлдэгчээс Банкинд эргэн төлөхөөр олгосон буцаан худалдах хэлцлийн (“урвуу репо хэлцэл”) дагуу худалдан авсан үнэт цаасыг гадаадын байгууллагаас авах авлага эсвэл дотоодын банкинд олгосон зээлийн аль тохиромжтойгоор нь бүртгэнэ. Буцаан худалдан авах болон худалдах үнийн зөрүүг хүүгийн орлого гэж хүлээн зөвшөөрөх ба үр ашигт хүүгийн түвшингээр “репо” хэлцлийн хугацааны турш хуримтлуулна. Буцаан худалдан авах болон худалдах гэрээгээр зарсан үнэт цаасны ангилалд үндэслэн Банк нь буцаан худалдан авах гэрээнүүдийг хорогдуулсан өртгөөр ангилна.

**Алт ба үнэт метал.** Олон улсын стандартын дагуу алт, үнэт металыг гадаадын банкинд биет болон биет бус хэлбэрээр хадгалдаг. Байршуулсан алт нь гадаад валютын нөөцийн нэгээхэн хэсгийг илэрхийлнэ. Эдгээр металууд нь трой унцаар хэмжигдэж бүртгэгдэх ба Банкны албан ханшийн дагуу төгрөгөөр илэрхийлэгдэнэ. Алтны арилжааны албан ханш нь Лондонгийн Алтны Захын Холбооноос зарласан үнэт металын ам.долларын ханшийг Банкнаас зарласан төгрөг-ам.долларын харьцах албан ханшаар төгрөгт хөрвүүлснээр илэрхийлэгддэг болно.

Олон улсын жишигт хүрсэн алт болон мөнгөн гулдмайг бодит үнэ цэнээр санхүүгийн байдлын тайланд бүртгэдэг бөгөөд өдөр бүр дахин үнэлдэг. Бодит үнэ цэнийг тогтоохдоо алт ба мөнгөний зах зээлийн үнийг харгалзан үздэг. Ханшийн тэгшитгэлийн бодит бус ашиг, алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрөх ба энэхүү бодит бус ашиг, алдагдлыг жилийн эцэст өөрийн хөрөнгө дэх “Үнэт металын дахин үнэлгээний сан”-д хаадаг (Тодруулга 25).

Банк нь алт, үнэт металаас гадна Монгол дахь үйлдвэрлэгч, компаниудаас цэвэршүүлээгүй алт, мөнгө худалдан авдаг (Тодруулга 13-ыг үзнэ үү). Бусад үнэт метал болох дурсгалын зоос болон цэвэршүүлээгүй алт, мөнгө зэргийг бараа материалаар бүртгэж өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь бүртгэдэг.

**Эрдэнэсийн сан.** Эрдэнэсийн сангийн тухай хууль нь анх 1994 онд батлагдаж байсан бөгөөд тус хуульд “эрдэнэс” гэдэг нь “түүхий эд, хайлш, химийн нэгдэл, бүтээгдэхүүн, түүх, соёлын дурсгалт зүйл зэрэг ямар ч байдалд байгаа үнэт металл, эрдэнийн чулууг хэлнэ” гэж заасан байдаг. Эрдэнэсийн санг үндсэн болон гүйлгээ сан гэж ангилдаг.

Үндсэн санд Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу эрдэнэсийн санд шилжүүлсэн олон улсын жишигт хүргэж цэвэршүүлсэн үнэт металл, засаж өнгөлсөн эрдэнийн чулуу, түүх, соёлын хосгүй үнэт, дурсгалт зүйл, үнэт металлээр хийж нөөцөд авсан зоос орно. Гүйлгээ санд үнэт металл боловсруулах аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн, мөн эрдэм шинжилгээний ажил, эмчилгээний хэрэгцээнд зориулан гүйлгээнд оруулах цэвэршүүлсэн болон цэвэршүүлээгүй үнэт металл, түүгээр хийсэн зоос, засч өнгөлсөн болон байгалийн төрхөөрөө байгаа эрдэнийн чулуу, сувд зэрэг зүйлсээс гадна Банкны “Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан тушаалын дагуу бүртгэгдсэн зүйлс багтана.

Банк нь Эрдэнэсийн санг НББОУС 16 стандартын дагуу дахин үнэлгээний аргачлалыг ашиглан үнэлдэг бөгөөд Олон улсын үнэлгээний стандартыг хэрэгжүүлдэг. Тайлагналын үе бүрийн төгсгөлд бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг хэмжээнд зөрсөн эсэхэд үнэлгээ хийж Эрдэнэсийн санг тогтмол давтамжтайгаар дахин үнэлдэг.

Дансны үнийн нэмэгдэл нь бусад дэлгэрэнгүй орлогын дансны кредит талд бүртгэгддэг бөгөөд өмчийн дахин үнэлгээний санг нэмэгдүүлдэг. Өмнө нь бүртгэгдсэн нэмэгдлийг бууруулж байвал бусад дэлгэрэнгүй орлогыг бууруулж, өмнө нь нэмэгдүүлсэн байсан санг бууруулдаг бол бусад бүх дансны үнийн бууралтыг тайлант жилийн ашиг алдагдалд тайлагнадаг. Хөрөнгийг данснаас хасах үед бодит болсон нэмэгдлийг дахин үнэлгээний сангаас хуримтлагдсан ашиг, алдагдал руу шилжүүлэн бүртгэдэг. Бодит үнэ цэнийн дэлгэрэнгүйг Тодруулга 33-с харна уу.



## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Гадаад валютын хөрвүүлэг.** Банкны үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт нь түүний үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үндсэн орчны үндэсний мөнгөн тэмдэгт байна. Банкны үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн тэмдэгт нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох “Монгол төгрөг” юм.

Мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг холбогдох тайлант үеийн эцэст төгрөгийн албан ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгжид хөрвүүлж бүртгэнэ. Төлбөр тооцоо хийх болон жилийн эцсийн Төгрөгийн албан ханшид мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийг үйл ажиллагааны мөнгөн тэмдэгтэд хөрвүүлэхэд үүсэх ханшийн олз, гарзыг орлогын тайланд (гадаад валютын хөрвүүлгийн ашиг, алдагдлаар) хүлээн зөвшөөрдөг. Түүхэн өртгөөр бүртгэдэг мөнгөн бус зүйлсийг тайлант жилийн хаалтын ханшаар хөрвүүлж бүртгэхгүй. Харин өмчийн хөрөнгө оруулалт зэрэг бодит үнэ цэнэ нь гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг бодит өртгийг тодорхойлсон өдрийн ханшаар хөрвүүлж бүртгэнэ.

2021 оны 12 дугаар сарын 31 болон 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх гадаад валют бүхий дүнг хөрвүүлэхэд ашиглагдсан ханш:

|                    | 2021 оны 12 дугаар сарын 31 (Төгрөг) | 2020 оны 12 дугаар сарын 31 (Төгрөг) |
|--------------------|--------------------------------------|--------------------------------------|
| Ам.доллар          | 2,848.80                             | 2,849.51                             |
| Зээлжих тусгай эрх | 3,987.16                             | 4,104.06                             |
| Евро               | 3,222.99                             | 3,495.78                             |
| Юань               | 447.15                               | 436.13                               |
| Иен                | 24.74                                | 27.58                                |

**Санхүүгийн үүсмэл хэрэгсэл.** Санхүүгийн үүсмэл хэрэгсэлд дотоодын банкуудтай хийсэн гадаад хүүгийн своп хэлцлүүд багтана. Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнэ нь эерэг бол хөрөнгөөр, сөрөг бол өр төлбөрөөр тусгана. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн жилийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Банк нь хейджийн бүртгэлийг хэрэглэдэггүй.

**Бусад хөрөнгө.** Бусад хөрөнгө нь авлага болон урьдчилж төлсөн зардлаас бүрдэнэ. Өрийн бичгийн авлагаас бусад авлага нь аккрузал суурийн дагуу хорогдуулсан өртгөөр бүртгэгдэнэ. Авлагыг гэрээний дагуу эрх үүссэн үед хүлээн зөвшөөрнө. Урьдчилж төлсөн зардлыг төлбөр хийгдсэн үед хүлээн зөвшөөрч тухайн ажил үйлчилгээ нь хийгдсэний дараа дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ. Авлагын Эрсдэлийн алдагдлын санг ирээдүйн төсөөлсөн нөхцөл байдлыг харсан ХЗА-ын загвараар тодорхойлно. ХЗА-ын загварыг хэмжихэд ашигласан мэдээлэл, таамаглал, тооцооллын аргуудыг Тодруулга 32-с үзнэ үү.

Өрийн бичгийн авлага нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар бүртгэгдэнэ. Бодит үнэ цэнийн дараа үеийн хэмжилтийг хийхдээ тайлант үе бүрийн зах зээлийн хүүгээр мөнгөн урсгалын хямдруулалтын аргыг ашиглана. Өрийн бичгийн хувьд зах зээлийн хүү нь Монголбанкны бодлогын хүү дээр нэмэх нь зээлийн эрсдэл байна.

Бусад өрийн бичгийн авлага нь ХӨ-өөр бүртгэж, үнэ цэнийн бууралтын үнэлгээг хийх бөгөөд үүнийг ирээдүйн төсөөлсөн ХЗА загварт үндэслэн тодорхойлно. Тодруулга 32-с үзнэ үү.

**Барилга болон бусад үндсэн хөрөнгө.** Барилгыг дор дурьдсанчлан дахин үнэлэгдсэн өртгөөс хуримтлагдсан элэгдлийг, мөн шаардлагатай бол үнэ цэнийн бууралтын зардлыг хассан дүнгээр тусгадаг. Банк эзэмшиж буй барилгыг анхны өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Барилга байгууламжийн дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү байгаа эсэхийг тайлант хугацааны эцэст дахин үнэлж баталгаажуулдаг.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дансны үнэ дахин үнэлгээгээр нэмэгдсэн тохиолдолд нэмэгдсэн дүнгээр бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгийн холбогдох дахин үнэлгээний санг нэмэгдүүлнэ. Тухайн хөрөнгийн өмнө үүссэн нэмэгдлийг хааж буй дахин үнэлгээний хорогдлыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөнд өмнө хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нөөцийн сангаас бууруулна; харин бусад бүх хорогдлыг тухайн жилийн орлого зарлагад хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлгээгээр нэмэгдсэн дүн бодитоор хэрэгжих үед барилга байгууламжийн дахин үнэлгээний нөөцийг хуримтлагдсан ашиг, алдагдлаар шууд хаана. 2020 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр барилга байгууламжийн дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү байхгүй гэж удирдлага үзэж байна.

Банк эзэмшиж буй тоног төхөөрөмжийг бүргэхдээ өртгөөс үнэ цэнийн бууралт болон элэгдлийг хассан дүнгээр бүртгэнэ. Урсгал засварын зардлыг гарсан тухай бүрт нь бүртгэнэ. Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн аль нэг бүрэлдэхүүн хэсгийг сольсон томоохон зардлыг капиталжуулж, сольсон хэсгийг ашиглалтаас хасна.

Үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг удирдлага тайлант хугацааны эцэст үнэлдэг. Ийм шинж тэмдэг илэрсэн тохиолдолд удирдлага хөрөнгийн бодит үнэ цэнээс тухайн хөрөнгийг борлуулах зардлыг хассан дүн эсвэл түүний ашиглалтын үнэ цэнийн дүнгийн аль ихээр нь нөхөх өртгийг тооцож, дансны үнийг нөхөх өртөг хүртэл бууруулж гарзыг тухайн жилийн орлого, зарлагад бүртгэдэг (хэрэв тухайн өөрийн хөрөнгө дэх хөрөнгийн дахин үнэлгээний сангийн дүнгээс давсан тохиолдолд). Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ, бодит үнэ цэнэ эсвэл борлуулах өртгийн тооцоололд өөрчлөлт орсон бол өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах бичилт хийдэг.

Олз, гарзыг тодорхойлохдоо борлуулалтаас олсон орлогыг бүртгэлийн дүнтэй харьцуулдаг ба олз, гарзыг тухайн жилийн орлого, зарлагад (бусад үйл ажиллагааны орлого, зардлын хэсэгт) бүртгэнэ.

**Элэгдэл.** Дуусаагүй барилгыг элэгдүүлэхгүй. Харин, үндсэн хөрөнгийн бусад зүйлсийн хувьд тэдгээрийн өртгийг доор тооцоолсон ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар үлдэх өртөг хүртэл нь элэгдүүлнэ:

|                                                          | Ашиглалтын хугацаа, жилээр |
|----------------------------------------------------------|----------------------------|
| Барилга                                                  | 6 – 60 жил                 |
| Оффис, конторын тавилга болон компьютер, тоног төхөөрөмж | 3 – 20 жил                 |

Банк ашиглаглалтын хугацаа нь дуусч байгаа хөрөнгийн үлдэх өртгийг тооцохдоо тухайн үед борлуулалтаас олох боломжтой үнээс борлуулалтын зардлыг хассан дүнг авдаг. Хөрөнгийн үлдэгдэл өртөг, ашиглалтын хугацааг тайлант хугацааны эцэст дахин үнэлж, шаардлагатай гэж үзвэл тохируулга хийнэ.

**Биет бус хөрөнгө.** Банкны биет бус хөрөнгө нь тодорхой ашиглалтын хугацаатай ба капиталжуулсан компьютерын програм хангамжууд багтсан байна. Худалдаж авсан компьютерын програм хангамжуудыг ашиглахад бэлэн болгоход гарсан зардлаар бүртгэлд тусгасан. Биет бус хөрөнгийн дүнг 4 жилийн хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулна.



### 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа эргэлтийн бус хөрөнгө.** Эргэлтийн бус хөрөнгө болон зарж борлуулах хөрөнгө (эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө багтаж болно) санхүүгийн тайлагналын зорилгоор санхүүгийн байдлын тайланд ирэх 12 сард борлуулж дансны үнийн ихэнх хэсгийг нөхөн авах боломжтой гэж үзэж байгаа бол Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа эргэлтийн бус ангилалд толилуулдаг. Дараах бүх шаардлагуудыг хангасан тохиолдолд хөрөнгийг дахин ангилна. Үүнд: (а) хөрөнгө нь одоогийн байгаа нөхцөл байдал нь борлуулахад бэлэн; (б) Банкны удирдлага нь худалдан авагч олох идэвхтэй хөтөлбөртэй; (в) боломжийн үнээр борлуулах тухай идэвхтэй сурталчилдаг, (г) ирэх жилийн дотор борлуулна гэж төлөвлөж байгаа, мөн (д) борлуулах төлөвлөгөөнд өөрчлөлт орох эсхүл түдгэлзүүлэх магадлал тун бага байна. Эдгээр хөрөнгүүдийг тайлант хугацааны эцсийн ангиллыг тусгахын тулд санхүүгийн байдлын харьцуулсан тайланд дахин ангилдаггүй. Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгийг элэгдүүлэхгүй. Дахин ангилсан эргэлтийн бус санхүүгийн хэрэглүүрүүдийг дансны үнэ ба бодит үнэ цэнийг борлуулах зардлын аль багаар бүртгэх шаардлагагүй.

**Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө.** Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө нь Монголбанкнаас 1993 оны 9 дүгээр сард гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгөн тэмдэгт бөгөөд тэдгээрийг нэрлэсэн үнээр нь өр төлбөрөөр бүртгэдэг. Банк нь бусад банкууд болон харилцагчид бэлэн мөнгө олгох үед гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө ба зоосыг нэрлэсэн үнийн дагуу өр төлбөрөөр бүртгэдэг. Банк бэлтгэл сан болон гүйлгээ касет буй төгрөгийг гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөнд оруулж тооцдоггүй.

**Төв Банкны үнэт цаас.** Банкны гаргасан үнэт цаас нь бодит үнэ цэнээрээ анх бүртгэгдэх ба түүнээс хойш хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо эдгээрийг гаргах эсвэл үүсэх үеийн хөнгөлөлт эсвэл урамшуулал, үр ашигт хүүг бүрдүүлж буй зардлуудыг авч үзнэ.

**Засгийн газрын хөрөнгө.** Засгийн газар болон бусад төрийн байгууллагуудын данс нь Засгийн газар болон бусад харилцагчдад төлөх үүсмэл бус өр төлбөр ба үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр бүртгэгдэнэ. Засгийн газрын хөрөнгийн дийлэнх нь Олон Улсын Валютын Сан (ОУВС), Герман улсын Засгийн газар (КФВ), Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны санхүүжилттэй хөтөлбөрийн хүрээнд Сангийн яамнаас авсан урт хугацаат зээлтэй холбоотой. (Тодруулга 21).

**Гадаад өр төлбөр.** Гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өр төлбөр нь анх бодит үнэ цэнээр бүртгэгдэх ба түүнээс хойш үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр бүртгэгдэнэ. Гадаад төлбөрийн дийлэнх хэсгийг Хятадын Ардын Банк (Хятадын Төв банк), Эм Ю Эф Жи Банк, ОУТТБанк, Каргилл ОУСБ -аас авсан зээл хамаарна. (Тодруулга 23).

**Дотоодын банкуудын хөрөнгө.** Банкинд харилцагч банкуудаас мөнгө шилжин орж ирэхэд дотоодын банкуудын хадгаламжийг хүлээн зөвшөөрдөг. Үүсмэл бус өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

**Болзошгүй алдагдлын нөөцийн сан.** Энэ нь өр төлбөрийн цаг хугацаа болон дүн нь тодорхойгүй санхүүгийн бус өр төлбөр юм. Банкинд өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулийн дагуу, эсвэл хууль эрх зүйн дагуу үүрэг хариуцлага хүлээх болсон, мөн уг үүрэг хариуцлагыг шийдвэрлэх явцад эдийн засгийн өгөөж агуулсан зарлагын урсгал гарах өндөр магадлалтай болон энэхүү үүргийг хүлээх нь найдвартай тооцоологдож, мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжтой болсон тохиолдолд нөөцийн санг тооцож бүртгэнэ.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Олон Улсын Валютын Сантай хамааралтай үйл ажиллагаа.** Монгол Улс болон Олон Улсын Валютын Сангийн (ОУВС) харилцаан дах Банкны үндсэн үүргээс шалтгаалж Банк нь ОУВС-тай хамтран ажилладаг. Банкны санхүүгийн тайланд СТОУС-ын дагуу хөрөнгө болон өр төлбөрийн тодорхойлолтын нөхцөлийг хангасан ОУВС-ийн хөтөлбөртэй холбоотой тооцоог хүлээн зөвшөөрсөн байдаг. Мөн Банк нь СТОУС-ын хүрээнд хөрөнгө болон өр төлбөрийн тодорхойлолтод нийцэхгүй ОУВС-д хамаарал бүхий тооцоог өөрийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй.

ОУВС-тай холбоотой хөрөнгө ба өр төлбөрүүд. Эдгээр санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөгдсөн ОУВС-тай холбоотой хөрөнгөнд Зээлжих Тусгай Эрх (ЗТЭ)-ээр илэрхийлэгдсэн хөрөнгө багтана (Тодруулга 8). ОУВС-д өгөх өр төлбөрт ЗТЭ-ийн хуваарилалт бүхий өр төлбөрүүд багтана (Тодруулга 23).

ЗТЭ-ээр бүртгэгдсэн хөрөнгө, өр төлбөрүүдийг тайлант өдрийн ЗТЭ-ийн төгрөгтэй харьцах албан ханшаар хөрвүүлсэн. Төгрөг, ЗТЭ-ийн албан ханшийг ОУВС-гийн тогтоосон ЗТЭ, ам.долларын ханшийн мэдээлэл болон тайлант хугацааны ам.доллар болон төгрөгийн Монголбанкны албан ханшид үндэслэн тооцсон.

**Монгол Улсын Засгийн газрын ОУВС-тай холбоотой хөрөнгүүд.** Банк нь холбогдох ОУВС-гийн сангуудыг худалдан авалттай холбоотой гэрээт эрх, үүрэггүй учир ОУВС-тай холбоотой тодорхой хөрөнгүүд СТОУС-ын дагуух хөрөнгө ба өр төлбөрийн тодорхойлолтод нийцдэггүй. Эдгээр хөрөнгөнд ОУВС-д хувь нийлүүлсэн хөрөнгө болон ОУВС-аас Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрийн хүрээнд авсан зээл багтана. Банк нь Монгол Улсын Засгийн газарт ОУВС-тай харилцахад нь санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг. Сангийн яам нь Монгол Улсын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг. Иймд, Монгол Улсын ОУВС-аас авах авлага болон (ОУВС-д нийлүүлсэн хувь хөрөнгө зэрэг) ОУВС-д төлөх өр төлбөрүүд нь Сангийн яамны хөрөнгө, өр төлбөр болох учир Банкны санхүүгийн тайланд тусгагдаагүй.

**ОУВС-д нийлүүлсэн хувь хөрөнгө.** Энэхүү хувь хөрөнгөнд тулгуурлан Монгол Улс нь ОУВС-гийн гишүүн орны хувьд зээлж авч болох тусгай төрлийн хөрөнгийн хуваарилалтын дүн болно. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь улс орон тус бүрийн хувьд өөр байдаг бөгөөд эдийн засгийн хэмжээ, цар хүрээнд тулгуурлан ОУВС-гийн Удирдах Зөвлөлөөс тогтоодог. Гишүүн байгууллагын саналын эрх, тусгай сангаас хүртэх санхүүгийн нөөцийн хязгаар болон зээлжих тусгай эрх (оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн)-д үндэслэн квот ногдох оролцогчийн хувь хүртэх хувь хязгаарыг тодорхойлдог. Монгол Улсын хувь нийлүүлсэн хөрөнгийн дийлэнх хэсэг нь МУ-ын Сангийн яамны зүгээс баталгаажуулсан үнэт цааснаас бүрдэх ба энэхүү үнэт цаас нь хүүгүй. Мөн үлдэх хэсэг нь ОУВС-д өгөх төлбөрүүдээс бүрдэх ба данс №1, №2 –ын талаар тодруулсан болно. Зээлжих тусгай эрхийн хуваарилалтын хувьд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 72.3 сая ЗТЭ (2020 онд 72.3 сая ЗТЭ) байна. Сангийн яам нь өрийн бичиг гаргаж энэхүү квотын төлбөрийг хийдэг тул Сангийн яамны актив хөрөнгөнд бүртгэгдэнэ.

**ОУВС-д гаргасан үнэт цаас.** Эдгээр үнэт цаас нь ОУВС-гийн зүгээс Монгол Улсын үндэсний валютад хуваарилагдах хувийг төлөөлөх ба дээр дурдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн тооцоонд үндэслэн баталгаажуулсан өрийн бичиг юм. Сангийн яам нь ОУВС-тай зээлийн эрхийн ашиглалтын талаар гэрээ хийсэн байгуулсан тохиолдолд өрийн бичгээр баталгаажуулдаг.

### 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

**ОУВС-ийн данс №1 болон №2.** Сангийн худалдан авалт, дахин худалдан авалт болон хувь нийлүүлсэн хөрөнгийн ажил гүйлгээ гүйцэтгэхэд данс №1-г ашигладаг. Монгол төгрөгөөр гүйцэтгэх ажил гүйлгээнд данс №2-г ашигладаг. Данс №1 болон №2 нь 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 752 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна (2020: 700.6 сая төгрөг).

**Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр (ӨСХ).** 2017 оны 5 дугаар сарын 24-нд ОУВС-гийн Удирдах Зөвлөл Монгол Улсын эдийн засгийн реформыг дэмжих зорилгоор Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр (ӨСХ)-ийн хүрээнд гурван жилийн хугацаатай 314.5 сая ЗТЭ-ийн дүн бүхий өргөтгөсөн санхүүжилтийг баталсан. ӨСХ-ийн хүрээнд ОУВС-гаас Монгол Улсад олгосон жилийн 1.53-аас 1.59 хувийн хүүтэй зээл юм. Санхүүжилтийг 2017 оны 5 дугаар сарын 25-нд Монголбанк болон Сангийн яамны хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичигт үндэслэн Монголбанкинд шилжүүлсэн.

Зээл болон түүний эргэн төлөлт нь ЗТЭ-ээр илэрхийлэгдсэн бөгөөд Монголбанк нь Сангийн яамны өмнөөс ОУВС-д хуваарийн дагуу эргэн төлөлтийг төлөлтийг 2026 онд багтаан хийнэ. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ӨСХ-ийн хүрээнд Сангийн яаманд өгөх өр төлбөрийн хэмжээ 3 жилийн хугацаатай, 155.2 сая ЗТЭ буюу 618,751 сая төгрөг (2020: 157.5 сая ЗТЭ буюу 645,616 сая төгрөг) байна. (Тодруулга 21).

**Дүрмийн сан.** Дүрмийн сан нь Өөрийн хөрөнгөнд багтдаг (Тодруулга 25).

**Ерөнхий нөөцийн сан.** Төв банк /Монголбанк/-ны тухай хуулиар жилийн цэвэр орлогын хамгийн багадаа 40 хувийг ерөнхий нөөцийн санд хуваарилах ба үлдэх хэсгийг (ө.х. хамгийн ихдээ 60 хүртэлх хувийг) Улсын Төсвийн данс руу шилжүүлж болно. Ерөнхий нөөцийн сан нь зөвхөн тодорхой хугацааны туршид хуримтлуулсан ба Банк өөрөө захиран зарцуулах бүрэн эрхтэй цэвэр ашгийг агуулдаг. Энэ санд Улсын төсөвт хуваарилсан болон цаашид хуваарилах дүнг оруулдаггүй. Учир нь эдгээр нь Засгийн газарт тухайн тайлант жилдээ шилждэг. Тайлант хугацааны бодит бус ашиг, алдагдал гарсан үйл ажиллагааны алдагдлыг хаах хангалттай нөөц байхгүй тохиолдолд ерөнхий нөөцийн сангаас нөхдөг болно. 2021 болон 2020 онд Банк нь хуримтлагдсан алдагдалтай ажилласан тул шилжүүлэг хийгээгүй.

**Бусад нөөц.** Бусад нөөцөд гадаад валют, алт, үнэт метал, барилгын болон эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний сан болон борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний санг оруулдаг (Тодруулга 25). Банк нь Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн дагуу гадаад валют, алт үнэт металын ханшийн тэгшитгэлийн бодит бус ашиг, алдагдлыг гадаад валют болон мөнгөжсөн алт, үнэт металын дахин үнэлгээний санд жил бүрийн эцэст шилжүүлдэг ба харин бодит бус алдагдлыг холбогдох сангуудаар хаадаг.

**Зээлтэй холбоотой үүрэг хариуцлага.** Банкинд зээлтэй холбоотой үүрэг хариуцлага байдаг ба үүнд аккредитив болон Хятадын Ардын банк (БНХАУ-ын Төв Банк, цаашид “ХАБ” гэх) –тай байгуулсан хэлэлцээр орно. Хэлэлцээр нь ХАБ-аас Банкинд юаниар олгосон санхүүжилт болон Банкнаас ХАБ-д төгрөгөөр олгосон санхүүжилт юм (Тодруулга 30).

Тайлант жилийн эцэст төлбөрийн үүрэг хариуцлага нь 1) анхны хүлээн зөвшөөрөлтийн хорогдуулалтыг тооцоогүй төлбөрийн тооцооны үлдэгдэл үүн дээр нэмээд 2) хүлээгдэж буй алдагдлын загвараар тодохойлсон эрсдэлийн сангийн дүнгээр хэмжигддэг. Хэрэв дуусгавар болгоогүй төлбөрийн үүрэг хариуцлагын дүнд хураамж авдаг бол энэ нь тухайн үүргийн хүчинтэй хугацаанд харгалзуулан орлого гэж хүлээн зөвшөөрдөг.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт.** Хүүгийн орлого, зардлыг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар илэрхийлдэгээс бусад өрийн хэрэгсэл бүрийн хувьд аккрузл суурь дээр үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ арга нь талуудын хооронд гэрээний дагуу төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого эсвэл зардал болгон бүртгэдэг.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар илэрхийлдэг өрийн хэрэгслийн (өрийн бичиг) хүүгийн орлогыг нэрлэсэн хүүгээр тооцоолж Тайлант үеийн ашиг алдагдлын тайланд “Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөх санхүүгийн хөрөнгийн ашиг, алдагдалын зөрүү” хэсэгт харуулна.

Худалдан авах эсхүл үүсэх үедээ хүлээгдэж буй зээлийн алдагдалтай байсан санхүүгийн хөрөнгүүдийн хувьд үр ашигт хүү нь ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцох хямдруулалтын хувь болох бөгөөд (ирээдүйн хүлээгдэж буй зээлийн алдагдлын урсгалыг мөн адил) уг хямдруулсан дүн нь анх хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнэ болно. Ингэснээр үр ашигт хүүд зээлийн алдагдлын тохируулга хийгдэнэ.

Хүүгийн орлогыг санхүүгийн хөрөнгийн цэвэр дансны үнээс үр ашигт хүүгээр тооцон гаргах бөгөөд харин (i) чанар муутай зээлүүдийн хувьд (Шатлал 3) хүүгийн орлогыг хорогдуулсан өртгөөс (ХЗА-г оруулаад) үр ашигт хүүгийн хувиар тооцдог бөгөөд (ii) худалдан авах эсхүл үүсэх үедээ чанаргүйдсэн байсан санхүүгийн хөрөнгийн хувьд анхны зээлийн алдагдлаар тохируулсан үр ашигт хүүг хорогдуулсан өртгөөр үржүүлэн тооцно.

Шатлал 3-т ангилсан байсан санхүүгийн хөрөнгийн зээлийн алдагдлын эрсдэл нь багагүй буурч, чанаргүй зээл гэж ангилахааргүй болсон тохиолдолд (мөн энэ үйл явдал нь тус ангилалд орсны дараа болсон тохиолдолд) хөрөнгийг Шатлал 3-с гарган дахин ангилах бөгөөд хүүгийн орлогыг үр ашигт хүүг цэвэр дансны үнэтэй үржүүлэн тооцно. Нэмэлт хүүгийн орлого нь өмнө нь ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгддөггүй байсан бол хөрөнгийг эдгэрснээс хойш зээлийн алдагдлын буцаалт гэж бүртгэгдэнэ.

Бусад бүх шимтгэл, хураамж болон бусад орлого, зардлын зүйлүүдийг аккрузл суурь дээр үндэслэн тухайн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй уялдуулан хүлээн зөвшөөрөх бөгөөд гүйцэтгэлийг нийт тохирсон үйлчилгээнээс бодитоор үзүүлсэн байгаа үйлчилгээний хувь хэмжээгээр тооцдог.

**Бэлэн мөнгө хэвлэхтэй холбогдож гарсан зардлууд.** Банк нь Монгол Улсын цаасан мөнгөн дэвсгэрт болон зоосон мөнгийг гүйлгээнд гаргадаг. Цаасан мөнгөн дэвсгэрт болон зоосыг хэвлүүлэхтэй холбоотой урьдчилж гарсан зардал нь “Бусад хөрөнгө” хэсэгт бүртгэгдэх ба тэдгээрийг үйлдвэрлэлээс Банкны бэлтгэл фондод шилжих үед зардал гэж хүлээн зөвшөөрдөг.

**Ажилчдын зардал болон холбогдох шимтгэлүүд.** Цалин хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг (элжийн амралт, өвчтэй байх үеийн нөхөн олговор, шагнал урамшуулал болон мөнгөн бус тэтгэмж гэх мэт) Банк ажилтнуудын холбогдох ажил үйлчилгээ үзүүлсэн жилд харгалзуулан зардал гэж хүлээн зөвшөөрдөг. Элжийн амралтын мөнгө, нөхөн олговортой бусад богино хугацаат чөлөө авалтыг, ажилтнуудад ирээдүйд нөхөн олговортой чөлөө авах эрхийг үүсгэх үйлчилгээг үзүүлсэн үед, харин өвчний улмаас чөлөө авах гэх мэт нөхөн олговортой богино хугацаат чөлөө авалтыг чөлөө авсан тухайн үед хүлээн зөвшөөрдөг болно.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Ажилтнуудын тэтгэмж.** Банк нь өөрийн дотоод журамд үндэслэн ажилтнуудын ажлын нөхцөл байдлыг сайжруулах, нийгмийн халамжийн асуудлыг шийдэх үүднээс тодорхой хөрөнгийг нийгмийн хөгжлийн санд хуваарилж, хуримтлуулдаг. Эдгээр дансдыг тэтгэмж, нөхөн олговор, ажилтнуудын гүйцэтгэлд суурилсан цалин урамшууллыг олгох, ажилтнуудын нийгмийн халамжийн хүрээнд бусад хэрэгцээг хангах зэрэгт ашигладаг.

Удирдлага нь 2021 оны 12 дугаар сарын 31 болон 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Нийгмийн хөгжлийн сангийн дүн нь эдгээр богино болон урт хугацаат төлбөрүүдийг төлөх бүрэн боломжтой, мөн хүлээн зөвшөөрсөн тусламж, тэтгэмжийн өр төлбөр нь тухайн тайлант өдрөөр тусламж тэтгэмжийн үүргүүдийн өнөөгийн үнэ цэнээс хүлээн зөвшөөрөгдөөгүй байгаа үнэлгээний тооцоо (актуар)-ны олз гарз болон гарсан үйлчилгээний зардлыг хассан дүнгээс материаллаг хэмжээгээр зөрөхгүй гэж үзэж байна.

**Орлогын албан татвар.** Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу Банк нь орлогын албан татвараас чөлөөлөгдсөн байдаг.

**Цэвэр дүнгээр бүртгэх.** Нягтлан бодох бүртгэлд санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг цэвэр дүнгээр бүртгэх хууль, эрх зүйн үндэслэл байгаа үед ба цэвэр дүнгээр төлбөр тооцоог барагдуулах төлөвтэй байгаа үед эсхүл санхүүгийн өр төлбөр болон хөрөнгийг нэгэн зэрэг барагдуулах төлөвтэй үед цэвэр дүнгээр бүртгэж болно. Дээр дурдсан эрх нь (а) ирээдүйд бий болох үйл явдалд тулгуурлаагүй байх, мөн (б) дараах бүх тохиолдолд хэрэгжих боломжтой байна: (i) үйл ажиллагаа явуулах энгийн явцад, (ii) үүргээ биелүүлээгүй тохиолдолд, болон (iii) төлбөрийн чадваргүй болсон эсхүл дампуурсан тохиолдолд.

**Санхүүгийн байдлын тайланг хөрвөх чадварын байдлаар тодруулах нь.** Банк нь үйл ажиллагааны тодорхой мөчлөггүй бөгөөд санхүүгийн байдлын тайланд эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөрийг тусад нь тайлагнадаггүй болно. Харин үүний оронд хөрөнгө, өр төлбөрийг тэдгээрийн хөрвөх чадварын дарааллаар тодруулдаг. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүдийг тус бүрийн хувьд тайлант хугацааны эцсээс 12 сараас дотогш эсвэл дээш хугацаанд төлөгдөх эсвэл хүлээн авах байдлаар нь дараах хүснэгтэд нэгтгэж тодруулав.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

|                                         | 2021 оны 12 дугаар сарын 31    |                                     |                   | 2020 оны 12 дугаар сарын 31    |                                     |                   |
|-----------------------------------------|--------------------------------|-------------------------------------|-------------------|--------------------------------|-------------------------------------|-------------------|
|                                         | Төлөгдөх болон хүлээн авах дүн | Тайлант хугацаа-наас 12 сарын дотор | Нийт              | Төлөгдөх болон хүлээн авах дүн | Тайлант хугацаа-наас 12 сарын дотор | Нийт              |
| <i>Сая төгрөгөөр</i>                    |                                |                                     |                   |                                |                                     |                   |
| Бэлэн мөнгө                             | 177,591                        | -                                   | 177,591           | 233,373                        | -                                   | 233,373           |
| Гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө  | 4,473,789                      | -                                   | 4,473,789         | 4,517,392                      | -                                   | 4,517,392         |
| Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт      | 1,810,041                      | 4,583,781                           | 6,393,822         | 2,155,507                      | 3,119,622                           | 5,275,129         |
| Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт     | -                              | 6,533                               | 6,533             | -                              | 6,595                               | 6,595             |
| Урвуу буцаан худалдан авах хэлцэл       | 3,467,428                      | 1,054,792                           | 4,522,220         | 4,584,830                      | 231,238                             | 4,816,068         |
| Алт ба үнэт метал                       | 1,594,676                      | 90,957                              | 1,685,633         | 1,405,887                      | 379,970                             | 1,785,857         |
| Эрдэнэсийн сан                          | 1,115,085                      | -                                   | 1,115,085         | 1,071,665                      | -                                   | 1,071,665         |
| Санхүүгийн үүсмэл хэрэгсэл              | 59,298                         | 17,805                              | 77,103            | 90,559                         | 65,860                              | 156,419           |
| Засгийн газрын үнэт цаас                | 672                            | 231,106                             | 231,778           | -                              | 227,407                             | 227,407           |
| Дотоодын банкуудад олгосон зээл         | 903,089                        | 584,219                             | 1,487,308         | 52,787                         | 408,527                             | 461,314           |
| Бусад хөрөнгө                           | 177,959                        | 141,762                             | 319,721           | 191,547                        | 232,126                             | 423,673           |
| Үндсэн болон биет бус хөрөнгө           | -                              | 116,024                             | 116,024           | -                              | 115,201                             | 115,201           |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө | 6,097                          | -                                   | 6,097             | 6,280                          | -                                   | 6,280             |
| <b>Нийт хөрөнгө</b>                     | <b>13,785,725</b>              | <b>6,826,979</b>                    | <b>20,612,704</b> | <b>14,309,827</b>              | <b>4,786,546</b>                    | <b>19,096,373</b> |

|                                | 2021 оны 12 дугаар сарын 31    |                                     |                     | 2020 оны 12 дугаар сарын 31    |                                     |                   |
|--------------------------------|--------------------------------|-------------------------------------|---------------------|--------------------------------|-------------------------------------|-------------------|
|                                | Төлөгдөх болон хүлээн авах дүн | Тайлант хугацаа-наас 12 сарын дотор | Нийт                | Төлөгдөх болон хүлээн авах дүн | Тайлант хугацаа-наас 12 сарын дотор | Нийт              |
| <i>Сая төгрөгөөр</i>           |                                |                                     |                     |                                |                                     |                   |
| Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө | (1,105,589)                    | -                                   | (1,105,589)         | 991,470                        | -                                   | 991,470           |
| Төв банкны үнэт цаас           | (8,622,184)                    | -                                   | (8,622,184)         | 7,952,438                      | -                                   | 7,952,438         |
| Засгийн газрын хөрөнгө         | (1,114,102)                    | (620,014)                           | (1,734,116)         | 1,454,101                      | 677,924                             | 2,132,025         |
| Дотоодын банкуудын хөрөнгө     | (4,471,877)                    | -                                   | (4,471,877)         | 3,871,397                      | -                                   | 3,871,397         |
| Санхүүгийн үүсмэл хэрэгсэл     | (334,171)                      | (135,587)                           | (469,758)           | 135,001                        | 168,500                             | 303,501           |
| Гадаад өр төлбөр               | (6,629,125)                    | (284,880)                           | (6,914,005)         | 5,789,508                      | -                                   | 5,789,508         |
| Бусад өр төлбөр                | (667,231)                      | -                                   | (667,231)           | 365,317                        | -                                   | 365,317           |
| <b>Нийт өр төлбөр</b>          | <b>(22,944,279)</b>            | <b>(1,040,481)</b>                  | <b>(23,984,760)</b> | <b>20,559,232</b>              | <b>846,424</b>                      | <b>21,405,656</b> |



#### 4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Банк нь санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүн нь дараагийн санхүүгийн жилд хөрөнгө, өр төлбөрийн хувьд хэрхэн нөлөө үзүүлэх талаар ач холбогдол бүхий таамаглал, үнэлэлтүүдийг хийдэг. Удирдлага нь өөрсдийн туршлага болон ирээдүйн үйл явдлын талаарх нөхцөл байдалд зохистой гэж үзсэн үнэлэлт, таамаглал зэрэг бусад хүчин зүйлүүдэд суурилан тооцооллыг тогтмол хянадаг болно. Мөн удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцад ач холбогдол бүхий тооцооллуудаас гадна тодорхой үнэлэлтүүдийг хийдэг. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үнэлэлтүүд болон дараагийн санхүүгийн жилд хөрөнгө болон өр төлбөрийн тайлагнасан дүнгүүдэд томоохон (мэдэгдэхүйц) хэмжээний тохируулга хийх шаардлага үүсэж болох ба үүнд дараах зүйлс хамаарна.

Тасралтгүй байх зарчим. Удирдлага нь эдгээр санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн. 2021 оны 12 дугаар сарын 31 болон 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны өөрийн хөрөнгө сөрөг, өр төлбөртэй гарсан ба Банк нь Үндэсний мөнгөн тэмдэгтийг гаргагч этгээд тул төгрөгийн хувьд хөрвөх чадварын эрсдэлд орохгүй гэж үзсэн бөгөөд урьдчилан харах болон ирээдүйд тасралтгүй байх зарчмын дагуу Банк үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхгүй байх эрсдэл тохиолдохгүй гэдэгт удирдлага итгэлтэй байна. Төв банкны тухай хуулийн 38 дугаар зүйлд зааснаар, төв банкны пассив нь актив хөрөнгөөс хэтэрсэн тохиолдолд Засгийн газар үнэт цаас гаргах замаар уг зөрүүг нөхөх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ. Иймд, Засгийн газар нь төв банкны алдагдлыг нөхөх үүрэг хүлээгээгүй ч хэрвээ Засгийн газрын үнэт цаас гаргах замаар Банкны алдагдлыг нөхөх нь Банкыг үйл ажиллагаагаа явуулахад дэм болж байвал боломжтой юм.

*Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилт.* ХЗА-ын хэмжилт нь арга зүй, загвар, мэдээллийн өгөгдлүүдийг тодорхойлох зэргийг багтаасан чухал тооцоолол байна. ХЗА-ын хэмжилтын арга зүйн дэлгэрэнгүйг Тодруулга 32-оос харна уу.

Зээлийн эрсдэлийн санд дараах бүрэлдэхүүнүүд чухал нөлөөтэй. Үүнд:

- дефолтын тодорхойлолт
- зээлийн эрсдэлийн томоохон өсөлт байгаа эсэхийг дүгнэх шалгуур үзүүлэлтүүд;
- дотооддоо ашиглах зээлийн эрсдэлийн үнэлгээ тогтолцоог боловсруулан ашглаж зээлийн эрсдэлийн түвшин бүр магадлалыг тодорхойлно;
- дефолт болох магадлал;
- дефолт болсон тохиолдолд хүлээх алдагдлын хэмжээ;
- макро эдийн засгийн хэтийн төлөвийг сонгох, тэдгээрийн магадлалыг жинлэх.

Банк нь хүлээгдэж буй зээлийн алдагдлын тооцоолол болон бодит зээлийн алдагдлын хоорондын зөрүүг багасгах модел болон түүнд ашиглах өгөгдлүүдийг байнга хянаж үздэг. Дэлгэрэнгүйг Тодруулга 32-с харна уу.

Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт. Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг тодорхойлохын тулд Банк тайлант үеийн эцэст санхүүгийг хэрэглүүрийн бүх хугацаан дахь дефолт болох эрсдэл болон анх хүлээн зөвшөөрөх үеийн дефолт болох эрсдэлийг харьцуулна. Үнэлгээгээр тайлант үеийн эцэст тодорхой нэг зээлийн эрсдэлийн түвшинд хүрэх гэхээсээ илүү зээлийн эрсдэлийн харьцангуй өсөлтийг нь авч үздэг. Банк нь бүхий л боломжит ашиглаж болохуйц бэлэн байгаа ирээдүйг харсан мэдээлийг хэт их зардал, хүчин чармайлт гаргалгүйгээр авч үздэг. Тодруулга 32-ийг харна уу.



## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

**4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)**

Бизнес моделийн үнэлгээ. Бизнес модел дээрээс үндэслэн санхүүгийн хөрөнгийг ангилна. Удирдлага бизнес моделийн үнэлгээг хийхдээ санхүүгийн хэрэгслүүдийн багц болон ижил байдлын түвшинг тодорхойлохдоо үнэлэлт өгсөн. Борлуулалтын гүйлгээг үнэлэхдээ Банк нь түүхэн давтамж, цаг хугацаа болон үнэ цэнэ, борлуулалтын зорилго, ирээдүйн борлуулалтын үйл ажиллагааны тухай хүлээлт зэргийг авч үздэг. Зээл чанаргүйдсэнээс үүдэн гарах боломжит алдагдлыг багасгах зорилготой борлуулалтын гүйлгээ нь “гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах” бизнесийн моделтой таарч байна. Зээлийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хамааралгүй бусад хугацаанаас өмнөх борлуулалтууд ч мөн дангаараа болон бүлгээрээ олон давтамжтай биш эсвэл үнийн дүнгийн хувьд их биш гэдгийг харгалзан “гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах” бизнесийн моделтой таарч байна. Мөн түүнчилэн зөвхөн стрессийн тохиолдлын үед эсвэл Банкны хяналтаас гадуур нэг удаагийн үйл явдлын үр дүнд хийгдэж болох санхүүгийн хөрөнгийн борлуулалт нь байнга давтагддаггүй бөгөөд Банкны зүгээс таамаглах боломжгүй байх ба бизнесийн моделийн зорилгын хувьд тохиолдлын гэж үзэх учир тухайн санхүүгийн хөрөнгийн ангилалд нөлөөлөхгүй.

“Гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах ба зарах” бизнес модел нь гэрээт мөнгөн урсгалыг цуглуулах болон тухайн хөрөнгийг борлуулснаас үүссэн мөнгөн урсгалыг цуглуулах нь мөн энэхүү бизнес моделийн зорилгыг биелүүлэхэд чухал, үүнд хөрвөх чадвартай байдлаа удирдахын тулд, тодорхой нэг өгөөжид хүрэхийн тулд, эсвэл тухайн хөрөнгийг санхүүжүүлэхэд ашигласан өр төлбөрийн хугацааг санхүүгийн хөрөнгийн хугацаатай нь тохируулахын тул гэх мэт.

Үлдсэн ангилалын гол зорилго нь худалдан борлуулсанаас үүсэх мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор удирдаж байгаа санхүүгийн хөрөнгийн багцууд багтах бөгөөд жишээ нь өмнө нь худалдан борлуулсан төлөв байх ёстой. Гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах нь энэ бизнес моделийн хувьд заримдаа тохиолддог.

Мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй эсэх үнэлгээ. Санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлтөөс (“ЗХҮТ”) бүрдэж буй эсэхийг тодорхойлоход үнэлэлт өгөх шаардлагатай.

Мөнгөний үнэ цэнийн элемент нь хувирах магадлалтай, жишээ нь хэрэв гэрээний хүүгийн түвшин давтамжтайгаар өөрчлөгддөг боловч тэр давтамж нь өрийн хэрэгслийн суурь хүүгийн түвшний чиглэлтэй таарахгүй байдаг, жишээ нь зээлийн хүүнд банк хоорондын 3 сарын хүүг ашигладаг боловч хүү нь сар бүр өөрчлөгддөг. Хувиргасан мөнгөний үнэ цэнийн нөлөөг тодорхой хэрэглүүрийн мөнгөн урсгалыг ЗХҮТ мөнгөн урсгалтай жишиг өрийн хэрэгсэлтэй харьцуулалт хийх байдлаар үнэлэх бөгөөд үүнийг тайлант хугацаа бүрт болон хэрэглүүрийн хугацааны туршид хуримтлуулан хийнэ. Үнэлгээг хамгийн боломжит бүх тохиолдолд хийсэн бөгөөд санхүүгийн зах зээлд тохиолдож болох санхүүгийн стрессийн боломжит нөхцөл байдалд ч мөн хийсэн байна. Мөнгөн урсгал нь жишиг үзүүлэлтээс ихээхэн зөрүүтэй байх тохиолдолд үнэлгээ хийгдсэн хэрэглүүрийн мөнгөн урсгалыг ЗХҮТ гэж үзэхгүй бөгөөд тухайн хэрэглүүрийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар бүртгэнэ. ЗХҮТ шалгуурыг даваагүй хэрэглүүрүүд бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэнэ.

Сангийн яамнаас авсан зээлийн болон дотоодын банкинд олгосон зээлийн анхлан хүлээн зөвшөөрөлт. Банк нь 32,267 сая төгрөг (2020 онд 27,936 сая төгрөг)-ийн Сангийн яамнаас авсан зээлтэй (Тодруулга 21) ба ба энэхүү хөрөнгийн эх үүсвэр нь Сангийн яаманд олгосон бүс нутгийн хөгжлийг дэмжих Азийн Хөгжлийн Банкны санхүүжилттэй.

#### 4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Энэ эх үүсвэр нь маш бага буюу жилийн 1-ээс 2.5 хувийн хүүтэй, сонгогдсон эдийн засгийн секторууд болон бусад бага хүү шаардлагатай өөр бусад тусгай зорилтуудыг хангах зорилгоор зээлдүүлэх нөхцөлтэй.

Удирдлага нь энэхүү зээлийг анхны хүлээн зөвшөөрөлт болон эхэлж бүртгэхдээ ашиг бүртгэх шаардлагатай эсэхийг харгалзан үзсэн. Ингэхдээ эдгээр зээлийг харилцан тохиролцсон төсөлд заасан тусгай зорилготой зах зээлд зориулсан буюу нийтийн ашиг сонирхолд үйлчлэх хүүгүй эсвэл маш бага хүүтэй зээлийн хэрэгсэл хэмээн удирдлага үзсэн. Энэхүү зээлийн эх үүсвэрийг ашиглан тодорхой шалгуур хангасан арилжааны банкуудад бага хүүгээр санхүүжилт хийх буюу зээл олгох боломжтой байна. Иймд эдгээр зээлийн анхны хүлээн зөвшөөрөлтийн олзыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй.

Санхүүжилтийн үр дүнд Банк нь шаардлага хангасан банкуудад хөнгөлөлттэй нөхцлөөр зээл олгох боломжтой болсон. Удирдлага нь дээрх хэрэгслүүдийг анхлан хүлээн зөвшөөрөх үед алдагдал хүлээн зөвшөөрөх шаардлагатай эсэхийг авч үзсэн. Эдгээр зээлүүд нь холбоогүй талуудад олгогдсон учир зээлийг зах зээлийн хүүгээр олгосон бөгөөд анх хүлээн зөвшөөрөлтийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн. Дээрх үнэлэмжид эдгээр хэрэгслүүд нь анхдагч зах зээлд олгогдсон гэдгийг авч үзсэн болно.

**Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнэ.** Банк нь гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэх, хүүгийн өсөлт, гадаад валютын зээлийн хэмжээг бууруулах, валютын ханшийн эрсдэлийг бууруулах орчныг бүрдүүлэх зорилгоор дотоодын банкуудтай үүсмэл хэрэгслийн хэлцлүүдийг тогтмол хийдэг. Эдгээр үүсмэл хэрэгслийг бодит үнэ цэнээр бүртгэдэг.

Банк нь 2017 оны 12 дугаар сараас хойш дотоодын банкуудтай шинэ урт хугацаат хүүгийн своп хэлцлүүдийг хийж эхэлсэн. Эдгээр нь 1-ээс 8 жилийн хугацаатай хүүгийн томъёололд үндэслэсэн төгрөг-ам.долларын своп хэлцэл юм.

Дээрх хэлцлүүдийн форвард ханшийг Мөнгөний Бодлогын Газраас эконометрик загвар ашигласан үнэлгээний аргачлалаар тооцоолсон. Дээрх урт хугацаат хэрэгслүүдийн үнийн талаар зах зээлийн мэдээлэл байхгүй. Удирдлага эконометрик загвар ашиглан форвард ханшийг тооцоолох нь хүүгийн аргад суурилсан томъёог ашигласнаас илүү оновчтой гэж үзэж байна. Ажиглагдахуйц зах зээлийн мэдээлэлд суурилагагүй төсөөлөл ашиглан үнэлсэн хэрэгслийн талаарх мэдээллийг Тодруулга 33-аас үзнэ үү.

Удирдлага дээрх санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөхөд олз, гарз үүсэх эсэхийг харгалзан үзсэн ба хэлцлүүд зах зээлд оролцогчдын хувьд сайн дурын үндсэн дээр явагдсан тул олз гарз үүсэхгүй гэж удирдлага үзсэн. Мөн тус үнэлэмж, дүгнэлтийг хийхэд үндсэн зах зээлийн хэрэгслийг илэрхийлж байна гэж удирдлага үзсэн болно.

**Дотоодын банкуудад олгосон зээлийн анхны хүлээн зөвшөөрөлт.** Банк нь Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд төгрөгийн зээлийг дотоодын банкуудад 2012 оны 11 дүгээр сараас олгож эхэлсэн. Эдгээр зээлүүдийг Засгийн газраас тогтоосон нөхцөлөөр олгосон ба Банк нь эдгээр зээлүүдийн нөхцөлийг тодорхойлоход ямар нэгэн эрхгүй байсан болно. Мөн тус хөтөлбөрт хамрагдах компаниудыг Засгийн газар тодорхойлж, тогтоосон бөгөөд Банкнаас санхүүжилтийг нь өгсөн зээлийг арилжааны банкуудаар дамжуулан компаниуд хүлээн авах эрхтэй. Үүний үр дүнд дотоодын банкуудад олгосон зээлийн хүүгийн түвшин нь жилийн 0.89-өөс 4 хувь байх боломжийг Засгийн газар бүрдүүлсэн.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

**4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)**

Бид эдгээр зээлүүдийн хүүг зах зээлийн хүүтэй адилтган үзэж, анх хүлээн зөвшөөрөх үед аливаа ашиг, алдагдал хүлээн зөвшөөрөх шаардлагатай эсэхийг үнэлж үзсэн. Энэхүү зээл нь Төв банкны үндсэн үүрэг болох мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, инфляцыг тогтворжуулах зорилгын хүрээнд зах зээлд мөнгөний нийлүүлэлтийг хийсэн бөгөөд зээлүүд тусдаа зах зээлийн сегментийн гүйлгээ (жишээ нь үндсэн зах зээл) мөн болохыг бид харгалзаж үзсэн. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд дотоодын банкуудад олгосон зээлийн үлдэгдэл нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 852,376 сая төгрөг (2020 онд 383,799 сая төгрөг) байна. Дотоодын банкуудад олгосон зээлийн талаар Тодруулга 9, холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар Тодруулга 3-г харна уу.

**Хадгаламжийн даатгалын корпорацид (ХДК)-д олгосон санхүүгийн дэмжлэг (зээлийн) анхны хүлээн зөвшөөрөлт.** Банк нь банкны системийн тогтвортой байдлын хүрээнд Хадгаламжийн даатгалын корпорацид 119,900 сая төгрөгийг жилийн 0.5 хувийн хүүтэй 10 жилийн хугацаатайгаар 2013 онд олгосон. Гэрээнд зааснаар, зээл нь 2023 оны 9 дүгээр сарын 30-нд эргэн төлөгдөж дуусах бөгөөд хүүгийн эргэн төлөлт жил бүр хийгдэж байна. Гэрээний дагуу, зээлийг (1) Төрийн банкны нэхэмжлэх эрх цугласнаар, (2) Төрийн банкны хувьчлалаас орж ирэх орлого, (3) Төрийн банкны олгосон ногдол ашгийн орлого болон (4) ХДК-ийн бусад орлогоор эргэн төлнө.

Тухайн өдөр, Засгийн газраас Төрийн банкны хувьцааг худалдан авах шийдвэрийг дэмжиж Банк нь ХДК-д богино хугацаатайгаар 85,000 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. Үүний үр дүнд ХДК нь Төрийн банкны 75 хувийг эзэмшиж байгаа бөгөөд гэрээний дагуу, санхүүгийн тусламжийн эргэн төлөлт нь Төрийн банкны хувьчлалын орлогоос төлөгдөнө.

Монгол Улсын банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилго болон банкны системийн дахин санхүүжилтийг эцсийн зээлдүүлэгчийн хувьд зохион байгуулсан онцлог байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр удирдлага тус санхүүгийн дэмжлэг бүхий зээл нь үндсэн зах зээлийн хүүгийн түвшинг илэрхийлнэ гэж дүгнэсэн. Эдгээр зээлийн үлдэгдэл 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 57,576 сая төгрөг (2020 онд 54,230 сая төгрөг). Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 17-аас үзнэ үү.

**Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-д олгосон санхүүгийн дэмжлэгийн Эрсдэлийн алдагдлын сан.** Дээр дурдсан санхүүгийн дэмжлэгийн нөгөө тал нь ХДК боловч эргэн төлөлтийн нөхцлүүд нь гэрээнд заасан байгаа. Иймд, болзошгүй алдагдлын нөөцийг энэ гэрээний хувьд өөрөөр хэмждэг бөгөөд гэрээнд заасан эргэн төлөлтийн аргачлалуудад тулгуурлана.

**Зах зээлийн түвшингөөс доогуур олгосон бусад санхүүгийн хэрэгслийн анхны хүлээн зөвшөөрөлт.** СТОУС 9-д санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөх дүн нь түүний бодит үнэ цэнэ байна гэж заасан. Санхүүгийн хэрэгсэл нь идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй болон эсвэл зах зээлийн бус хүүгээр олгогдсон тохиолдолд бодит үнэ цэнийг холбогдох үнэлгээний аргуудыг ашиглаж тодорхойлж болно. Тус үнэлэмжийг хийхдээ холбоогүй талуудын хооронд хийгдсэн ижил төстэй ажил гүйлгээ болон үр ашигт хүүгийн аргыг ашиглана. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (Тодруулга 3)-д тодруулсны дагуу, удирдлага нь мөн чанарын хувьд Төв банкны үндсэн чиг үүргийг илэрхийлж чадахгүй байгаа дараах ажил гүйлгээнүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх шаардлагатай гэж үзсэн.

#### 4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Банк нь 2015 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар Хөгжлийн банкны нийт 60,000 сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, жилийн 4 хувийн хүүтэй буюу зах зээлийн үнээс доогуур хүүтэй өрийн бичгийг худалдаж авсан. Эдгээр өрийн бичгийн анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ 31,397 сая төгрөг байсан бөгөөд Хөгжлийн банкны үнэт цаасны нэрлэсэн үнэ болон бодит үнэ цэнийн хоорондын зөрүү болох 28,603 сая төгрөгийг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны ашиг/алдагдалд хүлээн зөвшөөрсөн. 2021 онд эдгээр өрийн бичгүүд нь бүрэн төлөгдөж дууссан (2020: 55,650 сая төгрөг) байна. Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлогыг Тодруулга 3-аас, бусад дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 10-аас үзнэ үү.
- 2016 онд “Сайн” хөтөлбөрийг санхүүжүүлэхийн тулд Банк 453,712 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 1-3 хувийн хүүтэй Засгийн газрын үнэт цаасыг худалдан авсан. Удирдлага эдгээрийг 123,668 сая төгрөгийн бодит үнэ цэнэ бүхий санхүүгийн хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн ба анхны хүлээн зөвшөөрөлтийн гарз нь 330,044 сая төгрөг байсан. Энэ гарзыг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрсөн. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар “Сайн” хөтөлбөртэй холбоотой үнэт цаасны дансны үнэ 231,778 сая төгрөг (2020: 227,407 сая төгрөг) байсан. Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлогыг Тодруулга 3-аас, бусад дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 16-аас үзнэ үү.
- Банк нь 2016 онд банкуудтай урвуу буцаан худалдан авах хэлцлүүд байгуулсан бөгөөд хэлцлийн хүү нь 2016 оны 9 сарын 30-ны өдрийг хүртэл жилийн хувьсах хүүгээс 3 хувь хүүг хасаж тооцох нөхцөлтэй байсан ба 2016 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс жилийн 7.5 хувь тогтмол хүүтэй болсон. Удирдлага нь тус хэлцлийг зах зээлийн хүүгээс доогуур хүү гэж үзсэн бөгөөд 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, хүлээн зөвшөөрөх анхны бодит үнэ цэнэ нь 150,000 сая төгрөг, хүлээн зөвшөөрөлтийн алдагдал нь 23,426 сая төгрөг байсан. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бүрэн төлөгдсөн (2020: 62,327 сая төгрөг) байна. Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлогыг Тодруулга 3, бусад дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 12-оос үзнэ үү.

Зах зээлийн хүүгээс доогуур үнэлэгдэх хөрөнгүүдийн анх хүлээн зөвшөөрсөн алдагдлыг тухайн тайлант хугацааны ашиг эсвэл алдагдлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Дээрх ажил гүйлгээний анхны хүлээн зөвшөөрөлтийн хувьд алдагдлын хэмжээг тодорхойлохдоо, холбогдох ажил гүйлгээний талаарх мэдээллийг хооронд нь харьцуулах болон дараах итгэл үнэмшлүүдэд үндэслэн дүгнэлтийг хийсэн. Үүнд :

- Банкны бодлогын хүү нь Монгол Улсын Засгийн газар болон тухайн зээлдэгчийн хувьд эрсдэл гарсан тохиолдолд арилжааны банкуудад олгосон санхүүжилт нь зах зээлийн хүүгийн түвшинг ойролцоогоор илэрхийлж төлөөлөхүйц байна гэж үзсэн;
- Банкны бодлогын хүү нь жилд 2 хувиар ахиуц байдлаар нэмэгдсэн байгаа нь дотоодын компаниудад өрийн бичгээр (Тодруулга 17) баталгаажиж олгогдсон төгрөгийн зээлийн хүүгийн түвшиний эрсдэлийг ойролцоогоор илэрхийлнэ гэж үзсэн.

**Өрийн бичгийн бодит үнэ цэнэ.** Банк нь 2014 онд хэд хэдэн аж ахуй нэгжээс өрийн бичгийг нь худалдан авах замаар зээл олгосон бөгөөд нийтдээ 2014 онд 350,000 сая төгрөгийн, 2016 онд 465,000 сая төгрөгийн зээлийг 21 хувийн хүүтэйгээр, тодорхой гүйцэтгэлийн шаардлагуудын хангаж чадсан тохиолдолд 7-8 хувь хүртэл буурах боломжтой нөхцлөөр олгосон.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

**4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)**

Банкны удирдлага эдгээр хөрөнгийг бий болгоход гэрээний нөхцөл, гүйцэтгэлийн тодорхой нөхцлүүдийг хангах магадлалыг харгалзан эдгээр зээлийн зохих үр ашигтай хүүг тооцсон. Зээлдэгчдийг заасан нөхцөлийг хангах магадлал өндөр гэж удирдлага дүгнэсэн. Иймд бууруулсан хүү нь Монголын зах зээл дахь ижил төрлийн санхүүгийн хэрэгслийн зах зээлийн хүүг төлөөлөхгүй байсан тул анх хүлээн зөвшөөрөхдөө алдагдал тооцоолж бүртгэсэн. Үүний үр дүнд холбогдох авлагын бодит үнэ цэнийг анх хүлээн зөвшөөрөхөд 265,426 сая төгрөг, 2014 онд анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдал 84,574 сая төгрөг бүртгэсэн. Холбогдох зээлийн бодит үнэ цэнийг анх хүлээн зөвшөөрөхөд 371,722 сая төгрөг байсан ба 2016 оны 12-р сарын 31-ний өдрийн ашиг, алдагдалд хөрөнгийн зах зээлийн хүүгээс доогуур хүүгээр хөрөнгө хүлээн зөвшөөрөх үед 93,278 сая төгрөгийг алдагдал хүлээн зөвшөөрсөн. Эдгээр авлагыг СТОУС 9-д шаардсны дагуу ЗХҮТ-ийн шалгуурыг хангаагүй тул БҮЦӨАА ангилал руу шилжүүлсэн. Иймээс холбогдох авлагын бодит үнэ цэнийг шилжилтийн өдрийн байдлаар тооцсон.

Банкны удирдлага нь өрийн бичгийн бодит үнэ цэнийн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцох замаар гаргадаг. Бодит үнэ цэнийн тооцоололд, дараах ойлголтуудыг мэдэгдэж байгаа мэдээлэлд ашигласан. Үүнд:

- Ирээдүйн мөнгөн гүйлгээний магадлал: Удирдлага нь харилцагч талуудын санхүүгийн түүхэн мэдээлэлд үндэслэн ирээдүйн мөнгөн гүйлгээний магадлалыг үнэлж, зарим өрийн бичгүүдийн эргэн төлөлтийг хугацаанд нь бүрэн авах боломжтой гэж үзэж байна.
- Хямдруулалтын хувь: Банкны бодлогын хүү нь харилцагч талын зээлийн эрсдэлээс хамаарч өссөн. Харилцагч талын зээлийн эрсдэлийг зээлийн хүүгийн нөхцлөөс иш татсан зээлийн зэрэглэлд үндэслэн тодорхойлно. Эдгээр аж ахуйн нэгжтэй холбоотой зээлийн эрсдэл үүссэн тохиолдолд төгрөгийн эх үүсвэрийн зах зээлийн ханшийг боломжийн хэмжээнд тооцож байна гэж удирдлага үзэж байна.

Ажиглах боломжтой зах зээлийн мэдээлэлд үндэслээгүй таамаглалыг ашиглан эдгээр өрийн бичгийн бодит үнэ цэнийн талаарх мэдээллийг Тодруулга 33-с харна уу.

**Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-д тавих хяналт.** Банк Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-д хяналтын эрхтэй эсэх болон улмаар Банкны санхүүгийн тайланд түүнийг нэгтгэх хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Банк болон ХДК-ийн хоорондын харилцааны бодит байдлын талаар үнэлэлт хийсэн. Уг үнэлэлтийг хийхдээ дараах байдлыг харгалзан үзсэн. Үүнд:

- ХДК-ийн эрх мэдэл,
- ХДК-ийн үйл ажиллагаа дахь оролцооноос өгөөж хүртэх нөхцөл байдал, ХДК дахь өөрийн эрх мэдлээ ашиглан Банкны хүртэх ашгийн хэмжээнд нөлөөлөх чадвар. Банк ХДК-ийн үйл ажиллагаанд шууд оролцож чаддаг бол Банк ХДК-д эрх мэдэлтэй гэж үзнэ. ХДК-ийн дүрмийн дагуу Үндэсний хороо нь долоон гишүүнээс бүрдэх бөгөөд Банкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч Үндэсний хорооны гишүүн бөгөөд дарга нь байна. Үндэсний хорооны бусад зургаан гишүүд нь:
  - Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга;
  - Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга;
  - ХДК-ийн Гүйцэтгэх захирал;
  - Гурван гишүүнийг Банкны Ерөнхийлөгч, Сангийн сайд болон Банкуудын холбооноос нэр дэвшүүлнэ, харин Банкны Ерөнхийлөгч болон Сангийн сайдын хамтарсан тушаалаар томилно. (Банкуудын холбоо нь банкуудаас бүрдэх бөгөөд Банк ордоггүй байна.)



#### 4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Корпоративтай холбоотой бүх шийдвэр нь Үндэсний хорооны долоон гишүүний саналаар батлагдах ба аль нэг гишүүн нь ХДК-ийн үйл ажиллагааг удирдах давуу эрхгүй байна. Банкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч нь Үндэсний хороог даргалах боловч ХДК-ийн үйл ажиллагааг дангаар удирдах эрхгүй. Мөн Банк бусад гурван гишүүдийг томилох хязгаарлагдмал эрхтэй байгаа нь ХДК-д хяналт болон нөлөөгүй гэдгийг илэрхийлж байна. Иймд Удирдлага ХДК-ийн үйл ажиллагааг санхүүгийн тайландаа нэгтгэх шаардлагагүй гэж үзсэн болно.

**Эрх хүлээн авагч томилогдсон банкуудад тавих хяналт.** Банк нь Эрх хүлээн авагч томилсон банкуудад хяналтын эрхтэй эсэх болон тэдгээрийг санхүүгийн тайланд нэгтгэх шаардлагатай эсэхийг тодорхойлохдоо Банк болон тухайн банкуудын хоорондын харилцааны бодит байдлын талаар үнэлэлт хийсэн. Уг үнэлэлтийг хийхдээ дараах байдлыг харгалзан үзсэн:

- Банк нь хуулийн шаардлагын дагуу Эрх хүлээн авагч томилсон;
- Эрх хүлээн авагч нь зөвхөн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн байр сууринаас хандаж банкны татан буулгах тодорхой зорилготой ба тухайн банкны ямар нэгэн стратегийн шийдвэрийг гаргадаггүй;
- Эрх хүлээн авагч нь хуулиар тодорхойлсон хүрээнд ажиллах ба өр барагдуулах дарааллыг мөн хуулиар тодорхойлсон. Иймд, Эрх хүлээн авагч нь Банкны үр өгөөжид нөлөөлөх зорилгоор тодорхой шийдвэр гаргах эрхгүй болно;
- Эрх хүлээн авагчийн үйл ажиллагаанаас авсан үр өгөөж бага байна.

Дээрх зүйлүүд дээр үндэслэн хэдийгээр Банк нь эрх хүлээн авсан банкуудын үйл ажиллагааг удирдах эрхтэй боловч өөрийн эрхээ үр ашигт нөлөөлөх зорилгоор ашиглаж болохгүй ба тэдгээр үр ашиг нь эрх хүлээн авсан банкны гүйцэтгэлээс хамаардаггүй болно. Иймд удирдлага эдгээр банкуудыг санхүүгийн тайланд нэгтгэх шаардлага байхгүй гэж үзэж байна.

**Барилгын дахин үнэлгээ.** Банк нь барилга байгууламжийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад орлогод дахин үнэлсэн дүнгээр бүртгэдэг. Банк 2018 онд барилгын бодит үнэ цэнийг үнэлүүлэхээр хараат бус үнэлгээний байгууллагатай гэрээ байгуулсан. Барилгуудыг тухайн хөрөнгийн шинж чанар, байршил, нөхцөл байдал гэх мэт зах зээлийн бусад хүчин зүйлүүдэд тохируулан үнийг харьцуулах замаар зах зээлийн үнэлгээний сууриар үнэлсэн. 2021 болон 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар банкны удирдлага нь барилгын дансны үнэд материаллаг хэмжээний өөрчлөлт ороогүй гэж үзсэн. Энэ шийдвэр нь удирдлагын туршлагад үндэслэсэн бөгөөд Тодруулга 18-д тайлбайрласан ойлголтуудтай мөн хамааралтай.

**Эрдэнэсийн сан** Хүлээн зөвшөөрөлт. Банк нь Монгол Улсын Эрдэнэсийн сангийн тухай хуулийн дагуу Эрдэнэсийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулах ганц байгууллага юм. Эрдэнэсийн сан нь түүх, соёлын болон өв уламжлагдсан үнэт зүйлс мөн 1925 онд гаргасан зоос зэргээс бүрдэнэ. Эдгээр зүйлсийг музейд олон нийтэд үзүүлдэг бөгөөд музейн тасалбараас олсон орлогыг Банкны ашиг, алдагдлын тайланд бусад үйл ажиллагааны орлогоор бүртгэдэг. Нөөцийн удирдлага санхүүгийн зах зээлийн газар энэхүү Сангийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээ, харуул хамгаалалтын удирдлагыг хариуцдаг. Тиймээс, Удирдлага Эрдэнэсийн сангийн эдийн засгийн үр өгөөж нь Банкинд орж байгаа бөгөөд Санг Монгол Улсын Эрдэнэсийн сангийн хуулиар Банк хянадаг учир Эрдэнэсийн санг санхүүгийн байдлын тайланд хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх ёстой гэж үзэж байна. 1938 онд зооснуудыг гүйлгээнээс татсан. Эдгээр зооснуудыг Монголбанкны өмнөх буюу эрх залгамжлагч банк гаргасан ба засгийн газраас Эрдэнэсийн санд хандивласан гэж удирдлага үзэж байгаа учраас хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх нь зөв гэж үзэж байна.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зоос нь дараах хүчин зүйлст үндэслэн хүлээн зөвшөөрөх шалгууруудыг хангасан гэж Банкны удирдлага үзэж байна:

- 1925 онд гаргасан Монгол Улсын мөнгөн зооснуудыг Монгол Улсын Сангийн яамны шийдвэрээр 1938 онд гүйлгээнээс татсан. Эдгээр зооснуудын оронд шинэ мөнгөн тэмдэгтийг гаргасан.
- Эрдэнэсийн санг байгуулах засгийн газрын шийдвэрийн дараа засгийн газраас эдгээр зооснуудыг Санд хандивласан бөгөөд Банк нь Санг удирдах үүрэг хариуцлагын хүрээнд зооснуудыг хянах, хамгаалах үүрэг хүлээсэн.
- Засгийн газраас эдгээр зоосыг зарах, шилжүүлэх зөвшөөрлийг авсаны дагуу гуравдагч талд зоосийг худалдан борлуулсан/шилжүүлсэнээс үүссэн олз, гарзыг хуримтлуулах эрхтэй.
- Монголын соёлын өвийн төвөөс 1925 оны зоос нь БНМАУ байгуулагдсаны дараа гүйлгээнд гарсан анхны зоос, үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр тогтсоныг нотлох баримт, Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг төлөөлж буй чухал зүйл тул “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасны дагуу “соёлын өв”-д хамаарна гэсэн тодорхойлолтыг гаргаж өгсөн.

**Хэмжилт.** Банк Эрдэнэсийн санг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний компанийн бэлтгэсэн тайланд үндэслэн бодит үнэ цэнээр хэмжин бүртгэсэн бөгөөд нэмэгдлийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн. 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Эрдэнэсийн сангийн дансний үлдэгдэл 1,115,085 сая төгрөг (2020: 1,071,665 сая төгрөг) байна. Зах зээл дээр шууд ажиглагдах мэдээлэл дээр үндэслээгүй таамаглалыг ашиглан үнэлсэн зүйлсийн бодит үнэ цэнийн талаар мэдээллийг Тодруулга 33-аас харна уу.

**Толилуулгын өөрчлөлт.** Тухайн жилийн туршид банк нь ашиг алдагдлын тайлан болон мөнгөн гүйлгээний тайлангийн ангилалд толилуулгын зорилгоор өөрчлөлт оруулсан. Банк нь тус өөрчлөлтүүдийг санхүүгийн мэдээллийг илүү найдвартай харуулж чадна гэж итгэж байна.

2020 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон жилийн дүнг толилуулгын зорилгоор дахин ангилсны нөлөө дараах байдалтай байна.

| Сая төгрөгөөр                                  | Тодруулга | 2020<br>(өмнөх толилуулга) | Дахин ангилал | 2020 (Дахин<br>ангилсан) |
|------------------------------------------------|-----------|----------------------------|---------------|--------------------------|
| Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого | 26        | 694,862                    | (460,500)     | 234,362                  |
| Бусад адилтгах орлого                          | 26        | -                          | 42,810        | 42,810                   |
| Хүүгийн зардал                                 | 26        | (1,095,830)                | 279,419       | (816,411)                |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслийн алдагдал          |           | (381,196)                  | 138,271       | (242,925)                |
| Алт, үнэт металын арилжааны ашиг               | 27        | 879,608                    | (151,293)     | 728,315                  |
| Алт, үнэт металын ханшийн тэгшитгэлийн ашиг    |           | -                          | 151,293       | 151,293                  |
| Гадаад валютын арилжааны алдагдал              |           | -                          | (1,356)       | (1,356)                  |
| Гадаад валютын хөрвүүлгийн ашиг/(алдагдал)     |           | (459,090)                  | 1,356         | (457,734)                |
| ТАЙЛАНТ ЖИЛИЙН АЛДАГДАЛ                        |           | (361,646)                  | -             | (361,646)                |



## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТААМАГЛАЛ БОЛОН ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

| Сая төгрөгөөр                                                                                              | Тодруулга | 2020<br>(өмнөх толилуулга) | 2020 (Дахин<br>ангилсан) |
|------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|----------------------------|--------------------------|
| Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ                                                                             |           |                            |                          |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгддэг өмчийн хэрэгсэл борлуулсны алдагдал |           | -                          | (3,262)                  |
| Өрийн үнэт цаасны санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны ашиг/(алдагдал)                                   |           | -                          | 6                        |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслийн алдагдал                                                                      |           | (138,813)                  | 381,738                  |
| Бусад адилтгах орлого                                                                                      |           | (460,500)                  | 417,690                  |
| Хүүгийн зардал                                                                                             |           | 1,095,830                  | (279,419)                |
| Эрдэнэсийн сангийн цэвэр (өсөлт)                                                                           |           | (2,805)                    | 2,805                    |
| Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын цэвэр (өсөлт)                                                       |           | (680,150)                  | 680,150                  |
| Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгийн цэвэр бууралт/(өсөлт)                            |           | -                          | (1,698)                  |
| Бусад хөрөнгийн цэвэр бууралт                                                                              |           | 20,295                     | 421,829                  |
| Бусад өр төлбөрийн цэвэр өсөлт/ (бууралт)                                                                  |           | 331,892                    | (801,934)                |
| Хүлээн авсан хүү                                                                                           |           | 637,014                    | (421,829)                |
| Төлсөн хүү                                                                                                 |           | (1,097,097)                | 281,926                  |
| Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ                                                                          |           |                            |                          |
| Эрдэнэсийн сангийн цэвэр (өсөлт)                                                                           | 14        | -                          | (2,805)                  |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгддэг өрийн хэрэгслийн худалдан авалт     |           | (1,589,766)                | (292,273)                |
| Хорогдуулсан өртгөөр хэмжих өрийн хэрэгслийн худалдан авалт                                                |           | -                          | (751,163)                |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгддэг санхүүгийн хэрэгслийн борлуулалт    |           | 933,596                    | 122,662                  |
| Хорогдуулсан өртгөөр илэрхийлэгддэг санхүүгийн хэрэгслийн борлуулалт                                       |           | -                          | 243,880                  |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ                                                                  |           |                            |                          |
| Гадаад өр төлбөрийн өсөлт                                                                                  | 23        | 238,598                    | 45,766                   |
| Гадаад өр төлбөрийн эргэн төлөлт                                                                           | 23        | -                          | (45,766)                 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                                                        |           | 4,752,271                  | (1,698)                  |
|                                                                                                            |           |                            | 4,750,573                |

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 5. ШИНЭ БУЮУ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН СТАНДАРТУУДЫН ТАЙЛБАР, ХЭРЭГЖИЛТ

Дараах нэмэлт өөрчлөлтүүд нь 2021 оны 1 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон:

**КОВИД-19-тэй холбоотой СТОУС16-д оруулсан түрээсийн хөнгөлөлтийн нэмэлт өөрчлөлт (2020 оны 5 сарын 28-ны өдөр батлагдан гарсан бөгөөд 2020 оны 6 сарын 1-ний өдрөөс эхлэх ба түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө).** Нэмэлт өөрчлөлт нь түрээслэгчдэд КОВИД-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт нь түрээсийн өөрчлөлт мөн эсэхийг үнэлэхээс чөлөөлөх хэлбэрээр хөнгөлөлт үзүүлдэг. Түрээслэгчид түрээсийн хөнгөлөлтийг түрээсийн өөрчлөлт хийгээгүйтэй адилаар тооцож сонгох боломжтой. Практик хэрэглээ нь зөвхөн КОВИД-19 цар тахлын шууд үр нөлөөгөөр бий болсон түрээсийн хөнгөлөлтөд хамааралтай бөгөөд дараах бүх нөхцөлийг хангасан тохиолдолд хэрэгжүүлнэ: түрээсийн төлбөрийн өөрчлөлт нь түрээсийн өмнөх төлбөртэй бараг ижил хэмжээтэй эсвэл үүнээс бага хэмжээтэй байхаар шинэчилсэн; түрээсийн төлбөрийн аливаа бууралт нь зөвхөн 2021 оны 6 сарын 30-ны өдөр болон түүнээс өмнө төлөх төлбөрт нөлөөлдөг; түрээсийн бусад нөхцлүүдэд томоохон өөрчлөлт ороогүй тохиолдолд. 2021 оны 3 сарын 31-ний өдөр цар тахал хэвийн үргэлжилж буйтай холбоотой НББОУС3-өөс 2021 оны 6 сарын 30-ны өдрөөс 2022 оны 6 сарын 30-ны өдрийг хүртэл хугацааг сунгахаар нэмэлт өөрчлөлт оруулсан. (2021 оны 4 сарын 1-ний өдрөөс эхлэх ба түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө). Нэмэлт өөрчлөлт нь

Банкны санхүүгийн тайлангуудад тусгагдсан дүнгүүдэд материаллаг хэмжээний нөлөөг үзүүлээгүй.

**Зах зээлийн жишиг хүүгийн шинэчлэл (IBOR) - СТОУС 9, НББОУС 39, СТОУС 7, СТОУС 4 ба СТОУС 16-д оруулсан 2-р үе шатны нэмэлт өөрчлөлтүүд (2020 оны 8 сарын 27-ны өдөр батлагдан гарсан бөгөөд 2021 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө).** 2-р үе шатны нэмэлт өөрчлөлтөөр шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад гарч буй асуудлууд, тэр дундаа нэг жишиг хувилбарыг өөр жишиг хувилбараар орлуулах асуудлыг оруулсан болно. Нэмэлт өөрчлөлт нь дараах чиглэлийг хамарна:

- *IBOR-ийн шинэчлэлийн үр дүнд гэрээний дагуу бий болсон мөнгөн гүйлгээг тодорхойлох суурьт гарсан өөрчлөлтийн нягтлан бодох бүртгэл:* Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэж буй хэрэглүүрийн хувьд нэмэлт өөрчлөлтүүд нь практик үндэслэлээр аж ахуйн нэгжүүдээс зах зээлийн жишиг хүүгийн шинэчлэлийн үр дүнд гэрээний дагуу бий болсон мөнгөн гүйлгээг тодорхойлох суурьт гарсан өөрчлөлтийг тооцоолох СТОУС 9-ийн В5.4.5 дахь хэсгийн удирдамжийг ашиглан үр ашигт хүүгийн хэмжээг шинэчлэн тогтоохыг шаарддаг. Үүний үр дүнд шууд ашиг, алдагдлыг хүлээн зөвшөөрөхгүй. Энэхүү практик аргачлал нь зөвхөн дээрх өөрчлөлтөд хамааралтай бөгөөд зөвхөн IBOR-ийн шинэчлэлийн шууд үр дагаварт хамааралтай байх нөхцөлд л хэрэгжих бөгөөд шинэ суурь нь эдийн засгийн хувьд өмнөх суурьтай адил тэнцүү байх ёстой. СТОУС 9-ээс түр чөлөөлөх журмыг хэрэгжүүлж буй даатгагчид мөн ижил практик аргачлалыг хэрэгжүүлэх шаардлагатай. Зах зээлийн жишиг хүүгийн шинэчлэл хийсний үр дүнд түрээсийн төлбөрийг тодорхойлох суурийг өөрчилсөн түрээсийн өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлд хамруулахдаа түрээслэгчдээс үүнтэй ижил практик аргачлалыг ашиглахыг шаардах гэж СТОУС 16-д нэмэлт өөрчлөлт оруулсан.
- Хеджийн харилцаанд гэрээний дагуу тогтоогдоогүй эрсдэлийн бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх 1-р үе шатны хөнгөлөлтийн дуусах огноо: 2-р шатны нэмэлт өөрчлөлт нь аж ахуйн нэгжээс гэрээний дагуу тогтоогдоогүй эрсдэлийн бүрэлдэхүүн хэсэгт өөрчлөлт оруулах эсвэл хеджийн харилцаа цуцлагдахын аль эрт тохиолдсон үед нь 1-р шатны хөнгөлөлтийг гэрээний дагуу тогтоогдоогүй эрсдэлийн бүрэлдэхүүн хэсэгт хэрэглэхийг гүйцээх горимын дагуу зогсоохыг шаарддаг. Эрсдэлийн бүрэлдэхүүн хэсэгт 2-р шатны дуусах огноог заагаагүй.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 5. ШИНЭ БУЮУ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН СТАНДАРТУУДЫН ТАЙЛБАР, ХЭРЭГЖИЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Хеджийн нягтлан бодох бүртгэлийн тодорхой шаардлагыг хэрэгжүүлэхээс түр хугацаанд үл хамаарах тохиолдлууд: 2-р үе шатны нэмэлт өөрчлөлт нь IBOR-ийн шинэчлэлээс шууд хамааралтай хеджийн харилцаанд НББОУС 39 ба СТОУС 9-ийн хеджийн нягтлан бодох бүртгэлийн тодорхой шаардлагуудыг хэрэглэх түр зуурын нэмэлт хөнгөлөлт үзүүлдэг
- IBOR-ийн шинэчлэлтэй холбоотой НББОУС 7-ын нэмэлт тодруулгууд: Нэмэлт өөрчлөлтүүд нь дараахь зүйлийг тодруулахыг шаарддаг: (i) аж ахуйн нэгж өөр жишиг хувь руу шилжих шилжилтийг хэрхэн удирдаж байгаа, түүний ахиц дэвшил, шилжилтээс үүсэх эрсдэл; (ii) томоохон жишиг хүүгийн түвшнээр нь ангилсан шилжилт хийгээгүй үүсмэл болон үүсмэл бус санхүүгийн хэрэгслийн талаарх тоон мэдээлэл; мөн (iii) IBOR-ийн шинэчлэлийн үр дүнд эрсдэлийн удирдлагын стратегид гарсан аливаа өөрчлөлтийн тодорхойлолт.

**Зах зээлийн жишиг хүүгийн шинэчлэлийн нөлөө.** Банк хоорондын зах зээлийн жишиг хүүг ('IBOR') шинэчлэх нь зохицуулагчдын нэн тэргүүний зорилт болоод байгаа ба ихэнх IBOR хүүг 2021 оны 12 сарын 31-ний өдрөөс нийтэд мэдээлэхээ зогсоосон бөгөөд зарим ам.долларын LIBOR хүү нь 2023 оны 6 сарын 30-ны өдөр гэхэд нийтлэгдэхээ болино.

Доорх хүснэгтэд 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар жишиг хүү рүү шилжих үүсмэл бус санхүүгийн өр төлбөр болон дериватив гэрээний дүнг харууллаа:

| Сая төгрөгөөр                               | Ам.долларын LIBOR | Нийт дансны үнэ  |
|---------------------------------------------|-------------------|------------------|
| <b>Үүсмэл бус санхүүгийн өр төлбөр</b>      |                   |                  |
| Бусад зээлийн эх үүсвэр                     | 570,417           | 570,417          |
| <b>Нийт үүсмэл бус санхүүгийн өр төлбөр</b> | <b>570,417</b>    | <b>570,417</b>   |
| <b>Үүсмэл санхүүгийн хэрэглүүр</b>          |                   |                  |
| Хүүгийн своп хэлцлүүд: хэлцлийн дүн         | 4,348,663         | 4,348,663        |
| <b>Нийт үүсмэл санхүүгийн хэрэглүүр</b>     | <b>4,348,663</b>  | <b>4,348,663</b> |

Хуучин IBOR-д суурилсан санхүүгийн хэрэглүүрүүдийн тоо хэмжээ багасч байгаа тул Банк дээрх санхүүгийн хэрэглүүрүүдийн хөрвөх чадвар буурах эрсдэлд өртөх магадлалтай. Банкинд мөн IBOR хүү болон жишиг хүүгийн хооронд арбитражийн боломжит зөрүү үүсэх эрсдэлтэй байна.

Банк нь Монголын Банкуудын Холбооны гишүүдийг оролцуулсан ажлын хэсэг байгуулан IBOR-ийн шинэчлэлийн талаарх олон улсын шилдэг туршлагыг судлан, баталгаат овернайт санхүүжилтын хүү ("SOFR") зэрэг IBOR-д суурилсан санхүүгийн хэрэглүүрийг жишиг хүү рүү шилжүүлэх ажлыг хийж байна.

Банк нь 2021 оны 12 сарын 31-ний байдлаар Хятадын Ардын Банкнаас 5,463,574 сая төгрөгийн санхүүжилтийг авсан. Хүү нь жилийн SHIBOR+200 суурь нэгж нэмсэнтэй тэнцүү. Удирдлагын зүгээс SHIBOR хүүг зогсоохгүй гэж үзэж байна. Тодруулга 23-ыг харна уу.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 6. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ШИНЭЭР БАТЛАГДСАН МЭДЭГДЛҮҮД

2022 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд заавал мөрдөх стандартууд ба тайлбарууд шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн ба эдгээрийг Банк хугацаанаас нь өмнө хэрэгжүүлж эхлээгүй.

| Шинэ стандарт, нэмэлт өөрчлөлтүүд                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | Дагаж мөрдөх хугацаа           |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------|
| СТОУС 17 "Даатгалын гэрээнүүд" (2017 оны 5 сарын 18-ны өдөр батлагдан гарсан бөгөөд 2023 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө)                                                                                                                                                                                                                                                                             | 2023 оны 1 дүгээр сарын 1      |
| СТОУС 17 болон СТОУС 4-т орсон нэмэлт өөрчлөлтүүд (2020 оны 6 сарын 25-ны өдөр батлагдан гарсан бөгөөд 2023 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө)                                                                                                                                                                                                                                                          | 2023 оны 1 дүгээр сарын 1      |
| СТОУС 10 болон НББОУС 28-д орсон нэмэлт өөрчлөлтүүд – Хөрөнгө оруулагч, түүний хараат компани болон хамтарсан үйлдвэрийн хооронд хөрөнгө борлуулах болон хөрөнгө оруулах (2014 оны 9 сарын 11-нд батлагдсан ба НББОУС-ын зөвлөлөөс заасан хугацаанаас хойших тайлант хугацаануудад дагаж мөрдөнө).                                                                                                                                                | НББОУС3-өөс тодорхойлсон өдөр. |
| Өр төлбөрийг урт болон богино хугацаатайгаар нь ангилах - НББОУС 1-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд (2020 оны 1 сарын 23-ны өдөр батлагдсан ба 2022 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө).                                                                                                                                                                                                                    | 2022 оны 1 дүгээр сарын 1      |
| Өр төлбөрийг урт болон богино хугацаатайгаар нь ангилах, дагаж мөрдөх хугацааг хойшлуулах - НББОУС 1-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд (2020 оны 7 сарын 15-ны өдөр батлагдсан ба 2023 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө).                                                                                                                                                                                  | 2023 оны 1 дүгээр сарын 1      |
| Зориулалтаар нь ашиглахаас өмнөх орлого, алдагдалтай гэрээ – гэрээ гүйцэтгэлийн өртөг - НББОУС 16, НББОУС 37, СТОУС 3-т оруулсан хязгаарлагдах/цар хүрээний нэмэлт өөрчлөлт, СТОУС-д 2018-2020 оны хооронд хийгдсэн жил тутмын сайжруулалт - СТОУС 1, СТОУС 9, СТОУС 16 ба НББОУС 41-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд (2020 оны 5 сарын 14-ний өдөр батлагдсан ба 2022 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө). | 2022 оны 1 дүгээр сарын 1      |
| НББОУС 8 Нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг тодорхойлох тухай нэмэлт өөрчлөлт: (2021 оны 2 сарын 12-ний өдөр батлагдсан ба 2023 оны 1 сарын 1-ний өдрөөс хойших тайлант хугацаанд хүчин төгөлдөр болно).                                                                                                                                                                                                                                         | 2023 оны 1 дүгээр сарын 1      |
| Нэг гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөртэй холбоотой хойшлогдсон татвар – (2021 оны 5 сарын 7-ны өдөр батлагдсан ба 2023 оны 1 сарын 1-ний өдрөөс хойших тайлант хугацаанд хүчин төгөлдөр болно).                                                                                                                                                                                                                                               | 2023 оны 1 дүгээр сарын 1      |

Дээр өөрөөр дурдаагүй бол шинэ стандартууд болон тайлбарууд Банкны санхүүгийн тайлангуудад мэдэгдэхүйц их хэмжээний нөлөө үзүүлэхээргүй байгаа.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 7. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

| Сая төгрөгөөр                                            | Тодруулга | 2021 оны 12 дугаар сарын 31 | 2020 оны 12 дугаар сарын 31 |
|----------------------------------------------------------|-----------|-----------------------------|-----------------------------|
| Бэлэн мөнгө                                              |           | 177,591                     | 233,373                     |
| Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө: |           |                             |                             |
| - Гадаад валютын богино хугацаат хадгаламж               | 8         | 3,297,154                   | 3,509,327                   |
| - Хугацаагүй хадгаламж                                   | 8         | 789,202                     | 878,068                     |
| - Зээлжих тусгай эрх                                     | 8         | 387,299                     | 131,503                     |
| Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан                        |           | (56)                        | (1,698)                     |
| Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө                   |           | <b>4,651,190</b>            | <b>4,750,573</b>            |

Дээрх хүснэгтэд Мөнгөн Гүйлгээний Тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дүнг харуулав. Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтын аргыг Тодруулга 32-өөс үзнэ үү.

2021 оны 12 дугаар сарын 31-нээрх Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд тооцогдох санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэлийн чанарыг доорх хүснэгтэд харуулав. Банкны зээлийн эрсдэлийн үнэлгээний системийн тайлбарыг Тодруулга 32-оос үзнэ үү.

| Сая төгрөгөөр                                                                                                              | Гадаад валютын богино хугацаат хадгаламж | Хугацаагүй хадгаламж | Зээлжих тусгай эрх | Нийт             |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------|----------------------|--------------------|------------------|
| - Онц сайн                                                                                                                 | 3,297,154                                | 789,202              | 387,299            | 4,473,655        |
| Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд багтах гадаадын байгууллагуудад байршуулсан хөрөнгө, бэлэн мөнгийг оруулахгүйгээр | <b>3,297,154</b>                         | <b>789,202</b>       | <b>387,299</b>     | <b>4,473,655</b> |
| Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан                                                                                          | (1)                                      | (55)                 | -                  | (56)             |
| Дансны үнэ                                                                                                                 | <b>3,297,153</b>                         | <b>789,147</b>       | <b>387,299</b>     | <b>4,473,599</b> |

2020 оны 12 дугаар сарын 31-нээрх Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд тооцогдох санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэлийн чанарыг доорх хүснэгтэд харуулав.

| Сая төгрөгөөр                                                                                                              | Гадаад валютын богино хугацаат хадгаламж | Хугацаагүй хадгаламж | Зээлжих тусгай эрх | Нийт             |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------|----------------------|--------------------|------------------|
| - Онц сайн                                                                                                                 | 3,509,327                                | 878,068              | 131,503            | 4,518,898        |
| Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд багтах гадаадын байгууллагуудад байршуулсан хөрөнгө, бэлэн мөнгийг оруулахгүйгээр | <b>3,509,327</b>                         | <b>878,068</b>       | <b>131,503</b>     | <b>4,518,898</b> |
| Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан                                                                                          | (9)                                      | (1,689)              | -                  | (1,698)          |
| Дансны үнэ                                                                                                                 | <b>3,509,318</b>                         | <b>876,379</b>       | <b>131,503</b>     | <b>4,517,200</b> |

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хүлээгдэж буй зээлийн алдагдал нь 1-р шатлалд багтсан. Харилцагч тал нь төв банк эсвэл олон улсын санхүүгийн байгууллага (жишээ нь Английн Төв Банк) бол үнэлгээ хийгдэхгүй ба тухайн улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг авсан. Бэлэн мөнгө болон зээлжих тусгай эрх нь Банкинд зээлийн эрсдэл учруулахгүй. Тодруулга 32-оос зээлийн хүлээгдэж буй алдагдлын үнэлгээний дэлгэрэнгүйг харна уу.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 8. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ

| Сая төгрөгөөр                                            | 2021 оны 12 дугаар сарын 31 | 2020 оны 12 дугаар сарын 31 |
|----------------------------------------------------------|-----------------------------|-----------------------------|
| Гадаад валютын богино хугацаат хадгаламж                 | 3,297,154                   | 3,509,327                   |
| Хугацаагүй хадгаламж                                     | 789,202                     | 878,068                     |
| Зээлжих тусгай эрх                                       | 387,299                     | 131,503                     |
| Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө                    | 179                         | 179                         |
| Бусад хувь хөрөнгө                                       | 12                          | 13                          |
| Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан                        | (57)                        | (1,698)                     |
| <b>Нийт гадаадын байгууллагуудад байршуулсан хөрөнгө</b> | <b>4,473,789</b>            | <b>4,517,392</b>            |

**Богино хугацаат хадгаламж.** Гадаадын төв банкууд болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан 65 хүртэлх хоногийн хугацаатай (2020: 29 хоног) ам.доллар, юаны богино хугацаат хадгаламж болно.

**Хугацаагүй хадгаламж.** Гадаадын төв банкууд болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах дансдын үлдэгдлийг илэрхийлнэ.

**Зээлжих тусгай эрх (ЗТЭ).** ОУВС-д Монгол Улсаас төлөх хувь хэмжээтэй холбоотой нөөцийн хөрөнгийг нөхөх зээлжих тусгай эрхийн хадгаламжийг илэрхийлнэ. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 97.1 сая ЗТЭ (2020 онд 35.8 сая ЗТЭ) байсан бөгөөд хүү тооцогддог.

**Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө.** Энэ нь Дэлхийн банкны гишүүнчлэлийн нөхцөлийн дагуу байршуулсан хадгаламж болон түүнд оруулсан хувь хөрөнгө юм. Энэ дүн нь харгалзах өр төлбөрийн дүнтэй таарч байгаа ба хүү тооцогддоггүй (Тодруулга 23). Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын Төв банк болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудад байршуулсан тул энэ хөрөнгөнд үнэ цэнийн бууралт үүсэхгүй.

**Бусад хувь хөрөнгө.** Энэ үлдэгдэл нь Монгол улс СВИФТ сүлжээнд нэгдэн орох үед төлсөн хураамжтай холбоотой.

Доорх хүснэгтэд ХЗА-ыг хэмжих зорилгоор 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх гадаадын банкуудад байршуулсан хөрөнгийн үлдэгдлийн зээлийн эрсдэлийн чанарыг үнэлгээгээр харуулав. Бүх үлдэгдэл эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын Төв банкууд болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудад байршуулсан байгаа тул 1-р шатлалд багтсан. Банкны зээлийн эрсдэлийн чанарыг харуулах системийн тайлбарын талаар болон ХЗА-ын хэмжилтын аргыг мөн гадаадын банкуудад байршуулсан хөрөнгийн үлдэгдэлд хамаарах дефолтын тодорхойлолт болон зээлийн эрсдэлийн томоохон өсөлтийн тодорхойлолтыг Тодруулга 32-оос үзнэ үү.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

8. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ  
(ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгтэд 2021 оны 12-р сарын 31 ба 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн дансны үнэ болон Банкны эдгээр хөрөнгийн зээлийн эрсдэлд өртөх дээд хэмжээг харуулав.

| Сая төгрөгөөр                     | 2021 оны 12 дугаар сарын 31<br>Шатлал 1 (12-сар ХЗА) | 2020 оны 12 дугаар сарын 31<br>Шатлал 1 (12-сар ХЗА) |
|-----------------------------------|------------------------------------------------------|------------------------------------------------------|
| - Онц сайн                        | 4,473,846                                            | 4,519,090                                            |
| Нийт дансны дүн                   | 4,473,846                                            | 4,519,090                                            |
| Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан | (57)                                                 | (1,698)                                              |
| Дансны үнэ                        | 4,473,789                                            | 4,517,392                                            |

ОУВС хувь хөрөнгө болох зээлжих тусгай эрх, Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө, бусад хувь хөрөнгүүд нь эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэгт харьяалагддаг нэр хүнд бүхий олон улсын байгууллагууд тул Банкинд зээлийн эрсдэл учруулахгүй.

Эдгээр хөрөнгүүдийн аль нь ч барьцаа хөрөнгөгүй. Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгийн ангилал тус бүр дэх тооцоолсон зах зээлийн үнэлгээг Тодруулга 33-аас, хүүгийн түвшний шинжилгээг тодруулга 32-оос харна уу.

Дараах хүснэгтэд зээлийн алдагдлын санг тайлант хугацааны эхний болон эцсийн байдлаар харьцуулж харуулав.

| Сая төгрөгөөр                        | 2021 оны 12 дугаар<br>сарын 31 | 2020 оны 12 дугаар<br>сарын 31 |
|--------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| 1 дүгээр сарын 1                     | 1,698                          | 11                             |
| Эрсдэлийн сангийн (буцаалт)/алдагдал | (1,641)                        | 1,687                          |
| 12 дугаар сарын 31                   | 57                             | 1,698                          |



## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ

| Сая төгрөгөөр                                                               | 2021 оны 12 дугаар сарын 31 | 2020 оны 12 дугаар сарын 31 |
|-----------------------------------------------------------------------------|-----------------------------|-----------------------------|
| Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийн зээл                                      | 852,376                     | 383,799                     |
| Бусад зээл                                                                  | 669,803                     | 93,960                      |
| <b>Зээлийн алдагдлын сангийн өмнөх дотоодын банкуудад олгосон нийт зээл</b> | <b>1,522,179</b>            | <b>477,759</b>              |
| Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан                                           | (34,871)                    | (16,445)                    |
| <b>Хорогдуулсан өртгөөрх дотоодын банкуудад олгосон зээл</b>                | <b>1,487,308</b>            | <b>461,314</b>              |

Доорх хүснэгтэд 2021 оны 12 дугаар сарын 31 болон 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх хорогдуулсан өртгөөр бүртгэх дотоодын банкуудад олгосон зээлийн үлдэгдэлд байгуулсан зээлийн алдагдлын санг харуулав.

| Сая төгрөгөөр                            | 2021 оны 12 дугаар сарын 31 |                         |                  | 2020 оны 12 дугаар сарын 31 |                         |                |
|------------------------------------------|-----------------------------|-------------------------|------------------|-----------------------------|-------------------------|----------------|
|                                          | Нийт дансны үнэ             | Эрсдэлийн алдагдлын сан | Дансны үнэ       | Нийт дансны үнэ             | Эрсдэлийн алдагдлын сан | Дансны үнэ     |
| <b>Дотоодын банкуудад олгосон зээл</b>   |                             |                         |                  |                             |                         |                |
| Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийн зээл   | 852,376                     | (27,310)                | <b>825,066</b>   | 383,799                     | (14,960)                | <b>368,839</b> |
| Бусад зээл                               | 669,803                     | (7,561)                 | <b>662,242</b>   | 93,960                      | (1,485)                 | <b>92,475</b>  |
| <b>ХӨ-өөр бүртгэсэн нийт зээлийн дүн</b> | <b>1,522,179</b>            | <b>34,871</b>           | <b>1,487,308</b> | <b>477,759</b>              | <b>(16,445)</b>         | <b>461,314</b> |

**Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл**

2012 оны 11 дүгээр сараас Банк нь Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд тодорхой салбаруудын дотоодын компаниудад дамжуулан зээлдүүлэх зорилгоор төгрөгийн зээлийг дотоодын банкуудад олгосон. Эдгээр зээлүүд Засгийн газрын хамтарсан шийдвэрээр тодорхойлсон нөхцөлийн дагуу олгогдсон бөгөөд Банкны зүгээс нөхцөлийг тогтоох эрх мэдэл байгаагүй. Мөн энэхүү хөтөлбөрт хамрагдах компаниудыг Засгийн газар тодорхойлсон бөгөөд зээл олгох шийдвэр гаргасан тохиолдолд дотоодын банкууд Банкнаас санхүүжилтийг нэхэмжлэн авч, компаниудад дамжуулан олгосон.

Дотоодын банкуудад дэд хөтөлбөрөөс шалтгаалан жилийн 0.89-өөс 4.00 хувийн хүүтэй зээл олгосон. Банкны удирдлага үнэ тогтворжуулах хөтөлбөртэй холбоотой зээлийг анх хүлээн зөвшөөрөх үед ямар нэгэн алдагдлыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж дүгнэсэн. Тодруулга 4 болон 3-т удирдлагын зүгээс хийсэн холбогдох дүгнэлт болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар харна уу.

Банк нь Засгийн газар, Монголын ипотекийн корпораци болон дотоодын банкуудтай байгуулсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн гэрээ”-ний дагуу дотоодын банкуудад Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүжилтийн төлбөрийн дүнд давуу эрхтэй ИЗББ авсан.

## 9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд дотоодын банкуудад олгосон ипотекийн зээлийн үлдэгдэл нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 852,376 сая төгрөг (2020 онд 383,799 сая төгрөг) байна. Банкнаас дотоодын банкуудад олгосон ипотекийн зээлийн санхүүжилтийн хугацаа нь 1-ээс 6 жил, жилийн 1%, 2%, 4% хүүтэй.

“Ковид-19” цар тахлын нөлөөллийн эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2020 онд батлагдсан “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн хүрээнд зээлдэгчдийн санхүүгийн дарамтыг бууруулах зорилгоор Банкнаас олгосон ипотекийн зээлийн эргэн төлөлт болон хүүг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл зургаан сарын хугацаанд зогсоосон.

“Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль нь 2022 оны 1 дүгээр сарын 31-нд нэмэлт өөрчлөлт орж Банк дотоодын банкуудад олгосон орон сууцны зээлийн санхүүжилтийн төлбөрийг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд зогсоосон. Үүнийг зээлийн гэрээний өөрчлөлт гэж тооцох ба удирдлага холбогдох зээлийн төлбөр зогсоосон хугацаанд хүлээх алдагдлыг тооцоолж, санхүүгийн тайланд материаллаг нөлөөгүй гэж үзсэн. Тиймээс, зээлийн дансны дүнд тохируулага хийгээгүй болно.

### Бусад зээл

**Төгрөгөөр олгосон зээл.** Бусад зээлийн нэг хэсэг болох төгрөгөөр олгосон зээлд АХБ-ны дэмжлэгтэйгээр дотоодын банкуудад олгосон 1,811 сая төгрөгийн (2020 онд 2,350 сая төгрөг) зээл, Герман Улсын засгийн газрын (КФВ) дэмжлэгтэйгээр дотоодын банкуудад олгосон 8,358 сая төгрөгийн (2020 онд 11,944 сая төгрөг) зээл, Алт-2 үндэсний хөтөлбөрийн хүрээнд банкуудад олгосон 347,640 сая төгрөгийн (2020: 72,828 сая төг) зээл багтаж байгаа бөгөөд барьцаат зээлийн төрлөөр 14,318 сая төгрөгийн зээл (2020: 6,100 сая төг), шатахууны үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд 2021 онд 297,005 сая төгрөгийн зээлийг олгосон байна.

АХБ-ны зээлийг ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор дотоодын банкуудаар дамжуулан олгосон. АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төсөлтэй холбоотой зээл нь үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэ ажлын байрыг бий болгох зорилготой. Зээл нь жилийн 7 хувь (2020 онд жилийн 7 хувь)-ийн хүүтэй байна. 2022 онд эргэн төлөгдөх хугацаа нь болсон зээлүүдийн хувьд эргэн төлөлтийн хугацаа олгосон өдрөөс хамаарч ялгаатай байгаа болно.

Монгол Улсын жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор дотоодын банкуудаар дамжуулан олгосон зээл нь КФВ-ын I болон II хөтөлбөрүүдээр дамжин хэрэгждэг. Зээлийн гэрээний дагуу Банк зээлийн төлөх хугацаа болмогц тухайн дотоодын банкны Монголбанкн дахь данснаас хөрөнгийг шууд татах эрхтэй бөгөөд эргэн төлөлийн хугацаа 2022 оноос 2025 онуудын хооронд байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 167 дугаар тогтоолоор баталсан “Алт-2 үндэсний хөтөлбөр”, 2020 онд батлагдсан Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Монгол Улсын Их хурлын 2020 оны 32 дугаар тогтоолын хүрээнд Банк нь гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор алт олборлогч аж ахуй нэгжүүдэд дотоодын банкуудаар дамжуулан эргэлтийн хөрөнгийн зээлийг олгосон. Зээлийн хүү нь бодлогын хүү дээр 3 хувийг нэмсэнтэй тэнцүү бөгөөд хугацааны хувьд 24-36 сар байна. Санхүүжилтийн гэрээний дагуу Банк зээлийн төлөх хугацаа болмогц тухайн дотоодын банкны Монголбанкн дахь данснаас хөрөнгийг шууд татах эрхтэй.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

“Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль” батлагдсантай холбогдуулан 2021 оны 12 дугаар сараас эхлэн банк шатахууны үнийг тогтворжуулах зорилгын хүрээнд банкуудад зээлийг олгож эхэлсэн. Зээлийн хүү нь бодлогын хүүтэй тэнцүү бөгөөд 12 хүртэл сарын хугацаатай. Санхүүжилтийн гэрээний дагуу банк зээлийн төлөх хугацаа болмогц тухайн дотоодын банкны Монголбанкин дахь данснаас хөрөнгийг шууд татах эрхтэй.

**Гадаад валютын зээл.** “Бусад зээл”-ийн нэг хэсэг болох гадаад валютын зээлд банкуудын мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, банкны системийг сайжруулах АХБ-ны хөтөлбөрийн 671 сая төгрөг (2020 онд 738 сая төгрөг)-ийн зээл бүрдүүлж байна.

Дотоодын банкны ажилтнуудын ур чадварыг дээшлүүлж, банкуудын програм хангамжийг сайжруулах зорилготой зээлийг Монгол Улс болон Азийн хөгжлийн банкны хооронд байгуулагдсан гэрээний дагуу “Ди-Эй-Ай” (Тайланд) Лимитед компанийн зохион байгуулсан сургалтыг санхүүжүүлэх зорилгоор олгосон. Энэхүү зээл 14 жилийн хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй.

Монголын томоохон банкуудын олон улсын үнэлгээний агентлагуудаарх үнэлгээг Тодруулга 32-аас харна уу. Үнэлгээ хийгдээгүй Монголын дотоодын банкуудын хувьд Банк холбогдох арилжааны банкны хөрөнгийн зээлийн чанарыг сүүлийн үеийн санхүүгийн мэдээлэл, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, болон холбогдох бусад мэдээлэлд үндэслэн үнэлдэг.

Дотоодын банкуудын зээлийн алдаглын санг хүлээн зөвшөөрч, бүртгэхэд олон хүчин зүйл нөлөөлдөг бөгөөд хүлээгдэж буй зээлийн алдагдлын дэлгэрэнгүйг тодруулга 32-с харна уу. Хүснэгтийн гол өөрчлөлтүүдийг харуулбал:

- Шатлал 1, 2 болон 3-ын хооронд шилжүүлэхэд зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн (буурсан) тохиолдолд ангилал ахиулаж (бууруулах) бүртгэх бөгөөд 12 сарын ХЗА-аас нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдаглын дүнгээр хэмжинэ.
- Шинэ санхүүгийн хэрэгслийг бүртгэх болон үл хүлээн зөвшөөрөхөд байгуулсан нэмэлт ХЗА.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дараах хүснэгтэд өмнөх болон тайлант хугацааны зээлийн дансны үнэ болон түүнд байгуулсан ХЗА-ын өөрчлөлтийг харуулав. 2021 оны банкуудад олгосон бусад зээлийн үлдэгдэлд байгуулсан зээлийн эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлтийг доор харуулав:

|                                                                | Зээлийн эрсдэлийн алдагдлын сан            |                                            |                                        |                | Нийт дансны үнэ                            |                                            |                                        |                  |
|----------------------------------------------------------------|--------------------------------------------|--------------------------------------------|----------------------------------------|----------------|--------------------------------------------|--------------------------------------------|----------------------------------------|------------------|
|                                                                | Шатлал1<br>(12-сарын<br>хугацаатай<br>ХЗА) | Шатлал 2<br>(Нийт<br>хуцгаанд<br>ХЗА ЗЭМӨ) | Шатлал 3<br>(Нийт<br>хугацаанд<br>ХЗА) | Нийт           | Шатлал1<br>(12-сарын<br>хугацаатай<br>ХЗА) | Шатлал 2<br>(Нийт<br>хуцгаанд<br>ХЗА ЗЭМӨ) | Шатлал 3<br>(Нийт<br>хугацаанд<br>ХЗА) | Нийт             |
| <i>Сая төгрөгөөр</i>                                           |                                            |                                            |                                        |                |                                            |                                            |                                        |                  |
| <b>2020 оны 12 дугаар сарын 31</b>                             | <b>8,707</b>                               | <b>-</b>                                   | <b>7,738</b>                           | <b>16,445</b>  | <b>458,819</b>                             | <b>6,100</b>                               | <b>12,840</b>                          | <b>477,759</b>   |
| <i>Тайлант хугацааны Эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлт:</i> |                                            |                                            |                                        |                |                                            |                                            |                                        |                  |
| Шилжилт:                                                       |                                            |                                            |                                        |                |                                            |                                            |                                        |                  |
| - Нийт хугацаанд (Шатлал 1-аас Шатлал 2-руу)                   | (1,943)                                    | 1,943                                      | -                                      | -              | (14,313)                                   | 14,313                                     | -                                      | -                |
| - Үнэ цэнийн бууралт (Шатлал1 болон Шатлал 2-оос Шатлал 3 руу) | -                                          | -                                          | -                                      | -              | -                                          | (6,100)                                    | 6,100*                                 | -                |
| Шинээр бүртгэсэн болон худалдан авсан                          | 15,135                                     | -                                          | -                                      | <b>15,135</b>  | 1,255,189                                  | -                                          | -                                      | <b>1,255,189</b> |
| ХЗА-ын өөрчлөлт                                                | -                                          | 5,102                                      | -                                      | <b>5,102</b>   | -                                          | -                                          | -                                      | -                |
| Тайлант хугацаанд бүртгэлээс хассан                            | (1,811)                                    | -                                          | -                                      | <b>(1,811)</b> | (210,363)                                  | -                                          | (6,100)                                | <b>(216,463)</b> |
| Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт                                 | -                                          | -                                          | -                                      | -              | 5,691                                      | 3                                          | -                                      | <b>5,694</b>     |
| <b>Эрсдэлийн алдагдлын сангийн нийт өөрчлөлт</b>               | <b>11,381</b>                              | <b>7,045</b>                               | <b>-</b>                               | <b>18,426</b>  | <b>1,036,204</b>                           | <b>8,216</b>                               | <b>-</b>                               | <b>1,044,420</b> |
| <b>2021 оны 12 дугаар сарын 31</b>                             | <b>20,088</b>                              | <b>7,045</b>                               | <b>7,738</b>                           | <b>34,871</b>  | <b>1,495,023</b>                           | <b>14,316</b>                              | <b>12,840</b>                          | <b>1,522,179</b> |

\*Шатлал 3 дээр буй зээлүүд нь хангалттай барьцаатай.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгтэд 2020 оны зээлийн эрсдэлийн алдагдлын сангийн жилийн хөдөлгөөнийг харуулав:

|                                                                | Зээлийн эрсдэлийн алдагдлын сан             |                                            |                                        |              | Нийт дансны үнэ                             |                                            |                                        |               |
|----------------------------------------------------------------|---------------------------------------------|--------------------------------------------|----------------------------------------|--------------|---------------------------------------------|--------------------------------------------|----------------------------------------|---------------|
|                                                                | Шатлал 1<br>(12-сарын<br>хугацаатай<br>ХЗА) | Шатлал 2<br>(Нийт<br>хуцгаанд<br>ХЗА ЗЭМӨ) | Шатлал 3<br>(Нийт<br>хугацаанд<br>ХЗА) | Нийт         | Шатлал 1<br>(12-сарын<br>хугацаатай<br>ХЗА) | Шатлал 2<br>(Нийт<br>хуцгаанд<br>ХЗА ЗЭМӨ) | Шатлал 3<br>(Нийт<br>хугацаанд<br>ХЗА) | Нийт          |
| <i>Сая төгрөгөөр</i>                                           |                                             |                                            |                                        |              |                                             |                                            |                                        |               |
| 2019 оны 12 дугаар сарын 31                                    | 3,059                                       | -                                          | 4,707                                  | 7,766        | 437,453                                     | -                                          | 13,231                                 | 450,684       |
| <i>Тайлант хугацааны Эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлт:</i> |                                             |                                            |                                        |              |                                             |                                            |                                        |               |
| Шилжилт:                                                       |                                             |                                            |                                        |              |                                             |                                            |                                        |               |
| - Нийт хугацаанд<br>(Шатлал 1-ээс<br>Шатлал 2)                 | -                                           | -                                          | -                                      | -            | (6,100)                                     | 6,100*                                     | -                                      | -             |
| Шинээр худалдан<br>авсан                                       | 12,319                                      | -                                          | -                                      | 12,319       | 288,675                                     | -                                          | -                                      | 288,675       |
| Бүртгэлээс хассан                                              | (6,671)                                     | -                                          | -                                      | (6,671)      | (261,261)                                   | -                                          | (339)                                  | (261,600)     |
| ХЗА -ын өөрчлөлт                                               | -                                           | -                                          | 3,031                                  | 3,031        | -                                           | -                                          | -                                      | -             |
| <b>Эрсдэлийн<br/>алдагдлын сангийн<br/>нийт өөрчлөлт</b>       | <b>5,648</b>                                | <b>-</b>                                   | <b>3,031</b>                           | <b>8,679</b> | <b>21,314</b>                               | <b>6,100</b>                               | <b>(339)</b>                           | <b>27,075</b> |
| 2020 оны 12 дугаар сарын 31                                    | 8,707                                       | -                                          | 7,738                                  | 16,445       | 458,767                                     | 6,100                                      | 12,892                                 | 477,759       |

\*\*Шатлал 2 дээр буй зээлүүд нь хангалттай барьцаатай.

2021 оны 12 дугаар сарын 31-нээрх зээлд тооцогдох зээлийн эрсдэлийн үнэлгээний системийн дагуух зээлийн эрсдэлийн чанарыг доорх хүснэгтэд харуулав.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

| Сая төгрөгөөр                          | Шатлал 1 (12-сарын хугацаатай ХЗА) | Шатлал 2 (Нийт хугацаанд ХЗА ЗЭМӨ) | Шатлал 3 (Нийт хугацаанд ХЗА) | Нийт             |
|----------------------------------------|------------------------------------|------------------------------------|-------------------------------|------------------|
| <i>Дотоодын банкуудад олгосон зээл</i> |                                    |                                    |                               |                  |
| - Сайн                                 | 1,495,023                          | -                                  | -                             | 1,495,023        |
| - Хангалттай                           | -                                  | 14,316                             | -                             | 14,316           |
| - Дефолт                               | -                                  | -                                  | 12,840                        | 12,840           |
| <b>Нийт дансны үнэ</b>                 | <b>1,495,023</b>                   | <b>14,316</b>                      | <b>12,840</b>                 | <b>1,522,179</b> |
| Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан      | (20,088)                           | (1,943)                            | (12,840)                      | (34,871)         |
| <b>Дансны үнэ</b>                      | <b>1,474,935</b>                   | <b>12,373</b>                      | <b>-</b>                      | <b>1,407,308</b> |

2020 оны 12 дугаар сарын 31-нээрх зээлд тооцогдох зээлийн эрсдэлийн үнэлгээний системийн дагуух зээлийн эрсдэлийн чанарыг доорх хүснэгтэд харуулав.

| Сая төгрөгөөр                     | Шатлал 1 (12-сарын хугацаатай ХЗА) | Шатлал 2 (Нийт хугацаанд ХЗА ЗЭМӨ) | Шатлал 3 (Нийт хугацаанд ХЗА) | Нийт           |
|-----------------------------------|------------------------------------|------------------------------------|-------------------------------|----------------|
| <i>Банкуудад олгосон зээл</i>     |                                    |                                    |                               |                |
| - Сайн                            | 458,767                            | -                                  | -                             | 464,867        |
| - Хангалттай                      | -                                  | 6,100                              | -                             | 6,100          |
| - Дефолт                          | -                                  | -                                  | 12,892                        | 12,892         |
| <b>Нийт дансны үнэ</b>            | <b>458,767</b>                     | <b>6,100</b>                       | <b>12,892</b>                 | <b>477,759</b> |
| Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан | (8,707)                            | -                                  | (7,738)                       | (16,445)       |
| <b>Дансны үнэ</b>                 | <b>450,060</b>                     | <b>6,100</b>                       | <b>5,154</b>                  | <b>461,314</b> |

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх дээрх зээлүүд нь барьцаагүй болно. 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх хэвийн зээлээр барьцаалагдсан барьцаат зээлийн дүн 13,670 сая төгрөг байна.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 10. ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

| Сая төгрөгөөр                                    | 2021 оны 12 дугаар сарын 31 | 2020 оны 12 дугаар сарын 31 |
|--------------------------------------------------|-----------------------------|-----------------------------|
| БҮЦӨБДО-оорх өрийн үнэт цаас                     | 3,080,813                   | 2,350,220                   |
| ХӨБ өрийн үнэт цаас                              | 3,313,009                   | 2,924,909                   |
| <b>Нийт өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт</b> | <b>6,393,822</b>            | <b>5,275,129</b>            |

Доорх хүснэгтэд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх Өрийн үнэт цаасыг ангилалаар нь харуулав.

| Сая төгрөгөөр                                                                         | БҮЦӨБДО-оорх өрийн үнэт цаас | ХӨБ өрийн үнэт цаас | Нийт             |
|---------------------------------------------------------------------------------------|------------------------------|---------------------|------------------|
| <b>Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт:</b>                                          |                              |                     |                  |
| Олон улсын төлбөр тооцооны банкны гаргасан бонд                                       | 1,647,228                    | -                   | 1,647,228        |
| РАМПИ хөрөнгө оруулалтын данс                                                         | 928,574                      | -                   | 928,574          |
| АНУ-ын засгийн газрын үнэт цаас                                                       | 244,529                      | -                   | 244,529          |
| Олон улсын төлбөр тооцооны банкинд оруулсан хөрөнгө оруулалт                          | 146,463                      | -                   | 146,463          |
| Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны бонд                                      | 52,694                       | -                   | 52,694           |
| КФВ-ны бонд                                                                           | 30,085                       | -                   | 30,085           |
| Хятадын засгийн газрын бонд                                                           | 22,670                       | -                   | 22,670           |
| Европын хөрөнгө оруулалтын банкны бонд                                                | 8,570                        | -                   | 8,570            |
| Давуу эрхтэй ИЗББ                                                                     | -                            | 2,203,680           | 2,203,680        |
| Эрдэнэс бонд                                                                          | -                            | 780,615             | 780,615          |
| Эрдэнэс таван толгой бонд                                                             | -                            | 320,045             | 320,045          |
| Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бонд                                                 | -                            | 101,556             | 101,556          |
| <b>2021 оны 12 дугаар сарын 31 байдлаарх нийт өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт</b>  | <b>3,080,813</b>             | <b>3,405,896</b>    | <b>6,486,709</b> |
| Эрсдэлийн алдагдлын сан                                                               | -                            | (92,887)            | (92,887)         |
| <b>2021 оны 12 дугаар сарын 31 байдлаарх цэвэр өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт</b> | <b>3,080,813</b>             | <b>3,313,009</b>    | <b>6,393,822</b> |



## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 10. ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгтэд 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх Өрийн үнэт цаасыг ангилалаар нь харуулав.

| Сая төгрөгөөр                                                                         | БҮЦӨБДО-оорх<br>өрийн үнэт цаас | ХӨБ өрийн үнэт<br>цаас | Нийт             |
|---------------------------------------------------------------------------------------|---------------------------------|------------------------|------------------|
| <b>Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт:</b>                                          |                                 |                        |                  |
| РАМП хөрөнгө оруулалтын данс                                                          | 930,566                         | -                      | 930,566          |
| Олон улсын төлбөр тооцооны банкны гаргасан бонд                                       | 898,352                         | -                      | 898,352          |
| АНУ-ын засгийн газрын үнэт цаас                                                       | 278,804                         | -                      | 278,804          |
| Олон улсын төлбөр тооцооны банкинд оруулсан хөрөнгө оруулалт                          | 146,569                         | -                      | 146,569          |
| Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны бонд                                      | 47,800                          | -                      | 47,800           |
| КФВ-ны бонд                                                                           | 30,554                          | -                      | 30,554           |
| Европын хөрөнгө оруулалтын банкны бонд                                                | 17,575                          | -                      | 17,575           |
| Давуу эрхтэй ИЗББ                                                                     | -                               | 2,324,824              | 2,324,824        |
| Эрдэнэс бонд                                                                          | -                               | 547,155                | 547,155          |
| Хөгжлийн банкны үнэт цаас                                                             | -                               | 55,650                 | 55,650           |
| Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бонд                                                 | -                               | 34,694                 | 34,694           |
| <b>2020 оны 12 дугаар сарын 31 байдлаарх нийт өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт</b>  | <b>2,350,220</b>                | <b>2,962,323</b>       | <b>5,312,543</b> |
| Эрсдэлийн алдагдлын сан                                                               | -                               | (37,414)               | (37,414)         |
| <b>2020 оны 12 дугаар сарын 31 байдлаарх цэвэр өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт</b> | <b>2,350,220</b>                | <b>2,924,909</b>       | <b>5,275,129</b> |

## (а) БҮЦӨБДО-д бүртгэгдэх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт

1 дүгээр шатлалд БҮЦХӨБДОТ бүртгэх өрийн үнэт цаасууд багтдаг бөгөөд зээлийн эрсдэлийн үнэлгээний дагуу онц сайн гэсэн үнэлгээтэй байна. Тодруулга 32-т банкны эрсдэлийн үнэлгээний систем, ХЗА хэмжигдэхүүн болон БҮЦХӨБДОТ-оор бүртгэх үнэт цаасанд баримтлах ЗЭМӨ болон төлбөрийн чадваргүй байдлын тодорхойлолтыг тусгасан.

**Олон улсын төлбөр тооцооны банкны (ОУТТБ) бонд.** Өрийн үнэт цаас ба бондын зах зээлийн үнэд тулгуурласан бодит үнэ цэнээр хэмжигддэг. Бондууд нь 1,647,228 сая төгрөгийн дансны үнэтэй (2020: 893,532 сая төгрөг). Уг бондын хугацаа нь 30-аас 94 хоног (2020: 117 хоног) ба жилийн 0.1-2.96% (2020: жилийн 0.1-2.4%) хүүний өгөөжтэй. Банк эдгээр ОУТТБ-ын бондыг өндөр нэр хүндтэй, бага эрсдэлтэй гэж үзэж хөрөнгө оруулсан. Дэлгэрэнгүй мэдээллийг тодруулга 32-оос харна уу.

**“Рамп” Хөрөнгө оруулалтын данс.** Гадаад валютын нөөцийн удирдлагыг сайжруулах зорилгоор Монголбанк нь Дэлхийн банкны “Нөөцийн удирдлагыг сайжруулах зөвлөгөө ба нөөцийн удирдлага” төслийг 2011 оноос хэрэгжүүлсэн.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 10. ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хөрөнгө оруулалтын дансны үнэ нь 0.3 сая ам.доллар буюу 917 сая төгрөг (2020 онд 0.3 сая ам.доллар буюу 956 сая төгрөг) бүхий мөнгөн хөрөнгө, 326 сая ам.доллар буюу 927,657 сая төгрөг (2020 онд 326 сая ам.доллар буюу 929,610 сая төгрөг)-ийн үнэт цааснаас бүрдэж байна. Хөрөнгө оруулалтын дансыг АНУ-ын Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкинд байршуулсан.

Хөрөнгө оруулалтын дансны дийлэнх хэсгийг АНУ-ын засгийн газрын үнэт цаас болон бусад засгийн газраас гаргасан үнэт цаас эзэлдэг. Хөрөнгө оруулалтын данс дахь өрийн үнэт цаасны зээлийн эрсдэлийн чанарыг Стандарт энд Пүүрс болон Мүүдийсийн рейтингээр үнэлэхэд Аа3-аас Ааа зэрэглэлтэй буюу Онц сайн байсан. Дэлгэрэнгүй мэдээллийг тодруулга 32-с харна уу.

**АНУ-ын Засгийн газрын үнэт цаас** Бондын дансны үнэ нь 85.9 сая ам.доллар буюу 244,607 сая төгрөг (2020 онд 97.9 сая ам.доллар буюу 279,071 сая төгрөг) байна. Уг бондын хугацаа нь 1-ээс 3 жил (2020: 1-с 3 жил) ба жилийн 0.13%- 2% (2020: жилийн 1.125% -2.75%) хүүний өгөөжтэй. Эдгээр бондууд нь барьцаагүй. Дэлгэрэнгүй мэдээллийн Тодруулга 32-оос харна уу.

**Олон улсын төлбөр тооцооны банкны (ОУТТБ) хөрөнгө оруулалт.** Гадаад валютын нөөцийн удирдлагыг сайжруулах зорилгоор Монголбанк нь ОУТТБ-тай Нөөцийн удирдлагыг сайжруулах зөвлөгөө ба нөөцийн удирдлагын төслийг 2019 оноос хэрэгжүүлсэн. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хөрөнгө оруулалтын дансны үнэ нь 51.4 сая ам.доллар буюу 146,463 сая төгрөг (2020: 51 сая ам.доллар буюу 146,569 сая төгрөг) байна.

Хөрөнгө оруулалтын данс дахь өрийн үнэт цаасны зээлийн эрсдэлийн чанарыг Стандарт энд Пүүрс болон Мүүдийсийн рейтингээр үнэлэхэд Аа3-аас Ааа зэрэглэлтэй буюу онц сайн байсан. Дэлгэрэнгүй мэдээллийг тодруулга 32-с харна уу. 2021 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн ОУТТБ-тай байгуулсан санхүүжилтийн гэрээний дагуу Банк нь ОУТТБ-ын хөрөнгө оруулалтыг барьцаалж ОУТТБ-аас 43 сая ам.долларын санхүүжилт авсан. ОУТТБ -ийн санхүүжилтийн дэлгэрэнгүйг Тодруулга 23-аас үзнэ үү.

**Европын сэргээн босголтын банкнаас гаргасан бонд.** Банк Европын сэргээн босголтын банкнаас гаргасан ам.доллараарх бондод хөрөнгө оруулсан. Бондын дансны үнэ нь 18.5 сая ам.доллар буюу 52,703 сая төгрөг (2020 онд 18.5 сая ам.доллар буюу 47,864 сая төгрөг) байна. Бонд нь 3-аас 5 жил хүртэлх хугацаатай (2020 он 3 жил) ба дундаж жилийн хүү нь 0.1%-2.13% (2020: жилийн 0.1%-2.13%) байна. Эдгээр бондууд нь барьцаагүй.

**КФВ-ны бонд.** Бондын дансны үнэ нь 10.7 сая ам доллар буюу 30,097 сая төгрөг (2020: 10.7 сая ам доллар буюу 30,642 сая төгрөг) байна. Бондын дуусах хугацаа нь 3 жил (2020 он 3 жил) ба жилийн хүү нь 1.38% (2020: жилийн 1.38%) байна. Эдгээр бондууд нь барьцаагүй бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг тодруулга 32-оос харна уу.

**Хятадын засгийн газрын бонд.** Банк нь 2021 онд Хятадын ардын банкнаас гаргасан юанийн Хятадын засгийн газрын бондод хөрөнгө оруулалт хийсэн. Бондын дансны үнэ нь 50.7 сая юань буюу 22,681 сая төгрөг (2020 онд тэг) байна. Бонд нь 1 жилийн хугацаатай ба жилийн 2.24% хувийн хүүний өгөөжтэй. Эдгээр бондууд нь барьцаагүй. Дэлгэрэнгүй мэдээллийг тодруулга 32-оос харна уу.

**Европын хөрөнгө оруулалтын банкны бонд.** Бондын дансны үнэ нь 3 сая ам.доллар буюу 8,572 сая төгрөг (2020: 6 сая ам.доллар буюу 17,578 сая төгрөг) байна. Бондын дуусах хугацаа нь 3 жил (2020: 3 жил ) ба жилийн 1.75% (2020: жилийн 1.75%) хүүгийн өгөөжтэй. Эдгээр бондууд нь барьцаагүй. Дэлгэрэнгүй мэдээллийг тодруулга 32-оос харна уу.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 10. ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

БҮЦӨБДО-д бүртгэгдэх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтанд байгуулсан эрсдэлийн алдагдлын сангийн хөдөлгөөнийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доорх хүснэгтэд харуулав.

| <i>Сая төгрөгөөр</i>                                      | Эрсдэлийн алдагдлын сан            |              | Нийт дансны үнэ                    |                  |
|-----------------------------------------------------------|------------------------------------|--------------|------------------------------------|------------------|
|                                                           | Шатлал 1 (12-сарын хугацаатай ХЗА) | Нийт         | Шатлал 1 (12-сарын хугацаатай ХЗА) | Нийт             |
| БҮЦӨБДО-д бүртгэгдэх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт |                                    |              |                                    |                  |
| <b>2020 оны 12 дугаар сарын 31</b>                        | <b>421</b>                         | <b>421</b>   | <b>2,350,641</b>                   | <b>2,350,641</b> |
| <i>Эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлт</i>               |                                    |              |                                    |                  |
| Шинээр худалдан авсан                                     | 72                                 | 72           | 4,986,979                          | 4,986,979        |
| Бүртгэлээс хассан                                         | (380)                              | (380)        | (4,262,051)                        | (4,262,051)      |
| Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт                            | -                                  | -            | 99                                 | 99               |
| Бусад өөрчлөлт                                            | -                                  | -            | (589)                              | (589)            |
| <b>Нийт эрсдэлийн алдагдлын сангийн хөдөлгөөн</b>         | <b>(308)</b>                       | <b>(308)</b> | <b>724,438</b>                     | <b>724,438</b>   |
| <i>Эрсдэлийн алдагдлын сангаас бусад хөдөлгөөн:</i>       |                                    |              |                                    |                  |
| Ханшийн болон бусад хөдөлгөөн                             | -                                  | -            | 5,847                              | 5,847            |
| <b>2021 оны 12 дугаар сарын 31</b>                        | <b>113</b>                         | <b>113</b>   | <b>3,080,926</b>                   | <b>3,080,926</b> |

БҮЦӨБДО-д бүртгэгдэх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтанд байгуулсан эрсдэлийн алдагдлын сангийн хөдөлгөөнийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доорх хүснэгтэд харуулав.

| <i>Сая төгрөгөөр</i>                                      | Эрсдэлийн алдагдлын сан            |            | Нийт дансны үнэ                    |                  |
|-----------------------------------------------------------|------------------------------------|------------|------------------------------------|------------------|
|                                                           | Шатлал 1 (12-сарын хугацаатай ХЗА) | Нийт       | Шатлал 1 (12-сарын хугацаатай ХЗА) | Нийт             |
| БҮЦӨБДО-д бүртгэгдэх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт |                                    |            |                                    |                  |
| <b>2019 оны 12 дугаар сарын 31</b>                        | <b>80</b>                          | <b>80</b>  | <b>1,449,923</b>                   | <b>1,449,923</b> |
| <i>Эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлт</i>               |                                    |            |                                    |                  |
| Шинээр худалдан авсан                                     | 381                                | 381        | 1,590,147                          | 1,590,147        |
| Бүртгэлээс хассан                                         | (40)                               | (40)       | (758,933)                          | (758,933)        |
| Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт                            | -                                  | -          | 2,478                              | 2,478            |
| Бусад өөрчлөлт                                            | -                                  | -          | 4,854                              | 4,854            |
| <b>Нийт эрсдэлийн алдагдлын сангийн хөдөлгөөн</b>         | <b>341</b>                         | <b>341</b> | <b>838,546</b>                     | <b>838,546</b>   |
| <i>Эрсдэлийн алдагдлын сангаас бусад хөдөлгөөн:</i>       |                                    |            |                                    |                  |
| Ханшийн болон бусад хөдөлгөөн                             | -                                  | -          | 62,172                             | 62,172           |
| <b>2020 оны 12 дугаар сарын 31</b>                        | <b>421</b>                         | <b>421</b> | <b>2,350,641</b>                   | <b>2,350,641</b> |

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 10. ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

## (а) Хорогдуулсан өртгөөрх өрийн үнэт цаас

**Давуу эрхтэй ИЗББ.** МИК-ийн охин компаниудын гаргасан давуу эрхтэй ипотекийн зээлээр баталгаажсан бонд (Давуу эрхтэй ИЗББ). Банк нь 2013 оны 6 дугаар сарын 13-ны өдөр МИК болон дотоодын банкуудтай гурван талт “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г байгуулсан. 2016 оноос эхлэн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан ба Монгол Улсын засгийн газар гэрээнд оролцогч тал болсон. Уг гэрээний хүрээнд Банк дотоодын банкуудад олгосон бага хүүтэй зээлийн төлбөрт МИК-иас гаргасан давуу эрхтэй ИЗББ-ыг хүлээн авсан, энэ талаар Тодруулга 9-өөс харна уу. Тус бонд нь 30 хүртэлх жилийн хугацаатай, жилийн 1% болон 4.5% хүүтэй.

**Эрдэнэс бонд.** 2020 оны 1 дүгээр сард батлагдсан “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай” хуулийн дагуу төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК тус бүр нь 1 сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, жилийн 6% хүүтэй, 5 жилийн хугацаатай, 929,861 ширхэг бонд (цаашид “Эрдэнэс бонд”) гаргаж, уг бондоор дотоодын банкуудын шалгуур хангаж буй тэтгэвэр барьцаалсан зээлийн үлдэгдлийг төрөөс хаасан ба Монголбанк дотоодын банкуудаас энэхүү бондыг худалдан авах үүрэг хүлээсэн.

Уг бондын эргэн төлөлт төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компанийн эзэмшлийн Салхитын мөнгө, алтны ордын орлогоос төлөгдөнө. “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай” хуулийн дагуу Монгол Улсын Хөгжлийн Банк нь 550 тэрбум төгрөгийн баталгааг бие даан гаргасан. Эрдэнэс бондыг эзэмшсэнээр Монголбанкны өөрийн хөрөнгө буурсан тохиолдолд Засгийн газар үнэт цаас гаргах замаар нөхөн төлнө.

**Эрдэнэс Таван Толгой бонд.** “Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль 2020 онд батлагдсантай холбогдуулан эдийн засгийн чухал салбаруудыг дэмжих зорилгоор нэрлэсэн үнэ нь 100,000 төгрөгийн 3,110,000 ширхэг, жилийн 10%-ийн хүүтэй 2 жилийн хугацаатай Эрдэнэс Таван Толгой ХХК-ийн гаргасан бондыг банк худалдан авсан.

**Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бонд.** 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн төрийн болон тусгай албан хаагчдыг орон сууцжуулах хөтөлбөртэй холбоотойгоор Банк “Нийслэлийн орон сууцны корпораци (НОСК)” ХК-аас гаргасан түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондуудыг худалдан авсан. Банк нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий жилийн 8% болон 6% ын хүүтэй (2020: жилийн 8%), 15 жилийн хугацаатай 983,162 ширхэг (2020: 343,556) бондыг худалдан авсан. Уг бонд нь НОСК ХК-ийн эзэмшилд байгаа түрээсийн орон сууцнаас олох түрээсийн төлбөр болон орон сууцны барилгаар баталгаажсан.

**Хөгжлийн банкны үнэт цаас.** 2015 оны 9 дүгээр сарын 23 ны өдөр Банк Хөгжлийн банкны гаргасан зах зээлийн хүүгээс доогуур хүү болох жилийн 4%-ын хүүтэй 60,000 сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 6 жилийн хугацаатай үнэт цаасыг худалдан авсан. Эдгээр үнэт цаасны анхны хүлээн зөвшөөрөлтийн үнэлгээ нь 31,397 сая төгрөг байсан. 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд Хөгжлийн банкны үнэт цаасны нэрлэсэн үнэ болон зах зээлийн үнийн зөрүү болох 28,603 төгрөгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдлаар бүртгэсэн. Хүүгийн төлбөр хагас жил тутам хийгддэг. 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үнэт цаасны нэрлэсэн үнэ 55,650 сая төгрөг байсан, 2021 онд бүрэн төлөгдөж дууссан.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 10. ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

ХЗА-ын үнэлгээгээр ХӨБ хөрөнгө оруулалт нь санхүүгийн тайланд 1 дүгээр түвшинд буюу сайн зээлийн чанарын үнэлгээтэй байна. Тодруулга 32-т банкны эрсдэлийн алдагдлын сан болон, хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн үнэт цаасан дахь зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өөрчлөлтийг харуулав.

Хорогдуулсан өртгөөрх өрийн үнэт цаасанд байгуулсан эрсдэлийн алдагдлын сангийн хөдөлгөөнийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доорх хүснэгтэд харуулав.

| Сая төгрөгөөр                                                                   | Эрсдэлийн алдагдлын сан |               | Нийт дансны үнэ    |                  |
|---------------------------------------------------------------------------------|-------------------------|---------------|--------------------|------------------|
|                                                                                 | Шатлал 1 (12- ХЗА)      | Нийт          | Шатлал 1 (12- ХЗА) | Нийт             |
| <b>2020 оны 12 дугаар сарын 31</b>                                              | <b>37,414</b>           | <b>37,414</b> | <b>2,962,323</b>   | <b>2,962,323</b> |
| <i>Эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлт:</i>                                    |                         |               |                    |                  |
| Шинээр худалдан авсан                                                           | 43,873                  | 43,873        | 791,994            | 791,994          |
| Бүртгэлээс хассан                                                               | (4,903)                 | (4,903)       | (342,890)          | (342,890)        |
| Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилтийн загварын таамаглалд орсон өөрчлөлт | 16,503                  | 16,503        | -                  | -                |
| Бусад хөдөлгөөн                                                                 | -                       | -             | (5,531)            | (5,531)          |
| <b>Нийт эрсдэлийн алдагдлын сангийн хөдөлгөөн</b>                               | <b>55,473</b>           | <b>55,473</b> | <b>443,573</b>     | <b>443,573</b>   |
| <b>2021 оны 12 дугаар сарын 31</b>                                              | <b>92,887</b>           | <b>92,887</b> | <b>3,405,896</b>   | <b>3,405,896</b> |

Хорогдуулсан өртгөөрх өрийн үнэт цаасанд байгуулсан эрсдэлийн алдагдлын сангийн хөдөлгөөнийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доорх хүснэгтэд харуулав.

| Сая төгрөгөөр                                     | Эрсдэлийн алдагдлын сан |               | Нийт дансны үнэ    |                  |
|---------------------------------------------------|-------------------------|---------------|--------------------|------------------|
|                                                   | Шатлал 1 (12- ХЗА)      | Нийт          | Шатлал 1 (12- ХЗА) | Нийт             |
| <b>2019 оны 12 дугаар сарын 31</b>                | <b>6,627</b>            | <b>6,627</b>  | <b>2,436,048</b>   | <b>2,436,048</b> |
| <i>Эрсдэлийн алдагдлын сангийн өөрчлөлт:</i>      |                         |               |                    |                  |
| Шинээр худалдан авсан                             | 34,010                  | 34,010        | 1,714,725          | 1,714,725        |
| Бүртгэлээс хассан                                 | (3,223)                 | (3,223)       | (1,044,900)        | (1,044,900)      |
| Бусад хөдөлгөөн                                   | -                       | -             | (143,550)          | (143,550)        |
| <b>Нийт эрсдэлийн алдагдлын сангийн хөдөлгөөн</b> | <b>30,787</b>           | <b>30,787</b> | <b>526,275</b>     | <b>526,275</b>   |
| <b>2020 оны 12 дугаар сарын 31</b>                | <b>37,414</b>           | <b>37,414</b> | <b>2,962,323</b>   | <b>2,962,323</b> |

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 11. ӨМЧИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

| Сая төгрөгөөр                                     | 2021 оны 12 дугаар сарын 31 | 2020 оны 12 дугаар сарын 31 |
|---------------------------------------------------|-----------------------------|-----------------------------|
| <b>БҮЦӨБДО-оорх өмчийн үнэт цаас</b>              | 6,533                       | 6,595                       |
| <b>Нийт өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт</b> | <b>6,533</b>                | <b>6,595</b>                |

**Өмчийн хөрөнгө оруулалт.** Үүнд Олон улсын хөрөнгө оруулалтын банк болон Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банк (2020 онд Олон улсын хөрөнгө оруулалтын банк, Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банк болон Монголын банкны холбоонд оруулсан хөрөнгө оруулалтууд) багтдаг ба бодит үнэ цэнээр нь бүртгэдэг. Удирдлага бодит үнэ цэнийг хөрөнгө оруулалтын өртөгтэй ойролцоо байна гэж үзсэн.

## 12. УРВУУ БУЦААН ХУДАЛДАН АВАХ ХЭЛЦЭЛ

| Сая төгрөгөөр                                                      | 2021 оны 12 дугаар сарын 31 | 2020 оны 12 дугаар сарын 31 |
|--------------------------------------------------------------------|-----------------------------|-----------------------------|
| Нью-Йоркийн Холбооны нөөцийн банк                                  | 3,091,233                   | 4,393,375                   |
| Дотоодын банкууд                                                   | 1,430,989                   | 422,706                     |
| <b>ХӨ-өөрх урвуу буцаан худалдан авах хэлцлийн нийт дансны үнэ</b> | <b>4,522,222</b>            | <b>4,816,081</b>            |
| Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан                                  | (2)                         | (13)                        |
| <b>ХӨ-өөрх урвуу буцаан худалдан авах хэлцлийн дансны үнэ</b>      | <b>4,522,220</b>            | <b>4,816,068</b>            |

**Нью-Йоркийн Холбооны нөөцийн банк.** Банк нь Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкинд байршуулсан хадгаламжтай холбоотойгоор Автомат хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамрагдсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 250,000 ам.доллараас илүү гарсан тохиолдолд давсан дүнгээр Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкны буцаан худалдан авах гэрээ (буцаан худалдан авах репо)-нд хөрөнгө оруулалт хийгддэг.

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр буцаан худалдан авах репо гэрээнд оруулсан хөрөнгө оруулалт нь 1,085.1 сая ам.доллар буюу 3,091,233 сая төгрөг (2020: 1,541.8 сая ам.доллар буюу 4,393,375 сая төгрөг) байна. Энэхүү хөрөнгө оруулалт 1 хоногийн (2020: 4 хоног) хугацаатай бөгөөд жилийн 0-0.5 хувийн (2020: 0%) хүүтэй. Холбогдох хөрөнгө оруулалтыг барьцаагаар баталгаажуулдаг боловч тус хөтөлбөрийн хүрээнд худалдан авсан үнэт цаасыг тодорхойлох боломжүй байдаг.

**Дотоодын банкууд.** Дотоодын банкуудтай байгуулсан “Төгрөгийн” урвуу буцаан худалдан авах хэлцлүүд нь Төв банкны үнэт цаасаар (2020 онд Хөгжлийн банкны үнэт цаас болон Төв банкны үнэт цаас) баталгаажсан урт болон богино хугацаат хэлцлүүдийг илэрхийлдэг.

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дотоодын банкууд дахь төгрөгийн овернайт буцаан худалдан авах хэлцлийн дүн 330,191 сая төгрөг, 4 хоногийн хугацаатай, жилийн 7 хувийн хүүтэй (2020: 129,141 сая төгрөг, 4 хоногийн хугацаатай, жилийн 7 хувийн хүүтэй). Энэ гэрээ нь Төв банкны үнэт цаасаар баталгаажсан.



## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 12. УРВУУ БУЦААН ХУДАЛДАН АВАХ ХЭЛЦЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хөгжлийн банкнаас гаргасан үнэт цаасаар баталгаажсан урвуу буцаан худалдан авах хэлцлийн нэрлэсэн үнэ нь 65,000 сая төгрөг 6 жилийн хугацаатай жилийн 7.5% хүүтэй. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх дансны үнэ нь 62,327 сая төгрөг ба энэхүү хэлцэл нь 2021 онд бүрэн төлөгдөж дууссан. Нэрлэсэн үнэ ба бодит үнэ цэнийн зөрүү болох 23,426 сая төгрөгийг анх хүлээн зөвшөөрөлтийн алдагдлыг 2016 оны ашиг алдагдалын тайланд бүртгэсэн.

2021 оны 12 дугаар сарын 31-наар үлдэж буй дотоодын банктай хийсэн урт хугацаат, төгрөгийн урвуу буцаан худалдан авах хэлцлийн дүн 1,054,984 сая төгрөг (2020: 230,000 сая төгрөг), 2 жилийн хугацаатай, жилийн 6% болон 6.5% хүүтэй (2020 онд 6.5%) ба Төв банкны үнэт цаасаар баталгаажсан. Хэлцлийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх дансны үнэ 1,100,798 сая төгрөг (2020: 231,238 сая төгрөг).

Нью-Йоркийн холбооны нөөцийн банктай байгуулсан хорогдуулсан өртгөөр бүртгэх урвуу буцаан худалдан авах хэлцлийн зээлийн чанарын шинжилгээг 2021 оны 12 дугаар сарын 31 болон 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доорх хүснэгтэд харуулав.

| Сая төгрөгөөр                            | 2021 оны 12 дугаар сарын 31<br>Шатлал 1 (12-сар ХЗА) | 2020 оны 12 дугаар сарын 31<br>Шатлал 1 (12-сар ХЗА) |
|------------------------------------------|------------------------------------------------------|------------------------------------------------------|
| <b>Нью-Йоркийн Холбооны нөөцийн банк</b> |                                                      |                                                      |
| - Онц сайн                               | 3,091,233                                            | 4,393,375                                            |
| <b>Нийт дансны үнэ</b>                   | <b>3,091,233</b>                                     | <b>4,393,375</b>                                     |
| Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан        | (2)                                                  | (13)                                                 |
| <b>Дансны үнэ</b>                        | <b>3,091,231</b>                                     | <b>4,393,362</b>                                     |

Дотоодын банкуудтай байгуулсан хорогдуулсан өртгөөр бүртгэх урвуу буцаан худалдан авах хэлцлийн зээлийн чанарын шинжилгээг 2021 оны 12 дугаар сарын 31 болон 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доорх хүснэгтэд харуулав. Эдгээр хөрөнгө нь төв банкны үнэт цаасаар бүрэн баталгаажсан (2020: Төв банкны үнэт цаас, Хөгжлийн банкны бонд, Засгийн газрын үнэт цаас).

| Сая төгрөгөөр                     | 2021 оны 12 дугаар сарын 31<br>Шатлал 1 (12-сар ХЗА) | 2020 оны 12 дугаар сарын 31<br>Шатлал 1 (12-сар ХЗА) |
|-----------------------------------|------------------------------------------------------|------------------------------------------------------|
| Дотоодын банкууд                  |                                                      |                                                      |
| - Сайн                            | 1,430,989                                            | 422,706                                              |
| <b>Нийт дансны үнэ</b>            | <b>1,430,989</b>                                     | <b>422,706</b>                                       |
| Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан | _*                                                   | _*                                                   |
| <b>Дансны үнэ</b>                 | <b>1,430,989</b>                                     | <b>422,706</b>                                       |

\* Дараах дотоодын банкуудын урвуу буцаан худалдан авах хэлцэл бүрэн барьцаатай.



## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 12. УРВУУ БУЦААН ХУДАЛДАН АВАХ ХЭЛЦЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дараах хүснэгтэд тайлант хугацааны эхний болон эцсийн байдлаар ХӨБ урвуу буцаан худалдан авах хэлцлийн дансны үнэ болон эрсдэлийн алдагдлын санг харуулав:

| Сая төгрөгөөр                                                     | Эрсдэлийн алдагдлын сан  |             | Нийт дансны үнэ          |                  |
|-------------------------------------------------------------------|--------------------------|-------------|--------------------------|------------------|
|                                                                   | Шатлал 1<br>(12-сар ХЗА) | Нийт        | Шатлал 1<br>(12-сар ХЗА) | Нийт             |
| Урвуу буцаан худалдан авах хэлцэл                                 |                          |             |                          |                  |
| <b>2020 оны 12 дугаар сарын 31</b>                                | <b>13</b>                | <b>13</b>   | <b>4,816,081</b>         | <b>4,816,081</b> |
| Тайлант үеийн Эрсдэлийн алдагдлын сан дахь өөрчлөлт:              |                          |             |                          |                  |
| Шинээр худалдан авсан                                             | 2                        | 2           | 654,733,442              | 654,733,442      |
| Тайлант хугацаанд бүртгэлээс хассан                               | (13)                     | (13)        | (655,029,987)            | (655,029,987)    |
| Бусад өөрчлөлт                                                    | -                        | -           | 2,686                    | 2,686            |
| <b>Тайлант үеийн Эрсдэлийн алдагдлын сан дахь өөрчлөлтийн дүн</b> | <b>(11)</b>              | <b>(11)</b> | <b>(293,859)</b>         | <b>(293,859)</b> |
| <b>2021 оны 12 дугаар сарын 31</b>                                | <b>2</b>                 | <b>2</b>    | <b>4,522,222</b>         | <b>4,522,222</b> |

Дараах хүснэгтэд тайлант хугацааны эхний болон эцсийн байдлаар ХӨБ урвуу буцаан худалдан авах хэлцлийн дансны үнэ болон эрсдэлийн алдагдлын санг харуулав:

| Сая төгрөгөөр                                                     | Эрсдэлийн алдагдлын сан  |             | Нийт дансны үнэ          |                    |
|-------------------------------------------------------------------|--------------------------|-------------|--------------------------|--------------------|
|                                                                   | Шатлал 1<br>(12-сар ХЗА) | Нийт        | Шатлал 1<br>(12-сар ХЗА) | Нийт               |
| Урвуу буцаан худалдан авах хэлцэл                                 |                          |             |                          |                    |
| <b>2019 оны 12 дугаар сарын 31</b>                                | <b>74</b>                | <b>74</b>   | <b>3,254,511</b>         | <b>3,254,511</b>   |
| Тайлант үеийн Эрсдэлийн алдагдлын сан дахь өөрчлөлт:              |                          |             |                          |                    |
| Шинээр худалдан авсан                                             | -                        | -           | 763,680,353              | 763,680,353        |
| Тайлант хугацаанд бүртгэлээс хассан                               | (61)                     | (61)        | (762,118,783)            | (762,118,783)      |
| <b>Тайлант үеийн Эрсдэлийн алдагдлын сан дахь өөрчлөлтийн дүн</b> | <b>(61)</b>              | <b>(61)</b> | <b>(1,561,570)</b>       | <b>(1,561,570)</b> |
| <b>2020 оны 12 дугаар сарын 31</b>                                | <b>13</b>                | <b>13</b>   | <b>4,816,081</b>         | <b>4,816,081</b>   |

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 13. АЛТ, ҮНЭТ МЕТАЛ

| Сая төгрөгөөр                               | 2021 оны 12 дугаар сарын 31 | 2020 оны 12 дугаар сарын 31 |
|---------------------------------------------|-----------------------------|-----------------------------|
| <b>Бодит үнэ цэнээр</b>                     |                             |                             |
| Мөнгөжсөн алт                               | 1,594,121                   | 1,404,034                   |
| Мөнгөжсөн мөнгө                             | 555                         | 1,853                       |
| <b>Өртгөөр</b>                              |                             |                             |
| Алт олборлогчдоос худалдан авсан алт, мөнгө | 77,745                      | 353,458                     |
| Цэвэршүүлэхээр ачуулсан алт                 | 9,668                       | 24,309                      |
| Дурсгалын зоос                              | 3,544                       | 2,203                       |
| <b>Нийт алт, үнэт метал</b>                 | <b>1,685,633</b>            | <b>1,785,857</b>            |

Мөнгөжсөн алт болон мөнгө нь Английн Төв банк болон Джей Пи Морган Чейз банкинд байршдаг.

Алт олборлогчдоос худалдан авсан алт, мөнгө нь дотоодын алт олборлогчдоос худалдан авсан, цэвэршүүлэхээс өмнөх мөнгөжөөгүй алт болон мөнгө болно. Бусад үнэт метал болох дурсгалын зоосыг бараа материалаар бүртгэж өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь бүртгэдэг.

## 14. ЭРДЭНЭСИЙН САН

| Сая төгрөгөөр | 2021 оны 12 дугаар сарын 31 | 2020 оны 12 дугаар сарын 31 |
|---------------|-----------------------------|-----------------------------|
| Үндсэн сан    | 175,342                     | 145,701                     |
| Гүйлгээ сан   | 939,743                     | 925,964                     |
| <b>Нийт</b>   | <b>1,115,085</b>            | <b>1,071,665</b>            |

Доорх хүснэгтэд Эрдэнэсийн сангийн эд зүйлсийг шинж чанар, ангиллаар 2021 болон 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулав:

| Сая төгрөгөөр                                    | Зоос           | Соёлын үнэт зүйлс | Нийт             |
|--------------------------------------------------|----------------|-------------------|------------------|
| <b>2020 оны 1 дүгээр сарын 1-ээрх дансны үнэ</b> | 917,548        | 151,312           | <b>1,068,860</b> |
| Нэмэгдсэн                                        | 37             | 2,768             | <b>2,805</b>     |
| <b>2020 оны 12-р сарын 31-ээрх дансны үнэ</b>    | <b>917,585</b> | <b>154,080</b>    | <b>1,071,665</b> |
| Нэмэгдсэн                                        | 115            | 43,305            | <b>43,420</b>    |
| <b>2021 оны 12-р сарын 31-ээрх дансны үнэ</b>    | <b>917,700</b> | <b>197,385</b>    | <b>1,115,085</b> |

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 14. ЭРДЭНЭСИЙН САН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эрдэнэсийн сан нь түүх соёлын хосгүй үнэт зүйлс, 1925 онд гүйлгээнд гаргасан мөнгөн болон зэс зоос зэргээс бүрдэнэ. Эрдэнэийн сангийн хуулийн дагуу эдгээр үнэт зүйлс нь музейд байршиж олон нийтэд үзүүлдэг бөгөөд музейн тасалбараас олсон орлого нь банкны орлого, үр дүнгийн тайланд бусад үйл ажиллагаанаас орсон орлого хэсэгт хүлээн зөвшөөрдөг. Эрдэнэийн сангийн хуулийн дагуу сангаас хүртэх эдийн засгийн өгөөжийг банк хүртэх бөгөөд, үйл ажиллагааг нь удирддаг. Зоосыг 1938 онд гүйлгээнээс татсан. Эдгээр зооснуудыг Монголбанкны эрх залгамжлагч банк гаргасан боловч засгийн газраас Эрдэнэсийн санд хандивласан гэж удирдлага үзэж байгаа учраас хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх ёстой гэж үзэж байна.

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх зоосны дийлэнх хэсгийг 1925 онд Монголбанкны эрх залгамжлагч банк болох Төв банк нь анх гүйлгээнд гаргасан мөнгө болон зэс зооснуудаас бүрддэг ба дансны үнэ нь 908,476 сая төгрөг (2020 онд 908,476 сая төгрөг) байна.

Удирдлага 2018 оноос эхлэн эрдэнэсийн сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчлөн бодит үнэ цэнээр нь хэмжиж эхэлсэн ба хөндлөнгийн үнэлгээний компани болох “Мэйк э Диффэрэнс” ХХК-аар олон улсын үнэлгээний стандартын дагуу эрдэнэсийн сангийн эд зүйлсийг дахин үнэлүүлсэн. Эрдэнэсийн сан дахь эд зүйлсийг шууд харьцуулалтын арга болон орлуулах өртгийн аргаар үнэлсэн. Шууд харьцуулалтын арга нь гарал үүсэл, нөхцөл байдал, бэлэг тэмдгийн нэр, одоогийн эзэмшигч, тухайн зүйлийн онцгой байдал зэрэг тодорхой зах зээлийн хүчин зүйлсэд тохируулсан харьцуулж болох үнийг ашиглан олон нийтийн болон онлайн дуудлага худалдаа зэрэг зах зээлд тулгуурласан нотолгоог суурь болгон ашигладаг арга юм. Орлуулах өртгийн арга нь эд зүйлийн анхны шинж чанар, материалын насжилттай аль болох ойролцоо чанартай хөрөнгийг дахин үйлдвэрлэх өнөөгийн өртгийг тооцоолж гаргадаг арга юм. Бодит үнэ цэнийн хэмжилтийн дэлгэрэнгүйг Тодруулга 33-с харна уу.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 15. САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЭЛ

Санхүүгийн үүсмэл хэрэгсэл нь дотоод болон олон улсын санхүүгийн байгууллагуудтай байгуулсан хүүгийн своп хэлцлүүдийн бодит үнэ цэнийг илэрхийлдэг. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд нь зах зээлийн хүүгийн хэлбэлзэл, гадаад валютын ханш болон бусад хувьсагчуудаас шалтгаалан тааламжтай (хөрөнгө) эсвэл тааламжтай бус (өр төлбөр) нөхцөл байдалтай байдаг. Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь мэдэгдэхүйц хэмжээгээр хэлбэлзэж байдаг. Доорх хүснэгт нь хөрөнгө, өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнийг харуулж байна:

| Сая төгрөгөөр                                                 | 2021 оны 12 дугаар сарын 31 | 2020 оны 12 дугаар сарын 31 |
|---------------------------------------------------------------|-----------------------------|-----------------------------|
| <b>Хүүгийн своп: тайлант хугацааны эцсээрх бодит үнэ цэнэ</b> |                             |                             |
| - БҮЦӨАА-аарх санхүүгийн хөрөнгө                              | 77,103                      | 156,419                     |
| - БҮЦӨАА-аарх санхүүгийн өр төлбөр                            | (469,758)                   | (303,501)                   |
| <b>БҮЦӨАА-аарх санхүүгийн хөрөнгийн цэвэр бодит үнэ цэнэ</b>  | <b>(392,655)</b>            | <b>(147,082)</b>            |

Доорх хүснэгт нь тайлант хугацааны эцсээрх Банкны хүүгийн своп хэлцлийн авлага, өглөгийн бодит үнэ цэнийг харуулж байна. Хүснэгтэд харилцагч талын позици (ба төлбөр)-тэй цэвэршүүлээгүй бохир позицыг харуулсан бөгөөд холбогдох тайлант хугацааны хойших цаг хугацаанд хийгдэх төлбөр тооцоо бүхий хэлцлүүдийг мөн багтаасан болно.

| Сая төгрөгөөр                                                 | 2021                                |                                     | 2020                                |                                     |
|---------------------------------------------------------------|-------------------------------------|-------------------------------------|-------------------------------------|-------------------------------------|
|                                                               | Эерэг бодит үнэ цэнэ бүхий хэлцлүүд | Сөрөг бодит үнэ цэнэ бүхий хэлцлүүд | Эерэг бодит үнэ цэнэ бүхий хэлцлүүд | Сөрөг бодит үнэ цэнэ бүхий хэлцлүүд |
| <b>Хүүгийн своп: тайлант хугацааны эцсээрх бодит үнэ цэнэ</b> |                                     |                                     |                                     |                                     |
| - Ам.долларын өглөг (-)                                       | (370,632)                           | (741,393)                           | (271,928)                           | (810,556)                           |
| - Төгрөгийн авлага (+)                                        | 447,735                             | 271,635                             | 428,347                             | 507,055                             |
| <b>Хүүгийн свопын цэвэр бодит үнэ цэнэ</b>                    | <b>77,103</b>                       | <b>(469,758)</b>                    | <b>156,419</b>                      | <b>(303,501)</b>                    |

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 16. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС

| Сая төгрөгөөр            | 2021 оны 12 дугаар сарын 31 | 2020 оны 12 дугаар сарын 31 |
|--------------------------|-----------------------------|-----------------------------|
| Засгийн газрын үнэт цаас | 231,778                     | 227,407                     |

**Зах зээлийн хүүгийн түвшингөөс доогуур хүүтэй Засгийн газрын үнэт цаас.** Банк Засгийн газрын хэрэгжүүлсэн “Сайн” хөтөлбөрийн дагуу 453,712 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 1.0-3.0 хувийн хүүтэй, 1-15 жилийн хугацаатай Засгийн газрын үнэт цаасыг 2016 онд худалдан авсан. Эдгээр үнэт цаасны бодит үнэ цэнэ анх хүлээн зөвшөөрөх үед 123,668 сая төгрөг байсан. Бодит үнэ цэнэ болон нэрлэсэн үнийн зөрүү болох 330,044 сая төгрөгийг 2016 оны ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үнэт цаасны дансны үнэ 374,000 сая төгрөг 1.0 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай (2020: 374,000 сая төгрөг, 1.0 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай) байсан. Бодит үнэ цэнийн талаар Тодруулга 33-аас харна уу.

Засгийн газрын үнэт цаас нь БҮЦӨБДО-оор бүртгэгддэг. 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар “Сайн” хөтөлбөрийн засгийн газрын үнэт цаасны дансны үнэ нь 231,778 сая төгрөг (2020: 227,407 сая төгрөг). Үүнтэй холбоотойгоор удирдлагын зүгээс хийсэн үнэлэмж болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар Тодруулга 3 болон 4-өөс харна уу.

БҮЦӨБДО-оор бүртгэгдэх засгийн газрын үнэт цаасны ХЗА нь 5,842 сая төгрөг (2020: 3,635 сая төгрөг) ба тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдсан.

2021 оны 12 дугаар сарын 31 болон 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх үнэт цаасны дансны үнэ нь зээлийн эрсдэлийн хамгийн өндөр хэмжээг илэрхийлнэ. Банкны зээлийн эрсдэлийн чанарыг харуулах системийн болон хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтийн аргын тайлбарын талаар Тодруулга 32-өөс үзнэ үү.

Дараах хүснэгтэд нь БҮЦӨБДО-оорх засгийн газрын үнэт цаасны мэдээллийг харуулав.

|                                              | 2021 оны 12 дугаар сарын 31 | 2020 оны 12 дугаар сарын 31 |
|----------------------------------------------|-----------------------------|-----------------------------|
| Сая төгрөгөөр                                | Шатлал 1<br>(12 сарын ХЗА)  | Шатлал 1<br>(12 сарын ХЗА)  |
| Засгийн газрын үнэт цаас                     |                             |                             |
| - Сайн                                       | 93,917                      | 82,726                      |
| <b>Хорогдуулсан өртгөөрх нийт дансны үнэ</b> | <b>93,917</b>               | <b>82,726</b>               |
| Хасах нь: ХЗА                                | (9,800)                     | (3,958)                     |
| Нэмэх нь: Бодит үнэ цэнийн өөрчлөлт          | 147,661                     | 148,639                     |
| Нийт                                     | (1,911,027)   | (1,064,241) | (136,595)           | (435,659)                        | 515,811            | 34,096                           | (2,997,615) |

Бизнесийн ердийн үйл ажиллагааны үр дүнд дээр дурдсан үлдэгдэл дүнгүүд үүссэн болно. Удирдлага холбоотой талуудын ажил гүйлгээнд анх хүлээн зөвшөөрөлтийн олз/гарз бүртгэх шаардлагатай эсэхийг авч үзсэн. Уг үнэлэмжийг хийхдээ удирдлага нь дээрх ажил гүйлгээ нь анхдагч зах зээлд хийгдсэн гэдгийг анхаарсан. Дэлгэрэнгүйг Тодруулга 4-өөс харна уу.

Холбоотой талд олгосон урвуу буцаан худалдан авах хэлцэл, Эрдэнэс бонд, Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондоос бусад тайлант жилийн эцсээрх үлдэгдэл дүнгүүд барьцаагаар хангагдаагүй болно. Холбоотой талуудын өглөг эсвэл авлагад зориулж ямар нэгэн хүлээн авсан эсвэл гаргасан баталгаа байхгүй.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 31. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Импортын аккредитив гэрээ.** 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банк 22,475 сая төгрөгийн (2020: 35,898 сая төгрөг) холбоотой талуудын импортын аккредитив гэрээний өр төлбөртэй байсан. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 30-аас харна уу.

Банкны үндсэн удирдлагын цалин болон бусад тэтгэмжийн талаарх мэдээллийг дор толилуулав:

| <i>Сая төгрөгөөр</i>                                 | <b>2021</b> | <b>2020</b>  |
|------------------------------------------------------|-------------|--------------|
| Цалин хөлс                                           | 764         | 1,406        |
| <i>Нийгмийн болон тэтгэврийн санд төлсөн шимтгэл</i> | 113         | 207          |
| Тэтгэмжүүд                                           | 110         | 249          |
| Бусад олговор                                        | 5           | 189          |
| <b>Total</b>                                         | <b>992</b>  | <b>2,051</b> |

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 32. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банкны үйл ажиллагаа нь ямагт эрсдэлтэй байдаг ба эдгээрийг зөв тодорхойлж, хэмжиж, хянаж байснаар эрсдэлийг хязгаарлаж, бусад хяналтын бодлогоор удирддаг. Эрсдэлийг зохистой удирдах нь банкуудын үйл ажиллагааг хэвийн явуулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, тухайлбал инфляцыг зохистой түвшинд барих мөнгөний зөв бодлого явуулахад чухал ач холбогдолтой. Эрсдэлүүд нь банкны гол зорилгодоо хүрэх чадварыг хязгаарлах үр дагавартай байж болно. Ийм өндөр үр дагавартай эрсдэл Банкинд илүүтэй илрэх бөгөөд гадаад валютын хөрвүүлгээс хүлээх санхүүгийн гэнэтийн алдагдал нь үүний нэг жишээ болно. Санхүүгийн алдагдал нь бүхий л төрлийн санхүүгийн эрсдэлээс хамааралтай үүсдэг.

Санхүүгийн талаас нь авч үзвэл Банк нь зээлийн, хөрвөх чадварын болон зах зээлийн эрсдэлд өртөж болно. Үүнээс гадна үйл ажиллагааны, нэр хүндийн болон хууль, эрх зүйн зэрэг эрсдэлд өртөж болно. Одоогийн банкны эрсдэлийн удирдлага нь төвлөрсөн бус ба газар, хэлтэс тус бүр тэдгээрийн үйл ажиллагаанд учирсан аливаа эрсдэлээс сэргийлэх бодлогыг баримталдаг. Банк нь Монгол Улсын Төв банк учраас түүний эрсдэлүүд онцгой байдаг ба тэдгээр эрсдэлүүдийг Банк стратеги төлөвлөлтийн үйл явцаар дамжуулан хянаж, илрүүлж байдаг. Үүнээс гадна Банк нь эрсдэлийн хяналтын стратегийг боловсруулах ба зарчим, хүрээ, бодлого хязгааруудыг хэрэгжүүлэх ажлыг ерөнхийлөн хариуцах “Эрсдэлийн хороо”-г байгуулах боломжийг идэвхтэй судалж байна.

Одоогоор Хөрөнгө оруулалтын хороо нь эрсдэлийн стратегийг боловсруулж, шаардлагатай хязгаарыг тогтоох үүрэгтэй байхад Эрсдэлийн удирдлагын алба болон Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар нь үүнтэй холбоотой зарчмууд, үйлчлэх хүрээ, бодлого, хязгаарыг хэрэгжүүлдэг.

**Эрсдэлийн Удирдлагын бүтэц.** Захирлуудын зөвлөл нь эрсдэлийг хянах ба энэ асуудлаар эцсийн хариуцлагыг хүлээнэ. Гэхдээ эрсдэлийг тодорхойлох, удирдах, хянах үүрэг бүхий бие даасан нэгжүүд байдаг.

**Захирлуудын Зөвлөл.** Захирлуудын Зөвлөл ерөнхий эрсдэлийн удирдлага болон эрсдэлийн стратеги, бодлогыг батлахаас гадна эрсдэлтэй холбоотой асуудлаар Банкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгчид зөвлөмж өгдөг.

**Хяналтын Зөвлөл.** Хяналтын зөвлөл нь Банкны дотоод бүтэц, зохион байгуулалтад харьяалагддаггүй бөгөөд бие даасан хяналт тавьж, Банк доторх ерөнхий эрсдэлийн үйл явцыг нь хянах үүрэгтэй.

**Хөрөнгө оруулалтын хороо.** Хөрөнгө оруулалтын хороо нь Банкны санхүүгийн эрсдэлийг удирдах үүрэгтэй хамгийн үндсэн нэгж бөгөөд Захирлуудын Зөвлөл болон Ерөнхийлөгчид санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлогын талаар зөвлөмж өгдөг. Хөрөнгө оруулалтын хорооны бүрэлдэхүүнд Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Эрсдэлийн удирдлагын албаны захирал, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал, Санхүүгийн тайлан, бүртгэлийн газрын захирал нар багтдаг.

Хөрөнгө оруулалтын хороо нь тайлант оны “Жилийн хөрөнгө оруулалтын бодлого”-ыг хэлэлцэж, зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинг тодорхойлдог. Энэхүү зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинд үндэслэн улсын гадаад валютын нөөцийн бүтцийг гарган Ерөнхийлөгчид танилцуулж, батлуулдаг байна. Үүнд гадаад валютын нөөцийн бүтэц, түүний зохистой хэлбэлзэл, хөрөнгийн хуваарилалт, хөрөнгө оруулалтын хугацаа, боломжит хэрэгсэл, харилцагч байгууллагад тавьсан хязгаарлалт зэргийг тусгасан байдаг. Мөн Ерөнхийлөгч гадаад валютын нөөцтэй холбоотой харилцагч банк санхүүгийн байгууллагуудын жагсаалт, тэдгээрт тавих лимитийг улирал тутамд батлах ба энэ нь гадаад валют, зээл, хөрвөх чадвар, хүүгийн түвшний эрсдэлийг удирдах гол арга хэрэгсэл болдог.

### 32. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банкны санхүүгийн эрсдэлүүдээс Банкны нийт хөрөнгийн гадаад валютын нөөцийн харьцаанаас үүдэн гадаад валютын нөөцийн эрсдэл нь хамгийн чухал байдаг. Тиймээс Хөрөнгө оруулалтын хороо болон холбогдох газруудын үйл ажиллагаа нь гадаад валютын улсын нөөцтэй холбоотой эрсдэлийг удирдахад түлхүү чиглэгдсэн байна. Хөрөнгө оруулалтын хорооны өөр нэгэн үүрэг бол Эрсдэлийн удирдлагын алба, бусад холбогдох газруудад хяналт тавих, санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн эрсдэлийн бодлогын хэрэгжилт нийцтэй байгаа эсэхийг хянах үүрэгтэй байдаг. Санхүүгийн эрсдэлийг удирдах зорилгоор ашигласан аргуудыг доор толилуулав.

Эрсдэлийн Удирдлагын Алба. Эрсдэлийн удирдлагын алба (“ЭУА”) нь гадаад валютын улсын нөөцтэй холбоотой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, бусад эрсдэлтэй холбоотой үйл ажиллагаанд хараат бус хяналт тавих үүрэгтэй. Мөн гадаад валютын нөөцийн удирдлага, эрсдэлийн бодлого боловсруулах, бенчмаркийн биелэлтийг хангуулах, лимитийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг эрхэлдэг. Мөн түүнчлэн ЭУА гадаад валютын улсын нөөцийн эрсдэл, бүртгэлийн системтэй холбоотой эрсдэлийн арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлэх үүрэгтэй.

Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын журамд зааснаар, нөөцийн удирдлагын үндсэн зорилго нь төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, төгрөгийн ханшийг тогтвортой байлгахад оршино. Гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж буй гол зорилго нь:

- Мөнгөний бодлогыг дэмжих;
- Валютын зах зээлийн ханшийн хэт хэлбэлзлийг зохицуулах;
- Засгийн газрын гадаад валютын өр төлбөрт баталгаа гаргах;
- Улс орны хэмжээнд тохиолдсон гамшиг болон онцгой байдлын үед мөнгөний эх үүсвэр болгон хэрэглэх зэрэг болно.

Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийг бодлоготойгоор удирдаж, хянах нь гадаад валютын нөөцийн эрсдэлийн удирдлагын дээрх зорилгод дэмжлэг болно. Гадаад эрсдэлийг хянах зорилгоор Банк нь гадаад активыг сонгох, хуваарилах стратегийг тодорхойлдог. Үүнд нөөцийг байршуулах чөлөөтэй хөрвөх валютыг сонгох, валютуудын бэлэн байлгах хэмжээ, ямар бүтэцтэй байлгах, хөрвөх чадварын болон аюулгүй байлгах шаардлагуудад нийцүүлж хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийг ямар түвшинд барих, хүүгийн эрсдэлийг хянахын тулд хэрэгслүүдийн хугацаа ямар байх ёстой гэх мэт параметруудыг тогтоох зэрэг багтдаг.

Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар. *Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар* нь хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхой нэгжүүдээр дамжуулан хэрэгжүүлэх үүрэгтэй. Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал нь хөрөнгийн багцын бүтэц буюу хөрөнгийн бүрдэл хэсэг, хэрэгслүүд, харилцагч талууд, дуусгавар хугацаа, гадаад валютын нөөцийн хязгаарлалт зэргийг удирдах, хянах үүрэгтэй.

Дотоод аудитын газар. Банк нь зорилгодоо хүрэх, бодлого, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд Банкны үйл ажиллагаан дахь эрсдэлийн удирдлагын тогтолцоо зохистой, үр ашигтай эсэхийг шалгах, үнэлэх нь Дотоод аудитын газар (ДАГ)-ын эрхэм зорилго юм. ДАГ нь Банкны мөрдөж буй бодлого, холбогдох горимуудын төлөвлөлт болон зохион байгуулалт, зохицуулалт, хэрэгжилттэй холбоотой үйл ажиллагааны, эрсдэлийн удирдлагад хяналт тавих санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийн иж бүрэн байдал, аюулгүй байдлыг хангах зэрэг үйл ажиллагаанууд нь холбогдох хууль, журамд нийцэж буй эсэхийг шалгах үүрэг бүхий нэгж болно.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

**32. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)**

ДАГ нь эрсдэлийн ерөнхий болон тусгайлсан үнэлгээг хийдэг. Эрсдэлийн зэрэгт нь тааруулан дотоод боловсон хүчний нөөцийг зохистой хуваарилах үүднээс урт хугацааны болон жилийн төлөвлөгөөг боловсруулж эрсдэлийн ерөнхий үнэлгээг тодорхойлж гүйцэтгэдэг бол эрсдэлийн тусгайлсан үнэлгээг тодорхой нэг асуудал үүссэн цаг тухай бүр хийдэг. ДАГ нь Банкны 2021 оны хяналт, шалгалтын ажлын хөтөлбөр, жилийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа

Үйл ажиллагааны хэсэг нэг бүрийн болзошгүй болон бодит эрсдэлийн зэргийг тусган харуулж чадах шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж хяналт шалгалтын ажлын дэс дарааллыг тогтоосон байна. Энэ зорилгын үүднээс тодорхой зарим нэг шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулдаг ба шалгах гэж буй үйл ажиллагаанаас хамааран шалгуур үзүүлэлтийн төрөл нэг бүр дээр зохих жигнэсэн оноог гаргана. Үйл ажиллагааны хэсэг нэг бүр дээр жинлэсэн онооны Нийт дансны үнэг гаргаж, тэдгээрийг эрсдэлийн зэргээр нь өндөр, дунд, бага гэж ангилна.

Дотоод хяналтын системийг үнэлэх ажил нь дотоод аудитын ажлын маш чухал хэсэг юм. Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь зохистой горимууд, чадварлаг гүйцэтгэл байгаа эсэхийг баталгаажуулах түүнчлэн санхүүгийн тайлагналын системийн найдвартай байдал, бүх үйл ажиллагааны хууль журмын нийцлийг баталгаажуулах явдал юм. ДАГ нь хяналтын дүгнэлт болон өөрсдийн зөвлөмжүүдийг Ерөнхийлөгч болон Хяналтын зөвлөлд тайлагнадаг. Шалгалт бүрийн эцэст ДАГ Банкны удирдлагуудтай шалгалтын үр дүнг хэлэлцэж, удирдлагын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг эргэн хянадаг.

Зээлийн Эрсдэл. Зээлийн эрсдэл нь гэрээ байгуулсан хэрэглэгч, үйлчлүүлэгч, харилцагч талууд үүргээ биелүүлж чадахгүйд хүрснээс үүдэн алдагдал хүлээж болох нэг төрлийн эрсдэл юм. Банкны харилцагч талуудтай хийсэн ажил гүйлгээ болон банкны зээл олголтоос үүдэн зээлийн эрсдэл бий болдог бөгөөд энэ нь санхүүгийн хөрөнгөө нэмэгдүүлэх болон тэнцлийн гадуурх зээлтэй холбоотой үүрэг хариуцлагыг үүсгэдэг.

Банк зээлийн эрсдэлд өртөх хамгийн их магадлал нь санхүүгийн байдлын тайланд санхүүгийн хөрөнгийн дансны дүнгээр тусгагддаг. Санхүүгийн баталгаа, ашиглаагүй зээлийн шугам болон импортын аккредитивын хувьд хамгийн их өртөх магадлалтай эрсдэл нь үүрэг хариуцлагын дүнгийн хэмжээ байна.

Зээлийн эрсдэлийн удирдлага. Зээлийн эрсдэлийг хөрөнгө оруулалтын хөрөнгийг зөв сонгох, хөрөнгө оруулалтын хөрөнгийн зээлийн чанарыг хянах, хөрөнгө оруулалтын хөрөнгө бүрийн оруулах хөрөнгө оруулалтын хэмжээнд хязгаарлалт тавьж өгөх зэргээр удирдаж, хянана. Хөрөнгө оруулалтын төрлөөр нь зээлийн эрсдэлийн хэмжээнд тавих хязгаарлалтын хэмжээ болон оролцогч талыг сонгоход удирдлагаас байнга зөвшөөрөл авна. Эдгээр эрсдлүүдийг тойрох байдлаар хянадаг бөгөөд жил бүр эсвэл бүр ойр давтамжтайгаар хяналт тавина.

Зээлийн эрсдэлийг бууруулахын тулд гадаад валютын нөөцийг Ааа-с Аа3 болон Ааа зэрэглэлтэй Засгийн газар (эсвэл Төв банк)-ын болон олон улсын байгууллагуудын үнэт цаасанд хөрөнгө оруулдаг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хадгаламж болон мөнгөний зах зээлийн хэрэгслүүдэд учрах зээлийн эрсдэл нь олон улсын үнэлгээний байгууллагуудаас А3 болон түүнээс дээш зэрэглэл авсан харилцагчидтай ажил гүйлгээ явуулах замаар хязгаарлагдаж байна. Хэрэв харилцагч нь нэгээс дээш үнэлгээний байгууллагаас үнэлгээ (рейтинг) авсан бол хамгийн бага үнэлгээнд нь үндэслэдэг.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

**32. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)**

Дотоодын мөнгөний бодлогын үйл ажиллагааны хувьд Банк зээлийн эрсдэлээ бууруулахын тулд барьцаа хөрөнгийг түлхүү хэрэглэдэг. Төв банкнаас санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгийн жагсаалтад заасан үндсэн төрлийн барьцаа хөрөнгүүдийг дор дурдав:

1. Төв банкны үнэт цаас (ТБҮЦ);
2. Засгийн газрын үнэт цаас;
3. Хөгжлийн банкны үнэт цаас;
4. Санхүүгийн байгууллагуудын гаргасан зээл.

Банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүх зээлдэгч банкууд хангах үүрэгтэй ба хэрэв дотоодын зээлдэгч банкууд энэхүү харьцаануудаас нэгийг биелүүлээгүй тохиолдолд Банк тухайн банкинд олгох буюу олгосон зээлийн үйл ажиллагааг цуцалдаг.

Хязгаарлалт. Цаашилбал гадаад валютын улсын нөөцийн хувьд бүх харилцагчдад зээлийн хязгаар тогтоосон бөгөөд энэ нь зээлдэгчийн зэрэглэл, хөрөнгө, бусад хүчин зүйлд үндэслэнэ. Монголбанкны Ерөнхийлөгч нь зээлийн хязгаарыг улирал бүр тогтоох бөгөөд зээл нь тухайн хязгаартаа байгаа эсэхийг Эрсдэлийн удирдлагын алба өдөр тутам хянана. Банк өөрийн зээлийн эрсдэлийг хянахын тулд санхүүгийн хөрөнгийнхөө, ялангуяа банкуудад олгосон зээл болон бусад санхүүгийн хөрөнгө (Тодруулга 9 болон 17)-ийн насжилтын шинжилгээг хийж зээлээ эргэн төлөх чадвар нь муудаж буй харилцагчдын талаарх мэдээллийг Захирлуудын Зөвлөлд танилцуулах бөгөөд тус хурал дээр хэлэлцэн үзэж, холбогдох шийдвэрийг гаргана.

Тодруулга 30-д толилуулснаар Банк нь тодорхой хэмжээний зээлтэй холбоотой үүрэг хариуцлага хүлээсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газар эсвэл түүний харьяа байгууллагуудын хүсэлтээр Монгол Улсын хувьд чухал ач холбогдол бүхий (бараа, үйлчилгээ экспортлох гэх мэт) зээлийн үүрэг хүлээдэг. Энэхүү хэрэгслийн гол зорилго нь Засгийн газарт болон бусад төрийн байгууллагуудад санхүүжилтийн хөрөнгийг хангалттай байлгахад оршино. Нээсэн аккредитивүүд нь Банк өмнөөс нь төлбөрийг нь барагдуулах зайлшгүй үүрэг хүлээснийг илэрхийлдэг ба эдгээр хэрэгслийн эрсдэл нь зээлийн эрсдэлтэй ижил юм. Энэ төрлийн эрсдэлийг зээлтэй ижил аргаар бууруулж болно. Зээлтэй холбоотой үүрэг нь Хятадын Ардын банктай хийсэн гэрээтэй холбоотой (Тодруулга 30) ба ашиглаагүй хэмжээг тодорхойлно. Хийсэн шинжилгээндээ үндэслэн Банкны удирдлага нь энэ төрлийн харилцагчаас үүдэлтэй зээлийн эрсдэлд орох магадлал нь бага хэмээн дүгнэжээ.

Банк зээлийн эрсдэлд өртөх хамгийн их магадлал нь санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн бүртгэлээрх дүнд нөлөөлдөг. Зээлийн эрсдэл нь Тодруулга 12-д үзүүлсний дагуу барьцаа хөрөнгөөр багасч болно. Аккредитивууд болон своп хэлэлцээрийн ашиглах хэмжээг нэмэх хүсэлтээс үүдэх үүргийн хувьд зээлийн эрсдэлийн дээд хэмжээ нь энэхүү үүрэг, хариуцлагын дүнгээр илэрхийлэгдэнэ. (Тодруулга 30).

**Үнэ цэнийн бууралтын үнэлгээ**

Хүлээгдэж буй зээлийн алдагдал (ХЗА)-ын хэмжилт. Хүлээгдэж буй зээлийн алдагдал нь ирээдүйн бэлэн мөнгөний дутагдалын одоогийн үнэ цэнийг магадлалын үндсэн дээр жигнэсэн тооцоолол (өгөгдсөн хугацаанд дефолт болох эрсдэлээр жигнэсэн зээлийн алдагдлын жигнэсэн дундаж) юм. ХЗА хэмжилт нь олон янзын боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлогддог. ХЗА-ын хэмжилтийг Банкны хэрэглэдэг дөрвөн бүрэлдэхүүн хэсгүүдэд үндэслэн тогтооно: Үүнд дефолт болох магадлал («ДМ»), Дефолт болсон үеийн дүн («ДҮД»), Дефолт болсон тохиолдолд хүлээх алдагдлын хэмжээ («ДАХ») болон дискаунтчилсан үр дүн орно.



## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 32. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

ДҮД гэдэг нь тайлант хугацааны дараах зээлийн хүлээгдэж буй өөрчлөлтийг авч үзэн зээлдэгч ирээдүйд дефолт болох үед хэдий хэмжээний өртэй байх таамаглал юм. Зээлтэй холбоотой үүрэг хариуцлагын ДҮД-г Зээлийн хувиргалтын фактор (“ЗХФ”)-ыг ашиглан тооцоолно. ЗХФ гэдэг нь үүрэг хариуцлага бүхий үнийн дүнг тодорхойлсон тайлант хугацаанд тайлан тэнцэлд тусгагдах үнийн дүнд хувиргах магадлалыг харуулсан коэффициент юм. ДМ гэдэг нь зээлдэгч өгөгдсөн хугацаанд дефолт болох магадлалыг тооцоолдог. ДАХ гэдэг нь дефолтоос болж үүссэн алдагдлын тооцоолол. Үүнийг төлөх ёстой гэрээний мөнгөн урсгал болон зээлдэгчийн барьцаа хөрөнгөөс гарах мөнгийг оролцуулан хүлээж буй мөнгөн дүн хоёрын зөрүүнд үндэслэнэ. Ихэвчилэн ДҮД-ийн хувиар илэрхийлдэг. ХЗА нь тайлант хугацааны эцэст дискаунтчилагдан одоогийн үнэ цэнээр бүртгэгддэг. Санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн түвшингээр (“ҮАХ”) дискаунтын хувь тодорхойлогдоно.

Энэхүү санхүүгийн тайлангийн зорилгоор удирдлагын тооцоолсон ХЗА нь захиргааны зорилгоор голдуу ашиглагддаг циклийнх туршид тооцоолох тооцооллоос илүүтэйгээр тухайн цаг хугацааны тооцоолол байна. Тооцоолол нь ирээдүйг харсан мэдээллийг авч үздэг бөгөөд үүнд ХЗА нь зээлийн эрсдэлд нөлөө үзүүлэх макро эдийн засгийн гол хувьсагчуудын магадлалаар жигнэсэн дүнд тусгагддаг.

ХЗА загварчлал нь Худалдан авсан, шинээр гаргасан зээлийн – зээлжих чадамжаас үүдэлтэй үнэ цэнийн бууралттай (“ЗЧҮЦБ”) санхүүгийн хөрөнгүүдээс ялгаагүй боловч дараах зүйлсээр ялгаатай: (а) гэрээний мөнгөн урсгалд суурилхаас илүүтэйгээр хөрөнгийн анх хүлээн зөвшөөрсөн үед төлөгдөж болох байсан мөнгөн урсгалд суурилж нийт дансны үнэ болон хямдруулалтын хүүгээ тооцолно, (б) ХЗА нь үргэлж ХЗА-ийн ашиглалтын хугацааны турш байна. ЗЧҮЦБ хөрөнгө гэдэг нь анх хүлээн зөвшөөрөгдсөний дараа зээлийн үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгүүд, жишээ нь: өнгөрсөн хугацаанд нийлүүлж авсан бизнесээс гарч ирсэн үнэ цэнийн бууралттай зээлүүд.

**Дефолт болох, үнэ цэнэ буурах, дефолтоос гарах тодорхойлолт.** Зээлдэгч гэрээгээр хүлээсэн төлбөрөө 90 болон түүнээс дээш хоногоор хугацаа хэтрүүлсэн эсвэл Банк зээлдэгчийн барьцаа хөрөнгийг борлуулах замаар эргэн төлөлтийг гүйцээх магадлалтай бүх тохиолдолд тухайн санхүүгийн хэрэгслийг үл төлөгдөх магадлалтай гэж үзэн хүлээгдэж буй алдагдлыг тооцдог.

Харилцагчдын санхүүгийн хэрэгслийг чанарын үнэлгээгээр үнэлж зээлийг “үнэ цэнийн бууралттай” гэж үзэх болон эргэн төлөгдөхгүй байх магадлалуудыг Банк авч үздэг. Энэ тохиолдолд Банк харилцагчийн санхүүгийн хэрэгслийг үл төлөгдөх магадлалтай эсэхийг нарийвчлан шинжилж хүлээгдэж буй алдагдлыг 2-р шатлал эсвэл 3-р шатлалын алинд нь тооцоологдохыг тодорхойлох замаар үнэлгээг хийнэ. Чанарын үнэлгээг хийхдээ дараах хүчин зүйлийг харгалзан үздэг. Үүнд:

- Зээлдэгч нь эрсдэлд орох нөхцөл байдал үүссэн эсвэл ойрын хугацаанд эрсдэх магадлалтайг тодорхойлсон Банкны дотоод үнэлгээ;
- Зээлдэгч Банкнаас яаралтай эх үүсвэр авах хүсэлт гаргах
- Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй
- Зээлдэгч нь бусад зээлдүүлэгчдэд хугацаа хэтэрсэн өр төлбөртэй байх;
- Зээлдэгч нас барсан
- Зээлийн барьцаа хөрөнгийн борлуулалтаас эргэн төлөлт хүлээгдэж байсан боловч барьцаа хөрөнгийн үнэ цэнэ материаллаг хэмжээгээр буурах;
- Зээлдэгчийн эргэлтийн хөрөнгө материаллаг хэмжээгээр буурах эсвэл томоохон харилцагчаа алдах;



## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 32. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй
- Зээлдэгч (эсвэл зээлдэгчийн хамаарал бүхий аливаа хуулийн этгээд) нь дампуурлын талаарх өргөдөл мэдэгдэл гаргах
- Зээлдэгчийн тухай цуу яриа эсвэл санхүүгийн бэрхшээлтэй холбоотой баримтуудын улмаас хөрөнгийн биржид бүртгэлтэй зээл эсвэл хөрөнгийн эх үүсвэр нь цуцлагдах

Банкны журмаар санхүүгийн хөрөнгө нь дор хаяж 6 сар дараалан дефолт тодорхойлолтонд заасан нөхцөлүүдийг хангаагүй тохиолдолд дефолтоос гарч 3-р шатлалаас буурч болно. Дефолтоос гарсан хөрөнгийг 2-р шатлал эсвэл 1-р шатлалд ангилах шийдвэр нь дефолтоос гарах үеийн шинэчлэгдсэн зээлжих зэрэглэлээс болон зээл анх олгогдсоноос хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхээс хамаарна.

- **Зээлийн эрсдэлийн үнэлгээний систем.** Зээлийн эрсдэлийг үнийн дүнгээр нь санхүүгийн хэрэгслийг үнэлэх болон зээлийн эрсдэлийг хэмжихийн тулд Банк нь хөндлөнгийн олон улсын үнэлгээний байгууллага (Мүүдийс, Стандарт энд Пүүрс, Фитч)-ын гаргасан эсдэлийн үнэлгээг ашигладаг. Олон улсын санхүүгийн зах зээлийн тогтвортой бус байдлаас үүдэн Банк нь тодорхой талуудтай тэдний үнэлгээг авч үзэхгүйгээр худалдаа хийхээ бүрэн больсон бөгөөд оролцогч талын эрсдэлээ зохистойгоор авч үзээгүйгээс үүдэн системийн эрсдэлд хүргэх боломжтой байдаг.

Доорх хүснэгтэд хөндлөнгийн зээлийн үнэлгээг дефолтын магадлалтай хувьтай нь хамт үндсэн хэмжүүртэй нь тохируулж харуулсан:

| Зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр | Хөндлөнгийн үнэлгээний агентлагийн өгсөн тохирох үнэлгээ |              |
|---------------------------------------------|----------------------------------------------------------|--------------|
|                                             | C&P                                                      | Мүүдийс      |
| Онц сайн                                    | AAA to A-                                                | AAA to A3    |
| Сайн                                        | BBB+ to B-                                               | Baa1 to B3   |
| Хангалттай                                  | CCC+ to CCC-                                             | Caa1 to Caa3 |
| Тусгайлан хянах                             | CC to C                                                  | Ca to C      |
| Дефолт                                      | Дефолт                                                   | Дефолт       |

Зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр бүрээр зээлжих чадварын зэргийг тодорхойлсон:

- Онц сайн – зээлийн чанар маш сайн, зээлийн эрсдэл бага;
- Сайн – зээлийн чанар сайн, зээлийн эрсдэл дунд зэрэг;
- Хангалттай – зээлийн чанар дунд зэрэг, зээлийн эрсдэл хангалттай;
- Тусгайлан хянах – ойроос хянах шаардлагатай, сайжруулах удирдлагыг баримтлах хэрэгслүүд;
- Дефолт – дефолт болсон хэрэгсэл.
- Монголын томоохон банкууд нь олон улсын үнэлгээний байгууллагуудаар зэрэглэлээ тогтоолгодог учир дотоодын банкуудад байршуулсан санхүүгийн хөрөнгийг энэхүү үнэлгээн дээр тулгуурлан хянана. Үнэлэгдээгүй банкуудын хувьд, Банк тэдгээр банкуудын сүүлийн үеийн санхүүгийн мэдээлэл, Банкны Хяналт шалгалтын газраас гаргаж буй санхүүгийн харьцааны шинжилгээ болон хамааралтай хөрөнгийн зээлийн эрсдэлийг үнэлэхэд хэрэглэдэг мэдээлэл болон бусад мэдээлэлд тулгуурлан дүгнэлт гаргадаг.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 32. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Дефолт болох, болон шатлал тогтоох тодорхойлолт.** Банк дефолт болох магадлалыг тооцоолохдоо доор дурдсан нөхцөлүүдийн аль нэгийг эсвэл хэд хэдэн нөхцөлийг зэрэг хангасан зээлийг дефолт болсон гэж үздэг. Үүнд:

- Зээлдэгч нь гэрээний эргэн төлөлтийг 90 хоногоос дээш хугацаагаар хэтрүүлсэн.
- Дотоодын банкуудын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд Банкнаас тогтоосон шаардлагыг хангаагүй.
- Санхүүгийн хөрөнгийн зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа 100%-иас их.
- Дотоодын банкууд болон байгууллагуудын (Хөгжиж буй орнууд) Алтманы Z оноо 1.1 болон 1.8-аас доош гарсан.
- Зээл төлөгдөхгүй байх: Доорх нөхцөлүүд илэрсэн тохиолдолд зээлийн төлөгдөхгүй байх магадлал ихэсдэг:
  - гэрээний үүрэгт хүү эсвэл үндсэн төлөлтийг төлөөгүй эсвэл хугацаа хэтэрсэн.
  - дампуурлаа зарласан эсвэл хуулийн эрх хүлээн авсанаас үүдэн гэрээгээр хүлээсэн өр төлбөрийн эргэн төлөлтийг төлөхгүй байх эсвэл хугацаа хэтрэх магадлалтай болсон.
  - валютын ханшийн хямрал.
  - зээлийн гэрээний эргэн төлөлтийн нөхцөлд өөрчлөлт орсон эсвэл эрх бүхий байгууллагаас гэрээ байгуулсанаас үүдэн санхүүгийн үүрэг хариуцлагыг нь бууруулсан, үүнд гэрээний валютыг хүчээр өөрчилсөн (зээлдэгч эсвэл зээлдэгчийн эрх бүхий байгууллагаас) эсвэл анхны амлалтын зарим зүйлсийг хүчээр өөрчилсөн, жишээ нь индекс, дуусах хугацаа гэх мэт

Банкны удирдлага санхүүгийн хөрөнгүүдийн шатлалыг тодорхойлохдоо доорх шалгууруудыг тавьдаг:

| Но. | Шалгуур                                                   | Шатлал 1                                              | Шатлал 2                                                       | Шатлал 3                                             |
|-----|-----------------------------------------------------------|-------------------------------------------------------|----------------------------------------------------------------|------------------------------------------------------|
| 1   | Гэрээний эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн хоног           | 30-аас доош хоног                                     | 30-90 хоног                                                    | 90-ээс дээш хоног                                    |
| 2   | Дотоодын банкуудын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд | Банкнаас тогтоосон хамгийн доод шалгууруудыг хангасан | Банкнаас тогтоосон хамгийн доод шалгууруудыг хангаагүй         | Дефолт болсон/ дампуурсан                            |
| 3   | Дотоодын банкууд болон байгууллагуудын Алтманы Z оноо     | Банкууд: Z-оноо > 2.6<br>Байгууллагууд: Z-оноо > 3    | Банкууд: 1.1 < Z-оноо > 2.6<br>Байгууллагууд: 1.8 < Z-оноо > 3 | Банкууд: Z-оноо < 1.1<br>Байгууллагууд: Z-оноо < 1.8 |
| 4   | Зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа (LTV)     | 70%-иас бага                                          | 70%-100%                                                       | 100%-иас их                                          |

Дээр дурдсан шалгуур үзүүлэлтүүдээс гадна Банк олон улсын үнэлгээний байгууллагуудын банкууд болон байгууллагад өгсөн үнэлгээг хянадаг. Олон улсын байгууллагуудаас гаргасан зээлжих зэрэглэлийн ахих, буурах нь санхүүгийн хөрөнгийн шатлал тодорхойлоход тусгагддаг.

Дефолт болох үеийн үлдэгдэл. Дефолт болох үеийн үлдэгдэл (ДҮД) гэдэг нь үндсэн үлдэгдэл ба хүүний эргэн төлөлт, зээлийн төлбөрийн хоцролт дээр хуримтлагдсан хүү, г.м., тайлагналын өдрийн дараа бүртгэлийн дүнд нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан үзэж ирээдүйд чанаргүй болох өдрийн хүлээгдэж буй зээлийн бүртгэлийн дүнг хэлнэ.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 32. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

1-р шатлалд буй зээлийн ДҮД-ийг тооцоолохын тулд Банк нь 12 сарын хугацаанд үүсэж болох чанаргүйдэх үйл явдлыг Зээлийн Үнэ Цэнийн 12 сарын Хүлээгдэж буй Алдагдалыг тооцоход авч үзнэ. 2-р шатлал болон 3-р шатлалуудад ДҮД-ийг тодорхойлохдоо нийт хугацааны түүхэн чанаргүйдэх үйл явдлыг авч үзнэ.

Алдагдал хүлээх магадлал. Алдагдал хүлээх магадлал (ДАХ)-г Бизнесийн эрсдэлийн хэлтсийн зээлийн эрсдэлийн шинжээчид жил бүр үнэлдэг. ДАХ нь санхүүгийн хөрөнгийн чанаргүй болсон үнийн дүнд Банкны хүлээх алдагдлын түвшинг илтгэнэ. ДАХ нь харилцан тохиролцсон хэлбэр, нэхэмжлэлийн төрөл болон зэрэглэл, барьцаа хөрөнгө эсвэл бусад зээлийн дэмжлэг зэргээс шалтгаалан харилцан адилгүй байдаг. ДАХ нь ДҮД-ийн хувиар илэрхийлэгддэг. ДАХ-ийг 12 сар эсвэл зээлийн хугацааны туршид тооцдог бөгөөд 12 сарын LGC-ийг дараагийн 12 сард чанаргүйдэл болох тохиолдолд гарах алдагдлын хувиар тооцдог. Зээлийн хугацааны турш дахь ДАХ-ийг үлдэгдэл зээлийн хугацаанд гарах алдагдлын хувиар тооцдог.

Санхүүгийн хэрэгсэлд барьцаа хөрөнгө байхгүй, чанаргүйдлийн түүхэн өгөгдөл хангалтгүй байгаа тохиолдолд Банк шинжээчдийн дүгнэлтийг ашигладаг.

Банк нь ХЗА-д хамаарах бүх хөрөнгийг тасралтгүй хянаж байдаг. Аль нэг хэрэгсэл эсвэл хэрэгслийн багц нь 12 сарын ХЗА эсвэл хугацааны турш дахь ХЗА-д хамаарах эсэхийг тодорхойлохын тулд Банк анх хүлээн зөвшөөрсөнөөс хойш зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт байгаа эсэхийг үнэлдэг.

ДАХ-г тооцоолоход алдагдлын талаарх тоон мэдээллийн боломжит байдлаас хамаарч дараах аргачлалуудаас тохирохыг нь сонгоно:

- Дотоодын загвар бий болгоход алдагдлын талаарх хангалттай мэдээлэлтэй үед: Макро эдийн засаг, тухайн сектор, алдагдлын талаар хангалттай тоон мэдээлэлтэй үед загвар хөгжүүлэх замаар симуляцийн арга ашиглан ирээдүйд учрах алдагдлыг тооцох.
- Алдагдлын талаар тодорхой хэмжээний мэдээлэлтэй үед: Багцын арга буюу зээлийн барьцаагаар хангагдсан хэсэг болон барьцаагаар хангагдаагүй хэсэгт нэгэн ижил алдагдлын хувь тооцох, симуляцийн арга ашиглан ирээдүйд учрах алдагдлыг тооцох.
- Алдагдлын талаар мэдээлэл хомс буюу байхгүй үед: Ижил төстэй санхүүгийн хөрөнгийн алдагдлын хувь хэмжээний мэдээлэл, эсвэл гадаадын зохицуулалтын байгууллагаас гаргасан өгөгдлийг ашиглах.

Түүхэн өгөгдөл хязгаарлагдмал тул Банк ДАХ-г тооцоолохдоо Томсон Ройтерсийн өгөгдлийн терминалаас авсан, байгууллагын үнэлгээ болон гэрээний хугацаа бүрт харгалзах эргэн төлөлтийн хувийг ашигласан.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 32. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгтэд 2021 болон 2020 онуудад санхүүгийн хөрөнгө бүрт тодорхойлсон ДАХ-г харуулав.

|      | Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө | Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт | Урвуу буцаан худалдан авах хэлцэл | Засгийн газрын үнэт цаас | Дотоодын банкуудад олгосон зээл | Бусад санхүүгийн хөрөнгө |
|------|------------------------------------------------------|--------------------------------------|-----------------------------------|--------------------------|---------------------------------|--------------------------|
|      | Тодруулга (8)                                        | Тодруулга (10)                       | Тодруулга (12)                    | Тодруулга (16)           | Тодруулга (9)                   | Тодруулга (17)           |
| 2021 | 60%                                                  | 18% - 77%                            | 0%                                | 64%                      | 0% - 77.2%                      | 64% - 100%               |
| 2020 | 60%                                                  | 47% - 63%                            | 0% - 60%                          | 63%                      | 63%                             | 72%                      |

**Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (ЗЭМӨ).** Банк нь ХЗА-д хамаарах бүх хөрөнгийг тасралтгүй хянадаг. Санхүүгийн хэрэгсэл эсвэл санхүүгийн хэрэглүүрээс бүрдсэн багцын үнэ цэнийн бууралтыг 12 сарын ХЗА эсвэл зээлийн дуусах хүртэлх хугацааны ХЗА-ын аргачлалаар тооцох нь зохистой эсэхийг тодорхойлохын тулд Банк нь анхлан хүлээн зөвшөөрснөөс хойш тухайн хөрөнгийн зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (“ЗЭМӨ”) ажиглагдсан эсэхийг үнэлдэг.

Банк нь гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц ихэссэн тохиолдолд чанарын шинжилгээ хийдэг. Зарим тохиолдолд зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийн шалтгааныг чанаргүйдэл бус “Дефолтын тодорхойлолт”-д дурдагдсан үйл явдлуудтай холбож тайлбарладаг.

Ижил төстэй бүлэг хөрөнгүүдийн хувьд ХЗА-г тооцож байгаа тохиолдолд мөн дээрхтэй ижил буюу анх хүлээн зөвшөөрөх үеийн зээлийн эрсдэлийн хэмжээнд мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхийг шинжилдэг.

**ХЗА-ын загварын ирээдүйн мэдээллийн тохируулга.** Банк нь ХЗА-ын загварын бүрэлдэхүүн хэсэг болох ДМ-г ирээдүйн мэдээлэлд үндэслэн тохируулснаар ХЗА-ын загварт ирээдүйн макро эдийн засгийн хөгжил хэрхэн нөлөөлж болохыг тусгадаг. Банк ХЗА-ын загварын ДМ-г санхүүгийн хөрөнгийн онцлогоос хамаарч бүлгийн болон тусгай үнэлгээгээр тооцоолдог. Арга зүйн хувьд, оновчтой макро эдийн засгийн хүчин зүйлүүдийг урьдчилан сонгохын тулд хамаарлын шинжилгээг хийсэн. Улмаар энгийн регрессийн шинжилгээг ашиглан коэффициентуудыг тодорхойлсон. Тодорхойлсон коэффициентууд болон таамаглалуудыг ашиглан чанаргүйдлийн хувийн урьдчилсан таамаглал болон түүхэн дундаж чанаргүйдлийн хувийн харьцааг тооцож, ДМ-н ирээдүйн мэдээллийн тохируулгыг тооцоолсон. Банк нь дараах ирээдүйн мэдээлэлд үндэслэн ДМ-г тохируулж тооцооллыг гүйцэтгэсэн.

- Дотоодын банкуудад олгосон зээл

Банк нь олон улсын үнэлгээний байгууллагын (Стандарт энд Пурс) чанаргүйдлийн түүхэн үнэлэмж болон макро эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэн ирээдүйн мэдээлэлд суурилсан ДМ-ыг тооцсон:

- Жилийн дотоодын нийт бүтээгдэхүүн
- Инфляцын түвшин (1 жилээр хоцорсон)
- Зээлийн хүүгийн хувь (1 жилээр хоцорсон)
- Ажилгүйдлийн түвшин

Банк сүүлийн 20 жилийн макро эдийн засгийн хувьсагчид болон ДМ-ын түүхэн өгөгдөл дээр шугаман регрессийн шинжилгээ хийсэн ба уг шинжилгээгээр нь эдгээр хувьсагчид нь статистик ач холбогдолтой макро эдийн засгийн үзүүлэлт болох нь нотлогдсон.

- Дотоодын банкинд олгосон барьцаат зээл

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 32. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банк нь олон улсын үнэлгээний байгууллагын (Стандарт энд Пурс) чанаргүйдлийн түүхэн үнэлэмж болон макро эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэн ирээдүйн мэдээлэлд суурилсан ДМ-ыг тооцсон:

- Жилийн дотоодын нийт бүтээгдэхүүн
- Инфляцын түвшин (1 жилээр хоцорсон)

Банк сүүлийн 21 жилийн макро эдийн засгийн хувьсагчид болон ДМ-ын түүхэн өгөгдөл дээр шугаман регрессийн шинжилгээ хийсэн ба уг шинжилгээгээр нь эдгээр хувьсагчид нь статистик ач холбогдолтой макро эдийн засгийн үзүүлэлт болох нь нотлогдсон.

- ИЗББ болон Түрээсийн Орлогоор Баталгаажсан Бонд

Банк нь өөрийн сайтаар олон нийтэд нийтэлдэг нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь болон макро эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэн ирээдүйн мэдээлэлд суурилсан ДМ-ыг тооцсон:

- Улирлын дотоодын нийт бүтээгдэхүүн
- Нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь (1 улирлаар хоцорсон)
- Ажилгүйдлийн түвшин

Банк сүүлийн 10 жилийн макро эдийн засгийн хувьсагчид болон нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээлийн түүхэн хувь дээр шугаман регрессийн шинжилгээ хийсэн ба уг шинжилгээгээр нь эдгээр хувьсагчид нь статистик ач холбогдолтой макро эдийн засгийн үзүүлэлт болох нь нотлогдсон.

- Эрдэнэс Монгол Бонд

Банк нь өөрийн сайтаар олон нийтэд нийтэлдэг нийт уул уурхайн зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь болон макро эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэн ирээдүйн мэдээлэлд суурилсан ДМ-ыг тооцсон:

- Улирлын дотоодын нийт бүтээгдэхүүн (2 улирлаар хоцорсон)
- Нийт уул уурхайн зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь (1 улирлаар хоцорсон)

Банк сүүлийн 10 жилийн макро эдийн засгийн хувьсагч болон нийт уул уурхайн зээлд эзлэх чанаргүй зээлийн түүхэн хувь дээр шугаман регрессийн шинжилгээ хийсэн ба уг шинжилгээгээр нь эдгээр хувьсагчид нь статистик ач холбогдолтой макро эдийн засгийн үзүүлэлт болох нь нотлогдсон.

Эдгээр тохируулгын хүчин зүйлс болон тохируулагдсан ДМ хувиуд нь ирээдүйн эдийн засгийн өсөлтийн талаар сайн төсөөлөл өгч чадах тул ХЗА-ын загварын суурь төсөөлөл гэж үзсэн. Хамгийн сайн болон хамгийн муу төсөөллүүдийг тухайн загвараар таамагласан чанаргүйдлийн хувь дахь түүхэн тохируулагч хүчин зүйлүүдийг үндэслэн тооцсон ба тохируулагч хүчин зүйлийн тархалтыг тодорхой тоонуудаар хэмжсэн.

Өөр өөр эдийн засгийн хувилбар дахь ХЗА-г тухайн төсөөлөлд хамаарах ДМ хувьд үндэслэн тооцсон ба эцсийн ХЗА нь өгөгдсөн гурван төсөөллийн ач холбогдлын хувиар жигнэж тооцогдоно. Үүнд: хамгийн сайн болон хамгийн муу төсөөлөлд тус бүр 5% ба суурь төсөөлөлд 90% ач холбогдол өгсөн.

Эдийн засгийн хувилбарууд болон түүний тохируулагч итгэлцүүрийг ашиглан гарсан ХЗА-н үр дүнг дор харуулав. Бусад эдийн засгийн хувьсагчууд нь нөлөө хожуу ордог хувьсагчууд тул бодит статистикийг мэдээллийг ашиглав.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 32. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

| Түлхүүр үзүүлэлтүүд | ХЗА-ын хувилбар | 2021 оны 12 сарын 31 |                   | 2020 оны 12 сарын 31 |                   |
|---------------------|-----------------|----------------------|-------------------|----------------------|-------------------|
|                     |                 | Ач холбогдол         | 2022 оны төсөөлөл | Ач холбогдол         | 2021 оны төсөөлөл |
| ДНБ-ий өсөлтийн %   | Хамгийн сайн    | 5%                   | 14.40%            | 30%                  | 8.30%             |
|                     | Суурь           | 90%                  | 5.50%             | 40%                  | 6.40%             |
|                     | Хамгийн муу     | 5%                   | (2.60%)           | 30%                  | 4.50%             |
| Инфляцийн %         | Хамгийн сайн    | 5%                   | (0.50%)           | хамааралгүй          | -                 |
|                     | Суурь           | 90%                  | 6.70%             | хамааралгүй          | -                 |
|                     | Хамгийн муу     | 5%                   | 14.40%            | хамааралгүй          | -                 |
| Ажилгүйдлийн түвшин | Бүх хувилбарт   | 100%                 | 8.30%             | 100%                 | 10.80%            |

Дараах хүснэгтэд зээлдэгчийн зээлжих зэрэглэлд үндэслээгүй санхүүгийн хөрөнгө тус бүрийн ДМ-г харуулав.

| Санхүүгийн хөрөнгө                          | Суурь ДМ                                                 |
|---------------------------------------------|----------------------------------------------------------|
| Дотоодын банкуудад олгосон зээл             | <b>Стандарт энд Пурсийн</b> дефолт болох магадлалын хувь |
| Урвуу буцаан худалдан авах хэлцэл           | <b>Стандарт энд Пурсийн</b> дефолт болох магадлалын хувь |
| <i>Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт</i> |                                                          |
| Давуу эрхтэй ИЗББ                           | Ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээлийн %                 |
| Түрээсээр баталгаажсан бонд                 | Орон сууцны зээлд эзлэх чанаргүй зээлийн %               |
| Эрдэнэс бонд                                | Уул, уурхайн зээлд эзлэх чанаргүй зээлийн %              |
| Эрдэнэс таван толгой бонд                   | Уул, уурхайн зээлд эзлэх чанаргүй зээлийн %              |

Дараах хүснэгтэд бие даасан хувьсагчид болон түүхэн ДМ-ын шугаман регрессийн загварын үр дүнд гарсан ирээдүйн тохируулга болон ХЗА-ын загварын эдийн засгийн хувилбар бүрт ашигласан ДМ-ыг харуулав.

| Хувилбар     | Жинлэлт | Дотоодын банкуудад олгосон зээл |       | Давуу эрхтэй ИЗББ |       | Түрээсээр баталгаажсан бонд |       | Эрдэнэс бонд<br>Эрдэнэс таван толгой бонд |        |
|--------------|---------|---------------------------------|-------|-------------------|-------|-----------------------------|-------|-------------------------------------------|--------|
|              |         | Үржүүлэгч                       | ДМ    | Үржүүлэгч         | ДМ    | Үржүүлэгч                   | ДМ    | Үржүүлэгч                                 | ДМ     |
| Хамгийн сайн | 5%      | 0.12                            | 0.43% | 0.73              | 0.85% | 0.73                        | 4.61% | 1.08                                      | 15.57% |
| Суурь        | 90%     | 0.82                            | 2.90% | 0.83              | 0.97% | 0.83                        | 5.26% | 1.14                                      | 16.42% |
| Хамгийн муу  | 5%      | 1.04                            | 3.67% | 0.93              | 1.09% | 0.93                        | 5.87% | 1.2                                       | 17.21% |

Удирдлага нь гадаадын байгууллагуудад эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө буюу гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, гадаадын байгууллагуудын өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт зэрэгт ХЗА-г тооцоходоо Блумберг терминалын Чанаргүйдэх Магадлалын Үнэлгээний судалгааг ашигласан ба үүнд зээлдэгч талын зээлийн үнэлгээ нь ирээдүйн мэдээллээр тохируулагдсан гэж таамагласан. Үүний дагуу 12 сарын ХЗА-г эдийн засгийн хувилбар бүрт өгөгдсөн чанаргүйдэх магадлалыг дээр дурдсан санхүүгийн хөрөнгүүдэд ижил жинлэлтээр тооцоолсон.

## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 32. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Зах зээлийн эрсдэл.** Зах зээлийн эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн орж ирэх мөнгөн урсгалын дүн нь зах зээлийн хувьсагчууд болох хүү болон валютын хөрвүүлгээс шалтгаалан хэлбэлзэх эрсдэлийг хэлнэ. Зах зээлийн болон эргэн төлөгдөх чадварын эрсдэлийг тодорхойлохдоо удирдлагын гол анхаардаг зүйлийн нэг нь гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөр болон импортын бүтцэд зөрүүг тодорхойлох явдал юм. Банк энэхүү эрсдэлийг мэдрэмтгий байдлын шинжилгээг ашиглан удирдаж хянадаг. Гадаад валютын төвлөрлийг эс тооцвол Банкинд зах зээлтэй холбоотой өөр ноцтой зах зээлийн эрсдэл байхгүй байна. Одоогоор Банк нь үнийн бусад эрсдэлд онцгой байдлаар өртөөгүй болно.

**Ханшийн эрсдэл.** Ханшийн эрсдэл нь санхүүгийн хэрэгслийн үнэ цэнэ нь валютын ханшийн хэлбэлзлээс үүдэн өөрчлөгдөж байх эрсдэлийг хэлнэ. Ханшийн эрсдэлийг гадаад валютын багцыг төрөлжүүлэх замаар удирдаж болох ба дараах параметруудээр тодорхойлно:

- Гадаад валютын нөөцийн удирдлага
- Гадаад валютын нөөц болон гадаад валютаар илэрхийлэгдэх урт ба богино хугацаат хөрөнгө оруулалтын багцад эзлэх тухайн гадаад валютын хамгийн их байх хэмжээ

Гадаад валютын нөөцийг бүрдүүлэх валютын бүтцийг Хөрөнгө оруулалтын зөвлөлөөс жил бүр баталдаг.

Дараах хүснэгтэд тайлант хугацааны эцэст гадаад валютын болон ЗТЭ-ийн ханшийн төгрөгтэй харьцах харьцангуй боломжит өөрчлөлтөд (бусад бүх хувьсагчид тогтмол байхад) ашиг, алдагдал болон өөрийн хөрөнгөд үзүүлэх мэдрэмтгий байдлыг харуулсан. Хүснэгт дэх сөрөг утгатай дүнгүүд нь ашиг, алдагдал дахь болзошгүй цэвэр бууралтыг илэрхийлэх ба эерэг утгатай дүнгүүд нь боломжит цэвэр өсөлтийг илэрхийлнэ.

| Сая төгрөгөөр                                             | 2021.12.31-нээрх ашиг/<br>алдагдал болон өмч дахь<br>нөлөө | 2020.12.31-нээрх ашиг/<br>алдагдал болон өмч дахь<br>нөлөө |
|-----------------------------------------------------------|------------------------------------------------------------|------------------------------------------------------------|
| Ам.доллар 10%-аар чангарахад (2020: 10%-аар чангарахад)   | 455,422                                                    | 635,845                                                    |
| Ам.доллар 10%-аар сулрахад (2020: 10%-аар сулрахад)       | (455,422)                                                  | (635,845)                                                  |
| Юань 10%-аар чангарахад (2020: 10%-аар чангарахад)        | (455,114)                                                  | (479,091)                                                  |
| Юань 10%-аар сулрахад (2020: 10%-аар сулрахад)            | 455,114                                                    | 479,091                                                    |
| Евро 10%-аар чангарахад (2020: 10%-аар чангарахад)        | (19,752)                                                   | (16,504)                                                   |
| Евро 10%-аар сулрахад (2020: 10%-аар сулрахад)            | 19,752                                                     | 16,504                                                     |
| ЗТЭ 10%-аар чангарахад (2020: 10%-аар чангарахад)         | (70,215)                                                   | (71,512)                                                   |
| ЗТЭ 10%-аар сулрахад (2020: 10%-аар сулрахад)             | 70,215                                                     | 71,512                                                     |
| Алт 10%-аар чангарахад (2020: 10%-аар чангарахад)         | 159,468                                                    | 140,589                                                    |
| Алт 10%-аар сулрахад (2020: 10%-аар сулрахад)             | (159,468)                                                  | (140,589)                                                  |
| Бусад валют 10%-аар чангарахад (2020: 10%-аар чангарахад) | 28,434                                                     | 17,169                                                     |
| Бусад валют 10%-аар сулрахад (2020: 10%-аар сулрахад)     | (28,434)                                                   | (17,169)                                                   |

Эрсдэлийг зөвхөн Банкны үйл ажиллагааны мөнгөн тэмдэгтээс бусад мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн мөнгөн үлдэгдэл болон ЗТЭ-ээр илэрхийлсэн мөнгөний үлдэгдэлд тооцсон.



## МОНГОЛБАНК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 32. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгт нь 2021 оны 12 дугаар сарын 31-нээр Банкны алт ба үнэт металыг оролцуулсан мөнгөн хөрөнгө, өр төлбөрийг ханшийн мэдэгдэхүйц эрсдэлд оруулж буй валют, алт болон ЗТЭ-ийг харуулж байна.

| Сая төгрөгөөр                                   | Монгол<br>төгрөг    | Ам.доллар          | Юань               | Евро             | ЗТЭ                | Алт              | Бусад           | Нийт                |
|-------------------------------------------------|---------------------|--------------------|--------------------|------------------|--------------------|------------------|-----------------|---------------------|
| Бэлэн мөнгө                                     | 38                  | 72,542             | 51,136             | 35,712           | -                  | -                | 18,163          | 177,591             |
| Гадаадын санхүүгийн<br>байгууллага дахь хөрөнгө | -                   | 2,996,207          | 702,108            | 65,600           | 387,299            | -                | 322,575         | 4,473,789           |
| Дотоодын банкуудад олгосон<br>зээл              | 1,486,637           | 671                | -                  | -                | -                  | -                | -               | 1,487,308           |
| Өрийн үнэт цаасаарх хөрөнгө<br>оруулалт         | 3,312,896           | 2,835,320          | 245,606            | -                | -                  | -                | -               | 6,393,822           |
| Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө<br>оруулалт        | 6,533               | -                  | -                  | -                | -                  | -                | -               | 6,533               |
| Урвуу буцаан худалдан авах<br>хэлцэл            | 1,430,987           | 3,091,233          | -                  | -                | -                  | -                | -               | 4,522,220           |
| Алт ба үнэт метал                               | -                   | -                  | -                  | -                | -                  | 1,594,676        | -               | 1,594,676           |
| Засгийн газрын үнэт цаас                        | 231,778             | -                  | -                  | -                | -                  | -                | -               | 231,778             |
| Бусад санхүүгийн хөрөнгө                        | 298,108             | (81)               | -                  | -                | -                  | -                | -               | 298,027             |
| <b>Нийт санхүүгийн хөрөнгө</b>                  | <b>6,766,977</b>    | <b>8,995,892</b>   | <b>998,850</b>     | <b>101,312</b>   | <b>387,299</b>     | <b>1,594,676</b> | <b>340,738</b>  | <b>19,185,744</b>   |
| Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө                  | (1,105,589)         | -                  | -                  | -                | -                  | -                | -               | (1,105,589)         |
| Төв банкны үнэт цаас                            | (8,622,184)         | -                  | -                  | -                | -                  | -                | -               | (8,622,184)         |
